

Ц.ОЧИР

# БАГА ДАРГА



Бага дарга (1978 он) /роман/

Зохиолч: Ч.Очир

ISBN: 978-99962-1-635-0

© Энэхүү бүтээлийн эрх нь Монгол Улсын Зохиогчийн Эрхийн тухай хуулиар хамгаалагдсан болно. Бүтээлийг цахим хэлбэрээр түгээх эрхийг bookstore.mn цахим хуудас эзэмших бөгөөд зөвшөөрөлгүйгээр бүтнээр нь буюу хэсэгчлэн хувилах болон бусад ямар нэгэн хэлбэрээр олшруулах, ашиглахыг хориглоно.

[www.bookstore.mn](http://www.bookstore.mn)

Энэ ботийг аавтай минь хамт уран бүтээл туурвиж, жаргал зовлонгоо хуваалцаж бие биенийхээ онгодыг хөглөн дэмжиж явсан зохиолч, эрхэм хүн Р.Сайжаагийн гэгээн дурсгалд зориулав.

## Талархал

Энэхүү хоёр ботийг хэвлэхэд ховордож олдохоо байсан аавын маань зохиолуудыг хувийн номын сангаасаа өгч гүн туслалцаа үзүүлсэн зохиолч Г.Дүйнхэржавын охин, Тагнуулын Ерөнхий газрын Архивын албаны дарга, хурандаа Д.Буджавт гүн талархал илэрхийлье.

# Нэгдүгээр бүлэг

## Нүд үл итгэнэ

### I

Мичин жилийн хаврын адаг сар нэг л зэврүүн, ногоо цагаа ч үгүй, модны өнгө хүртэл үнсэнд дарагдсан тулга шиг ажээ.

Өглөө бүр ёсорхдог заншлаа дагаж цайны дээжийг гомбо гүр бурхны өмнөх их голт гуулин цөгцөнд дүүргэн тавьж, баян хангай, алтан дэлхий, лус савдаг, уул усны далдын эздэд биширч, хишиг ивээл гуйн сэмхэн залбирахдаа зурвас зулзаган ширэнгэ бүрхсэн намхан гүвээн дээгүүр алсад цэнхэртэн дүнсийх Тогоот хайрхны сүүмэлзэн үзэгдэх оройг нүд салгалгүй ширтэж, цайгаа дахин дахин цацлан өргөөд гэртээ эгэн орсон насан ахимаг авгай адсаганы сэжүүр дээр тахимдан сууна.

Үүд сэвхийлгэн орж ирэгчийг цочин харсан авгай уулга алдаж,

— Ээ! Ашгүй Нэмэх чи хүрээд ирэв үү. Аав чинь хаачаа вэ? Та хоёрын төлөө сэтгэл зовж дэг дуг хонолоо. Хоол хүнс бэлтгэж зэхсэн, бушуухан юм ууж идээд явж үз хүү минь. Хөөрхий, хөөрхий нялх амьтан шүү дээ гэж сайхь эх хүүгээ өхөөрдөж духан дээр нь үнсээд, модон тагшинд арвайн гурил хийж дээр нь цөцгийтэй өрөм бялхуулж өгөв.

Авгай туурганы амны ярагдсан зай завсраар байн байн гадагш ажиж нүдээ бүлтэлзүүлэн бодолхийлнэ. «Зам хөлөөс дайжиж бөглүү буйд газар амь хоохойлсон нүүдэл суудал эцэстээ юу болдог бол? Хүүд минь л гай дайрахгүй байвал хоёр хөгшин хар толгой ч яана гэж дээ. Хүүгийн эцэг дээлэндээ нөхөөс тавиулахдаа дотор нь нэг юм нууцлан оёулсан...» гэж санаа хоёрдон үймэрсэн эх, хүүгийн хонгор зул царайг хараа салгалгүй ширтэж,

— Нэмэх ээ! Та нар олуулаа юу? Цугларч зүгширтлээ тэндээ хоргодох хэрэг үү? гэж сониучлахад,

— Ээж ээ, санаа зовох хэрэггүй. Манай гол усны хөгшин залуу арваад хүн бий. Миний танил Санж, ах Дандтайгаа, би аавтайгаа байгаа, бүр ч таатай санагдах юм. Тогоот хайрхны ар өвөр, суга нугачаа, гүн гуу жалга, ой шугуйд мянган эр ч орогнон амьдарч болох нүх сүв алиныг тоочиж барах вэ гэж хүүгээ итгэлтэйгээр өгүүлснийг сонссон эх нүд тас анин наманчилж,

— Усан бороо, цасан шуурга, халуун хүйтэнд хадан хонгилоор гэрээ болгож, харанхуй шөнөөр ханиа хийнэ гэдэг чинь зэвүүн цаг болж дээ, бурхан тэнгэр далдын эзэд минь хүүгийн минь зам мөрийг ивээж өлзийгөө өгөх болтугай хэмээн үглэн даатгаж сүшиглэнэ.

Нохой боргоох чимээнээр гадагш сэм лавлан шагайгаад хойш алхам ухарсан авгай,

— Бүү үзэгд. Буу зэвсэг ёрдойлгосон гаж буруу байрын улсууд айсуй. Лам дээлээ нөмрөөд аавынхаа орон дээр түргэхэн хэвт. Үхлүүт хүнд өвчтөний башир үзүүлээрэй гэж амжин

захиад үл таних гийчдийг угтаж нохой хорихоор гарав. Нэмэхийн зүрх түг түг цохилж сэтгэл үймрэн бодохдоо «хэд хоногийн өмнө буурал аав минь сүү болсон өтгөн шаргал цай аягалж, яаралгүйхэн хэд оочилж тавиад, мод толгойдоо тамхи нэрж асаагаад хөмсөг өргөн эдэлгээндээ хуучирч хүрэн өнгө хувиран гандсан шандан даавуу дээлийн зүүн энгэрийн нэгэн нөхөөсөн дээр хараа тогтоон удтал ажиж,

— Энэ өчүүхэн нөхөөсний цаана миний хүүгийн зол жаргал нуугдаж байгаа юм гэж далд утгатай үг хэлээд, ээжид өгөхөөр сарвайхдаа дугуй захтай болгоорой. Хэрвээ бурангуй үйлтний нүд хуурах аяс тохиолдвол голомтын эзэн ганц үр минь, наад эгэл жирийн биш, ээлтэй бүхнийг шингээн хадгалсан энэ дээлээ өрөөлдөн нөмөрч, яг л хүнд өвчтөн шиг царайлан хэвтэх болно гэж аав хэлэхэд ээж,

— Бурхад, гэгээн богд, багш лам нарын сахиус авралдаа багтаах байлгүй. Хайрт амин сүнсээрээ ингэж муу ёр зөгнөдөг чинь юу билээ гэж сэжиглэн зэвүүцэхэд аав,

—Муу ёрыг, муу ёроор домнох ёсон бий. Нэр төрөө алдсан цагаан мангасын ходоодыг дүүргэх гэвэл нэгэнт хошуу байтугай бүх л аймаг шавь, хүн мал, газар устайгаа залгигдсан ч юм болохгүй дэг ээ. Ер нь иймэрхүү үймээн самууны цагт үхэхээс бусдыг хийж байж гэмээжин наанадаж өөртөө, цаанадаж түмэндээ тус хүргэх болно гэхэд ээж суларсхийн,

— Хүн болсоор лам зах залгаж үзээгүй. Гэвч чадах ядахаараа хичээе гэв.

— Аав аа! Би лам болох дургүй. Миний тав гэзэг овоо ургаж байна гэчихсэн чинь,

—Дур сонгодог цаг биш, ая дагадаг цаг гэдгийг ухаарч үз, хүү минь. Харин мартаагүй дээрээ үсийг чинь хусчихъя гэж тонгоргоо хайж эхлэхэд ээж,

— Өнөөдөр хатуу гариг шүү дээ! Хүүгийн минь тэргүүнд мэс битгий хүргэ гэж дургүйцэн хориг тавив.

— Самган минь өдөр судар хүлээх цаг биш дээ. Гал цог шиг ганц хүүгий минь бүү хэл, ямаан сүүлэн гэзэгтэй, яс арьсан өвгөн гэлтгүй над мэтийг цэрэгт хамж байна шүү дээ! Муу юм бүхэн түмэнд хал балгүй шиг холуур өнгөрөөсэй гэж аав хэлээд зоримог зан араншин нь зөөлөрч билээ.

«Гол усныхаа санаа нийлэгсдийг нэг доор цугларуулан уул хаданд нууц бүгүүлэхээр би аавын хамт мордож зам нийлэх, эс нийлэх олон хүнтэй шөнөжин маргаж хоноод, аав минь нууж бэлчээрлүүлсэн морьдоо авахаар зам салан одсон. Би түрүүлж ирдэг буруудах шиг боллоо» гэж Нэмэх бодож бухимдан байтал гадаа хүн шуугилдан бууцгаах чимээ сонсогджээ.

## II

Гэрийн гадаа сүр бадруулан бууцгаагчид гэр тойрон бүсэлж бугаа зэхсэн харагдана. Гэрийн үүд сэлмээр өлгөж тотгон дээр хаяж, сэжигтэйгээр орж ирсэн дөрвийн нэг, өндөр биерхэг орос дарга ор сандайлж, сэлэмний бариул дээр эрүүгээ тавьж дув дуугүй элдвийг ажиглана. Долир нүдтэй лагс эр, авдар сав, ор дэр нэгжиж, хоймрын авдар дотроос даавуунд боодолтой

юм гаргаж задлаад,

— Бууны сум байна гэж дуу алдахад, улаан царайт гүнгийн зэрэг хэргэмтэн авгайг ёрын хуруугаар дохин,

— Буу хаана байна, гарга гэж тулган зандарч Нэмэхийн толгой дээгүүрээ нөмөрсөн дээлийг хуу татан өшиглөж бос! гэж тушаагаад,

— Энэ залуу эр танай юу вэ? Яагаад хэвтэж байгаа юм бэ? гэж асуухад авгай,

— Хийдэд шавилан суудаг хүү минь. Үхлүүт өвчтэй, амьдын тамаа эдэлж байгаа хэцүүдсэн амьтныг та бүхэн толилж байгаа биз гээд олигтойхон «ёол» гэсэн дохиогоор хүүгээ сэмхэн хяламдана.

— Одоо цагийн ламбугай төрийн хар хүн шиг гээг тавьдаг болоо юу?! Танай эрхэмсэг хүүгийн өвчин бидний дуулиагаар туссан нь илт байна. Лам хар ялгаагүй цөмийг цэрэгт татна. Биднээс мултарсан ч, улаан намынхан хамна. Хүүг чинь цэрэгт авлаа. Цог золбоотой, ийм эрэлхэг эр буу зэвсэг зүүж, дайны талбайд дарь хүхэр үнэрлэх хоромхноо хамаг өвчин эдгэрч арслан барсын сүр жавхланд хувилна гэсэн үг. Хоол хүнс, морь уналга, сум хэрэглэлийг бэлхэн байлгасан, бидэнд сайшаалтай хэрэг. Харин гэрийн эзэн, буу хоёр хаана байна?! Мэдээжээр ууланд дүрвээ биз гэсэн сэжиглэлийг сонссон эхийн царай цонхийн цайж,

— Би өвчтэй хүүгээ цэрэгт яасан ч явуулахгүй. Юманд явсан эцгийг нь ирэхээр явуулъя. Эсхүл би өөрөө оронд нь явъя гэж балмагдахын эрхэнд үгээ ширүүсгэв.

— Чам шиг зуун чавганц байлаа ч нэгэн болхи мунгинаа эрийг орлож чадахгүй. Цэрэг дайчилгаанд хориг тавих аваас өчиггүйгээр цаазална гэж манай ноён дарга хэл! гэж байна хэмээн долир эрийг хэлмэрчлэхэд ээжийдээ муу юм болох вий гэхээс Нэмэх яаран босож, шалмаг хувцаслав.

Тэрбээр эхийнхээ хийж өгсөн аягатай сүүг нэгэн амьсгаагаар залгилж дундуур болгоод, буцаж ирэхдээ ууя гэсэн зөн билгээр буцаан өгөхөд цагаантны дарга Нэмэхийг том том харж, тууж гараад «өөрийнхөө эмээлтэй морийг уна» гэж тушаав.

Сайхь эх хагас хугасхан ухаанаар биеэ барьж, хүч түрэмгийлэгчдийн өмнө өвдөг сөхрөхгүй, тэвчээртэй байхаар шүд зууж байснаа гэнэт ухасхийж хүүгээ тэврэн зуурч,

—Хайрт хүүгий минь үлдээж хайрлаач, өршөөгөөч гэж дуу өндөрлөн гуйхад орос дарга уурсаж, мушгимал суран ташуураар хэд хэд ороолгоход Нэмэх, ээжийнхээ нүүр толгойг халхлан хаацайлах гээд гөвгөр гөвгөр гүвдрүү хүртэвч, эх хүү хоёр улам чанга тэврэлдэн зууралдахад ноён дарга ууртайгаар хашгичин,

— Наадхи зөнөглөсөн гичийдээ хүйтэн зэвсэг хэрэглэ гэж тушаасан ноён даргын хянга хамарт гонзгой шар нүүрэнд төрөлхөөс заяасан мэт ташуу цагаан сорви улам тод зурайж, хонх ёнх ёлтолзох ногоон нүд сүртэй хялалзахыг Нэмэх тогтоон ажиглаж хорсон зэвүүцэх агшинд

хялар цэрэг сэлэм сугалан гялалзуулахад, Нэмэх эхийнхээ чихэнд,

— Надаас түргэн холд, амь насанд чинь аюул гэж шивнэхийг эх бүүр түүр ухаараад гэдрэг суун тусаж, дахин гар сарвалзуулан ухасхийхэд хялар цэрэг түүний бугалга бүлчинг болд мэсээр сэт зүлбэж гэдрэг суулгав. Гэрээс хэдэн арван алхмын зайд савж ойчсон ээж нь торойн торойсоор бараа тасрахад Нэмэхийн нүдийг нулимс бүрхжээ. Хөсөр унасан эх ухаан бүүдийн сэргэж, нүүрээ маажин толгойгоо дүйртэл савчиж, ийш тийш гөлрөн ширтэхдээ тэртээ гүдгэр дээгүүр бүртэлзэн далд орж байгаа морьтонгуудын дундаас хайрт үрээ олж харах гэж хичээвч үл үзэгдэж, зөвхөн санаа сэтгэлд нь дүрслэгдэн,

— Хүүгий минь, эзэн төрийн сүлд өршөөх болтугай. Мэнд сайн яваад ээждээ түргэн эргэж ирээрэй гэж аман дотроо бувтнаад дахин ухаан балартав. Хэдий болтол хэвтсэнээ мэдэхгүй, хий дэмий сандарч, орчин тойрноо нэгжин ажиглавал айл амьтнаас зэлүүд энэ нутаг нам гүм дүнсийн нойрмоглоно.

Гэрээс холгүй өнгөрөх зөрөг замын зүүнтэйх тэнгэр цоройлсон хадан цохио улам ч сүртэй сүмбэрлэх нь засаг ноёны жасаа тамга суурьшсан хүрээний их чогчин дуганын ганжир адил аа. «Би тавин хэд хүртлээ олж үзээгүй юмаа энэ өглөө нүд үзэж, гараар барин сэтгэн ухаарсан маань миний бүх л үзэж харсан, үүрсэн дүүрсэн, сайн муу юм бүхнээс хамгийн аймшигтай, аюултай хэцүү юм энэ байлаа. Иш чааваас, хүн харвал миний муу бандийг аав шигээ ханхайсан лухгар эр болжээ гэх вий. Надад бол найм есөн сартайдаа хэдхэн цахиуран цихэр шүд цухуйлгаж баясан мишээсэн нялх амьтан тэр аяараа шиг санагдана. Дух, хацрыг үнэрлэхэд үнэр танар нь бүүр нярай шигээ байдаг юм. Эвий хөөрхий үр минь, дайн дажны хөлд өлзий бус үрэгдэлгүй, эсэн мэнд эгэж ирүүлэхийг догшин шүтээн, багш ламын сахиус болгоож үзээч» гэж сайхь эх аман дотроо хэлээд наманчлан, залбирах гэж гараа өргөх гэтэл баруун гар улаан нэлий болчихсныг хараад зүрх палхийн, дотор харанхуйлж бугалгаа базлан атгаж «шалавхан гэрийнхээ барааг харья» гэж боджээ.

Босгоо элгээрээ тэгнэн унаж, хэдэн агшны дараа тэргүүнээ өндийлгөхөд авдар шүүгээ, гал голомт, аяга таваг, тогоо шанага нь нүднээ тусаж, орон өөдөө хичнээн хүч гарган зүтгэж мөлхөвч сайхь эх тос дууссан зул жаргах адил болжээ.

### III

Нэмэхийн аав, нутгийн хоёр хүнтэй морьд голдуу хэсэг адууг бартаатай уул бараадуулахаар яаравчлан тууна. Энэ хоёрын нэг нь япон сийсанлий, нөгөө хоёр нь бярдан буу мөрөвчилжээ. Дүнсгэрдүү, дуугүй яваа ахимаг эр мөр зэрэгцэгчийн зүг нүүр эргүүлэн,

— Танай хүү өдийд гэртээ хариад, лав наашилсан байх аа. Гайгүй цовоо сэргэлэн эр болно доо гэхэд өвөгжир хүн,

— Хүү минь өдийд эргээ биз. Тэр бид хоёр цовоорхоор юу шалих вэ. Зориг чанга, түс тас амьтан болж магадгүй гэж санадаг. За байз, түргэхэн шиг нөгөөдүүл дээрээ очиж Тогоот хайрхны суганд лавхан шургаад авбал цааш явах замыг би сайн мэднэ гэв.

— Түүнийг хараач! Олон морьтой хүн биднийг чиглэн айсуй. Нэг нь онцгойрон наашиллаа

гэж залууг хэлэхэд Нэмэхийн аав дурандаад

— Нээрээ нэг нь бидэн рүү ирэх нь шиг байна. Гурав, гурваараа эгнэсэн долоон хэсэг гайхал явна. Хэрэг бишидлээ. Бид баригдвал тэртэй тэргүй амь хохирно. Тэгэхээр сумаа дуустал үзэлцэхээс өөр замгүй. Ээ насаа нэм гэж, би хориод сум даавуунд боож байснаа гэртээ мартжээ. За! Тэр ямай. Байгаагаараа олигтойхон долоолговол нэлээн хэдийн хөлийг амраанаа. За түргэлж үзье гэж шийдэмгий хэлэв.

#### IV

— Бүгд амархан сайн байцгаана уу? гэж нүүрмэг мэндэлж дөрөө мултлагчийг Дэчин гэдгийг таниад дотор уужирсан Нэмэхийн аав,

— Чи газрын хаанаас гараад ирэв? Цаадуул чинь юун улс вэ? гэхэд Дэчин тамхилах зуураа толгой сэжиж,

— Та нарын барааг цагаан гайхлууд харж, намайг явууллаа. Тэдэнд, та нарыг хэдэн гүү туусан өвөгчүүл явна гэж заль цохин хуурч, урд замаар чулуу хөөлгөж орхиё, зөв үү! гээд мушилзахад,

— Тэгж үз, Дэчин минь. Тэгэхгүй бол бидэнд гай тарина гэж хариулсан Нэмэхийн аавын харцанд хянуур хэрсүү дүр илрэнэ. Дэчинг буцаж явахад үнэмшин итгэж сэтгэл амрангуй байгаа хоёр нөхрөө ажигласан Нэмэхийн аав,

— Дэчин амьтан хүнд ад шоод болсон, хөө шиг дотортой хүн шүү! Үг нь бэлэн, инээд нь худал гэж мэдээрэй. Гурван хар толгойг битүүгээр түншээд явсан байх аа! Юу ч болсон бэлэн зэлэн зэхээстэй байя гэж сэрэмжлэн өгүүлэв...

\* \* \*

«За! муу лантуу Чойнболыг араар чинь тавьж амжлаа. Цагаантны гарт орсны дараа арван тавны цагдаагийн нэр сүрээр далайлган ташуурдахыг чинь үзэмц. Ер нь «лантууг» эртхэн далд хийлгэж авахгүй бол сүүлдээ яаж ч мэднэ. Ардын намынхантай сэм санаа нэгдэн нийлж тэдний ятгалгаар ойр орчныхоо хүн амьтныг үймүүлж байгаа нь гарцаагүй боллоо. Үүнийг нь илчлээд цагаан цэргийн даргаас нэмүүхэн хишиг хүртэнэ. Байз, байз Чойнболын хүү Нэмэх ааваасаа дутуугуй айхавтар чөтгөр дөө. Тэр хаана байгаа бол...» гэж Дэчин бодсоор яаран давхисаар гайхлууд дээрээ ирж заль мэхээ магтаж шангаа горилжээ.

Цагаантан гурван хэсэг болон тасарч араар нь ороож бүслэх маягаар яаралгүйхэн ахихад, адуучин гурав ч тулалдахаар зэхэв.

Цаадуулын зарим нь явгалж тал талаас улайран дайрч эхлэхэд Чойнбол гох мултлах бүрийд сум тоолон буудан унагаж, давшигчдыг толгой дараалахаар анана. Овоо хараагаа хичээнгүйлэн тааруулж гох дарах гэтэл зэргэлдээх нөхрөө толгой гулжисхийлгэхийг харж тус хүргэхээр өндийх агшин зуур буун дуу тасхийж баруун гар нь шархдав. Чойнбол буугаа шүд зуун атгаж гох дарах гээд чадсангүй. Цагаантан бүслэн авчээ. Амьд хэл олзолсондоо



олзуурхсан араатангууд шархтан гурвыг хээрийн штабтаа аваачиж, бууны сүмбээр бүлдруу гаргаж,

— Та нар ардын намынхантай нэгдэн нийлж агт уналга туслахаар явааг бид мэдэж байна. Тэдэнтэй хэдийнээс холбоо сүлбээтэй болсон бэ? Бушуу хэл, та нарын амьд гэрч энэ байна хэмээн Дэчин руу зааж хүч тулган байцаахад хөөрхий гурвын шарх хүндэрч, зодуур тамлалтанд нэрвэгдэн үг дуугарах байтугай толгойгоо даахгүй болж ухаан орж гарна.

«Та нарын гарт амь хохирсон нөхдийнхөө өшөөг хэд дахин авна. Бидний үйлс хэзээд мөнх...» гэх үг тамлуулагчдын дунд тодоос тод цуурайтна.

Энд тэндээс тав, гурваар барьсан хүмүүсийг морин жагсаалын цуваа болгон хөдөлгөж, хоёр хажуугаар цагаан цэргийн дарга, цэрэг харгалзан дагана. Цагаантны өмнө хойно эрх хав аятай бөхөлзөн нахилзаж хишиг горилон яваа намхан хар хүн бол Дэчин ажээ.

«Хий зайг тааруулж энэ шөнө оргоё, цаад хялар цахар чинь өрөөсөн нүдтэй гэлтгүй тун жархай гударга байгаа юм. Тэр бүдүүн мангарын манаа тааруулж л зулрая» гэх шивэр авир яриа олзлогдогчдод сэм сэм дамжигдана.

Жагсаалын цуваа замд шуударснаас хойш хагас өртөө яваад байтал дунд эгнээнээс туранхуй өндөр залуу морины ам гэнэт өөр тийш залж шууд зугтахыг харсан хялар цэрэг винтоваа мөрлөн буун дуу тасхийж, өндөр залуу эмээл дээрээ арай ядан тогтож цааш зугтав. Хялар цэрэг гүйцэн очиход, залуу жолоо татаж,

— Намайг нэгмөсөн алаад аль! Үүнээс цааш та нарыг дагаж алхам ч явахгүй. Хэн урьдсан яргачныг эрлэг номон хааны элчээр цаламдуулж шүүлгэнэ гэж нүд чичлэн ханхалзахад цахар цэрэг бууны амыг огцом өргөж,

— Гуйсныг байтугай, гуйгаагүйг цааш харуулдаг эрх нь энэ байна. Май! гээд бууны ам тулган гох мултлав. Залуу эр амь алдах хоромд бууны амыг биш, алуурчны зэвхий хөх царайг хүжийн гал мэт төөнөн ширтсээр хурц сүхэнд тас цавчигдсан зулзаган мод шиг гудайн унаад хөдөлсөнгүй.

Цагаантан цугларан тойрч ахмад цолтой ноён дарга нүдний цагаан шилээ засаж, амь хохирогчийг үл хайхран бие зүдрэлгүй нухсан ан амьтныхаа дэргэд сэтгэл хангалуун байгаа анчин гэлтэй даналзаж, хялар цэрэг руу тааламжтай харж,

—Та үнэхээр мэргэн бууч юм. Өдрөөр оргон зайлахыг улайн цайн зүрхэлсэн дайсныг дор нь ингэж тонилгох ёстой. Баатар гавьяа байгуулсны чинь төлөө эрхэм таныг дараа тушаал дэвшүүлнэ. Одоогоор алтан маниад нэгээр шагнасугай гээд халаасандаа гараа хийв.

Өөрийгөө чиглэн агаарт эргэлдэж буй ганц зоосыг алдалгүй шүүрэх гэж хичээсэн хялар цэрэг, зүүсэн мэсэнд нь чанхийж газар ойчсон маниадыг өвс шороотой хамт атгахад хүмүүс доог тохуу болон хөхрөлдөнө.

Цуваа цааш хөдөллөө. Эмх журамтай явцгаахыг сануулж шаардсан цагаантны хялар цэрэг

рүү, нүүрэндээ барзайсан сэвхтэй, хүрэн эрээн нүдтэй бүлиа эр гэнэт дайрч хутган «жад» гялс хийлгэхэд тэрбээр үхэтхийн ойчив. Цагааны дарга, цэрэг нар олон муур ганц оготноор даажигнах адил бүлиа эрийг сэлэмдэж, тархи толгойгоо хамгаалахаар сарвайсан гар нь мухарлагдаж, цээжин бие тэр гэхийн тэмдэггүй боллоо.

Зүрхээрээ хутгалагдсан цагаан цэргийг шинель дээр нь гэдрэг харуулж, эмч магадалсны дараа оршуулахыг зөвлөнө. Цааш харагчийг шинелээр бүтээж, толгойн тус газар сэлмийг газар хатгаж, малгайг өлгөлөө.

Зүг чигээ буруулсан цуваа хоногийн дараа бага үдийн хэрд намхан даваан дээр түр саатан цааш хөдөлж, дүүжлүүрийн газар ирэв. Цувааны эхэнд яваа Нэмэх зүүн гар талдаа дөрөө харшуулагч ахимаг эрээс,

— Энэ яасан хүн дүрсээ алдсан яргачид вэ? Би ийм юм үзэх байтугай, зүүдлээ ч үгүй. Яасан зүрх өвдмөөр юм бэ гэхэд,

— Дүү минь аяархан ярь. Бидний амь нас мэсний ир, бууны ам, дүүжлүүрийн аль нэг дээр яг барьцаанд байгаа гэдгээ санаарай. Нүд хальграм энэ үзэгдэл зүүд зэрэглээ ч биш, дүүжлүүрийн хядлага гээч нь байхгүй юу.

Бидний сэтгэл санааг шимшрүүлэн мохоож нэгээр нь нөгөөг хядуулах гэсэн бузар аргандаа үг дуугүй хавхдах гэсэн далдын хорон санаагаар хийгдсэн ов мэхийн нэг ээ! Ингэж хүний зүрхийг үхүүлэхдээ «хэрэв та нар бидний үг тушаалыг дагаж дарь хүхрийн хөшиглөсөн манан дунд дайтахыг татгалзвал ийм болгоноо гэсэнтэй утга адил гэхэд Нэмэх хиртхийн цочиж ард хоцорсон аав ээжий нь аврах «шүтээн» шиг бодогдоно.

Гурван морьтой хүн зэрэгцэн гарахаар тохируулан зоосон хоёр баганан шонгийн нуруунаас гурван хүн дүүжилжээ. Хувцас хүнар, төрх байдлыг харваас малчид байлаа. Нэгэн хүний нүүрийг бүрхсэн даавуун доороос буурал гээгний үзүүр цухайхад «аав шиг минь бууралтсан хүн юм» гэж Нэмэхэд бодогджээ. Харь дээрэмчдийн цусан мөрний хар зураасан толбыг Нэмэх ойртон ойртотлоо нүд үл итгэн «хиймэл мануухай, хувцас хүнартай чихмэл дүрс» хэмээн бодож байснаа яг доогуур нь шурган гарахдаа зүрх алдан, нүдээ тас аньчихсан байжээ. Зэрэгцэж яваа ахимаг эр нүд цавчилгүй ширтэж, санжиганах хүүрийн хөлийг шүргэн өнгөрөхдөө нэгийг сайн таньж, уй гунигийн далдалж болшгүй нууцыг Нэмэхэд цохлон хэлэх гээд зүрх алдан түгжирчээ.

# Хоёрдугаар бүлэг

## Нөхрийн захиа

### I

Да хүрээний цагдан журамлах газрын түшмэл Дамдиндорж албандаа эртлэн морилоод, давхарлаж зузаалсан олбогт суудалд буурьтай сууна. Тэрбээр өтгөн гээгтэй хавчиг толгойн мэлзэн духаа дарсхийж духдуулсан цэнхэр шаазан жинстэй, хар хилэн малгайн сагалдаргыг чангалан засаж, хүрэн бор ов тов цоохор царайгаа барайлган бодолхийлнэ.

«Манай түшмэл гуай тун их хилэнтэй байх шив. Сэтгэл нь үймрэх юм лав учирсан байх» гэж цагдаа Цогоо цохлон бодно.

— «Уулын эзэн» үлдээд бусад нь гарцгааж бай гэж тушаасан түшмэл арван тавны цагдаагийн эрээн алаг хантаазтай, дөч эргэм насны өндөр тэгш нуруутай хүдэр эрийн бардам сүрлэг харцнаас үл мэдэг дальтарч,

— Цог оо! Чамд аминчлан итгэхээс өөр аргагүй боллоо. Урьд шөнө манай өнөөх «тийрэн» миний жаал зугаа хатуу эдлэлийг цөлбөж богцлоод жороо хээр бага загалаар унаажин алга болсон байна. Хэрэг нэмж тариад нэр сүр хөөдөж, эд юм үрэгдэхээс урьдаж үзээрэй гэж итгэмжилсэн дүр үзүүлж доргиоход Цогоо,

— Түшмэлтэн минь зарлигийг тань ёсчлон дагая. Хэрвээ танай хүү Жамсранчойн халуун мөрийг мөшгисөөр нүүр тулгарлаа гэхэд шууд барьж андлаад ирэх үү? гэж эргэлзэн лавлахад түшмэл,

— Яахаа чи өөрөө мэд. Гарт минь л оруулаад орхи гэв.

Түшмэлийн мэнгэртсэн цээж дотор үе үе давчдаж бугшин ханиалгаж, эргэн хургацах бодолдоо автагдана. «Хорин долоон жилийн өмнө би хорин тавтай, ид халуу оргиж явахдаа хошуу тамганд өргөх бичээчээс хальж туслах түшмэлийн буурийг горилж байсан цаг аа. Эцэг эхийн шахалт хавчилтын аясыг дагаж гэрлэж билээ. Албадлагын авгайгаа хаяж орхиод өөрийн нүдээр шунан шүүхээр долоон хошуу даншиг наадамд очиж, түмний хөл хөдөлгөөн дотроос арилгасан сонгино шиг цэвэрхэн бүсгүйтэй учралцсан шүү. Зүрх сэтгэлийн тавилангаар заяагдсан түүнээ ханилсан нөхөр нь болох лантуу Чойнболоос сүр хүч, эд хөрөнгөөр бардан түрж улайн цайн салган суусан. Тэгэхэд одоогийн уршиг таригч гэдсэнд нь ирж, удалгүй амаржаад эсэн мэнд бойжин гэр хотлоор өлзий жаргалтай амьдарч байтал арав дахь жилдээ хөөрхий эх нь халуун хижгээр бурхан болсон. Үүнээс хойш хорвоогийн жам аясыг дагаж миний хувь зохиол арван долоон жилд гурван эхнэр солиход нэг нь ч нойтон сормостой юм унагасангүй ээ. Хүү минь ийнхүү гурван хойт эхийн хатуу хүйтэн гараар нударгалагдсаны гайгаар ингэж гаж буруу замд орсон байж болох юм. Зам мөрийг эртхэн шиг зөвтгөн засах явдал эцэг нэр зүүсэн миний толгой дээр тохогдох хэрэг ээ. Яая даа байз, яая. Мөглөндөж хашраах уу? ...эсхүл цөлөөд үзэх үү? шоронд хорьж хатаах уу?... миний хүү ингэж хатуургах хэрэг түвэг хийсэн үгүй ээ. Тэгэхээр яах ёстой вэ? Зөөлөн арга хэрэглээд үзэх нь л

зөв. Ядаж цаг төр үймж, гамин чандруу, цагаан, улааны дайн самуун дэгдээд хэцүү байна. Гамин хүрээг эзлээд байхад ар өвөрт нь бүлтаж амь хоохойлох аядсан. Одоо цагаан борооны хавчилт шахалт бараг яс маханд хүйт даалгаж аргалах аргагүй хэцүү еэ. Харин улааныхны хувьд гэвэл одоогоор ийм тийм гэж санаа сэтгэлээ зовоох хэрэггүй. Цаг дээр нь яахаа шийднэ» гэж ээдэй баадай бодолд автан цөхөрч суутал шөнийн эргүүлийнхэн эргэн бараалхаж дээрэм хулгай, зодоо цохио гээд эсэн бусын хэрэг явдлын тухай айлтгахад өөрийн мэргэн шүүлтэнд цаг үргэлж итгэн бардамнадаг түшмэл,

—За хө! Өнөө гайхал цагаан шөрмөс Вандан бас орооцолдоо юу! Энэ өдрийн шүүн тунгаалтыг эрэмгий эрээр эхэлнэ. Түүнийг бушуу оруул гэж омогдонгуй өгүүлтэл зөрж бараалхсан нэгэн цагдаа мэхэсхийн толгой дохиж,

— Түшмэлтэн гуайд онцын чухал айлтгал байна гэвэл,

— Айлтгал гэнээ. Бас ямар уршиг дэгдэж орхио вэ? Хэл, хэл гэж уцаарлан харахад,

— Хүрээний хамгийн их нэр цуут худалдаачин Далайбуян гуайнх хоёр гамин орогнуулж байсныг авч ирэхэд худалдаачин өөрөө танд бараалхана гээд хүлээж байна гэж хэлээд мэхэсхийн биеэ эгцлэн зогсоход түшмэл таашаангуйгаар,

— Ванданг түр азнаад их худалдаачин гуайг одоо надтай нүүр учруул гээд суудал засан ихэмсэг дүртэйгээр тавлан сууна.

Худалдаачин Далайбуян орж ирмэгц намс намс хэд алхан зог тусаж дороо бөхөлзөн,

— Өндөр их түшмэл таны амгаланг айлтгая гэж хичээнгүй мэндэлсэнд түшмэл,

— Эрхэм худалдаачин таны амрыг айлтгая. Та дээшээ сууж айлд. Ямар тухай хэргээр морилж яваа вэ? гэж үл мэдэгч болон асуухад худалдаачин,

— Түшмэлтэн гуай! Та ядуу худалдаачин намайг болгоож өршөөхийг гуйя. Би жаахан буруутай ч, нарийн яривал буруу байхгүй. Хүний газар гүний нутагт ядарч яваа амьтсыг хэд хонуулсанд буруу юу байв гэж зальтайгаар өгүүлээд мушилзан тал засаж бие цагаатгахад түшмэд овжингоор;

— Цагаантны гарт л ороогүй чинь яамай. Хэрэв тэдэнд... гээд дүүжлэгдэхийг хуруу гараар заан ойлгуулахад Далайбуян айдас хүрч бие чичрүүлэн хоёр гараа элгэндээ тэвэрч,

— Танай эзэн төрийн сүлд аварч, намайг тантай дахин нүүр учрууллаа гээд нялуунаар инээх аядан болор мэт тунгалаг чулуун шилнийхээ алтлаг хүрээн дээгүүр зальжин харцаар нүд эргэлдүүлж түшмэдэд нэгэн нууц зүйл мэдүүлж амжсандаа тайвширч хөлсөө арчин инээмсэглэнэ.

Түшмэл дотуураа дэвэрч хөөрөн байгаа сэтгэлийн хөдөлгөөнөө хүчээр барьж, баярласандаа жумалзаж цэр тагласан хоолойгоо хяхар татан засаж,

— Та бид хоёрын явдал зүүний үзүүр орох зайгүй болж, энэ удаад гэвэл танай буруудсан үйл

мөрийг зөвтгөн цагаатгасны төлөө урьд танаас хүүтэй зээлдсэн мянган лан мөнгөний тэн хагасыг суутгах болов шив дээ. Аа харин хоёр хар толгойдоо л шингээхгүй бол аюултай гэдгийг худалдаачин гуай... гэж түшмэл анхааруулахад түүний үг бүрийг анан тунгаасан худалдаачин «цагаатгасан», «суутгах», «аюултай» гэдэг үгсийн утгаар хор шар нь буцалж «суутгах болов шив дээ» гэсэн лавлалт голыг харлуулж бушуухан салахын мөрөөсөөр,

— Түшмэл гуай! Би гэдэг хүн тун их гялайлаа. Таныг насан турш мартахгүй гэж хий зулгайдахад түшмэл нүд ихэсхэн талархаж,

— Эрхэмсэг худалдаачин та гэртээ харихаар морилно уу? Санаа битгий зов. Танай наймааны ажил өлзийтэй сайн бүтнэ гэж ерөөгөөд суудал өндийн үдэв.

## II

Цагдаа Цогоо дэлийг дарж зассан ац хондлойтой тарган хул морины жолоо угзчин гудамж зээлийг сүлжин цогиулахдаа «манай залан гуай хүрээ хорооны цагдаа нарыг захиран ёсчлуулах түшмэдийн дотроос бичиг үсэг сайтай, ухаалаг хашир эрийн тоонд орох түшиг томоо бүхий хүний нэг мөн. Цаг төр донслон үймж байгаа одоо үед алсын бодол холын хараагаар ардын намын талыг баримталж тэдэнд сэм хэл залгуулах, сэнхрүүлэх бичгийг нууцаар тарааж, улаан талын нэгэн орос хүнтэй зузаан түншилж хэдийн зам мөрөө таньж байдаг залан гуай хаашаа бол... Би өсгийгий нь дарж мацна. Харин энэ явдлын далимаар залангийн сайн сайн түншид хэл залгуулах юу магад. Уулзаад авья гэж бодсоор явж зүүн Сэлбийн баруун эргийн хавьцаа нямбай гэгч барьсан шургааган хашаатай том хүрэн хаалганд тулж буухад, хашааны гадаа зогсож буй хөллөгөө хос морьд бүхий даавуу бүрхүүлтэй, дөрвөн дугуйт тэрэгний жолоо баригч, янжуурын хөх утаа залхуутай сорж, эзнээ гарч ирэхийг хүлээн харуулдана. Бас эмээлийн бүүрэгнээс жолоо сойж сул орхисон хоёр морь байх нь цэргийн хүн байгааг илчилнэ. Цогоо бага хаалгын модон онисын суран татуургыг сурмаг татаж ороод зүүн талын гэрт шууд орвол цагаантны эргүүлийн хоёр цэрэг мах түрж хөшиглөсөн таташнаас хомхойрон хооллож байв. Мэнд усаа мэдэлцэж суухад гэрийн эзэн учир ойлгож,

— Та залан гуайтай уулзах нь уу? Өргөөндөө морилж байгаа гэхийг сонсоод эгэн гарч том таван ханатад гэтэж хянамгай тайвнаар ороход залан баруун талын хашлагат намхан модон орны өмнө олбогт суудал дээр завилан сууна. Зүүн талд явган сандайлганд суугаа, ногтолж ургуулсан сахлаа цэвэрхэн засаж янзалсан хянуур хурц харцтай дөч гаруй насны залирхаг байрын орос байв. Энэ хоёр яриа хөөрөө дэлгэн хоол цай ууж идэн аминчлах нь хэзээ язааны танилууд ажээ.

— Сайн хүн санаагаараа гэгчээр ашгүй чи хүрээд ирдэг сайн байна гэж залан олзуурхангуй хэлэхэд Цогоо,

— Залантан гуай! Би түшмэл гуайн зарлигаар түүний хүү өнөө гайхлыг мөрдөж баривчлахаар зүүн тийш алс явах болов. Энэ далимыг ашиглаж амжуулах таны таалал бий эсэхийг лавлахаар ирлээ гэхэд залангийн царай баяр хөөрөөр улаа бутран гэрэлтэж,

— Их сайн байна. Одоохон ярилцъя. Миний зузаан танилтай танилц. Монгол нэр Ханбаяр, орос оросын дотроос хүний мөсөөр гэвэл ёстой жин дарах лут эр гэж мэдээрэй. Энэ

нөхөртэй танилцсаны ачаар би ертөнцийн түмэн гайхлын дундаас даян тамжид маань явал зол жаргалтай золгох вэ? гэдгийг сонсож мэдээд мөхөс ухаанаа сэлбэн засаж, аниаст нүдээ нээж эхэлсэн дээ. Түмний тусын тулд амь бие дүйж, эд хөрөнгө үл хайрлан зүтгэгчдийн ул мөрөөр түүх сударт бичигдсэн байх тавилантай ч байж мэднэ. Юм, юм хоорондоо холион бантан болон хутгалдаж байна шүү дээ. Тэгэхээс ч өөр мэх алга. Ардын намын холбоо сүлбээтнийг илрүүлж, ухуулан сэнхрүүлэх бичгийг хурааж үгүй хийх эрэлчин энд тэндгүй гүйлдэж байна. Хэдхэн мөчийн өмнө энэ тухай тусална уу? гэж надаас хүсэж ирсэн хоёр эрэлчин зүүн гэрт зочилж байгаа, Ингээд бодохоор алт, гууль алин болохыг тунгаахад мунгинаж ч мэднэ.

Арван тавны цагдаагийн алаг эрээн хантаазаар халхавчлан бүтээж байгаа уйл явдал өлзийтэй байвал боллоо гэж залан ухаалгаар тайлбарлахад Ханбаяр гэгч орос нөхөр эрхий хуруу гозойлгож,

— Та манай «худалдааны» ажилд тун их тус хүргэнэ гэж таашаав. Залан гуай мөнгөн аягатай зөөг цайгаа оочилж бодолхийлэн байснаа,

— Энэ эр дээхэн үедээ хан төрийн түшмэд арван тавны цагдаа нарыг түгшүүлж, хараал зүхлийг хүртсэн, халхад алдартай шилийн сайн эр, «уулын эзэн» байснаа хөвч хангайгаасаа бууж «талын эзэн» болж есөн шидийн муу үйлтнийг нударгалж хумхихын хажуугаар... гээд инээмсэглэн хөгжинө.

Ханбаярыг салах ёслол хийгээд гарч одоход үлдсэн хоёр яриагаа үргэлжлүүлэв.

— Май хө! энэ хэдэн сэнхрүүлэх бичгийг Чойнбол цагдаад гардуулж өгнө дөө. Хэрэв уулзалдахгүй бол тараадгаараа тараачихаарай. Та биднийг нэгжих эрхтэн дархтан одоохондоо байхгүй. Гэвч сайн анаж яваарай. Уулзалтын итгэмжлэх нууц дохио «Мавган залан гуай мэнд дамжуулж байна билээ» гэж хэлэхэд лантуу Чойнбол «мэнд сайн байна гэж хариу айлтгаарай» гэвэл бүрэн итгэж болно.

Чойнбол эдэлгээндээ гандаж хүрэн өнгө хувирсан шандан даавуу дээлийн зүүн энгэрийн нөхөөс ханзалж дугтуйтай захиа өгнө. Тэгээд хамаг хэрэг бүтлээ гэсэн үг гээд залан босож Цогоогийн баруун дал мөрөн дээр элэгсгээр гар тавьж,

— Аян замын үйлсээ өлзийтэй бүтээгээд түргэн ирээрэй гэж ерөөв.

...Хулгайч муу үйлтний мөрийг мөшгөн илрүүлэхдээ хооллож ундлахын адил дадаж идээшсэн ажил гэж бат итгэдэг цагдаа Цогоо энэ ажилд сэтгэл бардам явна. Харин Залантны найдвар захиасыг гүйцэд сайн бүтээе гэж бодно. «Өчигдрийн бараалхалтаар манай залан гуай орос Ханбаяр хоёрын утга учир гүнзгийрсэн ярианд нэг л сонин зүйл байна. Ер нь залантан гуайн төрөлхийн соргог ухаан улам бүр тэлж, хүн ардын аз жаргал, сайн сайхны нууц цоожинд түлхүүр тааруулахад орос түнш нь оюун түлхүүр болжээ» гэж Цогоо бодсоор давхина.

### III

Эршүүд харцтай хорин долоо найм орчим насны бүлирхаг эр, сульдсан морьдын аясыг

дагуулан гэлдрүүлсээр дөрөлж дээр гарч овооны дэргэд буугаад хөтөлгөө моринд ачсан бараа сүрээр үл ялих боловч хүндэвтэр тээштэй хар булигаар богцоо тохош дээрээс түүртэлгүй авч газар тавьж ийш тийш сэжигтэй ажиглана.

Толгой эргэн манасхийж бүүдийсэн хараанд нь хэд хэдэн өртөө алсалсан Богдын хүрээ наана цаана болон сүүмэлзэж, буурь сууриараа эргэлдэн газраас тасран хөндийрч бүх юмс нүүгэлтэх хар бараан үүлнээ эрчлэн хуйлрах адил гунигт хий үзэгдлээр төрсөн эцгийн нь сүрлэг дүр тодорчээ. Ямар ч гэсэн намайг хүн болгосон хүн эцэг минь гэж бодох тутам жолоо эргүүлэн залж буцаж очоод бүлчимгүйтсэн гаж буруугаа хүлээхийг хүснэ. Гэсэн ч аавынхаа хэрцгий догшин зан авир, зодуурын хүчээр нухлан дарах гэсэн санаанд эрстэн зөрж ийнхүү хогшил хөрөнгийн соронд нь хүйтэн гар дүрж муу замд шуударснаа зөв гэж Жамсранчой бодно.

Жижиг богцноос чанасан мах гаргаж идэх зуураа мөр мөшгөн ирэх арван тавны цагдаагийн гараас мултрах аргыг хайн санааширч, огцом ширүүссэн амьсгалаа уужруулахыг оролдон «Ээ дээ! Жамсранчой минь, чиний явах замын хүзүү урт шүү» гэж аман дотроо шивнээд хөмхий зууна.

\*\*\*

Эмээл дээр хөндөлдөн суусан шийдэмгий янзын эр, морины жолоо хичээнгүй залж, сэрэмж гярхай харцаар түмэн ослын зангилгааг тайлан зөв бурууг дор нь тунгааж чадна гэдэг зан араншиндаа эрдэн усны эрэг, уулын орой ширтэн ергүүлсээр зам чигээ алдаж онон явна.

Тэрбээр, Жамсранчойн түр амсхийгээд мордсон дөрөлж дээр бууж, асааж хаясан шүдэнзний мод, мөлжсөн далны ясыг нүдлэн ажаад «За гайгуй! муу нусгай минь чи сайндаа хоногоос хэтрэхгүй. Цогоо цагдаа гуайнхаа хүлэгний амтыг амталнаа» гэж бодоод нэрсэн тамхины утааг хомхой сорж шившээд урт цагаан соруулыг нударганы омгоор нямбай гээч зүлгэн булигаар гэрт хийж түрийлээд мориндоо мордож газрын уруу гүйн хар алхаагаар алхлуулав.

## IV

— Намайг цагаан цэргийн дарга нартай уулзаад эргэж иртэл Нэмэхийг аргалан хоргоож байгаарай гэж цаад хар санаат Дэчин чинь захиад явлаа гэж итгэмжлэн шивэгнэсэн үгийг Нэмэх сонсоод,

— За! Санж минь одоохон амжихгүй бол бидний хүзүүнд бугуйлын битүү гогцоо углагдлаа гэсэн үг, Шимээн хаана байна гэж дуулдах төдий шивэгнэнэ. Үдшийн бүүдгэр гэгээнд сүүдэгнэн айсуй хүний урдаас сандарч буй дүр үзүүлэн тэвдэн гуйгч Санж, Дэчинтэй мөргөлдөх шахам тулгарч,

— Нөгөө гайхал зугтаж ариллаа. Тийшээ хар гүйхээгээрээ явсан гэж зүүн урагш мөр буруулан заахад Дэчин зог тусан агзасхийж,

— Муу нохойн гөлөг чамайг дээ гэж зангаад араасаа ойртон ирж яваа цэргийн дарга нартай тосон уулзаж Нэмэх оргосон тухай ховлов.

— Яалаа гэнээ!? Барон жанжинтны их цэргийн жагсаалын ялгуусан хүрээнээс зугтсан зулбасгыг одоохон амьдаар нь барьж авчир. Бүрэн зэвсэгтэй цэрэг дагуулаад яв! Хэрэв олж ирэхгүй байвал өөрсдөө дүүжлэгдэнэ гэж мэдээрэй гэж тулган тушаасанд Дэчин хормой дэвсэн бөхөлзөж, түгшсэн зүрхээ дарж өндийв.

Цагаан цэргийн хуарангаас оргосон Нэмэх, Шимээн хоёр бүтэн өдөр шөнийн турш заримдаа зүг чиг алдан од, нарны баримжаагаар хойт зүг чиглэн алхана. Хэн хэнийх нь хөл холгож, шуд зуун явсаар хоёр дахь хоног дээрээ хот айл тааралдаж, хотны хойт талын бор гэрт ороход ахимаг насны авгай, эмэг ээжтэйгээ байгаа нь үг ярианы өнгөнөөс илэрхий ажээ. Тэд бие биеэс гэрэвшин сэжиглэж мэнд амраас цааш үг дуугарахгүй хэсэг суужээ.

— Та бүхэн айх гайхах хэрэггүй. Уналгаа хулгайд алдаж, зовж зүдэрч яваа явуулын хоёр гэсэн Нэмэхийн үгийг гэрийн хоёр үнэмшин өрөвдөж, байгаа жаахнаараа аятай тавтай ундалж хооллоод, замын хүнс болгож ганц таваг ээзгий, хэдэн хурууд өгөв. Аяны хоёр явж, бургасан шугуйд бүгж хоноод нарнаар голын эрэг даган явтал тэртээ улаан үзүүрээр гарч ирсэн хоёр морьтой хүн шууд чиглэн айсууг харсан Нэмэх хөмсөг зангидан,

— Энэ лав бид хоёрыг мөрдөн хөөгч байх аа. Одоо яах вэ?

— Эхлээд уг аясыг даган туршина, дараа нь үзээд алдана. Өөр ямар ч мэх байхгүй гэж Шимээн шийдмэг хэлэв.

— Орос монгол хоёр нохой гараа өргө гээд Дэчин морин дээр ташаа тулан хөндөлдөхөд цагаан цэрэг сэрэмжлэн бууны хоолойд сум хийж замгаа түлхэв. Нэмэх гар өргөсөн чигээр цээж түхэлзүүлж,

— Дэчин гуай! Би учир мэдэхгүйн харгаагаар буруутлаа. Та миний аавын нэр алдрыг бодож өршөөн суллана уу? гэсэн гуйлт үгэнд Дэчин улам омгорхон,

— Зөнөг халтрыгаа дууриаж балчир «аав» та их цагаан цэргийн эрх тушаалтанд шийр заана гэнээ. Одоо тонилгож орхимоор байна. Гэвч сумнаас дүүжлүүр арай амт шимттэй байлгүй. Бушуу яв! Хэрэв хүлж андалбал хэрэгцээтэй газар хүрэлгүй талийх навсаахай шив дээ! гээд ихэрхэн үл тоомсорлож тамшаана. Тэд голын эрэг дээр түр саатан амрахаар бууцгаав. Цагаан цэрэг, цэрэг богцноос чанасан мах гаргаж идэхэд Дэчин дэргэд нь очиж тал засан горьдож шүлс залгина.

— Цаад боохой дагасан гэрийн нохойгоо хараач! Хоол горьдож шүлсээ савируулж суугааг нь гэж Нэмэх шивэгнэхэд Шимээн нүд ирмэн одоо ухасхийн дайръя гэж дохио өгөхийг анзаарч ойлгосон Нэмэх ухасхийлээ. Нэмэх эр бярын аагаар Дэчинг нүүрээр газар мөргүүлж муужруулаад эргэн харахад Шимээн цагаан цэргийн бууг аман талаас нь барьчихсан, цагаан цэрэг хутга далайж байгаа харагджээ. Шимээн нүд ирмэхийн зуурт ухасхийн бууны бөгсөөр цагаан цэргийн толгойн тус газар гуядахад тэрээр тас гэдрэг ойчив. Гарт гавлагдсан цагаан цэрэг, Дэчин хоёрыг хүлж ил газар орхиё. Ус уух хувь байвал хүлгэнээсээ салаг гэж шийдэв. Тэр хоёр унаажсандаа ихэд олзуурхав. Нэмэх шийдэмгийгээр, Дэчингийн дэргэд очиж,

— Та өөрийн хийсэн муу үйлийн төлөө энд залхаалт эдлэх болно гээд дээлийн нь өнгөнөөс



хуулан авч,

— Уудам хорвоог сайн харж ав! Нүдийг чинь боочихоор ертөнцийг дахиад хоёроороо харахгүй байж магадгүй шүү! Сайн санаат хүн тааралдвал өршөөж мэднэ. Харин бид хоёрын хойноос дахин мөрдвөл ахин ингэж уучлахгүй гэж мэдээрэй гэв. Дэчингийн угийн хар царай улам ч падан харлаж, нүдээ хялалзуулан хялав хялав харж, агадаж тэвдсээр,

— Амьд мэнд үлдээвэл нүд боолгох, хүлж баглуулах жаргал. Би дахин муу муухайг өвөрлөхгүй гэж хэлэх нь цагаатгалын хуурай үг гэдгийг нүдний харц, үгний өнгөөр Нэмэх гадарлан ойлгож дургүй хүрэвч, эр хүний замын хүзүү урт, үүнийг цааш харуулаад ч яахав гэж боджээ.

Голын эргээс холдож, хөндий толгодын дундуур нэвт зурайсан дардан замын бэлчирт бууж түр амсхийсэн Нэмэх, Шимээн хоёр чухам хаашаа явахаа шийдэж ядан бие биеэ дуугүй ширтэнэ. Нэмэх шороо тоос болсон сөөсгий тав гэзгээ маажиж илэн гүн шүүрс алдаж,

— Цагаан цэрэг, Дэчин хоёр ёстой зөв замаа оллоо гэхэд,

— Бид хоёр ч зөв замаа олсоон хө! Нэмэх ээ, намайг гаднаас харахад орос боловч дотор тал монгол шүү. Би монгол газар төрж өссөн болохоор зан заншил, хэл сайн мэднэ. Ярьдаг яриа, иддэг хоол, уудаг унд монгол шүү дээ. Чамд аав ээж байна. Надад бас аав ээж байна. Хоёул нутаг буцмаар байна. Би юуны өмнө аавтайгаа уулзах хэрэгтэй гэж Шимээн хэлэв. Нэмэхийн нүдэнд халамжит эцэг эх нь үзэгдэх шиг болж,

— Танай аав хаана байгаа юм бэ? гэж огцомхон лавлахад,

— Ар Хиагтад бий. Би аавтайгаа Хиагт хот олон орсон. Тэртээд цэнхэртэх хөх нурууны цаана холгүй гэж бодогдоно. Миний хүү хэзээ ч улааныхныг дагах хэрэгтэй гэж аав минь аминчлан захисан юм.

— Яагаад тэр вэ? гэж Нэмэх асуугаад гайхан харна.

— Улаантныг, аав хүү шиг хүсэл зорилго, амьдрал нэгтэй, хүнийг хайрлаж тус хүргэдэг улс. Тэгэхээр тэдэнтэй нийлэх нь л зөв гэж итгэл төгс захисан юм. Ер нь цаг төр бишдэж улаан, цагаан, гамин гээд аль ч учир нь олодохгүй алаан хядаан энд тэндгүй дэгдээж морин туурай тажигнуулагчид цөөнгүй болжээ. Нэмэх ээ! Чамд онцлон захиад аавын минь захиж, миний сэтгэлд шингэн ууссан улаантныг нь л дагавал буруугуй байх шүү. За! Чи аав, ээж рүүгээ яв даа! Би аав руугаа явлаа. Монголын зүйр үгэнд эр хүний замын хүзүү урт гэдэг.

Дахин баяртай уулзъя гээд Шимээн, Нэмэхийг тэвэрч үнсэхэд тэр хоёрын нүдэнд нулимс хуран цийлэгнэнэ.

Гүн хөх далайд сэлж яваа бяцхан завь гэлтэй хоёр жижиг бөөн юм торойн холдсоор зэлүүд нутгийн зэрэглээтэх гүвээ толгодын дээгүүр далд орж бараа тасрав.

Нэмэхийн морь үе үе зогсоход ташуур тушаавч бүр сүүлдээ шээс савируулан, хөх мах

татавганан хөлсөө дуслуулж байснаа дөрвөн хөлийг үеэр нугалсан адил үхэтхийн сөгдөж, хоёр чих бууж, тунгалаг хар нүд нь модны ногоон ялаа аятай ногоорон гөлийжээ. Нэмэх, мориноос эмээл хазаарыг салгаж, толгойг засаж тавив.

Эзгүй хээр эмээлт мориноос салж явгарсан эрийн гишгэсэн мөр нойтон шаварт хүнхийн барлагдаж гунигтай алхана. Цавчим хавцлыг огтолж нэвтрэх жим улам бартаажиж, хазгай гишгэвэл тээр доор эргэлдэн ногоорох цээлд шидэгдсэн чулуу мэт полхийн анир чимээгүй болно гэж бодохоос дотор арзасхийж алхам бүрээ болгоомжилно.

Хавцлын бэл рүү бууж өнчин хайлаасны сүүдэрт гэдрэг харан хэвтсэн Нэмэх, огторгуйн номин цэнхэр мандал ширтэн сэтгэл тайтгарчихсан байжээ. Гэнэт тэнүүн тайван тэнгэрээс дүүгүүрийн чулуу гэлтэй ер бусын ёрын дуун доошлох чимээнд давхийн цочиж гар тохойлдон өндийвөл хайлаасны мөчир шүргэн газар унасан бяцхан шувуухайг Нэмэх олж харав. Бахардсан бялзуухайг алган дээрээ тавьж сэргээх гэж оролдох агшинд толгой дээгүүрээ эргэлдэн нисэх орог саарал харцагыг харж, хорсол тэмцэл буцалсан Нэмэх чулуу шүүрч нүүлгэхэд харцага алсын уул тийш нисэж алга боллоо.

—Мөрөөрөө амьтан чи бас л дайсанд хөөгджээ. Сэргэ! нис! амьдар! гэж аман дотроо хэлээд өд сөдийг илэн таална. Бялзуухай далавч дэрхийлгэн дээш хөөрч жиргэх нь бас нэгэн аз жаргалын эрэлчин гэж санагдана.

Нэмэх, дэлгэр баян хорвоогийн сайхан муухай хутгалдсан эрээн бараан дундаас хайрт аав ээжийгээ олж харах хүсэлд хөтлөгдөн цааш алхжээ. «Толгой эргээд нэг л биш. Нэрлэх уул, ус ч алга. Төөрчих шиг боллоо. Сайхан танил Шимээнээсээ хэрэггүй ч зам саллаа. Хамт яваад яахаа үздэг байж...» гэх бодолд умбан явсан Нэмэх араасаа гүйцэн ирж яваа хөтөлгөө морьтой хүнийг харж эгэн зогсохдоо «нэг чонын амнаас мултарч, нөгөө чонын аманд орлоо» гэж бодогдох хоромд «эхлээд уг аясыг даган туршина. Дараа нь үзээд алдана. Өөр ямар ч мэх байхгүй» гэж Шимээний хэлж байсан нь сэрхийн буухад сульдсан биед хүч зоригийн гал бадарчээ.

Арван тавны цагдаагийн хувцас хэрэглэлээр нь аавыгаа гэж горилсон Нэмэх нүд арчиж ажин харвал биш. Дөч эргэм насны хүдэр эр шазуур зууж харагдана.

—Дэгдээхий минь чамайг хэн гэдэг вэ? Яаж задрахаараа өдий хар багаас лам харыг хосолж дамшиглаж яваа нь энэ вэ? Сөөсгий тавыг харвал төрийн хар хүн гэлтэй. Дугуй захтай дээл өмссөнийг чинь харвал лам гэмээр. За холион бантангийн тулам минь өчгөө бушуухан өг гэж ёжлон тулгасан Цогоогийн нүдэнд эдэлгээндээ өнгө хувиран гандсан шандан даавуу дээлийн зуун энгэрийн нөхөөс тусахад «Чойнбол» гэсэн нэр толгойд зурсхийж,

— Нэр хэн гэдэг вэ? гэж агадуугаар асуув.

— Нэр Нэмэх. Хүрээнээс нутаг харихаар гарч, зам алдаж явна гэж хуурсандаа бантаж дууны өнгө өөрчлөгдөхийг гадарласан Цогоо,

— Гандан дээрээс хөдөөлсөн банди лам гэдгийг ам санаа хоёр чинь өчиж байхад, дуу хоолой чинь тэс өөр юм илчлээд байдаг чинь юу билээ. Ер нь чи цагаантанд баригдаж, түүнээс

оргож явааг царай чинь илчиллээ. Чамд өөрийн биш бусдын хүйтэн мэс байгааг харахад ч хүний амь нас хохироосон учир холбогдол ч байж болно. Анжгайн нь алдар гэвэл Цогоо, ар халхын арван тавны цагдаа нарын дундаас айргийн тавд цоллуулдаг эр дээ! гэж өөрийгөө дөвийлгөсөн үгийг нь Нэмэх амыг дагуулан,

—Миний хувьд та онцгой мэргэн айлдаж байна гэв

—Би чам дээр мөрдөн хөөж яваа хогийн хулгайчаа гээд буучихсан чинь биш байдаг байна шүү. Гэсэн ч буудаг юман дээрээ буучих шив бололтой. Чамайг янгинатал хүлж арван тав ташуурдвал зохивч хүлэг ташуур хөнгөдөх аавын «цээж» шив дээ гэж Цогоо тохуурхангүй хэлжээ.

«Манай аав арван тавны цагдаа» гэж хэлье гэж Нэмэхийн аман дээр гарч ирсэн мөртөө амаа хамхиж хэлээ зуужээ. Мориныхоо нуруу амрааж байгаа цагдаа Цогоо замын хүнсээ задалж Нэмэхэд дал авч өгөхдөө нүд ирмэн зальтайгаар,

— Хүн бол хүн л байх ёстой. Тийм ч учраас чи бол миний зочин. Тэгээд би чамайг хүндэлж дал өгч байгаа юм шүү! Түүнээс энэ богт чөмөг өгөх ёстой юм гэж идэж суугаа чөмгөө харуулж маг маг хөхөрч байснаа,

— За аавын цээж минь бүх үнэнээ ярьчих. Би чамайг ярьсан яриагүй мэдэж байна. Чамайг шударга эр үү? Шударга бус эр үү гэдгийг шалганаа гээд Цогоо инээмсэглэнэ. Нэмэх, түүний үгийг тоосон шинжгүй махаа зажлах хооронд ийш тийш элдвийг ажих нь сайн эр санагдахад Цогоо дахин оролдох хэрэггүй гэж боджээ.

Цогоо бохидсон гаансны толгойг мөнгөн сэтгүүрээр сэтгэн, гутлын ээтгэр хоншоорт аяархан тогшиж,

—Нэмэх ээ! салаалсан хоёр замын алинаар явбал дээр вэ? гэж гэнэт туршин асуухад ингэж дөгөөхийг санах байтугай түүний гараас мултрах арга хайн бодож суугаа Нэмэх нүүр эргүүлж нүд гялалзуулан том харснаа,

— Бартаат зам ахлах болов уу... Би хаашаа явах болж байна? гэж сөргөөж асуухад Цогоо дөлгөөн тогтуун харж,

— Замын талаар чи яг онож хэллээ, муу хүн самбаанд, чоно бороонд гэгчээр хар санаатан өдөрт бартаа, шөнөд харанхуйгаар ханиа хийдэг үнээн. Аа харин чи надтай хамт явж хулгайч мөрдөж барихад хань хамсаа болно. Цааш явах газрыг чинь би мэднээ гэвэл Нэмэх,

— Танд хань болж, зам нийлэх эсэхийг бүү мэд дээ. Та хашир томоотны хувьд нэгийг бодож байгаа байлгүй гэх шийдмэг үгэнд Цогоо тохирсон хариу өгөхийг хичээж эв ая барин,

— Надад хамсаа болох эр гэдгийг харангуут би мэдсэн. Одоо айх зовох хэрэггүй. Намайг дагаад яв. Хожим хойно ч арга зүй нь олдож, ам хэлээ ойлголцох байх аа гэсэн цагдаа Цогоогийн үг бүрийг хичээнгүй анаж сонссон Нэмэхийн дотор бага зэрэг тайвшран онгойж «зуугийн хагас насанд хал үзэж, дол цохин хашир башир сууж буйржсан аавын минь адилхан

албатай энэ хүнийг дагаад байвал аавтайгаа ч уулзах юун магад» гэж товлон бодоод,

— Та хаашаа бол, би хамт гэх Нэмэхийн түс тас үгийг талархаж таашаасан Цогоо,

— За одоо хоёулаа мордноо. Чи энэ бор морь эмээллэ гэж хөтөлгөө морио заажээ.

## V

Нэр үл мэдэх газрын зөрөг замаар жолоо сунган давхих агшинд Цогоо газар орны нэрийг нэгт нэгэнгүй нэрлэн бодно. Нэгэн гүвээн дээгүүр давахад хөндий дотор хөтөлгөө морьтой хүн ергүүлж байхыг Цогоо харж,

—Нэмэх ээ! Нөгөө учраа маань энэ мөн дөө гээд моринд ташуур өгч довтолгон одоход Нэмэх дагаж хоцрохгүйг хичээн мөр даран цогиулжээ. Холоос үл танигдах хүн, араас гүйцэн очсон Цогоог эргэж хараад жолоо татан зогсож, сайн эрийн зориг гарган эмээл дээр хөндөлдөн, сүртэй ширүүнээр ширэв татахад Цогоо бүдүүн хулсан ташуураа бат атгаж,

—Мориноос буу! Хэрэв эсэргүүцвэл дор чинь нам цохино шүү. Аавын алдар нэрийг барсан хөсрий муу гударга. Түшмэл гуайнхаас хумсалсан юмаа үрэн таран хийгээгүй биз? гэж яаран асуухад Жамсранчой зэвүүтэйгээр инээмсэглэх дүр үзүүлж

— Үгүй, үгүй. Амжаагүй явна гэж уцаарлангуй хариулна.

Тэд хүрээний зүг шуудран хөдлөв. «Түшмэл гуайн хүү Жамсранчой хулгайчийг барьснаас халих олзтой гэнэгүй тааралддаг ямар аз хийморь вэ? Магван залан гуайн хэлийг залгуулах хүний дохиот дээлийг өмссөн залуу заавал нэгийг хэлж, хоёрыг дуулгах нь дамжиггүй. Гэхдээ энэ залууг санаа сэтгэлийн талаар буулгаж гартаа оруулж авах хамгийн чухал. Юу боловч нөхөөст дээлтэй нь залан гуайн гарт халуун чихийг атгуулья» гэж Цогоо бодно.

Тэгэхэд Нэмэх «сайн нөхөр Шимээний онцлон захисан үг... аав ээжтэйгээ уулзан золгож элэгсэг хайрт сайхан царайг харах сан» гэдгийг л сэтгэл зүрхэндээ шингээн бодож явна.

# Гуравдугаар бүлэг

## Эхний мэнд

### I

— Данд аа! Нэмэх Шимээн хоёр тамаа цайж яваа байх даа. Цагааны цэрэгт оролгүй шалавхан нэг тийш болох юмсан. Хойт зүгт сүрхий бужигнаан болж байгаа бололтой. Цагаан дээрэмчдийг дарж дийлдэг чадалтан байвал гүйцэх нь тэр гэсэн үгэнд Санж зориг орон сэргэж,

— Хэрвээ цагааны яргачдын саварт базагдвал чиний лантгар тавсангийн мөлжүүр догь байх вий. Тэгэхдээ миний ясан цоохойдойгоор урьтаж илднийхээ ирийг нийлэн туршаад чам руу шүлс залгин дайрахад хэн маань ч хожно гэж бүү сана гэхэд Дандийн бодол гүнзгийрэн толгой сэгсэрч,

— Арван тавныхан, цагаан цэргийн дарга нарын өмнө хойно шарвалзан эргэлдээд байгаа нь биднийхээ арьс махыг хамтран зулгаах, эсхүл хэд хэдээр хороох нь дээ. Яая гэхэв. Хонины ээлж таарлаа гэсэн үг гэж итгэл алдан шивэгнэлдэнэ.

Үл таних монгол түшмэл барон жанжны их цэрэгт элсэн ороогүй шийр зааж үлдэгсдийн ар өврөөр тойрч хүн бүрийг шинжих хоромд «Дүүжлэхдээ тарган туранхай, чадалтай чадалгүй гэж шилдэг болох нь дээ. Бүү үзэгд» гэх айж ширвэгдэн байгаа үг сэм дамжигдана.

Түшмэл, цагаан цэргийн даргын өмнө очиж толгой дохин ёсорхоод цөхрөл алдан зогсогчдын зүг хуруу чичин заахад буриад хэлмэрч хэрдээ ихэрхэн,

—Батын Санж, Сампилын Данд урагш алхаад! гэх дуун маш эргэлзэлтэй сонсогджээ. Тэрхүү түшмэл, цагаантны түр байрласан хуарангаас зайдуу гараад дагуул цагдааг дуудан товч хэдэн үг хэлж, хар хээрийн нуруунд хондгойхон сууж «чү» гэхэд тэших нь ёстой усан тэлмэн жороо морин байлаа.

Цагдаа, мориндоо мордож нэр цохогдсон хоёрын зүг дээрэлхэнгүйгээр нүд ихэсгэж баргар царайгаар,

— Миний морины товор товор алхаатай хөл нийлүүлэн алхацгаа! Манай цагдаагийн газрын босго өндөр шүү! Бүдэрч харлав, мэдээрэй гэхэд Санжийн дургүй хөдөлж бурмиг дуугаар,

— Танай эрхэмсэг түшмэлтний алдрыг сонсож болохсон болов уу? хэмээн товч лавласанд цагдаа,

— Манай ноёнтны алдрыг Дамдиндорж гэдэг. Ам хэл ширүүн, гар гүжирмэг, тэгнээ л гэвэл буцахгүйдээ гэж зүрхийг үхүүлэх санаагаар өгүүлэв.

Цагдаа ийм тийм гэж зандарч, муухай харахаа болив. Харин ч элдэв хошин үг хошигнож тоглоом тохуу болох нь нөгөө хоёрт хөгжөөнтэй.

Цагдаагийн газрын амаргүй босгыг алхсан Санж, Данд хоёр дүүжлээстэй банз шаахай, хүлэгний олс мэтийн зодуурын хэрэгсэл хараад дотор хүйт дааж гайхан зог туссан боловч,

— Сайн байцгаана уу? гэсэн Нэмэхийн халуун дотно мэндчилгээгээр сэтгэл сэргэж баяртай уулзацгаажээ. Нүүр тулан золгосон хэд, түшмэлтэнгээс цөм сүрдэж, бүлх залгисан адил гөлөлзөхийг хэдийнээ ажиж амжсан түшмэлийн захирангуй дуу сүртэй гээч паргин хүнгэнэж,

— Та гурвын хоёрыг их баронтны сул цэргээс сонгож авсан гэдгийг мэдэж байгаа биз гээд Санж, Данд нарыг ээлжлэн харна. Аа харин энэ тэнхээтэй байрын хөдөөний эрийг манай хашир цагдаа Цогоо замын аясад тааралдаж урхилж ирсэн явдал сайн хэрэг. Та бүгдийн бие бялдар, эр бярыг харгалзан арван тавны цагдаа болголоо. Энээ тэрээ гэж дур сонгохыг хөөн хэлэлцэх явдалгүй. Ууж идэж түр амарцгаагаад манах цагдах ажилд явцгаах болно. Мэдэв үү? аан гэж тулгахад тэднээс хариу өчин айлтгал айлтгах хүнгүйг анзаарсан түшмэл,

— Гарцгаа! гэх ганц үгээр дуугарч ядав. Шинэ цагдаа нарын орон гэргүй нь амь хоргоддог навсгар хар гэрт яриа хөөрөө, наана цаанатай байх болов. Нэмэх, манаанаас бууж харих санаатай явж байтал түүгээд ижилсгэчихсэн юм шиг тайрмал сүүлтэй өндөр морьд унасан цагаантны гурван даргатай халз тулгарч, бусдаас гуйж өмссөн даалимбан дээл дээрээ сүр бадруулан хэрэглэсэн цагдаагийн хантаазаар ул барих санаатай жаахан гэдэс хийж нүд бүлтэлзүүлэн буй хоромхноо түшмэлийн ширүүвтэр зальжуу дүр тодорч, «... хэрвээ барон жанжинтны цэргийн дарга, цэрэгтэй нүүр учирвал дороо хөл дээр яг гозойж ёслол хүндэтгэж байгаарай» гэсэн үг санаанд буухад баруун гар өргөн эрхий долоовор хуруугаа ёрдойлгон ёслох аялтал зэгзгэр туранхай дарга нүд гялалзуулан хилэгнэж, гөрмөл суран ташуураар тархи толгой, нүүр нүдгүй хэд ороолгож гарын шар ус тараагаад цааш оджээ.

Нэмэхийн уй гунигаар сэвтэн шархалсан зүрхэнд өнгөрсөн цагийн үхэл хөнөөл дахин үзэгдэх мэт тодорч,

— Би энэ чоныг хаана үзлээ. Хүн биш, ёстой чөтгөртэй хэдийд хаана нүүр учирсан байх билээ. Аа тийм, энэ гайхал зандалчин тэр нэгэн гунигт өдөр намайг гэрээс хөөж гаргаад ээжийг зодож тарчилган, миний нүдний өмнө мэсэлсэн яргачин яг мөн байна. Чамайг гүйцэд сайн таньсан бол бодийг хөтөлдөг байжээ. Одоо чамайг авгай хүний үс тавьж, ууж өмсөөд явсан ч танихаа танина гэж хорсонгуйгаар занан бодсоор босгоо алхахад нөхөд нь тосон гайхацгааж ам, амандаа,

— Нүүр царай чинь яачихаа вэ. Хумсных биш, зодуурынх байна. Түшмэл гуай! зугаагаа гаргаа юу?

— Цагаан чөтгөрт гөрүүлж орхилоо. Танил чөтгөр маань ингэдэг байна шүү? гээд ёсолгоо хөдөлгөөнөө л буруу хийчих шиг боллоо гээд тайлбарлан мушилзахад Санж хөхүүнээр инээмсэглэж,

— Ноён даргын зөв. Чи ёслох биш доромжилжээ. Цэргийн дэглэмээр ёсорхохдоо долоовор дунд хуруугаа ёрдойлгож ёслох байтал долоовор, эрхий гозойлгоод буруутсан байна гэхэд Нэмэх нөхдийн өөдөөс ширтсэн хэвээр,

— Миний буруу ч байя л дээ! түүний төлөө тэд хүн махлах ямар хэрэг байна. Өгөр хөсрийнүүдтэй нэгийгээ үзэж, нэхий дээлээ тайлахаас нааш буцахгүйдээ гэж шүд зуун, зориг чангалан омгорхоход Данд ёжлонгуй мөртөө найрсгаар,

— Өчигдрийн үлдээсэн өвчүүгээ хэдэн аяга халуун цайтай цохичих. Тэгэхээр тэнхээ тамир чинь улам бадарч, барс адил болно. Тэр үед цагааны даргатай хав дөрвөлжлөхөд болно. Бид засуулд гарахад бэлхэн байна гэж хошигноход, Нэмэх уур омог дарагдаж, сэтгэл тайтгаран инээмсэглэв.

## II

Зуны нэгэн тунгалаг шөнө ажээ. Цогоо, Нэмэх тэргүүтэй хэсэг цагдаа онож олох ажлаа сайн бүтээх гэж санаа сэтгэл түгшүүлэн, дүнсгэр царайлж нэгэн айлын хашааны хаалганд орох гэтэл сул тавьсан «гарз» нохой дүүлж дайран хавьтуулах шинжгүй. Нохой хорихыг шаардавч эс хэрэгссэнд, уурласан араатны аманд сэлэмний үзүүр гэнэдүүлэн зуулгаж ёврон муужруулжээ. Тэд нэг, нэгнийхээ мөрөн дээр шатлан авирч хашаа давж оров. Мөөрөн шалтай том цагаан гэрт орвол ахимаг авгай өөрийгөө өрхийн тэргүүлэгч Дулдайн авааль гэргий Лхам гэв. Айж балмагдан байгаа хоёр бүсгүйн нэгийг төрсөн охин Сайнзаяа, нөгөөг зарц Гүнчин «цагаан солиотой юм» гэж нэмэн тайлбарлаж, зүүн орон дээр хэвтэж байгаа хүний талаар аг таг өнгөрчээ.

Цогоо анзааргагүй маягаар,

— Лхам гуай! Та тамхи татдаг уу? гэсэнд хамаг боолхой илчлэх асуудал уу? гэж сэжиг төрсөн авгай биеэ цэнэж,

— Манай хар хүнээс өөр энэ гэрт хэн ч гаанс зуухыг зүрхэлдэггүй гэв.

— За тийм болог. Хэн гэгч айл болж байна?

— Би Дулдайнх гэж хэлээ биз дээ.

— Дулдай гуай яваад удсан уу?

— Өглөө л гарсан, алга л байна.

—Энэ тамхи нэрээстэй урт гуулин гаансанд хэн тамхи нэрээд татаж чадалгүй тавьчихсан юм бэ? гэж тулган асуухад авгайн царай минчийн улайж дуу хураачих нь бүүр ч сэжигтэй. Цогоо орон дээр хэвтэгчийн зүг гар сунган зааж,

—Энэ хүний нэрийг хэн гэдэг юм бэ? Өвчтэй хүн үү? гэхэд авгай,

— Та бүгд суугаач. Би цай, хоол хийе.

— Бид цай, хоолоо ууж идсэн, хэрэггүй.

—Энэ миний эгч, төрөлхийн хэлгүй юм гэнгүүт Цогоо «үнэхээр хэлгүйчүүд хэн хүнд

түвэгтэй байдаг нь мэдээж. Гэсэн ч...» гэж бодоод Нэмэхэд босго гэсэн дохио өгөхөд тэрбээр «хэлгүйг» өндийлгөхөд цонхийсон туранхай цагаан гамин байв.

Дулдайн гэрийнхнийг, нуусан гамингийн хамт цагдаагийн газар авч явжээ. Бие далдалж амжсан гэрийн эзэн Дулдай тэднийг хашаагаар гарах чимээгээр том чингэлгэн авдрын ёроолоор доош ордог нүхэн зоорины тусгай үүдээр гарч хагуу эдлэл мөнгө төгрөг нууж хадгалсан зоорины шавар шороо хөдөлсөн эсэхийг магадлаад санаа амран нам унтжээ.

Өглөө эртлэн босож гэр бүлийн хүмүүсийг суллаж авахаар Дулдай яаран гарав. Чийгний үнэр ханхийсэн давчуухан өрөөнд түшмэл дуу өндөрлөж, зодуурын хөдөлгөөний аясаар ёолох дуун гинших нь байцаан шүүх ажил хийгдэж байгааг гэрчилнэ. Түшмэл зузаан дэвсрэг бүхий суудалд тухлан завилж, хаш цагаан чулуун соруултай ганснаас янлиуны үнэр сэнхийж утааг хомхойрон савсуулах самбаандаа хэний хүн болохыг сонирхохын оронд,

— Гамин чандруу өмгөөлсөн учир шалтгаанаа бушуу өч гэж хэрцгийлж, дошгирч, нүдэнд өртсөнөөс эхэлсэн нь охин Сайнзаяа таарчээ. Тэрбээр дал мөрөн дээгүүрээ урагш унжуулсан ганц сүлжмэл гэзэгний үзүүрийг имрэн оролдож,

— Би нуусан удаагүй, манайхаар ирээд байна гэдгийг цагдаагийн газар удаа дараалан хэлж байсан шүү дээ гэж эрс шууд хэлэхэд

— Аа тийм бий чи. Бүрэн зэвсэгтэй харь элэгт дайсантай ам санаа нэгдэн хуйвалдаж зүс хувирган нуусан эзний нэг биш гэж мэлзэх хэрэггүй. Үнэнээ өч гээд дэвэрч уурссан харцаа тэвчиж ядан барайлгаж цагдаа нарыг хэрсүү ажигласнаа Нэмэхийг хуруу чичин дохиод,

— Залуу баатар минь чи, азтай байна. Эхнийхээ мэндийг энэ эрхэмсэг гүнжийн хацраар илэн таалах болно. Наад шаахайгаа ав, хоёр хацар дээр нь ээлжлэн арван тав, тав тавиад орхи гэж ширэв татан тушаахдаа «ийм бүлиа гарын пянд горзгор бүсгүй талхинд элдэгдсэн арьс шиг умбарах вий хөөрхий» гэж бодно.

Арван наймтын ягаахан хацрыг урж зулгааж мэндэлнэ гэхээс Нэмэхийн дотор манасхийн хөөрч гар салганан эхний цохилтыг хий даялаад өөрийн зүүн гарыг цохичихов. Хоёр дахиа албан хүчээр дөнгөж шүргүүлэн илбэл бүсгүй.

— Ёо, Ёо, Амь авар! Шүд яйрчих шиг боллоо. Аав аа, ээж ээ гэж хашгиран дороо цовхчиход түшмэлийн царай алаглан хувьсхийж,

— Юун айхавтар янгууч өлөгчин бэ? Хэний ч хараажаар дөнгөж шүргүүлээд авахад тэгж сүйд болохоор өвдлөө гэж үү?! гээд урт хумстай долоовор хуруугаар Нэмэхийг дохин дуудав. Түшмэлийн энэ дохио сайнгүй тэмдэг гэдгийг хэзээний андаж эндэхээ больсон Цогоо яс хавтганан хүлээнэ.

— Нэмэх, чиний гар шинэдээд шөрмөсөндөө хэтэрхий баригдаж байгаа учраас уршиг таригч бүсгүй гөлийж, арьс махнаас нь урьтаж наад муу зодуур чинь гутаж харлах нь гэнгүүт, ухас хийж шаахайг шүүрэн мэхийн хоёр хацрыг хэд хэд цохиж,



— Май хө! Яг л ийм шүү маягаар цохивол арай дээр байх гэж егөөдсөнд Нэмэхийн зүрхийг мөсөөр жигнэх адил болгож, дотуураа хор шар буцлахын эрхээр гар хэтэрхий чичирч шаахайгаа зориуд газар алдахад түшмэл хөмсөг зангидан ярвалзаж,

— Чи надтай хэрхэх санаатай байна. Аяар аажуухан шиг аагийг чинь дараад өгөмз. Санж чи энэ хонгорын хацрыг «илээтэх» гэхэд тэрбээр алдаж онож байвч Нэмэхийг бодвол арай дээр шиг түшмэлд санагджээ.

— Чи гарын шөрмөсөө зөв хөдөлгөж байна. Нөгөө хацар дээр тавиарай. Хэд билээ? ес, арав, түр хүлээ. Дандад шаахайгаа өг. Наадхийнхаа бариулыг сулавгархан атгаад олигтойхон далайж, яг буулгахдаа аяархан тавьж шувтраад тат. Тэгэхээр л амт шимт ааг нь мэдэгдэнэ гэв.

Сайнзаяа дуу шуугаа хурааж, шүд зуусныг түшмэл хараад ухаан жолоогүй хилэгнэж,

—Чи хэн гэдэг гөлгөн халтар нь билээ. Золбин гичийнээс сая унасан улаан зулбадас байтлаа шазуур зууна гэнээ хө! Энэ шаахай гэдэг зодуур бол гэм алдсан хүнд алсдаа өлзийгөө өгөх жамтай, ззэн төрийн цаазын нэгэн зүйл. Би үүгээр чинь хоол олж идсээр хорь шахам жил болохдоо яаж цохиход ямар шүү янзтай хорсгодгийг томьёолох болсон. Миний үгийг гал ус гэвэл гэж л бай хэмээн омогдон өгүүлнэ.

—Энэ янгуучныг гаргаад нөгөө нэг залуу бүсгүйг оруул гэхэд Цогоо айлтгал байна гээд «зарц охин солиотой юм шүү дээ» гэж тайлбарлав.

Түшмэл өөр өөдөө аймхай харцаар ширтэн гөлөлзөж байгаа үл таних залуу бүсгүйг харж «галзуугүй сэн бол тун цэвэрхэн, аятайхан ч дагина байна хөөе. Надад галзуу тусмаа сайн. Эднийх хэний хэн гэгч айл, чухам хаана байдгийг мэдэх юмсан» гэж бодоод,

— Үүнийг гарга! Авгайг бушуу оруул гэж гадаа хүлээлгэж байгаа хоёр бүсгүйг харгалзан буй Нэмэх, Сайнзаяагийн ам хэлийг таталж байж хэдэн үг солив. Сайнзаяа «энэ муу хар юм зөрөөд өнгөрсөн ч нүдээ сугалчих нь халаг байдаггүй бил үү...» гэж бодогдоход дургүй хүрч дуугаа хураачихав. Хайр дурлалын халуун илчинд сэтгэл уярч, зүрх догдлон цэцгийн тоос хүртэхийг хүссэн зөгий мэт болсон Нэмэх сэтгэл шулуудаж, эр зориг гаргаж шийдэмгийгээр,

— Хонгор хоёр бүсгүй минь одоо яваад бушуухан харь, нэхэл дагал болоход хүрвэл би аргална. Аа харин Сайнзаяа! Чи... гэхэд бүсгүй ичингүйрэн жишүү харж,

— Та яасан сайн хүн бэ! Тус болсон ачийг чинь мартахгүй. Манайхаар энэ зэрлэг түшмэлийн хүү Жамсранчой гэгч хүн орж гарч байдаг. Тэгэхдээ надад сүйд болж л байдаг юм. Би санаанд ордоггүй гэж бүх үнэнээ сүүн цагаан сэтгэлээр тоочиход Нэмэхэд таатай санагджээ.

Гудамжинд хоёр бүсгүйтэй уулзсан залуу хархүү сайхан зангаар инээмсэглэж, Сайнзаяад хандан хачирхсан байдлаар,

— Чи яагаад ер бусын энгэсэг тавьчихаа вэ? гэж огцом лавлавал Сайнзаяа хүйтнээр хөх инээд алдаж жарвалзан тохуурхаж,

— Харцын өчүүхэн бүсгүй намайг өндөр дээдсийн хүү чамд хатан болгохоор танай аав урьтаж бэлэг сүйгээ тавьсны тэмдэг болгож шаахай гэгчээр шан хүртээж, тамга дарсан нь энэ ээ гэж егөөдөхөд Жамсранчой гүн шүүрс алдаж бодолхийлснээ «би ч бас баригдаж эрүү шүүлтэнд шүүгдэж, зоолсон ноходод зовлогоо зулгаалгачихаад л явж байна» гэж хорсолтойгоор хэлэв. Сайнзаяа ч үг дуугарсангүй. Жамсранчой ч дахиж үг ярьсангүй хоёр тийш салан одов.

### Ш

— Цохь! Олигтойхон гэж бачимдан бархирч байгаа хоромд үл таних хүн уухилж аахилан орж ирэнгүүт түшмэлийн өмнө өвдөг сөхрөн бөхөлзөж айлтгал эрэхдээ өврөөсөө унагаасан хүнд эдлэл шалан дээр падхийхэд түшмэлийн нүдэнд биш, чихэнд тавин лангийн бөгтөрхөн ембүү «үзэгдэх» шиг санагджээ.

— Амархан сайн байна уу? ямар тухай хэргээр явна гэж түшмэл сүрлэг ихэмсгээр асуухад гаднаас ирэгч алга хавсран атгаж ялимгүй урагш ахиж хушуу цорвойлгоод,

— Жа дээдэс минь айлтгал байна. Өчүүхэн харц ард Дулдай миний бие өчигдөр зээлийн газар өглөө эртлэн гарч, шөнө оройтож гэртээ ирлээ.

— Тэгээд? гээд түшмэл анхааралтайяа сонсож, алга загатнан сууна.

— Өрх гэрт минь золгүй явдал тохиолдож халамжит гэргий, хайрт охин, зарц бүсгүйн хамт танай газар баригдаж ирсэн сургийн дагуу бие алжаан бараалхаж ирлээ гэхэд түшмэл Дамдиндорж тоомсоргүйгээр ярвайж,

— Манай цагдаагийн газар баригдаж ирсэн танай ам бүлийн хүн гурав биш, дөрөв байх аа. Нэг хүнээ мартдаг нь гайхалтай хэрэг байна.

— Дээдэстэн минь та андуураа юм болов уу! дөрөв байх ёсонгүй, гурав гэв.

— Тийм биш ээ. Таны гэргий, охин, зарц нар хамтран хуйвалдаж нэгэн овжин гаминг зүс хувилган хаацайлсан лут том хэрэгт холбогдсон шүү дээ! Гэвч хөнгөвчлөн үзэх талыг барьж танай охинд гучин шаахай хүртээвэл зохих байв. Гэтэл шинэ цагдаа нарын дадлагагүйгээс болж шаахайдуулсан нэр зүүснээс цаашгүй. Харин танай авгай бид хоёр л ам санаа дүйхгүй, хэдрэлсэн учир ахиухан амтлуулахаас өөр замгүй болоод байж байтал та ам мөлтөс орж ирлээ гэж түшмэлийг хэлэхэд Дулдай нүд эргэлдүүлэн сандарч,

— Үйл лай нь зузаарсан бол эрхэм дээдэс та бүхэн хичнээн ч аргалаад аргалаад нохой хорих биш. Гэсэн ч та цэцэн цэлмэгээр болгоосонд баярлалаа. Танд аминчлах жич өчиг бий билээ гээд энэ тэр рүү залирхгаар харахад сэдэв цохисон түшмэл, Дулдайгаас бусдыг түр гадагш гаргахад Дулдай үг дуугүй өндөс хийн урагшилж жижиг цагаан бааданд нямбай баглаж боосон жингээр хүнд зүйлийг түшмэлийн гарт атгуулав. «Мөнгөний ер бусын хүчин гэгч мөн ч гайхалтай, чадалтай юм даа. Тавьхан лан атал миний гэр бүлийн халуун амийг түшмэлийн гараас булааж аваад над руу шидэж орхино доо» гэж Дулдай бодохоос сэтгэл цагаатаж, дотор горойж байсан муу юм бүхэн замхран алга болж мушилзан инээмсэглэж,

— Түшмэлтэн та болгооно уу? Ийм зөвүүн цагт нэгэн гамингийн амийг аварсныг мянган хүний аминд орсонтой тэнцэх буян хурааж хойт насандаа диваажингийн оронд бурхан хутгийг олно гэсэн багш ламтны айлдсаныг даган биширч, ядуу харц би ийнхүү уршиг удсан түмэн буруугаа биедээ хүлээнэ. Бидний хэдэн ядуусыг өршөөж уучилна уу?! гэсэнд түшмэлтэн түргэн салахын түүс болж,

— Цаад хэдийгээ аваад бушуу тонил гэх эрх тушаалын дээрэлхсэн үгэнд Дулдай дотроо эгдүүцэвч гаднаа баярлаж талархсан дүр үзүүлж гарах зуураа нэгэн үг өлгөн хэлэх гээд бантан тээнэгэлзэнэ. Түүний бодлоор бол «юу ч гэхэв дээ, түшмэлтэн өөрийнхөө хүү Жамсранчойг манайхаар элээ шиг эргэлдэн орж гардгийг мэдсэнсэн бол яалаа гэж бэрийнхээ хацрыг шаахайгаар «мэндэлнэ» гэжээ. Энэ тухай үг цухуйлгахад аягүй юу?... Аяндаа өөрөө надад сөхөрч сүй бэлгийн хадаг дэлгэх нь гарцаагүй. Гэвч цаг төрийн байдал юу гэгч болдог бол... Хиагт орчим тун их үймээнтэй дуулдаг боллоо. Хэрэв ардын нам гэдэг нь ялж дийлээд шинэ засаг төр тогтновол энэ түшмэл тэр талд нь яаж ийгээд орчих овжин хүндээ» гэж бодно. Дулдай авгайгаа дагуулан гэрийн зүг гэлдэрчээ.

Түшмэлтэн хахуулийн юмтай баадангаа яаран задалж хараад хумхин нууж сэтгэл хирдхийн уурсаж, гарын доорхи бүх хүмүүсийг дуудан аваачаад,

— Үүнээс хойш хэрэг түвэг таригчдын дотор язгуур угсаатан ихэс дээдэс баян худалдаачид, тэдний үр хүүхэд төрөл төрөгсөд байвал надад урьдаар сонсгож бай! Өнөөх цагаан шөрмөс хүрээ Вандан ойрдоо чимээ тасарчээ. Түүнийг оосорлогдвол хацар хонгоор нь та нарыг хэвшил суулгах гэсэн юм. Ер нь хэрэг гаргагч үйлтэнгүүдэд зодуурын там даамай хүртүүлэхээр эхлээд арьс мах хүрэгтэн нөжирч, дараа нь шалбарч цустай шүүс гарна. За энэ үед л мэдэхгүй гэдэг мянган үгний бөглөө мултарч өчиггүйгээр үнэнээ тоочих тавилантай. Өнөө зүсээ хувилган нуугдагч гаминг оруул... гээд уруулаа шазав татав хийлгэнэ.

«Муу сайн шинэ цагдаа нараар охидын хацрыг шаахайгаар шүүлгэсэн тоглоом хэрдээ зугаагайгаар барах уу? Тавьтын бөгтөргийг атгаж орхилоо шүү дээ» гэж сэтгэл ханан хөгжиж суутал эргүүлийн цагдаа Нэмэх сандрангуй орж ирж,

— Түшмэлтэнд онц яаруу айлтгал байна. Ардын намынхны цэрэг Тахилтаар давж Сэлбэ гол уруудан үерийн ус шиг давалгаалан ирж байгааг чих цохиод яаран ирлээ гэхэд түшмэл суудлаасаа уулгалан өндийж,

— Яасан бузар муухай үгтэй ам муут вэ? Бушуу явж үнэн худлыг туршаад ир! Цогоо чи морьт явган цагдаа нарыг буу зэвсэгтэй нь цуглуулж бэлэн байлга гэж түшмэл тушаагаад суудалдаа лагхийтэл суун тусаж духныхаа чийхарсан хөлсийг арчиж тэвдэн сандрах нь гэмт хүн гэлбэлзэнэ гээчийн үлгэрийг үзүүлэх ажээ.

## Дөрөвдүгээр бүлэг

### Бажгар дурдан алчуур

#### I

Морьт эргүүлийн цагдаа Нэмэх шөнө дунд хэвийхэд ид харуулдаж хянах ажилдаа явсаар л... Дундголын хавьд бүдэгхэн гэрэл гялс хийгээд замхрахад сэжиг төрөн хагас мөрөвчилсөн буугаа гардаж гэтэн ойртож явтал араас бүслэн дайрсан таван хүн гуд татан буулгахаар хүч хэрэглэсэнд, нэгэн удаа хий буудаж, бууныхаа бөгсөөр нэгний цээж рүү цохин ёвроход тэд түүнийг баривчлан хүлжээ.

— Би арван тавны цагдаа Нэмэх байна. Та нар улаан, цагааны аль тал нь болж таарах нь вэ? гэж цухалдсанд үг дуугүй буу тулган туусаар жодгор майханд оруулбал лааны үзэгдэх төдий сүүмэлзээнд зүс эс танигдах дарга нарын дундаас нэг нь нам даруу дуугаар,

— Чи шөнийн цагаар буу зэвсэг хэрэглэн юу хийж явсан хүн бэ? гэж монголоор ойлгомжтой асуугаад Нэмэхийг хариу хэлэхээс урьтан,

—Та гэрэлд жаахан дөхнө үү? гэв.

«Ардын журамт цэргийн хамт ирсэн улаан оросын цэрэг гэдэг нь байжээ. Нэгийг нь ёворч орхисон юу болоо бол?...» гэж зовсон Нэмэх,

—Би арван тавны цагдаа, хүлэг суллаж зэвсэг өгнө үү? гэж эрс тэс хэлсэнд дор нь суллажээ.

— Нэр хэн бэ?

— Нэмэх гэсэнд хэлмэрч залуу

— Нэмко! Нэмко! Чи Нэмко? гээд урагш ухасхийн хантаазны дугуй шар тэмдгээс базан атгаж, нүүр тулган ширтээд Нэмко хэмээн дуу өндөрлөж хүзүүдэн тэвэрч авахад Нэмэх сая сэрхийн ухаарч,

— Шимээн! Шимээн! гээд тэврэлдэхэд мэл гайхсан дарга, цэргүүд тойрон шавжээ. Тэд орос монгол хоёр эрийн намтар, үйл явдлыг товчхон сонсож Нэмэхийг цай, хоолоор дайлж, тал засан зочилжээ. Шимээн үүр цайтал Нэмэхтэй гадуур явахдаа тэр нэгэн өдөр салснаас хойш, хэн, хэн нь хэрхэн яаж явснаа хуучилж сэтгэл ихэд хөдлөн салж ядсаар явна.

#### II

Нэмэх, эргүүлээс бууж ирээд цайгаа ууж дугхийн амрахаар яйжгий модон орон дээр гэдрэг харан хэвтэв. Утаанд харласан бургасан тооноор цэлийн цэнхэртэх огторгуйн номин хөх мандлыг ширтэнэ. Урьд шөнө үл ялих эндэгдэл гаргасан маань Шимээнтэй уулзуулдаг байжээ гэж санахаас сэтгэл хөөрөн хөдөлнө. Энэ сацуу Нэмэхэд шал өөр юм бодогдов. «Наад банз шаахай чинь нэг ёсондоо надад хоол ундыг орлох болжээ» гэж хэлж байсан түшмэлийн

үг үнэхээр түүнд дадал заншил болон тогтсон Манжийн харгис хэрцгий хуулийн гайгаар Нэмэх сайн таних бүсгүйнхээ хацрыг зулгаасандаа харамсан сэтгэл өвдөнө. Энэ ер бишийн учрал Сайнзаяа бүсгүйн үнэн сэтгэлийн нууц увидаст шивэгнэлт болон мөнхөрч, Нэмэхийн зүрхийг гижигдсэн мөчөөс залуу эр хайр дурлалын дөлөөр сэтгэл улам бадран явах болжээ.

«Аль нутгийн хонгор вэ? Чи минь одоо хаана байна. Аав ээжийн хатуу чанга захиргаанд, торонд орсон болжмор шиг байна уу? Эсхүл хээр талын анхилуун бэлчээрт хонин сүргийн дэргэд уяхан дуугаа эгшиглэж баясан уярач сууна уу?» гэх мөрөөдлийн шивнээ бодол, самбар хаалга тэлэн савж сандчин орж ирсэн цагдаа Санжийг хараад тасалджээ.

### III

— Нэмэх ээ! Бушуу босоорой. Буу зэвсгээ ав. Түшмэл гуай бүх цагдаа нарыг цуглуул гэсэн. Юу болохыг бүү мэд гэж Санжийг хэлэхэд Нэмэх өндийж,

— Түшмэл гуай! Ардын намынхантай тулалдах нь уу? Бидний хэдэн цагдаа үзэлцээд, үзэлцээд дийлэхгүй юм тэр байх аа. Журамт цэрэгт туслахаар ирсэн улаан оросын үй түмэн цэрэг Хүрээг хэдэн давхар бүсэлсэн гэнэлээ. Өнгөрсөн шөнө улаан оросын цэрэгтэй хамт эргүүл хийлээ. Өнөөх гайхал цагаан бароноо бодвол нүүр учрахад таатай улс билээ. Эднүүсийг ардууд «номхон улаан» гэж нэрлэдгийг санахад ёстой олж өгсөн нэр гэж бодогдлоо шүү. Эхлээд бид бие биеэ танилгүй ширүүн шиг үзэлцсэн. Баригдаад хэсэг дарга, цэрэг дээр хүргэгдэн очсон чинь тэдэнтэй бужигнаж яваа найз Шимээнтэй тааралдаж ижий ахай болон учир явдлаа ойлголцлоо. Эд нартай дайтна гэвэл би хувьдаа чадахгүй. Аа харин муу сайн гамин, баронтой бол дөрвөн мөч, шүдээр ч үзэлцэнэ ээ хэмээн гэжүү үг хаян Нэмэхийг гэдэлзэхэд Санж,

— Мэтгэлзэхэд мэрэг төлөг хэрэг болох сон болов уу? Өнөөдрийн хувьд хүлэг, ташуур хоёр маань ямар шүү зэвсэг хэрэгсэл байгааг мэдэхээ больж байнаа гэхэд Нэмэх,

— Миний сайн нөхөр Шимээний онцлон хэлсэн захиа үг санаанд урган буулаа. За! байз. Одоохон хөдөлнө. Бумны бужигнаан дундаас төөрөлдөн будилсан Сайнзаяа хонгортойгоо нүүр учрахыг хэн байг гэх вэ? гэж хөгжин сэргэхэд, зөөг цай ууж суусан Санж,

— Эр хүн, ийм л хийморьтой байх хэрэгтэй. Чин үнэнийг хэлбэл урьдаар засаг төрөө төвхнүүлж, дараа нь тулга тогоогоо угсарвал... гэж хэлээд эргэн гарахад Нэмэх яаран дагалдав.

### IV

Бага үд болж байлаа. Баяр хөөрөөр сэтгэл бялхсан Да хүрээний олон мянган оршин суугчид Богдын шар орд, голын сэрүүн лавиранд залардаг их замын дагуу өндөр хотны хойт сул чөлөө рүү хуран цугларчээ. Шинэ төрийн сүлдэнд мөргөх ёслолыг нүд чилээн ширтэн хүлээцгээнэ. Ардын журамт цэрэг, орос улаан цэргийн олон мянган дарга цэргийн сүрт жагсаал жигдэрч, газар зоож бэхэлсэн дөрвөн тулгууртай модон индэрт ардын нам, ардын засгийн газрын тэргүүлэх хүмүүс, цэргийн дарга нар, лам, ноёд эрхтэн дархадын хамт гарч иржээ. Шинэ засгийн газрын тэргүүнээс илтгэн ярьж эхлэхэд хүмүүс бие, биеэс өрсөн юм сонсох гэж

урагш тэмүүлэн дэглэм журам алдагдуулна.

Энгэр заам задгайлж хайш яайш хувцасласан дундаж насны эр олны дундуур зүтгэн өндөр хөх өвгөнтэй мөр зэрэгцэн зогсож,

—Өнөөдөр арга улирлын нэгэн мянга есөн зуун хорин нэгэн оны долдугаар сарын арван нэгний өдөр бөгөөд ардын засгийн газар... хэмээн илтгэн хэлэх үгийг дамжуулан хэлэхэд чих хатуу өвгөн учир үл ойлгон гайхаж,

—Өчигдөр арга барагдлаа гэнээ гэхэд,

— Ээ дүлий дүмбэд минь! Ардын нам, ардын засгийн газар хүрээнээ залран ирээд, ард олон бидэнд эрх чөлөө, энх жаргал авчирч байна гэж учирлангуй чанга чанга дуу өндөрлөн хэлэхэд цагдаа нарын дундаас биеэрхэг хархүү урагшлан дөхөж,

— Вандан чи бас л үймээн шуугиан дэгдээж ханаагүй байна уу? Одоохондоо тантай мөрийцөн наадах хүн энд байхгүй биз. Дуугүй байж болохгүй байвал яв гэж омогдон зандрахад нөгөө хархүү,

— Яана гэнээ хө! Цогоо чи сайхан мэдээрэй. Чи чинь автономит засагтайгаа сөнөж устаагүй хэрэг үү?! Урьдын адил тархи толгой дээгүүр гишгэлдгээ татаарай хө! гэж эгдүүцэн эсэргүүцэхэд уур унтуугаа барьж ядсан цагдаа Цогоо хүлэгний нарийн сур хэд нугалан гуядав.

—Шинэ төрийн сүлд авраарай. Ингэж л махалдаг яргачид шүү! хэмээн зориуд дуу чангатган хашгичсанд индэр дээрээс нэгэн нуруулаг эр цагдаагийн зүг сүртэй ширтэж эрэгцүүлэн ажсаны дараа «хүн зодож болохгүй» гэж гараар заан дохив.

Индрийн нөгөө талд Нэмэх өргөн цээж тэлэн, гараа тэнхээ мэдэн алдлан сарвайж үе үе урагш хушууран түрэгчдийг тогтоох гэж мэрийн ажиллахдаа залуу бүсгүй бүрийн нүүрийг ажин харах гэж самгардавч Сайнзаяагаа олж хараагүй л байв.

— Түрийнээс гаанс улайн цайм луйвардаад зугтлаа. Энэ согтуу дээрэмчинг харав уу? гэсэн явган хэл ам, хэрүүл маргаан үүсэж эхлэхэд нэгэн залуувтар эрийг цагдаа нар хүлээд чирэн зайлуулахыг оролдож буй хоромд индрээс бууж ирсэн идэрхэн эр тэсэж ядан хэлэхдээ,

— Наад хүлгээ тайлж, энэ хүнийг сулла. Би ардын засгийн газрын ажилтны хувьд хэлж байна гээд цааш одов.

Цагдаа нар бие бие рүүгээ том том харж, «чиний л гай. Минийх биш ээ, чинийх, түшмэл гуайн л хийдэл» гэсэн шивэр авир яриа ярилцана. Залуугийн хүлгийг тайлаагүй л байв.

Индэр дээр, орос даргад болж байгаа явдлыг хэлмэрчилж байсан Шимээн, хүлэгтэй залууг бушуу түргэн сулла, түрэглэ гэж дохихыг анзаарч ойлгосон Нэмэх хүлгийг тайлав. Оросын дохиог харсан Санж,

— Наадхийн чинь хүлгийг чангал гэж тэр орос дохиод байна билээ гэж мэдэмхийрэн хэлэхэд,

— Чи буруу ойлгосон байна. Бид хоёр чинь үгээр биш нүдний харц, гарын хөдөлгөөнөөрөө бүгдийг ойлголцдог болсон ах дүү нар шүү дээ гэж нэмэхэд сайрхан хэлээд мушилзан инээмсэглэнэ.

Журамт цэрэг, эмх дэглэмд туслахаар аравт, аравтын эгнээгээр индэр тойрон хүч нэмлээ.

Том хар гэрт хэсэг цагдаа цэрэг, энгийн маргалдаж сууна. Тэдний дунд баяр хөгжөөнтэй суугаа Нэмэх нөхдийн зүг баясгалантайяа инээмсэглэж,

## V

— Өдөр, өдрөөс өнөөдөр гэвэл миний төрсөн өдөр боллоо гэхэд Данд гайхангуй харснаа,

— Яахаараа тэр билээ хө! Чи чинь нэг настай, нялх сэвлэгтэй атлаа улцан зовхины доогуур цагдаа эрийн сүрлэг харц эргэлдүүлсэн, хушуу эмжсэн сахалтай хүүхэд болж таарах нь ээ? гэвэл Нэмэх улам хөгжин,

— Өшөөт дайсанд хэлмэгдсэн хөөрхий аав, ээжийнхээ гэгээн дурсгалыг хүндэтгэн санаж, эрхт төрийн цагдан сэргийлэх цагдаа цэрэг болсондоо баярлаж байнаа. Ардын цагдаагийн мэндэлсэн энэхүү баярт өдрийг мартаггүйн тулд долдугаар сарын арван есний өдрийн их үдэд өөрийгөө төрсөн гээд тогтооё. Авгайтайгаа суугаад хүүхэдтэй болбол аавын чинь төрсөн өдөр нэг биш, хоёр гэж хэлэхэд хөгжилтэй байх биш үү? гэхэд Санж,

— Холын бодол хожмоо хожих тавилантай байж магадгүй юм аа. Тиймээс даган баясьяа гэхэд хүмүүс инээлдэв.

— За, за. Тэр ч тийм байдаг байж. Магван залан гуай буурь зааж өөр газар дээгүүр ширээ түшсэн гэж байгаа. Аа харин манай түшмэл бид хоёрыг таягдах байх даа гэж санасан чинь майга хөлөө бараг шат алгасуулаад тавьчих дөхжээ. Амиа ч аргалах эр юм аа. Одоо хуучин сууриндаа л гэсэн үг. Дотуураа тун додигор байгаа юм шүү! Шинэ төрийн хоол шингэц сайтай байгаасай билээ гэж цагдаа Цогоо илэн далангүй айлдсаныг сонссон цагдаа нар нирхийтэл инээлдэж хөгжилдөнө.

## VI

Цэргийн цуваан дунд яваа Нэмэх усан баймли буу мөрөвчлөн бүсэн дээгүүр сум ярайлгасан дайз, гуулин бариултай урт сэлмээ хааяа хааяа суга татан сургуулилан эргүүлэхдээ,

—Энэ хатан болд сэлэм миний гарт ивээл, дайсанд үхэл учруулна гээд сэлмээ гэрлэн цээж ханхалзуулахад,

—Муу эр дайнд хөөрнө гэдэг зүйр үгийн оронцог бидний дунд байхгүй. Цөм эрэлхэг баатар эрс, түүний дундаас... гэж хэн нэгэн ёжин өгүүлээд Нэмэх өөд нүд ирмэн харахад,

—Тийм ээ, тэр баатар эр нь би байна гэж Нэмэх хэлээд мушилзан инээмсэглэнэ.

Журамт цэргийн даргын шийдвэрээр их амралт улаан үзүүрийн суман өртөөн дээр хийжээ.

Тайны гэрт тараан буулгахад орон байрны багтаамжгүйгээс зарим нь ойр орчны айлаар тарахад арван морьт цагдаа цэрэг дагуулсан түшмэл Дамдиндорж том цагаан гэрт буусан нь Дулдай баяных байжээ.

Түшмэлтнээс бусад нь майхан, илүү гэрт хоноглов. Дулдай, зочинд хөл алдан долигонож, хонины бүхэл махаар зоог барин, галуун хүзүүт ваарнаас угсруулан хүндагалсан хатуу дарсанд халамцан зориг орж эхэлсэн түшмэл гал тогоотой зууралдаж байгаа зарц Гүнчинг таашаан хяламдах зуураа Дулдайд гоёчлон,

— Танайхыг энд гэж ер зүүдлээгүй. Сайн хүн санаагаар гэгчийн үлгэр болж, ерөөлт учралаар бид бүхнийг нүүр учруулан золгуулж байна хэмээн аядангуй өгүүлсэнд Дулдай,

— Жа түшмэлтэн гуай! Гамин, Барон-цагаан, улаантны хөл үймээнээс дайжин, цаг төрийн дүн нуруу, байр байдлыг харзнахаар хэдэн малаа хариулдаг, нутгийн таних айлын хаяанд өдөр шөнийг өнгөрөөсөн шүү л байна. Да хүрээ сонин ихтэй гэх шив лээ. Та ямар тухай хэргээр морилж яваа вэ? гэж сониучилна. Завилан тухалж суусан түшмэл Дамдиндорж, өвдгөө үнэрлэж хамраа яатайлган цээж хэржигнүүлэн буй хар алаг муурын толгойг илэн таалж,

— Муур гэдэг амьтан өөрийн цэцэн мэргэн зөнгөөр сайн мууг урьдаас мэддэг юм гэнэ лээ. Миний үйлс бүтэмжтэй болохыг билэгдэж байх шиг байна. За! энэ ч яахав ардын нам, ардын засаг юутай хийтээгээ залраад шинэ төр улсаа бататган мандуулж хуучин яамд татагдан таягдаж тамга хэргээ шилжүүлэв шив дээ. Дээгүүр хэргэмтэнгүүд ч бараг суудал ширээ мултарч, дундуур, доогуурхи мань мэт нь тэр талд үг хэл дүйсэн санаагаар түр зуур нийлсэн болж, мөн л юмны байрыг битүүхэн харцгааж байх шиг байна. Би хувьдаа арван тавны цагдаагаас ардын цагдаа болж ая эвийг тааруулан шургаж хэрдээ мундахааргүй хэргэм зэрэгт дэвшсэн гэж бодож байгаа. Энэ зуурын явдал гэвэл цагааны үлдэгдлүүдтэй тулалдахаар явж байна.

Харин санаанд буушгүй ийм таатай завшааныг... гээд модон хүйт маузар бууны бариулаас зүүсэн шинэхэн хадаг тайлан авч сэргээн засаад Дулдайн зүг нүүр эгцлэн хоёр гардан дэлгэсэн хадгаа өргөсхийн,

— Таны өлзий буянт охин бол миний хүү Жамсранчойн үүрдийн хань ижил нь төдийгүй нас жил, суудал яг тохирчээ гэж лам багш нар шоодон болгоосон юм даг. Үр хүүхдүүдийн хэтийн буян заяанд ивээл хишиг мөнхжин орштугай! гэж хэлээд хадгийг бурхны ширээ дамнуулан тавьж, адис хүртэн суухад Дулдай гүдэсхийн дороо займчиж,

— Дорд мулгуу охин минь. Дээдэс таны таалалд соёрхогдсон бол бурхан ивээх болтугай гэж мишилзэн зулгайдвал түшмэл онц тааламжтай инээмсэглэж,

— Би энх тунх байхдаа хүүгээ хань ижилтэй болгоё гэж аль эртнээс сэдсэн хэдий боловч цаг төр хавчиж өдий хүргэлээ. Гэвч бурхдын ачаар өнөөдөр бэлэг сүйн цагаан хадгаа дэлгэн барьж бэр буулгах охины сүйд нэгэн зуун лан цэвэр цагаан мөнгө амлая. Хуримын өдрийг дараа шийднэ гэж бардамнан дээрэлхэх зан араншин нэвт шувт шингэсэн түшмэл, энэ бүхнээ охин бярууны арилжааны чинээ ч санасангүй ээ.



Дулдай хатуу дарснаас шимэн балгаж уруул жимийн тамшааж «...ингээд ганц охиноо нэгэн зуун лан цалин цагаан мөнгөөр дүйж үнэндээ наймаа тохирлоо гэсэн үг үү? миний охин арай ч зуухан лангийн үнэтэй амьтан биш дээ? Гол сүнс нь эрхтэн, дархтантай худ ураг барилдах нь таатайгаар барах уу? Хожим хойно мянган, мянган лангийн үнэ цэнэтэй тэнцэх болно» гэсэн хоёрдмол бодол юугаан орхин ядаж,

—Хөөе Лхам аа! Цаад охиноо дууд гэв.

## VII

Сайнзаяа орж ирэн, аймхайгаар гайхан зогсоход аав нь:

—Миний охин хадам аавдаа сөхрөн золго гээд түшмэлийн зүг алга дэлгэн хүндэтгэж дохиход охины нүүр барсхийн, нүд алаглаж аргагүйн эрхэнд өвдөг сөхрөн мэхэсхийсэн болоход, түшмэл баясан мишээж согтуу нүдээр ширтэн,

— Миний хайрт бэр гээд дэргэд ойртсон бүсгүйн эрүүний дороос баруун гарын долоовор хуруугаар дэгээдэн духыг үнсэх аялбал Сайнзаяагийн дотор сэрхийж хамаг бие хүйт даан, хоёр хацар нь хорсон шархирах шиг болж «Цохь! Олигтойхон цохь. Ураад бай. Юугий нь гамнан хайрласан лүд вэ? Гарын чинь шөрмөс татчихав уу?...» гэж зандчин байсан түшмэлийн харгис хэрцгий дуун сонсогдох шиг болжээ.

## VIII

Үдшийн гэгээтэй уралдан цэргээ жагсааж бүрэн эсэхийг бүртгэн тооллого хийхэд нэг хүн дутсан нь Нэмэх байлаа. Оройн хоолны дараа Дулдайн охиныг дагуулан зүг буруулахыг лавтай сайн ажсан харуулын цэрэг нөхрөө хайрлаад үг цухуйлгасангүй. Үүрийн шар гэгээн дор дун бүрээний цангинах дуунаар жагсаал жигдрэхэд Нэмэх байрандаа байж байв.

Буугаа гэрнээс суга татан авахын халаг байсан түшмэл, бууны бариулаас барьж тавин нүүр минчийлгэн хилэгнэж Нэмэх өөд хуруу чичлэн зангаж,

— Нохойн гөлөг чи! Өчигдөр орой хайчсан бэ? Бушуу хэл гээд давшлав. Нэмэх айж тэвдсэн шинжгүйгээр,

— Дулдай гуайн охинтой... гэхэд түшмэл үгийг тас дайран,

— Дайсантай тулалдах зам зуур ингэж садарлан самуурч завхайрч явна гэнээ. Жинхэнэ тулалдаанд орвол хурим хийх гээд арилах усан тэнэг шив дээ! Манай ардын шинэ засаг чам зэргийн ганц жулдрай хархүүгээр дутахгүй хө. Байлдааны цагийн хатуу цаазыг баримталж чамайг дор чинь хороогоод их жанжинд учир үнэнийг өчих нь миний эрх мэдэл гэж сүржигнээд ёоз муутай нүдээр Нэмэхийг өрөмдөх адил ширтэнэ.

— Наад муу новшоо банзан зодуур орлуулан арав ташуурд гэж тушаахад Нэмэх буу сэлмээ өөрөө авч тавиад хонгоо гарган түрүүлгээ харж хэвтэв. Хулсан ташуурын цохилт эхлэхэд түшмэл ханцуй дотроо хуруу даран сэмхэн тоолно. Арьс маханд цус хуран нөжирч хүрэнтсэн

хонго хорсон хөндүүрлэвч Нэмэх шүд зуун босож хувцаслана. Нэмэх хөх цэнхэр өнгийн баржгар дурдан алчуур нандигнан эвхэж өвөртлөхийг ажсан түшмэл «Сайнзаяа бүсгүй өчигдөр өврөөсөө гаргаж нүүрээ арчаад байсан алчуур дүрээрээ байна» гэж санагдахад зэвүү хүрч, хор шар буцлавч яаж ч чадсангүй ээ.

## IX

Журамт цэргийнхэн тав дахь хоногийн үдээс хойхно цагаантантай гэнэт тулгаран тулалдаан эхэлжээ. Их бага буун дуу нирхийн нүргэлж, нууц газраас пулемёт тачигнана. Цагаантан унах нь унаж, ухрах нь ухарч ийш тийш хэсэг бүлгээр сарнин зугтана. Энэ мөчид журамт цэргийн зарим аравт анги явгалан мөлхөж, нэгэн өндөрлөгийн төлөө үхэн хатан амь дүйж давшина. Эргэн тойрон сум шунгинан исгэрч, морьд янцгаан хүний ёолох хашгирах дуун сонсогдож нүдэн балай, чихэн дүлий болжээ. Сум зөөгч цагдаа цэрэг Данд пулемёт үүрэн урагш хүч түрэн тэмүүлж харагдав.

Нэмэх зүрх оволзон хөөрч, чухам юухан болж төгсөхийг үл төсөөлөвч, нэг бол наймаа, хоёр бол хожоо гэсэн бодолд хөтлөгдөнө. Гэнэт морьтойгоо онхолдон унаж, ухаан дэг дуг орж гаран газар элэглэн хэвтэж, ойртож ирсэн хоёрыг дор нь буудан унагажээ. Түшмэл Дамдиндорж цагааны даргыг сэлэмдэхээр элдэн айсуйг харж, дайсныг угтуулан буудахад онхолдон ойччихов. Нэмэх ухасхийн түшмэлийн хойгуур хойш харан сундалж, тэр хоёр гал нээсээр л явжээ.

Буудагдсан морь газардахаас өрсөн хоёул үсэрч, үхсэн морины ард бие нуун хэвтэцгээнэ. Овоо хараанд тааралдсан бүрийг буудаж, цааш харуулсаар л байв. Гал зогсож, үзэгдэж харагдах ч юмгүй болжээ. Нэмэх, түшмэлийг харж «юм аа гэж... Сайнзаяаг минь надаар, намайг өөрөө арьс маханд «хээ» тавьж хэрцгийлсний ор сорви одоо ч арилаагүй байна. Үүнийг бодохоор гомдмоор хүн дээ. Аав, ээжийн минь амь насыг хөнөөсөн дайсныг хамтран устгах гэж явааг бодохоор...» гэж санагдахад хилэнцэт тэр явдал зэрэглээ мэт замхарна.

Түшмэл «юуны урьд ардынхны гараар атаат дайсныг дараад авах юм хуна. Тэгсний дараа... эцэс сүүлд нь энэ муу цагдаа цэрэг мэтийн юмтай учир зүйгээ олох нь бараг алга урвуулахын төдийд амжина. Гэхдээ надтай энэ Нэмэх мэтийн тооцоо бодох хүн бишгүй бий шүү. Гэвч эд гамин барон биш шүү дээ!...» гэх хоёрдмол бодолдоо хаврын тэнгэр мэт сэтгэл уймрана.

Нэмэхийн буу гэнэт тасхийж, уул хадны цуурай нэгээс нөгөөд дамжин нүргэлнэ. Тэрбээр эзэн нь алагдсан эмээлтэй морь барьж унаад эргэх хоромд түүнийг бараадан ирж явсан түшмэл дайсны суманд өртөгдөн навгасхийн унахыг харав. Нэмэх туслахаар давхиж очив.

Хажуунаас довтолсон харь элэгтний сэлэмтэй гарыг цавчиж хүндээр шархдуулахад өрөөсөн гартай дайсан арга барагдаж, буун өгөхөөр толгой бөхийлгөн гар өргөлөө. Нүүрийг зэрвэс ажин харсан. Нэмэхийн нүднээ мөнөөхөн зурвас сорвит цагаан цэргийн авилгаач дарга яг мөн харагджээ.

Үнэн шударгын тонгоргон мэсээр нэхсэн хонзон харьсан ч, эдний гарт хөнөөгдөн амьдрал жаргалын үндэс таслагдсан аав ээжээ санан дурсагдах агшинд баруун гар гэнэт ясандаа янгинаж цус садран гарахыг хараад Сайнзаяагийн бэлэглэсэн баржгар дурдан алчуур гаргаж

боохоор оролдон байтал өөрийн талынхан иржээ.

— Алганы доод хэсгийг сэт авчихлаа. Наад алчуураараа боо! Хөөрхий хайртын минь хөлсний үнэр шингэсэн юм. Одоо тулалдаанд асгаруулсан миний цус шингэг! Түшмэл гуай бас шархадсан шүү. Шалавхан очиж туслаарай гэж хэлсэн Нэмэх цугларах бүрээн дуунаар нөхдийн хамт тэр зүг жолоо залав.

## Х

Үхлүүт шархадсан түшмэлийг дамнуурган дээр цэргүүд, дөрөв дөрвөөр ээлжлэн дамнаж Да хүрээнээ авчирчээ. Цэргийн оточ санаа тавин шамдан эмчлэвч сар хоногоор доройтон өдрөө хулээх болов.

— Өнөөдөр ямар гариг вэ? гэсэн түшмэлтний лавласан асуулт гэр бүл, дотно хүмүүсийн сэтгэлийг улам шаналгана. Хүү Жамсранчой аавын дэргэд үргэлж сахин эцэг үрсийн элбэрэл журмыг ёсчлон биелүүлнэ.

Цогоо, Нэмэх, Санж, Данд нар байнга эргэж тойрон санаа сэтгэлийг засаж, шинэ ёсны учир байдлыг ярихад түшмэлтэн сонирхон хариу лавлан бишрэн баярлана. Өр шир, өглөг авлагаа захисны дотор худалдаачин Далайбуянд таван зуун лан мөнгө өгөхөөс өөр өргүй гэжээ.

Худалдаачин Далайбуян бичээч Ариунсангийн хамт ирж түшмэлтэнтэй их л найрсаар ёсорхон уулзахдаа:

— Таны бие амгалан сайн байна уу? Лагшин тэнхээ ямар байгааг асуухаар ирлээ гэсэн зулгайдал, цай идээний дараа элсэнд асгасан ус адил болж,

— Түшмэлтэн гуай. Одоо, цаг төр итгэлгүй болж, үймээн самуун ихтэй болсон учир нутаг бараадъя гэж бодож байна. Нөгөө хэдэн лан мөнгөө та бодно биз гэхэд Дамдиндорж амьсгаадан өндийж,

— Та чухам хэдэн лан гэж бодож байна. Дансандаа харна уу гэхэд мөнгө атгах нь гэж яарсан Далайбуян бичээчдээ хандаж,

— Дансыг сөхвээ гээд өөрөө тоог лавлан ахин дахин харснаа

— Яг таван зуун лан байна. Таньдаг сайн хүн танаас сүүлийн хэд хоногийн хүү, хүүгийн хүү аваад юу хийнээ. Та л түргэн эдгэрвэл таатай байна гэсэн манж үгээр эвтэйхэн дайвар өгч амжлаа. Түшмэлийн царай барайн хүрээнтэй дургүйцэнгүйгээр,

— Эрхэм худалдаачин та! Намайг үхэх нь гэж яарч ирсэн бололтой. Би эцэслэвч миний төрсөн хүү Жамсранчой энэ байна. Мөнгөө дараа аваарай гэхэд сандарсан худалдаачин,

— Хай! хэдхэн лан мөнгийг их түшмэл танаас авсан, эс авсан ч яах вэ. Би зүгээр бие асуух далиманд цухуйлгасан юм. Та түргэн эдгээрэй гэж хэлээд мэхэсхийн гарчээ.

Түшмэл Дамдиндорж тэр өдөр хүүдээ ганцаарчлан захисан нь:

—Миний хүү аавыгаа бурхан болчихвол Дулдай гуайгаа түшиж, охинтой нь толгой холбоорой. Төр улсад муу санаж хэзээ ч болохгүй. Амгалан сайн цагийн эхтэй золгосон гэдгийг ухаарч амьдрал үйлсээ бодоорой! Хүний амь нас бүү хохироо! Хүүхдэд хайртай бай. Мөнгө цагаан, нүд улаан гэдэгт хууртаж болохгүй. Аав нь хүнээр гарын шар ус тарааж байснаас хүн алж, хүрээ талж яваагүй юм шүү! Эцсийн эцэст онцгойлж захирад цагийн аясыг дагаж, сохрын газар сохор, доголлонгийн газар доголлон явах хэрэгтэй.

Тэгэхдээ мууг дагавал могойн хор гэдэг үнэн. Аавынхаа энэ бүх үгийг ёсчлон дагавал наанадаж миний нүгэл хугасрана. Цаанадаж чиний зам өлзийтэй байх болно.

Баруун хашааны зүүн талын жижиг модон байшингийн босгоны дотор талын шалны гурван банзыг ховхолж, газрыг малтахад хөмөрсөн ширмэн тогоо бий. Доош нь малтаарай, авдартай юм гарна. Энэ эцгийн чинь өв хөрөнгө, үүнийг хүү чи өвлөх ёстой. Гэсэн ч чамд эд, мөнгө нөхөр биш, хүн л нөхөр болох цагтай золгосон гэдгийг санаарай. Аа харин аавд чинь эд, мөнгө нөхөр болж тийм юм хураасан байнаа гэж хоног тоолсон сүүлийн үед л ухаарлаа. Тэгэхлээр миний хүү тэр мөнгөнөөс худалдаачны өрийг төлөөд, үлдсэнийг аавынхаа хойт төрөлд л зориулчихаарай гээд түшмэл хүүгийнхээ духан дээр удтал үнсэж, унтрах гэж байгаа дэнгийн улайсан гол шиг нүдээ анивчина.

Түшмэл Дамдиндорж гэнэ гэнэ амьсгал тасалдаж, нүдний хөдөлгөөн сулран суларч, царай цонхийн цайхад, Жамсранчой,

— Аав аа! Аав аа! Хүүгээ битгий орхиоч гэж хоолой зангируулан уйлсанд түвд номоор аг маггүй сэвж, ном шивнэн айлдаж байсан багш лам нүд ихэсгэн эргэлдүүлж,

— Жамсранчой! Битгий уйл замд нь тотгор болж сүнс нь хоргодно гэж аяархан шивнэнэ. Уй гашуудлаар усан нүдлэгчдийн дотор цагдаа Нэмэх, Санж, Данд, Цогоо нар байв.

Заншил дагаж, нас барагчийн гэрийн доторхи бүх эд хогшлыг гаргаж ханхайлсан нь уй гунигийн зүрх шимшрүүлж нам гүм болов. Гүнгэрваат бурхны өмнөх ширээн дээр их голт мөнгөн цөгцөнд мандаасан зулын дөл өлөн хөх өнгөөр гологноно. Түшмэлийн мөнхөд нойрсон буй шарилын нүүрийг бүтээсэн хадаг, нөмөргөсөн дээл бүхэн дээр тусаж байгаа зулын бүдэг гэрэлд, юм бүхний өнгө хувиран бүүдийж үнсээр бүрхэгдсэн адил санагдуулах ажээ.

# Тавдугаар бүлэг

## Алганы хатиг

### I

Хот, хөдөөд баян тарган нэртэй Дулдайнх дөрвөн цагийн эргэлтэнд хөл тасарна гэж байдаггүй. Заримдаа бүх л өдрийн турш шөнө дөл болтол хөлд дарагдана. Тамхины суунаг саарал утаан дунд худал инээдээ ид бах болгон домбо шавхан ёроолыг гаргагчийн нэг, эцэнхий моринд архи өгч жороо сайвар оруулан хэрхэн залилан наймаалснаа онгирон гайхуулна. Нөгөөх нэг нь нударга ханцуй дотроо гар хуруу барьж атгалцан панз үсэргэх арга мэх мэдэхгүй хүнийг мэхэлж тавыг тавь, тавийг таван зуу хэмээн зоос мөнгөнд өртүүлэн хуурч, хударгаар суух мөн ч бахдууштай гээд чухам худал, үнэний зааг дээр тулахаар «нээрэн, нээрэн» гэж мэтгэнэ.

Томоохон пүүс дэлгүүр үүд нээхээ больж, бараа таваар нүдний гэм болж эхэлсэн үед бэл бэнчинтэй бол баахан торго дурдан авч зарсан хүн алсдаа мөнгөн төгрөгөөр бөөлжинө гэж эрээ цээргүй хошигнолдоо итгэн баясана. Галзуу согтуучуудаас ялгаагүй дэвэргэн ярианд залхаж цөхөхдөө гал, тогоо угсруулан цай чанаж байгаа Лхам бүүр ядарч залхахын эрхэнд орон дээр сунаж унан түр зуур хэвтгээд босно.

Дулдай авдар налан хөл жийж, халуун цай аягалан тавиад тамхи нэрэхээс өмнө урт чулуун соруулаа хорхойтон ажиж, хэн урьтаж үнэ өгөх бол гэсэн шиг байн байн арчин зулгэж хааяа өнгөцхөн худал инээдээр даган баясагчийн дүр үзүүлнэ. Ийм нэгэн үдшийн яриа хөөрөөний цагаар Да хүрээний цуутай худалдаачны нэг Далайбуян, бичээч Ариунсангийн хамт зочлон ирэхэд хүмүүс тарж одлоо.

Хуучин түншид Дулдай хөл хөөрцөг болон, хэлэх байх үгээ олж ядан ая тал засна. Лхам тунгалаг шингэн хар цай чанаж, сонгино сармис, халуун ногоогоор амталсан хар шөл хийгээд дэлбэн амсартай нимгэн эрээн шаазанд аягалж зочдод өгөв. Дулдай лонхтой хар архи задлан жижиг мөнгөн тагшинд мэлтэлзүүлэн хүндагалж өргөн барихад худалдаачин мэхэлзан ёсорхож аажуухан балгаад тавина.

Худалдаачин, Дулдай хоёрын наймааны холбогдолтой үл ойлгогдох битүү хатуу үг яриан дунд хааяа «хар бурам»-ны тухай цухалзана.

Дулдайн үг дуу цөөрч дотуур тамираа илрэхээс болгоомжлон дарснаас хянуур балгана. Таваг дүүрэн овойх бүхэл махнаас хутга хүргэж ядан огтолж, Далайбуяныг үл ойшоох байдлаар духдан хараад,

— Та тэгээд надаар худалдуулахаар өгсөн юмаа борлосон, эс борлосон ч данс бодохоор ирээ юу? гэж дурамжхан асуугаад жижигхэн боодолтой юмыг аяганы ширээн дээр түгхийтэл тавиад гүрдийн томорсон хөх судаст махлаг гараа яаралгүйхэн татаж,

— Тавь, тавиар толгойлсон гурван зуун янчаан шүү! Та дансаа нээж үзээрэй гэхэд Далайбуян

ваадантай юм яаран задалж, цаасанд хуйлсан мөнгөн янчааны нэгжийг хичээнгүй тоолоод бусад боодол руу нүд бүлтийлгэн харах зуур,

— Миний бүүр зузаан түнш Дулдай минь! Энэ хар бурамны наймааг их яаруу хийх хэрэгтэй байна. Таны гарт үлдээд байгаа юмыг дэнслэн хэмжье гээд бичээчид дохин «дэнсээ гарга» гэв. Дулдай гэнэт санаа аван,

— Лхам аа! Хашааны хаалга сайн түгжээрэй гэж болгоомжлон захиад дотор нь олон хэсэглэж адил хэмжээгээр жижиглэж боосон юмыг гаргаж өгөхөд Далайбуянгийн гүрээний судас гүрс гүрс хийж, хүзүү сунган бараг шүүрэх шахам гардаж аваад хэд дахин магадалж хэмжсэний дараа,

— Үлдсэн нь ердөө энэ үү?! Миний дэнс ли ч алдахгүй. Гэтэл данс яасан их зөрж байна вэ? гээд хэмжүүр барьсан гар нь салгалан чичирч, цонхийн царайлж байж ядахын эрхэнд аажуухан шимэж байсан хүндагатай дарсаа пүл, цал залгиснаа ч анзаарсангүй ажээ.

Дулдай таг чиг болж, Далайбуянгийн зэвүүг хүргэн уурлуулахыг хичээсэн боловч худалдаачин биеэ барин цэнэж «уураар алдана, аргаар хожно» гэж бодоод сайхан зан гарган хүндагатай архиа сэлбэн Дулдай руу ч, Лхам руу ч барьж мушилзан худал инээмсэглэнэ.

— Хар бурамны наймаа тун барагтайхан байгааг та өөрөө мэднэ шүү дээ! Би түргэн борлуулах гэж зарим үед өгвөл зохих үнээс тэн хагасыг сааж зараад өөртөө сохор зоосны ч ашиггүй л байгаа. Гэсэн ч та бид хоёр ойлголцоно гэж бодож байна. Одоо танд чухам хэдэн янчааны өртэй хоцрохоо мэдье. Дансаа сайн шүүж, хэн хэнийгээ л бодоорой гэвэл, Далайбуян бичээч хоёр удтал сампингийн эрхи шажигнуулсны эцэст,

— Мянга нэлээд гаруй юм үлдээд байна гэхийг сонссон Дулдайн царай харлан барайж,

—Тэгж ярихгүй. Хэрвээ түүндээ тулбал над шиг нь өөрийгөө эхнэртэйгээ худалдсан ч таны өрийг төлөөд гүйцмээргүй юм босож байх шив гэв. «Луйвардах санаатай байна. Яаж салгаж авах вэ» гэж худалдаачин бодонгуут боодолтой янчаан, хар бурмыг аяганы ширээн дээр буцааж тавихдаа,

—Өөрөө сайн бод. Тийм л байна шүү дээ. Үнэн юмны төлөө түнш улс, хэл ам муруйж юу хийнээ. Заавал янчаан гэхгүй. Хатуу эдлэл оролцуулан авахад болно гээд худалдаачин Дулдайн зүүн гарын ядам хуруун дахь том алтан бөгжийг хорхойтон ширтэнэ.

## II

Морьт эргүүлийн цагдаа Нэмэх эргэж тойрох ажлаа гүйцээж мухарлаад Сайнзаяатайгаа самбаачлан уулзахаар очиж, хашааны гадаа чих тавин түгжээтэй хаалгыг халж ядан түлхэж байтал гэрт өндөр нам дуугаралцан, зодоон цохион үүсчээ. Тэгэхэд «эцэг нь Сайнзаяад гар хүрч байх шиг байна» гэж бодохоос яс хавгайж сэтгэл яарсан Нэмэх хамар хашааны айлын жижиг хаалгаар орьё гэж шийдлээ.

Гэрт хэрүүл маргаан гал руу тос дусаасан адил болж, Далайбуян босон харайж үүд рүү

араараа ухарч, ухарч Дулдайн элгэн хавьд мөргөж, муухай орилон дайрна. Дулдай ялимгүй бие займруулсанд худалдаачин авдарны цоожинд духаа хэгз мөргөн эргэхдээ цус савирсан толгой нь салганан,

— Дулдай аллаа. Амь авар! хэмээн дүрэмдэн хашгирч, дахин дайрахдаа толгойгоо эмзэглэн цээжээр турэн сүржигнэнэ. Дулдай эгдүүцэн хилэгнэж худалдаачны өрөөсөн эгэм рүү хүчтэй ёврон нүдрахад гэдрэг ухран тээглэж ойчихдоо аяганы ширээ татан унагаж, зүүн талын модон орны нүүрт дагзаар савж тэрий буужээ.

— Та минь ээ болиоч ээ. Яасан муухай юм бэ? гэж Лхам Дулдайд хориг тавихад,

— Хэрүүл маргаанаар юу хийнээ. Алив, таны нөгөө юм болгоныг аргаар, хөлд нь сууж байж бүтээнэ шүү! гэж цэцэрхдэг чинь. Амь биш, мөнгө гэдгийг ойлгоорой гэж бичээч, худалдаачныг зэмлэн буруушаана.

Ингэж Хөглөж байх үеэр цагдаа Нэмэх орж ирснийг Лхам авгай л мэджээ. Цагдаа будлиант явдал өөд анхаарлаа тавилаа. Зүүн орны өмнө зүс таних хоёр худалдаачин, нэгийнхээ цусаар эрээнтсэн дух, нүүрийг цэвэрлэх гэж оролдоно. Дулдай, хоймор суудалдаа дув дуугуй уухилан амьсгаадаж, шамласан нүдаргаа буулгаж харагдана.

Хажуулдаж унасан аяганы ширээ, боодол задарч асгарсан олон тооны мөнгөн янчаан, цаасанд нямбайлж боосон боодолтой юм ундуй сундуй хэвтэнэ. Цагдаа харсан хоёр худалдаачны гар нэг зэрэг пүрштэй юм шиг сарвасхийж мөнгөн янчаан дотроос хэд хэдэн боодолтой юм шунагаар базан атгах нь Нэмэхэд онцгой сэжиг төрүүлэв.

— Та бүхэн энэ юмнуудад битгий гар хүрээрэй, Дор дороо хөдлөхгүй байх хэрэгтэй гээд гэрийн эзнээс хэнээс хэрүүл зодоон үүссэн шалтгааныг лавлавал Дулдай үл тоомсорлох байдлаар,

— Худалдаачин гуай бид хоёр ганц ганц тагш дарсанд халамцан өр авлагын үл ялих юухан хээхэн юмнаас ам муруйлцаж байхгүй юу. Энэ маань ямаан омгоор өөрийнхөө цусыг өөрөө үзсэнээс өөр онцын юм болоогүй гэж тогтуун тайвнаар тайлбарлаж, эхнэр Лхамд хандан,

— Аль вэ? цагдаа хүүд унд хоол өгөөч гээд хүндаганд архи дүүргэн,

—Идээ идээний дээж, үүнийг цайнаас урьд тогтоочих гээд аядуухан сарвайхад Нэмэх аягатай архийг хоёр гардан хүндэтгэлтэй авч уруул хүргэж буцаан өгөхдөө,

— Би архи уудаггүй гээд толгой ялдамхан сэгсрэхэд Далайбуян үг хэлэх шалтаг хайн маасганаж цагдаагийн зүг хуурмаг мишилзэн элгэн дээрээ хоёр гараар зөөлхөн дарж нахилзаад,

—Би чамайг анзаарч сайн ажвал таних хүү байна. Энэ зузаан түнш Дулдайгаас хэдхэн янчааны авлаганы төлөө данс зөрж муухай юм болох шахлаа. Шал дэмий уурлалцан бас жаахан жаахан хашгирсан буруу шүү! Та биднийг өршөөж хайрла. Шинэ эзэн төр сайхаан шүү гэж долигонон «энэ муу тэнэмэл жаал шиг цагдаад хэдэн янчаан атгуулахад амаа

ангайгаад бушуухан зайлна. Нохой унамар яагаад энд ирсэн бэ? Эдний охиныг эргүүлж харуулдаж яваад л ийм гай болох шиг боллоо. Аргална даа» гэж санаа засан байтал цагдаагийн «Олон таван үг бүү ярь» гэсэн сүрлэг дуу тархи толгой задлах мэт санагдахад худалдаачин өвдөг үл мэдэг чичирч, хоолойн дээр нь бөөн хар юм тээглэжээ.

— Таны халаасандаа хийсэн боодолтой юм юу вэ? үзэж болох уу? гэж тулган асуухад Далайбуян хуурамчаар мушилзан инээмсэглэж,

— Жаахан «хар бурам», эдний охинд бэлэг бол гон өгөх санаатай авчраад өгч амжилгүй мөнгөн дотор унагаснаа авч хармайлсаан шүү. Охиндоо өгөөрэй гээд Лхамд гардуулах гэхэд Нэмэх зуураас тосож аваад дор нь задалж «хар тамхи» гэж таньжээ. Цагдаа, «энэ муу юу мэдэх вэ?» гэж өөрийг нь элэг барьж байгааг гадарлан мэдээд хариу болгож,

— Ёстой жинд сайн чанартай «хар бурам» мөн байна. Ийм амттай бал бурам манай цагдан сэргийлэхэд тун их хэрэгцээтэй байдаг. Би худалдаж авъя. Харин одоогоор үнийг өгч чадахгүй, очоод өгнөө гэж ёжингүй хэлэхэд, хэрэг бишдлээ гэж мэдсэн худалдаачин «..нус, нуухнаас салж чадаагүй шахам хүүхэд шиг харагдах байтал энэ яасан айхавтар санаа нь өтөлсөн чөтгөр вэ? Царай алдсан луйварчин Дулдайгаас хамаг хэрэг мандлаа. Энэ муу амны нь салиа арилаагүй юм наана цаана юм огт мэдэхгүй. Шинэ цагдаа яаман дээр очоод үзье. Хэдэн янчаан л гарна биз. Эзнээ олж атгуулах хэрэгтэй. Тэгсэн цагт хэрэг, хэрэг биш болноо. Ер нь тэнд сайн танилтай болж авах хамгийн чухал» гэж бодсон худалдаачин бүлээн хар цай аягалан ихэмсгээр оочилж дээгүүр харан үл тоомсорлосон царай гарган сууна.

### Ш

Дулдай дагтаршсан хогноос ёс төдий домнон хүрздэж даачаа тэрэгний тэвш рүү хаяж оромдох зуураа «Хай зайлуул, Сонгино хайрхан нүднээ илхэн шовойж байна. Тэр нэгэн цагт би идэрхэн байжээ. Наадхи дэнж хажуугаар зүсланд гарч, хүний өөрийн бараг тав, зургаан зэл дүүрэн унага зэллэж, зах зээлд нэг удаа орж ирэхэд олон хавчиг айрагтай наашилдаг байлаа. Намар гүү тавьж найрын дугараа барихад арслан хээтэй улаан авдраар дундуур мөнгөн төгрөг байдаг сан. Одоо санахад чамламгүй олбор байжээ. Тэр ч яахав, зах зээл дээр хөдөөнөөс мал авчирч, хүрээнээс торго дурдан хөдөө гаргаж өгөхөд гоц үнэ хүрнэ. Хямдхаан сул хаялаа гэж буцаж ирээд бусдын сэтгэл хайнцуулан доргиогоод хожиж байхад мөн ч урамтай байжээ. Цаг тун өөрөөр хувирчээ.

Би наймаанд шунаг хорхойгоор донтсон гэлээ гэхэд Далайбуяныг яаж гүйцэх юм бэ? Энэ муу шунал нэвчсэн харийн худалдаачин хэтэрхий эрт дэвэрч, над руу давшилснаас хамаг хэрэг буруутаж, үйл тамаа цайж байна. Уул нь ая зүйг олж чадвал хар тамхи гэдэг чинь хожих хожоогоо бөөн бөөнөөр хайрладаг ид шидтэй эд дээ! Үнэнийг хэлэхэд Далайбуян гуайгаа гурван мянга шахмаар ар зоогоор нь тавьчихсан. Гурван мянган янчаан гэдэг бага биш, их тоо. Зарж үрэхээр зарим үед их биш, бага болчихдогийг ямагт санаж, гурван мянгыг гурван түм болгон өсгөж олбордох аргыг хайх нь худалдаачин хүний урдаа барьдаг ганц чарам хийх арга байхгүй юу.

За тэр ч яахав санаж явбал болно байлгүй. Энэ лайнаас мэнд мултарвал Далайбуянтай дахин эвлэрч ашигтай арилжааг үргэлжлүүлнэ ээ. Гэвч худалдаачны нэрлэснээр хар бурмын



наймааг болгоомжтой хийхгүй бол миний хувь тавилан шинэ цагдаагийн газарт атгагдаж, аюул сүйрэлд унахад бэлхэн...» гэж бодсон Дулдай царай барайлган хөрзийж, хулхи буулган дэмий л, өнгөрсөн тааламжтай явдлаа сөхөн бодож, тэр бүх үйлийн охиор сэтгэл хямран уйтгарлана.

Охин Сайнзаяа, ээжийтэйгээ домботой халуун цай, чанасан тарган мах, гавьжийн дугуй боов авчирч өгөхөд Дулдай ядарч хөшсөн биеэ сул тавин газар лагхийтэл суун тусаж шороон дээр завилж хар цагаан дугуй идэж ууна.

Энэ үед дунд зэргийн насны шөрмөслөг эр магнай дээгүүрх тамирдлын хөлсөө гарын араар шударч, хүрээ өрөөсөн гарт тулгуурдан тэдэн дээр ирж мэндлэв.

Дулдай том хэрчиж үмхсэн махаа төвөн хоолойгоо бүлхэлзүүлэн залгиад,

— За хө, Вандан панзаар сонин сайхан юутай вэ? Чи чинь жаран хараасаа нэгийг нь алдаж орхиод, түүнээ эрж яваа гэлүү? гэхэд Вандан нүүрэн дээр даажигнан шогчилсныг үл анзаарсан шинж гаргаж,

— Та ч тээр жил алдчихсан сохор зоосоо эрж явна уу? гэхэд Дулдай хуурамчаар инээмсэглэх ая үзүүлж, ая тал засан,

— Манай авгайн хийцэлсэн цайнаас ууж, махнаас ид. Ирэх жилийн дөчин есний гайтай гахайны оронд хог малтаж өдөр шөнөгүй хүрээдсэний шан хоёр алга цэврүүтүүлэв шив дээ гэхэд Вандан залирхагаар нүд солбиулан,

— Та бид хоёр шиг нь ч хог болжээ. Хогийг хогоор гээд муухан инээмсэглэж ийш тийш ажигласнаа,

— Цаана чинь нөгөө хогийн шавдуулагч шиншлэн айсуй. Оромдсон болж нүдийг хуурахгүй бол амьдын тамаа нэмүүлж эдэлнэ шүү гэхэд Дулдай суудал өндийн босож хүрээ барьж,

— Өө! өнөөх хувхай цайсан дамшиг байна шүү дээ! гэж шивэгнэнэ. Нэмэх жолоо татаж, эмээл дээрээ сондгой сууж амар мэнд эрэх ялдамд,

— Жаахан шавдуухан хөдлөөрэй. Өчигдрийг бодвол огт гавиагүй байна. Яг л эрүүл хөрсийг гаргуулна гэж мэдээрэй гэж тулган шаардахад барьц алдан зүрхшсэн Дулдай,

— Дулдай гуайгаа харж үзээрэй, хүү минь. Ер нь ийм товцог толгой шиг болсон хогон овоог над мэтийн ядарч доройтсон үгээгүй амьтас үүрээд үүрээд яаж гэтлэх вэ гэж битүүхэн егөөдөж, юу гэх нь бол гэж цагдааг нүүр эгцлэн харав.

— Таны алга цэврүүтэх тусам нударган зодооны хор шар арилж, ухаан сууна гэж Нэмэх ам таглахад уурсан шарлахсан Дулдай хүрээ чанга атгаж угсруулан хүрээдэв. Нэмэхийг цааш одоход Дулдай, Ванданг дуудаж дэргэдээ ирүүлээд,

— Арван тавны цагдаагаас, ардын цагдаа гэдэг ялгаа нь юу байгаа юм бэ. Түргэн хөдлөхгүй бол гар хөлтэй чинь ярина гэж ханхалзаж байна. Бодвол мухарлаж тайрна гэсэн л үг байх даа.

Ер нь энэ алаг эрээн хантааз дээр нь юу гэж бичсэн байдаг бол... гэж сонирхоход,

— Хай, чөтгөр бүү мэд. Бичиг үсэг гаргадаг сан бол унших сан. «Арван тавны цагдаа» гэдгийн оронд «ардын цагдаа» л гэж бичээ биз. Бидэнд юу гэж бичсэн ч падгүй хэрэг гэж Вандан үл тоомсорлоход Дулдай,

— Цаад царай алдмар чинь та нарын овоолсон хог гэж тулгаж байгааг сонсов уу хөөе! Би л Түшээт хааны аймгаас хогоо хормойлон ирж ноёдынхоо нэр алдрыг бузарлаагүй юм даг. Вандан чамайг Дарьгангын хорооноос шуудайд хог түхийлгэн үүрч амбан хааны хороо руу харайлгаж явсан гэвэл хэн ч үнэмшихгүй байх. Ер нь эрт урьдаас ингэж хүрээ хороон дотроо овоолж дагтаршсан бургтийг биднээр нурууг минь хотойтол үүрүүлж тамлана гэж тэр цагт ухаарсан сан бол... цаана! чинь бас нэг тийрэнд хорлуулмар айсуй гэхэд Вандан,

— Нэг чөтгөрийг жинсрэгдэн дарахад, дахиад хэд хэдэн ороолон босдог гэж лам багш айлтгадаг шүү дээ. Аа, Цогоо байна. Хөдөлсөн болохгүй бол горигүй гээд! босов.

— Энэ чинь гар хумхин суудаг газар биш ээ. Бушуухан хөдөлж, олигтойхон ажиллаарай. Вандан таг, бас л жөрх чангаасан хэвээр байна уу? Банд татаж, бажгар уруудуулан, байдгийг хаман өвөрлөж, хожоо мөрийгөөр холиож, нуруу үүрч явдаг цаг өнгөрсөн шүү! Торгууль, албадах ажил хөнгөдөөд байвал хар гэрт нямба хийхээр ухаарах л болно гээд Цогоо хяламдан харахад:

— Цагдаа л бол цагдаа байдаг юм байна. Арван тавны цагдаа та нарт муу нэртэй, луу данстайгаас биш л халхад гэвэл хүрээ Вандан гэдэг чинь хүзүүний мах биш ээ хө! ёстой аавын хүү, алтан шооны нүх гэж мэдээрэй. Яахав мөрийцөгч, панзчин, архичин аль муу муухай үйлтэн бүхнийг би төлөөлж, тэдний өтгөн шингэнийг хормойлох болжээ.

Хэдэн арав, зуу зуун жилээр нөөцөлсөн «үүцнээс» чинь эвдэрхий домбо, цоргогүй данх, зэвэнд идэгдсэн хайчны гуя, хазаарын амгай зуузай, тав мултарсан дөрвөлжин хадаас, хагархай ваар сав, банз шаахай чинь хүртэл гарах юм байна шүү дээ. Харин жаран хар гэвэл ширхгээр байтугай, хэлтэрхийг ч олж харсангүй. Тэгэхээр надад холбогдолгүй хог шиг санагдах юм гээд! Вандан, Дулдай өөд нүд ирмэн ханхалзана.

— Дараагаар цэцэрхэх үг үлдээвэл танд ашигтай байх аа. Хүрээ даяар оволзон хөдөлж байгаа их ажлаас хойш сууж дэг дэглэм эвдэх гэвэл гомдохооргүй гаваг хүртээнэ гэж санаарай гэж Цогоо эрс шууд хэлэв.

Эдэнтэй ширүүлээд сайнаа үзэхгүй гэж бодсон Вандан цэврүүтсэн алгаа байн байн хялам хялам харж зүрхшин халгана.

— Вандан гуай! Та товлож анхаарах хэрэгтэй. Урьдынхаар бол хүний цох цэврүүтүүлдэг байсан, тэгвэл одоо алга чинь цэврүүтэж байна. Энэ ашигтай цэврүү! гэж Цогоо анхааруулаад цааш явж явган сууж хуурай мантуу идэж байгаа хүн дээр очиж,

— Далайбуян гуай, Ядарч байна уу? Албадан хоног дөхөж байна. Сайн ажиллана аа гэв.

— Хай ядрахгүй яах вэ? гээд Далайбуян өврөөсөө «хадмаа» янжуур гаргаж тамхилаад,

— Насан турш ийм ажил хийж үзээгүй болохоор илдүүр ханав бололтой. Та хар даа! Хоёр гарын алганд хатахааргүй хатиг гарав шүү! Хүнд хөлсөлж болох уу? гэж гуйхад хажууд ирсэн цагдаа Нэмэх мушилзан инээмсэглэж,

— Энэ хатдаг хатиг. Тэгэхдээ мөнгө л наадхийг чинь хатаана даа гэж тоглоом шоглоом болгон хэлэхэд Далайбуян залирхагаар нүд ирмэн,

— Бүүр нарийн яривал би энд чинь чимх хог хаяагүй. Амь зуухын эрхээр хорин хэдэн жил худалдаа наймаа хийхэд янжуурын үнсээ хүртэл саванд хийдэг байсан шүү! гэж цэцэрхээд залуу цагдааг араар тавих үг цухуйлгах гэтэл Нэмэх, худалдаачны нууцгай мэхэндээ бардамнаж худал инээхэд дургүйцэж,

— Энэ хогон овооноос зөвхөн өөрийнхөө бургтгийг хумсан толион төдийгөөр ч гэсэн танин ялгаж чадаад, түүнээ зөөж цэвэрлэхийг ардын цагдаа би дуртай зөвшөөрнө гэв.

— Чи юу хэлнээ. Яаж би түүнийг ялгаж таних юм бэ? Цагтаа миний ухаан хоёр тал зоосыг эвлүүлбэл бүтэн болно. Дахиад нэг ижлийг олж нэмбэл хоёр зоостой тэнцэнэ гэдгийг мэдэж байсан. Одоо оюун билэг минь битүүрч, орчлон хорвоогийн жам ёсыг ч ойлгохоо байж, сохор зоос олох аргагүй цагтайгаа учрав шиг байнаа гээд худалдаачин толгой сэгсэрч, мухардсан байдлаар гүн санааширч хүний гар хүрээгүй хүрзээ шүүрч хогноос өнгөцхөн хүрздэх агшинд хожмын нэгэн хорон санаа нь буцлан байв.

#### IV

Нүхэн оромжинд шар эсгийн тасархай сүүжин доороо дэвсэж, ухаан сэхээгүй унтаж байгаа гуч орчим насны бие бялдар булиа эрийг сэрээж уулзсан Нэмэх,

— Нэр хэн бэ?

— Гомбодоо.

— Гэр орон чинь хаана байдаг вэ?

— Хоргоддог орон гэр минь энэ ээ.

—Та ямар амь зуулгаар амьдардаг хүн болж байна?

—Өдөржин мах үүрч, олсон хэдэн зоосоор голоо зогоодог хүн дээ гэж Гомбодоо хуурамчаар хэнэггүй хариулсандаа бантан «Хэрэв энэ цагдаад нүдлэгдвэл гараа гавлуулна гэсэн үг! Ай...» гэж бодоод шүүрс алдахыг цагдаа Нэмэх мэдэвч чухам юу бодож байгааг тааварласангүй ээ.

Цогоо ирж Нэмэхээс учрыг асууж мэдээд «бас нэгэн гэр оронгүй гуйлгачин нэмэгдэж байна уу? Юу ч гэсэн тэтгэн тэнхрүүлэх газар хүргүүлье. Ийм идэр залуу эр гар хөл хөдөлгөхөөр хоолтойгоо залгана» гэж Цогоо, Нэмэхэд хэлэв.

Гомбодоог алдалгүй харуулдаж байсан Дулдай цагдаа нарыг нааш цааш явж энүү тэрүү болж байх хооронд ая эвийг тааруулан сэм уулзаж,

— Чамайг Гомбодоо гэл үү? гэж нүүрмэг асуувал

— Тийм ээ, Гомбодоо. Та юу гэв? гэхэд Дулдай энэрэнгүй царайгаар,

— Цагдаа нарын уран мэхнээс мултарна гэвэл санахын гарз. Чамайг тэтгэх нэрээр хүзүүнд чинь дөнгө сайхан углах гэж байгаа юм. Эдэнд уургалагдмагц мөдхөн хамар чинь сартайж, хамаг бие чинь сарьсална гэсэн үг. Эр хүнд лай тохиолдоход, зай гаргах ёстой. Ийм сайхан эрүүл саруул эрд амь зуух зам урд уулын амнаас уужуухан байх вий. Энэ учир тоймоо алдсан бужигнаан дунд уусан шингэчих. Нохой мордохтой адил ажлын төлөө цагдаа нар сүр бадруулан хөөцөлдөхгүй орхино. Аа харин ах чинь ядуу зүдүү хүнд тус хүргэхийн төлөө төрсөн хүн. Хүнд тусалж яваад л буруудаж, албадан ажил хийж байгаа царай нь энэ. Ахыгаа бараад. Хоол, хувцас байнаа байна. Санаа дүйвэл цэвэрхнээс цэвэрхэн зарц бүсгүй ч бий гэв.

«Ийм догь томоотой хүнийг түшихэд лав газардахгүй байх аа... эсхүл цагдаагийн хэлдэг тэтгэж тэнхрүүлэх газар нь ч очдог хэрэг үү? Ээ горьгүй байх. Энэ хашрын үгийг дагаж азаа туршаад үзье гэж бодсон Гомбодоо,

— Танайхыг би олох болов уу? гэж хэлэхэд Дулдай гараа хөөрөгнийхөө даалин руу шургуулж тэмтчин хоёр хурууны завсар чимхэн гаргаж ирсэн зоосыг Гомбодоогийн алган дээр тавихдаа «Энэ дамшиг чинь арван мөнгийг минь аваад зэсэрчих вий дээ» гэж бодоод амьсгалаа дотогш гүн татаж,

— Хөлсний тэргээр оч. Манай эхнэрт намайг очтол гэснийг хэлээрэй. Ойр зуурын ажил юу эс мундах вэ? Зарц бүсгүйд залуу эр туслахгүй сууна гэж байхгүй байлгүй гээд нүдээ зальтайгаар эргэлдүүлж гэрээ тодорхой заав.

Гомбодоог түргэн түргэн алхаж гудамжны бүлан тойрон далд орохыг ажин харж байсан Дулдай дороо навгасхийн сууж гаанс тамхиа гаргажээ. Тэрбээр тамхиа сорон «байз, байз! ийм булиа эр муугаар эргэж багалзуурдан төхөөрчихөөд бүх л насан турш хурааж хумьсан хөрөнгө хогшлыг минь цөлмөж орхивол яана... эцэг өвгөдөөс үе улиран тахиж шүтсэн бурхан шүтээн минь болгоох байлгүй» гэж санаа засан тайвшрав.

Дулдайн сэтгэлд дахин «бүх л насан турш мэтгэж бодоод олоогүй олбор дээрээ гэн гэнэтхэн ингээд буучихдаг хэрэг үү? Ямар гээч аз вэ? Шарны хүч хүзүүндээ, хүний хүч гартаа байдаг болохоор Гомбодоо надад нас шүд гүйцсэн тэрэгний шар гэсэн үг. Энэ амьд олзоо алдчихгүй байхыг бурхан шүтээндээ даатгая...» гэж бодоод тамхины утааг «фүү» гэж үлээгээд аньсан нүдээ нээхэд Гомбодоо гэрт нь орж явах шиг харагдаад замхран алга болжээ.

## Зургаадугаар бүлэг

### Манааны байранд

#### I

Салхи үлээж, нэвсгэр бараан үүлээр хаяа манасан огторгуй гэнэт харанхуйлан бүрхэж, хүйтэн бороо хувингаар ус цацах адил асгарна. Шөнийн ээлжийн манаанд гарсан цагдаа Нэмэх бараа таваар задгай өрж хураасан банзан хашааны төв дунд өндөрлөн босгосон харуулын байраа эзэгнэн зогсоно. Тэрбээр тал тал тийш сэрэмжлэн харуулдаад доош бууж эргэж тойрон харахдаа нандигнаж хайрладаг буу зэвсгээ норгож зэвэнд нүдүүлчих вий гэж санаа тавин арчилна.

Ус нэвт даасан даавуун цув биеэс хөндийрөн жиндүүлж эхлэв. Үдшийн бүүдгэр гэгээг залгих адил түнэр харанхуй нөмөрч шон модны оройд татуургаар дүүжилсэн шилэн хоргот дэнгийн ёлтолзох гэрэл сүүмэлзэх нь сэжиг төрүүлэн дарамт болох мэт санагдаж бөхөөв. Нэмэх юу юунаас илүү өөрийн соргог хараанд итгэнэ. Хаанаас аюул учирч болох эгзэгтэй нүх сиймхий байдгийг арван хуруу шигээ андахгүй, бас хичнээн хэмжээний багцаанд ямар амьтны дуу чимээ гарахыг ч нүдээр биш, сонсголоор төсөөлж чадах дадлага суужээ.

Тэнгэр хаяалдан сийрч, алсад цахилах зурвас гялбаанд наламгар цув нөмөргөсөн лужир том мануухайн бараан дүрс тодроод замхарна. Чанга чанга ханиалган бие илчлэгч, сэжигтэй этгээд бүртэлзэн дөхөхөд «зогс»! гэж Нэмэх анхааруулаад зогсохгүй болохоор толгой дээгүүр дараа дараагаар хий буудав. Буун дууг юман чинээ санахгүй бүртэлзэн байсан дүрс улам тодроход гурав дахь сумаа биед нь барьж гох дарахад хүний ёолох дуун сонсогджээ.

Буудагдан зугтаагчийн хамсаатан алаг эрээн иштэй хутга мөр талаар амандаа зууж дөрвөн хөллөн гэтэн гэтсээр Нэмэхийн ард хэдхэн алхам ирж амьсгаа даран чагнан зогсоно. Үл ялих чимээгээр буундаа сум хийж зэхэн эргэн харжээ.

Халз тулгарсан биерхэг хүний гарт мэс гялсхийхэд Нэмэх самбаа алдалгүй бие барин гохоо дарав. Буун дуунаар эргүүлийнхэн ирцгээж учрыг мэдэн, орчин хавийг нэгжин магадлавч буудагдсан шархтан байтугай сэжигтэй этгээдийн барааг ч олж харсангүй. Цагдаа Нэмэх харуулын индэрт байранд гарч харуулдан зогсохдоо «Саяын санамсаргүй довтлолтыг дарга итгэх болов уу? Би нүд хараатай зүүдэлж будлиагүйгээ сайн мэдэж байна» гэсэн бодолд хөтлөгдөн сэрэмжлэн чагнаж ажна. Нохдын улих, боргоох, хуцах чимээн дунд дамар, тогшуур модны тог тог торжигнох дуун сонсогдоно. Энэ нь аймаг, дацангийн сан жас буюу худалдаа пүүсний манаач нарын сэрэмжтэй байгааг илтгэж байгаа ажлын нэг арга ажээ.

Намрын тогтуун тунгалаг өглөө үүдээ цэлийтэл нээх адил алтан шар нар мандан гийж, энх амгалангийн мэндээр мишээнэ. Манааны байрнаас хариу мэндэлсэн залуу цагдаа Нэмэх наран сөргүү цацрах шаргал туяан доор сүрлэг сайхан үзэгдэх хайрхан хангайн баруун суга, хөндийн дардан замыг хараа тогтоон харж бодолхийлнэ. «Хүн гэдэг нэг бол алаг эрээн хорвоогийн хар бараан сүүдэрт дайрагдан шаналдаг, эсхүл сүүн цайлган сэтгэлээ дэрвэлзүүлж, зол жаргалын наранд ээж ивээгдэж явах юм даа. Ай даа, хорвоо ертөнцийн жам

аа гэж хязгаар төгсгөлгүй юм. Хуучин цагийн харанхуй манан дунд төөрөлдөж дүүжлүүрт санжиганан байсан хайрт аавыгаа таниагүй шүү. Би өөрөө оргож зайлсны хүчээр дайсны гараас мултарч сайн нөхөр Шимээн, Цогоо нартай тааралдаж тэдний ачаар сайн сайхныг үзэж явна. Гэвч хайрт аав, энэрэлт ээжийгээ эцсийн замд тэгж үдэх муу заяат байжээ. Өмнөх замаа сайн харж, хазгай гишгэлтээ анаж яваарай» гэсэн Цогоо гуайн үгийг цаг үргэлж санаж явъя. Хожим хойно би аавын буурь буурьдах тавилантай. Хөөрхий зайлуул миний аавархдаг ч өдий байх аа. Тэгэхдээ юмыг урьдаас таах бэрх ээ. Сайнзаяатай дэр нийлүүлэн төвхнөж, тооноор угаа уугиулан тогоо тослох юм бол үр хүүхэд заяаж, зол жаргалд умбах л болно доо! Би анх ямар шүү янзын амьтан байлаа. Арван тавны цагдаа болоод шаахайн зодуураар Сайнзаяагаа... түшмэл гуай намайг шүргүүлэн цохиж, будилж байгаа чинь учиртай байна гээд хөмсөг зангидан гар дахь шаахайг угз татан бүлааж яалаа... одоо яах вэ? Ардын цагдаа болж зам мөр минь...» гэж бодсоор дараачийн халаа иртэл ойр тойрноо нүд гүйлгэн хянан харуулдсаар байв.

## II

Харанхуй гудамжинд нохой боргоож хоёр хүн, нэгийгээ сугадан түшиж сэмхэн урагшлахдаа ийнхүү ярилцана.

— Би амжихын даваан дээр золтой л авахуулчихсангүй. Соргог гэж нохойноос илүү новш юм аа. Хоёр зээрдийн хүчинд амь мэнд мултарлаа. Ядаж ганц боодол бараа гартаа оруулж авсан бол ашгай юу? Ингэж амьсгаатай бөөн мах чирч явахын оронд дэнхийтэл бараа үүрээд хээв нэг алхалж явсан бол хийморь золбоотой байх шүү дээ. За гайгүй ээ! Санаандаа тултал ахих өдөр ирэх байлгүй. Аавын шадар түнш байсан Далайбуян гуайтай уулзана. Тэрбээр нэгийг заавал хэлнэ гэж шивэгнэж амьсгалаа дарж ядахад нөгөөх нь

— Жамсранчой! Өөх ч биш, бүлчирхай ч биш гэдгийн үлгэр боллоо. Ёо, ёо. цус их гарч, тамир тэнхээ ч суларч байна. Би нөгөө мантуун хамарт Чойнболын гайхал Нэмэхээс өөр хүн бий гэж бодсон чинь, үгүй нөгөө босоо сэрээ яг мөн шиг байдаг юм. Энэ удаад амь хохироогүй минь дээдийн заяа. Тэр эцгээ дууриавал уу?.. ёстой л бидний эрлэг дээ гээд шүд зуун амьсгаадна.

— Дэчин гуай, бүтээгүй юмны төлөө төвөнгөө бүлхэлзүүлэх дэмий хэрэг. Бушуухан хөдөлж нөгөө маарамба гуайнд очиж шархны түргэн цагаан эм үнэ цохин авч хэрэглэе. Хэрэв гэдэлзвэл амыг нь барьж байгаад аялуулахаа мэднээ гэж сайхан юм бий хэмээн бардамнан ярина.

## III

Хэд хоногийн дараа үл таних маарамба цагдан сэргийлэх газар яаралтай ирж өчин мэдүүлэхдээ,

—Дөрөв хоногийн өмнө шөнө дөл орой болсон хойно танихгүй хоёр хүн орж ирэв. Надаас шархны эм шаардан авч, нэгийнхээ мөрний дээд талын шинэхэн шарханд хийсэн гэжээ.

«Тэр хоёр этгээд маарамбад ийм шархтан явна гэж олонд тарааж, дэмий үг чалчсан байвал

уу...» гэж занан сүрдүүлээд явжээ. Тэр хоёр хэлэхдээ «моринд чиргүүлж үхэх шахлаа гэж хэлсэн боловч мэсний шарх шиг санагдсан. Зүс царайгаа буруулж бид хоёрыг бүү ажигла гэж тушаасан учир...» гэж маарамба гэрчилсэн байна.

Энэ зүүн мөрний шонтгорын доогуур шарх, сорвитой, намхан хүнийг олон хоног эрж олох ажилд цагдаа Нэмэх томилогджээ.

#### IV

Сайнзаяа үдээс өмнө нэг айлд очих хэлэлцээтэй байжээ. Гэтэл аав нь дургүйцэн шазуур зууж,

—Гутал амархан олддог эд биш ээ. Жилд хоёрыг элээж хаяад байвал хөгшин хонины насгүй болсон аав нь олж өгөхөд хэцүү л байх шүү! Түмэн олноос зовохгүй бол... гэж ам хэл таталсан аавынхаа нууцгай үгэнд битүүгээр эгдүүцэн «зуны дэлгэр сайхан цаг шүү дээ. Гуталд боогдож, хөлөө хорих уу?...» гэж бодсон охин, тайлсан хар бүлигаар наамал гутлаа орны хөлд тавихад Дулдай хараад «гадуур алцганан дэмий тэнэхий чинь ганц сайн хорио байх аа» гэж бодоод сэтгэл тайвширна.

«Маргааш ядуу ангийн залуу хүмүүс нэр цуутай нэгэн айлын байшинд цугларна. Тэд нарын дундаас сайн дурыг дагуулан бошгыг халах хувьсгалт залуучуудын эвлэлийн гишүүнд элсүүлэх юм. Чи ороорой гэж найз хүүхний хэлсэн үг үнэн болов уу? Над мэтийг голоод авахгүй байвал...» гэж бодсоор яаран алхахад амбан хааны хороонд хойш харсан том хүрэн хаалга нүднээ тусчээ. Тэрбээр болзсон газраа Нэмэхтэй уулзаж,

—Чи очно биз?

—Очноо гээд Сайнзаяаг элэгсгээр хайрлан харсан Нэмэх,

— Урьд шөнө манаанд зогсож байсан чинь үл мэдэгдэх этгээдүүд халдаж золтой л бөндгөрөө авахуулчихсангүй гэхэд Сайнзаяагийн нүд үргэж цочсон унааны нүд аятай тормолзож,

— Яасан аймаар юм бэ? Ер нь цаашдаа тун анхааралтай байхгүй бол юу ч болж мэднэ. «Чөмөгнөөс хутгаа, нойрноос морио» гэсэн үг бий шүү гэж анхааруулан захиана.

— Үгүй чи яагаад хөл нүцгэн явна вэ? гэж Нэмэхийг хайрлангуй асуухад,

— Аав сэдэв цохисон шиг байна... эв аяыг нь тааруулж хоёр гутлаа барьцаанд... гээд Сайнзаяа мушилзан инээмсэглэжээ.

— Аятайхан арга хэрэглэж ээ! гээд Нэмэх тас тас хөхрөв. Тэр хоёр гудамжны булан тойрон одов. Жижиг дүнзэн байшинд багтаж ядан цугларсан залуус шавиагаа ханатал сэтгэл зүрхний үг яриагаа хүүрнэнэ.

—Одоо шивэр авир яриагаа больё гэх дуунаар тасалгаанд нам жим болов. Ахимаг насны үл таних зузаан бор хүн бошгыг халах эвлэлийн гишүүн байхын ач холбогдол, эвлэлийн гишүүн хүн бусдад юугаар үлгэр жишээч байх талаар таниулан ярьж өгөв.

— Энэ цугларсан үгээгүү ядуу ардын үр хүүхэд та нарын дотор тайж буюу хутагт хувилгаад зэрэг ангийн этгээдийн үр сад байхгүй биз гэж лавлахад нэгэн зэрэг,

— Байхгүй гэж бардам хариулцгаалаа.

— За! тэгвэл монголын хувьсгалт залуучуудын эвлэлийн гишүүнд элсэх хэн хэн байна? гэвэл «би, би» гэж ам өрсөн чанга хэлэхэд хурлын дарга,

— Сайн байна. За нэрээ бичүүл. Чимээгүй гэж захирав. Овог нэрээ дэс дараалан бичүүлэгчийн эхэнд Дулдайн Сайнзаяа, Чойнболын Нэмэх... гээд дэс дараалан бичив. Арван хүнийг гар өргөн баталж, жижиг дөрвөлжин цагаан батлахыг хүн бүрт олгов.

— Үүнийг хүнд үзүүлж үл болно. Амь мэт хадгалж яв гэж захижээ. Нэмэх, Сайнзаяа хоёр эвлэлийн гишүүн болоод баяр хөөр болон гэр гэртээ харьжээ. Дулдай охиноо уур унтуутайгаар угтаж,

— Чи хэл мэдээгүй хаачаад ирэв? гэж эгдүүцэн асуухад Сайнзаяа зориг гарган,

— Би залуучуудын эвлэлийн гишүүнд элсээд ирлээ гэхэд Дулдай эхнэртээ зориуд гоцлон анхааруулж

— Харав уу? хөөе Лхам аа! Дураараа наргих нь ээ. Ядаж олны дунд хөл нүцгэн явдаг, хүний нэр төрийг боддог болоосой!

— Аав танаас айгаад...

— Айсных ч биш, бүдүүн хүзүүлснийх байх аа. Битгий ингэж дүрсгүйтэж бай гэв. «Хориод, хориод үг авахаа болилоо. Хөлд нь төмөр тушаа хийлтэй биш» гэж Дулдай цөхрөнгүй бодно.

«Ямай, ямай. Миний охин нэгийг бодоо биз. Хүнд заавал нэгэн зол заяа байх ёстой» гэж бодсон эх Лхам хайрлан харна. Ам хагарсан дээрээ аавыг туршина гэж бодсон Сайнзаяа,

— Аав аа! Би соёлын сургууль гэдэгт орж бичиг үсэг сурна. Үсээ тайруулж ногоон даавуу цамц өмсөнө, сайхан аа гэхэд Дулдай палсхийж,

— Чи солиорч байна уу? Ийм сайхан гээг үсээ тайрч байдаг эм гэж байдаг юм уу? Оготор шаазгай шиг харагдах нь нүдэнд хүйтэн гэж яав аа! Чи бид хоёр шиг нь бичиг ном сурч, төрийн хэрэгт оролцож, түмэн олонд нэр цуутан болно гэж санааны гарз.

Битгий нэг эх захаа алдаад байгаарай гэж сануулаад хялайн харжээ.

## V

Жил өнгөрлөө. Сайнзаяа жигтэйхэн баяр хөөртэй явдаг болжээ. Үсээ тайруулж, бор ногоон даавуу цамц өмсөж, суран бүс бүслэн шөвгөр хушуутай савхин гутал өмссөн явах нь сэтгэлд ямагт бахдал төрүүлнэ. Эвлэлийн батлах бичгээ эхлээд дотуур цамцны энгэрийн өргөн хажлаганы доогуур хийж оёж хадгалдаг байснаа сүүлдээ цамцанд тусгай халаас оёод түүндээ



хийж явдаг болжээ. Өөрийн үе тэнгийн насны хэд хэдэн залууд учрыг ятган ойлгуулж, эвлэлийн гишүүнд элсүүлсэнд баясана. Нэг нэгэндээ хэл хүргэж, бүх гишүүдийн хурал хийгээд хурлын дараа «Интернационал» гэдэг дуу бүгдээрээ хоолой нийлүүлэн дуулахад Сайнзаяагийн сэтгэл улам ч сэргэж зориг дээр зориг, хүч дээр хүч нэмнэ. Сайнзаяа, хайрт найзтайгаа нүүр учрах болгонд,

— Нэмэх ээ! хэдийд хуралтай вэ? Нөгөө дуугаа чи бүрэн тогтоосон уу? гэхэд Нэмэх,

— Тогтоосон, тэгэхдээ зарим «СССР» үгийг нь хэл хальтраад олигтой хэлж чадахгүй юм аа. Мөн сайхан дуу шүү! гээд хөгжилтэй инээмсэглэнэ. Эвлэлд орсон өдрөөс эхлэн бичиг үсэг сурах сан гэдэг хүсэл өрнөсөн Сайнзаяа соёлын сургуульд оржээ. Тэрбээр намхан цагаан модон вандан ширээний ард сууж хялгасан хошуутай хулсан бийр барьж (нянтай) бэхний саванд нийлнэ.

Нэмэх, манааны байрт бичиг үсэгтэй хүн бүхнээр бичиг заалгаж сурахын төлөө мэрийнэ.

## Долоодугаар бүлэг

### Цагаан гүүний сүү

#### I

Шөнийн эргүүлд гарсан Цогоо, Нэмэх хоёр энэ тэрийг сэжиглэн хүүрнэнэ. Нэмэх,

— Цогоо гуай! Иймэрхүү содон үнэрийг... гэж хэлээд шар эсгийн түлэнхий үнэр хамар цоргих адил яг л тэр үнэр санаанд буулаа гэвэл Цогоо,

— Үнэрч байх явдал цагдаа хүнд илүүдэхгүй. Ер нь энэ хавьд маш нөөцтэй «уурхай» байх шиг байгаа юм. Уурхай илрүүлнэ дээ гээд үнэртэн гэтсээр шавар хэрмэн хашаатай асарлан барьсан том хаалганы өмнө тулан зогсож, сэмхэн орох аргыг хайна. Зуудаг нохойг устгахаас өөр мэхгүй болж бэлдэж зэхсэн, дотроо «хар бурамтай» мантуугаа хаяжээ. Хашаан өөд дүүлэн цоройж байсан даага шиг хар нохой мантууг үнэрлэж байснаа үмхэн хазаж «хар бурмыг» амталмагц үхэтхийн сөхөрч сүүл нь алгуурхан сунаж хоёр нүд нь шаазан адил болов.

Сэжигт байшингийн гэрэл гэнэт унтрав. Тэр хоёр хаалгаа тайлж өгөхгүй болохоор «цагдаа байна» гэв. Энэ чацуу хаалга онгойв. Тэр хоёр орж шүдэнз зурж дэн асааж, «босоцгоогоорой» гэв. Бүхлээр зэрэгцэн хэвтэж байгаа гурван луухаан дуртай дургуй өндийж хэнэггүй царайгаар,

—Юу болсон бэ? яагаад сараалж эвдэв гэж агсам зангаар уурссан боловч цагдаа нарын буу зэвсгийн зангалтанд нэг нь гарт атгасан юмаа алдаж шалан дээр чанхийх чимээтэйгээр унасан нь хурц иртэй заазуур байв.

Өрөөний баруун бүлангийн нааран ханзны хар хилэн аравчийг сөхөхөд жижигхэн хаалга байв. Гурван луухааны гал дээр тос хийсэн адил дүрэлзэж байсан уур омог ус хийж унтраасан түймрийн үнс мэт боллоо. Байшингийн мухрын нууц тасалгаанд бага шиг модон тавганд царцаасан хар тамхи эрийгтэл өрсөн байв. Хар тамхийг хураахад хар царайт луухаан харамсан цухалдахдаа толгойгоо хана мөргөн гэдрэг савж унаад орь дуу болов. Түүнийг хэн ч аргадаж энээ тэрээ болсонгүй. Хэсэг зуур уухилан хэвтэж байгаад босож суулаа.

— Өөрийгөө өөрөө хорсгосон зодуур амт шимт базаахгүй байдаг гэж хууч үг бий. Та дахиад битгий дүрсгүйт гэж хар царайт луухаанд Цогоо сануулав. Давхар өрөөний даавуу унжлагат хаалгыг татаж ороход халуун ханзан дээрх намхан ширээний баруун, зүүн талд бие бие өөд харан хэвтэж буй бүстэй бүсгүй, хоёр хүн, хоёул ижилхэн урт гуулин гаансанд хар тамхи хор хор сорон татаж тэр хоёрын хөлс дааварлан, ухаан санаа түр зуур сэргэх мэт болох боловч нүдэнд харагдах бүх юм бүүдийж зүүрмэглэх агшинд зүүдлэх мэт байжээ.

— Босцгоо! гэсэн дуунаар тэр хоёр давхийн цочин сэрж хөнжилдөө хөлбөрөн сандарцгаажээ. Шаардлагын хүчээр босож ирсэн нөмгөн хүүхэн өөрийгөө «Хандсүрэн» гэв. Тэрбээр хатингар бор царайтай, нуруу туруу гоолиг аятайхан биетэй хүүхэн ажээ.

—Би та нартай хамт явах хэрэг үү гэж Хандсүрэн нүүрмэг асуувал Цогоо,

—Тэгнэ. Түргэн хувцаслаарай гэв.

—Арвинсан гуай! Та бас хамт явна шүү гэж цагдаа, толгой дээгүүрээ хөнжил нөмөрч таг чиг хэвтэгчийг босгов.

## II

«Ноднин жилийг бодвол энэ жил дөрвөн гүүтэй болохоор муу сайн хар тамхичдын хосыг шувтрахаа Вандангийн бор авдар мэднэ ээ. Туул ээжийн «сүүгээр» сүлэгдсэн шүүрхий айргаар өдөрт гурван удаа гургуйдуулаад нэг хүн, нэг янчаанаа гээнээ гэсэн үг» гэж Вандан бодохоос хөх инээд хүрнэ.

Гэр, майхны гадаа зэлтэй хэдэн унаганы дэргэд хүрээ Вандан ханхайн зогсож морин тэрэг айсууг дурандаад «багын танил Хандсүрэн минь чи ирж явдаг маш сайн байна. Сайн хүн санаагаараа...» гэж аман дотроо бувтнаснаа өөрөө ч анзаарсангүй ээ.

—Ёо, ёо, ёо гэдэс дотор базалж сүйд хийх нь ээ. Морь ч морь, тэрэг ч тэрэг, хөлсийг нэмээч гэж нөхөр луухаандаа эр гарган тунирхсан Хандсүрэн хүүхэн морь тэрэгчийн хажуу хавиргыг базалж нүүрийг ширтэн ажиж маасганана.

— ёо, ёо, ёо. Бас л базаллаа гэж баширлан ёолоход луухаан,

— Хай! Хандсүрэн, чи жаахан жаахан тэсваа. Тэрэгчээ! нэг янчаан нэмье. Түргэлж үз гэхэд өрөөсөн гартаа жолоо цулбуураа хумхин атгаж, нөгөө гараар газар руу даялан зааж,

— Та энэ шавар шалбаагийг харж байна уу? Зам их муу байна шүү дээ. Гэвч түргэлье. Одоо юухан байх вэ?! гэж хэлээд шилбүүрээ сурмагаар тас няс хийлгэн дуугаргаж морио гуядан дэргүүлнэ.

«Хандсүрэн ямар хүнтэй ирээ бол» гэж бодсоор дөхөж ойртсон Вандан, Хандсүрэнг зөвхөн хужаатай ирснийг харж баярлахдаа дотор нь мэлсхийж, мэнд амрыг мэдсэний дараа гэрт орохыг урьжээ.

Цай идээний дараа Вандан инээмсэглэсээр,

— Арвинсан гуай! Хэд хонох вэ? Нэг хүн өдөрт нэг янчаан, орон сууц, хоолны үнэ жич авна гэхэд,

— Нэг хүн өдрийн нэг янчаан гэнээ гээд луухаан нүд ихэсгэн харамссан боловч нэгэнт энд ирээд хоосон буцалтай биш, хэд хоноё гэж шийдээд,

— Бид хоёр долоо хононоо гэх үг цухуйлгангуут Вандан,

— Арвинсан гуай! Захих юм байна. Гай болж цагдаа тааралдаж шалгавал, би гэдэс дотрын өвчтэй хүн. Энэ буянтай хүний буянгаар гүүний сүү ууж бие сайжирч байна гэж хэлнэ шүү!

Цагаан гүүний сүү гэдэг чинь олодохгүй оюун эрдэнэ гэж мэдээрэй! «Хар бурам», Үхсэн чийг хоёрын хорыг дарах нь ч амтай юм шүү! гээд Вандан зальтайгаар инээмсэглэх дүр үзүүлнэ.

### III

Намар оройтох тусам хүн хар ирэхээ больжээ. Гүү тавьсан өдрийн шөнө турш найрлаж, мөрийцөн тоглов. Үүрээр сэмхэн орж ирсэн хоёр хүний нэг байцаагч Жав, нөгөө нь цагдаа Нэмэх ажээ.

«За мөн муухай гэнэ алдлаа. Цагдаа нарт ганц бэлэн хоол аягалж өглөө дөө. Мянга гаруй янчаан шүү! Хөсрийн муу луухаан Арвинсангаас л боллоо. Тэр л... Гэвч чиний өврөөс Хандсүрэн хүүхнийг суга татах болсон маань хамгийн их олз. Хэдэн янчаан ямай, бага хэрэг. Дахиад л олох юм чинь» гэж Вандан бодно.

Цагдан сэргийлэхийнхэн, Вандангийн гараар санамсаргүй хийгдсэн хар тамхичдын хорыг анагаах цагаан гүүний сүүний хүчээр хар тамхичдыг зун, намаржин нэр хаягаар нь бүртгэж авчээ. Тэд, ёстой хар тамхины эздэд ариутгалын туулга уулгах ажлаа ямар аргаар эхлэх тухай яриа хөөрөө болж боловсруулан төлөвлөж ажиллах болжээ.

### IV

Намрын хонгор шар наран уулын оройгоор далд орон нуугдаж, шөнөжин шивэрсэн хүйтэн бороо үүрээр гийв. Ширүүн салхинд хөөгдсөн бараан үүлс нүүгэлтэн хуйларч хойш, урагш нүүнэ. Навчис унан нүцгэрч байгаа модны мөчирт бялзуухай хоргодон суух нь хатуу хайруу цаг ирж байгааг зөгнөх ажээ. Эртэлж боссон эр эм хоёр далан давхрыг чиглэн хойно урдаа орж алхсаар, гүдгэр далангийн бэл рүү буусан зэргэл саарал манан дотор орж алга болжээ.

— Хандсүрэн минь больж үзээч! Учраа ярилцъя гэж аядуу хэлээд араас мөр даран ойртож яваа нөхөрөө зог тусан эргэж харсан оворжиж буй идэрхэн хүүхэн олсны тасархай нугалж атгасан гараа улам чанга атгаж,

— Вандан гуай, Вандан гуай! гэхээр Вандан ширээн дээр байнга шажигнаж байдаг даалууныхаа вандан дөрөв шиг өөрийгөө төвийлгөж байна уу? Чи юу, юу гэнээ. Санасан газраараа сажлах миний дур гэнэ үү? Чи хаагуур янхантаж яваад ирэв гэнэ үү? Аяга цай хоол бушуу хий. Бид хэд хэцүүдлээ. Хөсрий жингэр минь шалавлаач гэж нүд үзүүрлэнэ гэнээ. Чи өөрөө юу бүтээж суугаа гударга вэ? Хамаг гэр орноо нохой гахайн хэвтэр шиг болгочихоод сууж байдаг чинь сайхан уу? Орон гэрт чинь ойтой амьтан шагайх аргагүйг мэддэг болоосой. Тамхины манарсан суунаг хөх утаан дунд хүүе хааяыг мэдэхээ больсон, улцайж улаан нүдэлсэн даалуучингийн дунд эргүү мал шиг эргүүтээд сууж байна гэж бодож байна уу? Гай нь таараагүй бол гайгүй байлгүй. Гал тогооны хүний толгойг өрхийн тэргүүлэгч эр нөхөр нь мэддэг муугийн зан биш, монголын жам гэж цэцэрхэнэ гэнээ. Хэт галзуураад байвал мөчий чинь тас цохиод суулгаж орхино шүү гээд орны хөл руу унан тустал түлхэл үү чи! яагаад халуун банш үмхчихсэн юм шиг хацар түмийлгэн гөлөлзөөд байх хэрэг юу байна. Эмэгтэйчүүдийг дарладаг цаг чинь өнгөрсөн гэж мэдээрэй. Ажил төрөл амь зуултаа даалуунд шингээж шимтэнэ нээ. Чамайг цагдан сэргийлэх лав мэдсэн дээ. Хүнд амьдрал хэрэггүй болсон хойно, амь хэрэггүй. Би боож үхээд нүднээс чинь далд орьё гээд цааш

ухасхийхэд Вандан элдэн хөөж, барьж авах шахан, арай гүйцэхгүй хөөсөөр л ажээ.

Морьт эргүүлийн цагдаа Нэмэхийн хорин дөрвөн цагийн эргүүл шалгалтын ажил амгалан тайван өнгөрч, дараагийн ээлжийн хүнд «тайван хоносон» гэдэг хоёрхон үг батлан хэлэх цаг дөхсөн байв. Тэрбээр «зах зайдуу газраар эргээд буухад яг таарна» гэж бодоод гүвээн дээр гарч мориноос буужээ. Өрөөсөн нүдний сунаг дурангийн нь хараанд тольдогдсон, манан дотроос гарч ирсэн сэжигтэй хүнийг Нэмэх амдан очиж уулзвал нэр цуутай мөрийцөн тоглогч хүрээ Вандан байжээ. Тэрбээр мэндийн дараа залгаж хэлэх гэсэн үгээ амьсгалын түрэлтэнд алдаж орхиод дахин цэнэн анаж,

— Эхнэр бид хоёр тун үл ялих юмнаас марган ам муруйлцсан юм. Тэгсэн тэр маань олсны тасархай бариад гүйхээр нь би хойноос нь хөөгөөд гүйцсэнгүй. Ээ бүү үзэгд. Муу ёрд даллагдсан түүнийг чөтгөр ч хөөгөөд гүйцээ гэж үү? Ууртай ч гэсэн ухаантай хүн юм сан. Оёдлын ажил гээч нэг юманд (ажилд) орсноос хойш ааш зан нь эвдэрчихсэн хүн. Ямар гээч шулмас тийрэн хорлочихдог юм бол оо? Өдийд уурын мунхгаар бурхан болчихоод ч байгаа бил үү? Ай хөөрхий, хорвоод тийм эхнэр надад дахин яагаад ч заяахгүй юм шүү! Цагдаа та! тус хүргэж үзээч гээд ганц хоёрхон нулимс бөмбөрүүлэхэд, «Вандан гуай, яаж тамлагдаж, баярлаж байсан ч ингэж нулимс унагаа болов уу...» гэж бодохоос түргэлье гэдэг бодол цагдаа Нэмэхэд зурсхийн буужээ.

— Вандан гуай, Та миний ард сундална уу? Түргэхэн явж олъё гэв. Дөрөөтэй, дөрөөгүй дөрвөн хөлөөр хүч нэмэн давирахад янхигар бор морь сүүл хөдөлгөн хашигнана. Нэмэх эхлэн үг өдөж,

— Би хэдий нас залуу ч, хоёр төрийн нүүр үзэж хоёуланд нь цагдаагийн ажил хийж явна. Тэгэхэд өөрөө өөрийнхөө учрыг олно гэж яваа хүн үзээ ч үгүй, сонсоо ч үгүй юм. Авгай чинь танд л амь насандаа хүртэл гомдож дээ? гэж огцом асуухад, Вандан барьц алдан тэвдэсхийж,

— Манайх эцэг өвгөдийн үеэс дошгин шүтээнтэй айл. Эхнэр бид хоёрын хийсэн нүгэл хэтрэхээр бурхан хилэгнэсэн болов уу гэж санана. Би ч бас хуучин шинэ хоёр төрд элдвийг үзэж, шинэ төрийн анхны ажилд алгаа цэврүүтүүлж явсныг чи мэднэ шүү дээ? гэж энгийн цайлган маягаар хэлэв.

—Вандан гуай! Нүгэл олон янз байдаг байх аа. Гэвч таны зовхи улцайсан нүд урьд шөнө ёстой хар нүгэл хийснийг гэрчлэн хэлэх мэт бодогдож байна гэж Нэмэх тулган туршихад хүрээ Вандан дуу хурааж зовонгуйрчээ. «Энэ чинь санаа нь өтөлсөн гайхал юм. Шөнөжингөө даалуудсан гэж яг мэджээ. Хамаг хэрэг Хандсүрэнгээс болох нь байна. Хэрэггүй энэ дамшигт сархигныхаа баасыг тоочлоо. Хэл аманд орооцолдон хэрэг өдөгдөх шиг боллоо. Одоо баригдвал алга байтугай бүх бие цэврүүтнэ» гэж хардан бодсоор явж тэр хоёр намхан толгой дээр гарч харжээ. Нэмэх тэртээ жалгад бүртэлзэн торойж буй хүний дүрсийг олж үзжээ.

Хандсүрэн гишгэж өнгөрсөн улбаагаа санахаас дотор палхийж, сэтгэл өвдөж, зүрх шимширнэ «...ид шид., ил далдын эзэд, бурхан шүтээний аврал, хүчин чадлын ачаар хүн бүхэн буурал хорвоогиин жаргал, зовлон дунд хутгалдан амьдрах ёстой гэж үү?-. Би л гэж балчир багаар хатуу ширүүн үрэлтэнд дайрагдан гэнэдэж арчаагаа алдсан амьтан байжээ. Одоо өнгөрсөн үеийн гунигт явдлыг дурсан санахаас бөөлжис цутгаж дотор дээр бөөн хар юм горойхыг яана.

Хүнд алтаар цуггасан зүрх заяадаггүй болохоор миний эндэгдэн осолдсон минь буруутай юу? Буруугүй ч байсан байж магадгүй.

Энэ цагийн сайхантай тийм идэр залуудаа золгосон бол мөн ч ихийг үзэж, сайн сайхан бүхнийг хүртэх байжээ. Ай хөөрхий юутай гуниг, юутай хачин цаг үе байгаа вэ.

Вандантай нийлсэн чинь хогийн хар даалуучин болсон байсныг даанч мэдсэнгүй дээ! Одоо яая гэхэв. Хэдэн жилийн өмнө зуны сайхан зугаатай өдөр байж билээ.

Тэгэхэд багын танил Вандан маань цэл залуугийн ойворгон араншин ор мөргүй арилж, намба төрхтэй ид тогтонги насны эр харагдаж билээ. Вандан жавхаа сүрийн оргил шингээсэн том алаг нүдний түвшин дөлгөөн харцаар сэтгэл үнэнийг товгой хэлэх мэт нүүр учран золгоход би элээ халаг болон хормойдсон шүү дээ! Бас л дэмий юм хийж дээ. Хүүеэ өнөөх улигт „гайхал гараад ирэв үү?...» гэж уулгалж, бүлшны мааньг ёдрын модноос олсны нэг үзүүрийг урхидан, нөгөө үзүүрээр хоолой боох хуурмаг маяг үзүүлэн хэвтэж байхыг Вандан харж дуу алдан тэвэрч,

— Иш Хандсүрэн минь ингэх гэж байх уу? Энэ нойтон хамуут толгойн буруу гээд алгаараа алгуурхан духаа илж ширтэхэд «хүний янз үзэж туршиж байна» гэж бодогдож билээ. Ингээд би цааш зугтаж, үнэхээр ч үхчихье гэж бодсон. Гэтэл...

— Ёо, ёо, юу болов гээд зовуурьтай дуугарсан эхнэрийнхээ мөрөн дээр гар тавьсан Вандан,

— Ашгүй шинэ төрийн сүлд ивээж, цагдаа бид хоёрыг нүд ирмэх зуур нүүр учруулсны ачаар дагина шиг царайг чинь дахин харлаа гэхийг сонссон Хандсүрэн дотуур хилэгнэн уурлаж, «Дагина болдог нь ч юу билээ?! Энэ завхарч лойсон даалуучинг мөрнөөс дээш хэтэрхий авируулбал бие эрхтэн халхалдаг хувцсыг минь ч мөрийд өгөөд шувтрах хүний үнэргүй амьтан. Ашгүй чи цагдаа элдээд ирдэг сайн хэрэг. Чи өөрөө өөрийнхөө биед шингэж ууссан зэсийг хөөрөгдөн цухуйлгах гэсэнтэй утга адил. За тэгвэл чамайг хулихыг чинь буулгах арга оллоо» гэж Хандсүрэн хорсон бодож,

— Даалуучаан! нөгөөдүүл чинь гэтэл Вандан үгийг тас дайран угтуулж,

— Хандсүрэн минь ингэж үг хэл татлаад юу хийнэ вэ? Нойргүй хоносон энэ цагдаа залууг хайрлаж үзээч! Үүнээс хойш би чиний үгэнд орж юу гэвэл заагаар шувтарч байя хэмээн баруун гар өргөн наманчлахад цагдаа Нэмэх,

— Дахиад ингэж уршиг бүү удаж байгаарай. Гэртээ харьж ажил төрлөө бодоцгоо гэв.

## V

Вандангийн гэрт хоцорсон мөрийцөн наадагчид булхайцан хэрүүл маргаан үүсгэж, зарим нь нударга буулгаж нэгийнхээ хөмсгийг шалав цохиж, эд хогшил элдвийг ундуй сундуй болгож, жаран хараа ор дэрний онгорхой хөндий, авдар савны зай завсарт цацлан хаясан байжээ.

Эв зүйгээ ололцсон эр эм хоёр эргэж ирээд юм хумыг өөд татаж, тэднийг эвлэрүүлэх

санаатай цай хоол хийж байтал цагдаа Нэмэх байцаагчийн хамт ирж бүгдийн мэндийг мэдэн суулаа. Тэрбээр үг дуугүй сэм ажиглаж байснаа,

— За! хэн хэн юу юугаар мөрийцөн тоглосон үнэнээ нуулгүй хэлцгээ! Гэм бурууг дарвал эцсийн шийтгэл хүртэнэ гэж мэдээрэй гэж тулган асуувал бие биеэ гайхан харж тээнэгэлзэн байх агшинд Вандан мөр хавчин сүрхий гайхах дүр үзүүлж,

—Эхнэр бид хоёрыг хээр будилж явах хойгуур эд ирцгээж, балга тагш юм хувааж балгаад зургаан хүний тавил мавил гээд ярилцаж байсан гэж дүйвүүлэхэд Нэмэх босож, зуухны хавиас хоёр даалуу, орны хөндийгөөс лууг зоос нэгийг олж бариад,

Битгий хөдөл! Нэгжлэг хийнэ гэсэн байцаагчийн үгийг сонссон мөрийцөгчийн нэг,

— Гэмт хэрэг хийгээгүй байхад дур зоргоор нэгжинэ гэдэг чинь... гээд цээж мурын ханхалзахад,

— Та томоотойхон байгаарай. Хожим хойно дэвж, дэлсэн ч цаг хугацаа олдох байлгүй гэж Нэмэх ёжин хэлээд шууд нэгжиж эхэлжээ. Хүрэн суман даалуу, мөнгөн зоос, мөнгөн хэт хутга, алтан бөгж, чулуун соруултай гаанс, сувдан даруулга, жижиг тойгон ембүү, мөнгөн аяга, соёо цохилуур зэрэг зүйлийг илрүүлэн хумьж тавьжээ. Мөрийцөгчид аман дотроо «чамаас боллоо, чиний л буруу» гэж бувтнаж бие биеэ хялалзах агшинд нүд ирмэлцэн дохилцож залуу цагдааг араар тавихыг хичээнэ. Мөрийцөн тоглодог хэсэг этгээд илрүүлэн барьснаа цагдаа Нэмэх үүрэгт ажлын минь нэг гэж бодсоор ажил дээрээ иржээ.

# Наймдугаар бүлэг

## Нууц зоорь

### I

Далайбуян дэг дуг нойртой хонож, эртлэн босоод буурал суусан шингэн сахлаа имрэн оролдож, намхан ширээн дээрх толинд тольдов. Гялаан хуйхтай гозгор толгойн цэлхгэр зовхит бүлцэн нүдэлсэн царай зүсээ хараад бие агзасхийж, амьсгаа давхцах шиг болжээ. Худалдаачин хананд өлгөөтэй хүрэн зандан жаазтай гэрэл зураг тийш хараа шилжүүлж ажихад тэр зураг амилах шиг санагдана. «Махлаг цагаан царайд уруул эмжсэн ширвээ хар сахалтай, нууц увидсыг далдалсан овжин сэргэлэн харцат залуу эр нүүр дүүрэн баясгалантай инээмсэглэж нүд онийлгох нь залуу цагт та өөрөө шүү дээ» гэж хэлэх шиг бодогджээ. Тийнхүү сэтгэл хөндсөн эзэн нааш цааш холхин дотоод өрөөнөө орж хаалга түгжээд,

— Тийм ээ! Би өөрөө яг мөн. Харь нутагт ирж суурьшсан хоёр дахь жил авахуулсан зураг. Тэр цагт хорин долоон настай, юу санавал бүгд бүтдэг хийморь золбоотой явжээ. Далайд дусаал нэмэр гэдэг ёстой үнэн. Цэн пун мөнгө гэдэг чинь... эд хөрөнгийн эхний дээжийг дээжилснээс хойш гучин хэдэн хавар өнгөрчээ. Анхны тэр урьхан хавар адил миний үйлс дандаа далгин дэлгэрч, нууц зоорь минь хожоо ашгийн мөнгөөр байн байн дүүрч, мөн ч төгс сайхан, дутах гуцах юмгүй жаргалтай байж хөөрхий! Гэтэл энэ шинэ төрийн дэглэм горим тогтож хэдхэн жилийн дотор шинэ хоршоо, шинэ мөнгө хүртэл буй болдог байна шүү! Намайг үхэл багалзуурдаж яах учраа олохгүйд хүргэлээ. Сэтгэл санаанд буусан ганц ухаан Да Хүрээний бүх пүүс, худалдааны эзэдтэй сэмхэн яриа дүйж, бараа таваарын үнийг нэгэн зэрэг буулгана гэдэг хамгийн зөв, мэргэн арга олов. Ингэснээр шинэ хоршоог цохиж унагаах, нэгэнт гарт орсон мөнгө зоос янчааныг буцааж гаргахгүй нууц зооринд хурааж чадвал шинэ төрийн эздийг багалзуурдаж амаар шороо үмхүүлэхэд хүргэж байгаа нь тэр. Миний эчнээ бодол эцсийн завшаанд хүргэхдээ хүргэнэ. Шуудайтай арвайн гурил доторхи хүүдийтэй хар тамхиа хил нэвтрүүлж мөнгө өвөрлөөд зогсохгүй, хормойлж байлаа. Мөрийтэй тогпоом олон газар гаргаж аяа мөн ч их олз ашиг олдог байжээ. Тэгээд яалаа! цагдаа нар салхи авч шиншилж байж бариад, миний гарыг мухарласан шүү! Энэ цагдаа нар илбэтэй. Эд илбэтэй байхад би бас илбэтэй байж болноо. Эцсийн удаа илбийн ухаанаа зарна даа! Түшмэлийн хүүгийн гараар могой бариуля. Түүний эцгийг мөнгөөр худалдан авч болсон юм чинь... Ажил бүтсэний дараа сэжиглэгдвэл хатуу цагаан нунтгаас зохих тунгаар өгөхөд үүрд сэрэхгүй нойрсоно. Жижигхэн мөртлөө хамгийн ээлтэй, нууц зоорь минь үнэт янчаан, мөнгөн зоосоор дүүрэн дээ. Ардын хоршооныхон манай худалдаа пүүснээс бараа, мөнгө зээлдэхгүй хаана нохой унаж гарах вэ? Ингэж нүхэнд түлхэн унагааж чадвал миний хүсэл гүйцнэ гэж Далайбуян өөрөө өөртөө шивнээд хаалганы түгжээ огцом мулталж эргэн сууж бичээч Арвинсанг орж ирэхэд худалдаачин нүүр эгцлэн харалгүй,

—Худалдаа, лангууг бушуу онгойлгож, бараагаа дахиад хямдруул гэж ихэмсгээр зөвлөөд гартаа зугаа болгон эргүүлж буй хоёр жижиг зааны ясан бөмбөлгийг эргүүлэн зугаацна.

Худалдаа пүүснүүд үнийг нэгэн зэрэг хямдруулсан барааг лангуу тавиур дүүргэн өрж, худалдагч, бичээч нар хүн хүний өмнө өнгө үзэмж, яс чанарыг магтан сайшааж,



—Манай пүүсний торго, дурдан, чисчүү, минчүү, шандан даавуу нарийн бүдүүн даалимба хоргой, хошоо мяндас жуушаан цай, дүнс, янжуур ёоз ёозоор овоолгоостой байна. Ямрыг авбал ав баа гэж дур сонгож

— Үнэ хичнээн хямдхан, санаа байвал өртөг өг. дүйж ч болно хэмээн уян хатнаар ятгаж шунаг харцаар хуурмаг анивчин мишээж хүзүү сунгана.

Далайбуяны пүүснээ орж ирсэн залуухан бүсгүй Сайнзаяа, дээлийн эмжээр орой ам хоргойг сонирхон үнийг асуухад худалдагч,

—Хай! хямдхаан өгнө. Хоёр хацар дээр нэг нэг үнсүүваа гэхэд ичингүйрэн нүүр буруулсан бүсгүйн сэтгэлд зэвүүцэл төрж өврөөс түрийвч гарган аравтын дэвсгэр авч;

—Та манай энэ шинэ мөнгийг үнсвэл үнс, төгрөг гэдэг юм. Гэвч би энэ мөнгөнд илүү хайртай учраас бариулах хүсэлгүй байна гэж цаашлуулан ёжиж намжирдахад худалдагч,

—Мөнгө хичнээн үнэтэй ч чиний царайг яаж гүйцнээ гээд жалхгүй болсон жартгай нүдээ анивалзуулан горилоход бүсгүй бадран оволзох уураа барьж ядан хуурамчаар инээмсэглэсэн болж,

—Баян пүүсний худалдаачин харц ядуу борчуултай наймаа хийх дургүй байдаг нь аргагүй ээ! Ард хүн ардын хоршоонд очъё доо, тэнд шинэ бараа, сонин содон юм их бий гэнэлээ. Үнэ цэнэ ч хямдхан гэнэлээ гээд гарч одов.

Арвинсан бараа өрсөн тавиурын ард гиюүрэн хольхиж уйдан байтал худалдаачин эзэн орж ирээд, зуу хүрэхгүй хэдэн шинэ дэвсгэртийг хэд дахин тоолж царай бөрцийлгөн нүд анивчиж,

—Ердөө энэ хэдхэн төгрөгийн бараа зарсан хэрэг үү?

—Тийм!

—Барааны үнийг дахиад хямдруул! Ардын хоршоонд очиж ардууд барааг хэрхэн яаж худалдан авч байгааг нүдээр үзнээ гээд эргэн гарах гэтэл хаалга дээр Жамсранчой халз тулгарчээ,

— Миний сүй билэгт хүүхэн Сайнзаяа суудлын хөнгөн тэргээр одоохон ирнэ. Тантай сайн танилцуулах далимд дээлийн торго авч өгье гэж бодож байна. Торго зээл өгнө шүү гэсэн Жамсранчойн үгийг сонссон Далайбуян хэтийн нэгэн зүйл бодож,

—Түнш чамдаа бараа, бас хүүгүй мөнгө зээлүүлж болохгүй яах вэ? гэж хожим хожих бодолдоо хөтлөгдөн тал засав.

Сайнзаяа аргалан хоцорч орондоо зарц бүсгүй Гүнчинг явуулжээ. Морин тэрэгтэй хүн ирж явахыг харсан Далайбуян Жамсранчой хоёр угтан очиж, бүсгүйг таньж сэтгэл хэртхийн гонсойж буцаан хөөжээ.

Худалдаачин энэ завшааныг ашиглан дараа уулзахаар Жамсранчойн чихэнд товтой хэдэн үг

сэм хэлээд салав.

Анхны хоршоонд хүмүүс пиг дүүрч, бараа таваар тасралтгүй худалдан авна. Цагдаа Нэмэх, Сайнзаяад бэлэглэх дээлийн торгон дээр буухаар зориглон, олны дундуур шахалдан ахисаар лангуунд тулж зогсоод,

— Тэр хар хөх торгыг аваад өгөөч! Ямар үнэтэй юм бэ? гэхэд худалдагч торгыг үзүүлэх зуураа,

— Орой ам нь... төгрөг, хуйлаагаар авах уу? гэвэл Нэмэх,

— Одоохондоо бөхөл толгой торгон дээр буух бэнчин хүрэхгүй. Нэг дээлийнхийг авья гэв.

Далайбуян, бичээч Арвинсанг дагуулан ирж олны дунд нааш цааш эргэлдэн, гархилсан өлөн нүдээр хялан хялан харж «Энэ шинэ хоршоо пүүс яасан их адтай байна вэ? Зарж байгаа бараан дотор нь Содномдоржийн пүүснээс хураасан бараа зүсээрээ байна. Энд ирэхээр ингэж түргэн зарагддаг ямар учир байна вэ?! Миний муу пүүс ч авсанд орж гүйцжээ» гэж амь тэмцэн бахардаж духанд дааварласан хөлсөө гарын алгаар дарлан, бичээч өөдөө сэм дохиж дагуулан түүнийг нэгтээ зарахаар шивнэлдэн яаралтай явуулжээ.

Хаврын хуйсганасан орой өргөн чөлөөнд хөл хөдөлгөөн татарсан байв. Пүүсний их хаалга хавьцаа саравчнаас дүүжилсэн шилэн хоргот гэрэл ёлтойн сүүмэлзэнэ.

Бэлтгэл нууц хаалгаар орж ирсэн зочноо тосож хүлээн авсан бичээч Арвинсан, данжаадын байранд оруулж мэнд мэдэлцэв. Намхан ханзны голд зассан гар зандан ширээний баруун талд нь зочин нутгийн заншил даган өвдөг нугалан сууна.

Бичээч, тогооч нар гүйлдэн, янз янзын үнэртэй амтлаг зууш таваг тавганд хийж өрөөд хатуу дарсны бөглөө авч тавив.

Далайбуян зочноо ууж идэхийг шаардаж, шилэн аяга адил нимгэн, хээ хуар гоёмсог шаазантай архийг зөвхөн дээш өргөн ёсорхоод,

— Танай аав мөн ч сайн хүн байж билээ. Бид хоёр бүүр эртний түнш улс шүү дээ! Аавыг чинь санахаар чамайг дандаа хайрлаж явдаг. Тэр цагт хүүтэй зээлүүлсэн мөнгө одоо эх хүүгийн хамт яг мянган лан болоод байгаа ч үүнд сэтгэл зовох хэрэггүй. Энэ дансны тооцоо! гээд даршмал ногооноос савхдах ядан өгүүлэхэд зочны царай хувьсхийж,

— Далайбуян гуай! Та мянган тоогоор миний хоолойг зуу дахин ороож боох санаатай байгаа юм биш биз? Тэгж ярих дээр тулбал зөрүү холын зай нь танай нутгаас манай нутагт хүрэх замын уртаас хальж магадгүй байх шүү! Ер нь тэгээд манай шинэ төгрөгөөр бодвол мянган янчаанд чухам хэдэн төгрөг авах гэж бодож байна. Би төлнөө, төлнө гэж зочин ам бардам хэлээд аягатайгаа балгаж, эгцлэн харахад Далайбуян дотуураа бэмбэгнэвч гаднаа зальжин зан хэвээр,

— Хай таньсан ах дүү нар тийм ёоз муутай хатуу үгээр юу хийнээ. Нэгэн нууц яриа байна.

Хэрвээ бид хоёр үг санаа дүйж тохирвол би гомдоохгүй их шан хүртээнэ шүү! гээд уруулаа шазав татав хийлгэн ярвайлгахад тамхины утаанд шарласан шүд, нүүрний хөдөлгөөн зочинд тааламж муутай харагдаж аягуйрхэх байдлаар

— Таны саяны үг миний зүрхийг зүүгээр шивэх мэт санагдлаа. Гэвч эрхэм худалдаачин гуай! Та чухам юу хэлэх гэсэн юм бэ? гээд эргэлзэн харвал худалдаачин,

— ...Чадах уу? гээд мушилзах дур үзүүлэх нь шүдээ зууж, хөмсөг зангидан хилэгнэх адил байв.

— Чаднаа, бүрэн чадна. Харин миний амь хохирвол хохь болж хог дээр хаягдана гэсэн үг үү? гэсэн Жамсранчойн үгийг таашаасан худалдаачин Далайбуян,

— Их сайн байна. Та бол амь биеэ хамгаалж чадах сэргэлэн зоригтой эр учраас хэзээ ч сэтгэл бардам байх болно. Бүх юм бүтнэ гэдэгт итгэ гэж хоосон магтаж сайрхана.

— Данжаад гуай! та ухаан оюун далай мэт уудам байтал миний амь насыг арай хямд үнэлж байх шиг. Юу ч гэсэн дэнчин барьцааг сонсьё гэвэл Далайбуян төвөн хоолойг бүлхэлзүүлэн хэсэг дуугуй сууснаа,

— Хай! манай түншийн хүү Жамсранчой! чи ёстой баатар зоригтой. Чамайг хэр баргийн мэс ч мохоож няцаахгүй. Бид хоёрын яриа ингээд яг таг шийдэх шив. Хэлэлцээт шөнө манай нууц хаалга аяархан нам гүм онгойно гээд босов.

Данжаад өрөөний буланд тавьсан цагаан модон авдрын таг сөхөж гар шургуулан жижиг хөмөн богцтой хүнд юм дааж ядан гаргаж ирээд,

— Жаахан цул мөнгө, хэдэн янчаан. Битгий чамлаарай! Юм бүтээсний дараа хэдэн цэн алт нэмж шагнана гээд давхар өрөөний баруун хатавчны новшин дундаас эсгий гутлын толгой гарган дотроос нь жижиг буу, сум авч нүдээ бүлтэлзүүлэн хялам хялам харж,

— Энэ авсаархан эд танд хэрэг болох уу? гэж сорингуй асуухад зочин шанаа маажин,

— Одоогоор буу зэвсэг хэрэггүй. Хэрэглэх цаг тохиолдвол... гэж шууд цааргалахад Далайбуян барьц алдан гайхаж,

— Тэгвэл яах вэ? гэж амандаа дурамжхан бувтнаад, сэтгэлд буусан сэвээ арилгах гэж хундагатай архиа авч балгахдаа асгаснаа ч анзаарсангүй ээ.

Жамсранчой, лонхтой дарснаас дараа дараагаар хэд дахин хундагалан ганц ганц амьсгаагаар хөнтөрч огцом босож, данжаадын дэнчин болгосон юмыг өрөөсөн гараар мөрөн дээр тохож үүд рүү эргэхдээ,

—Далайбуян гуай! та юм бүтээгүй байхад ийм их шан хайрлаж байгаа чинь дэндүү итгэж байгаа юм шүү?... гэж тал зассан мөртөө хүйтнээр инээмсэглэхийг худалдаачин ажжээ.

«Хэрэв явдал үйл бүтэмжгүй болоход хүрвэл яанаа! за яахав. галзуу араатан шиг мөртөө мал

шиг мангар шүү дээ! тэгэхээр учрыг олж болохгүй яах вэ» гэж хар хороор буцалсан санаагаа тайвшруулан засах гэж хоёр гараа элгэндээ тэвэрч нахис нахисхийн,

— Хай! Зоригт эр Жамсранчой! Чиний ажил үйлс өлзийтэй бүтэх болтугай гэж хуурмаг ерөөнө.

Жамсранчой, бичээч Арвинсангаар үдүүлэн гарч пад харанхуй гудамжинд замхрах адил алга болов. Эрт урь орсон тэр нэгэн хаврын шөнө Дарьганга, Сэцэн хааны хороонд хоёр хэсэг газар галын аюул зэрэг гарч өрвөлзөх дөлнөөс дээш хар утаа бургилж ухаа улбар гэрлийн туяанд хавь ойрын гэр хашаа гэрэлтэнэ. Эргүүлийн цагдаа нар галын аюулын дохио болгож хэд дахин хий буудаж, тэр зүг яаран очихоор түргэлж харагдана. Айлын гадаа үхэр тэргэнд ачаатай өвс, саравчинд хураасан нуруу өвс, хашааны хамт шатжээ. Усан хөөрөгний ганц хоёрхон машины хажуугаар бэржээнт хувцастай гуулин малгайт эрс, дөрвөн дугуйт морин тэргэн дээр байрлуулсан гар хийт усан хөөрөг, том том модон гантай усны хажууд зэрэгцэн сууцгаана. Жолоо барих эр гуравлаж хөллөсөн морьдоо зүрх хөөрөнгүй исгэрч давхиулахад дугаа модонд дүүжилсэн хонхнууд хоржигнон гудамж зээлийн ноход сүүл хавчин хойно урд орж хуцан гүйлдэнэ.

Яг энэ мөчид хоёр хүн хашаа буландаж нэг нь нөгөөдөө,

-Би эндээс харуулдан сэргийлнэ. Чи цоожий нь эвдэж, ороход бэлэн болгоод баруун тийш эргэж арав алхаад намайг хүлээ. Би морь тэрэгчийг аваад очно гээд одов. Ийш тийш сэрэмжлэн гэтсээр ардын хоршооны арын хаалганд тулж зогссон мөнөөх эр, үзүүр талыг дөрвөлжлөн нарийсгасан богино төмөр гадсаа бүснээс авч бариад, цоож бэхлэвч төмрийн битүү гогцоонд давхар шургуулан хөшин эргүүлж туршина. Тэрбээр багажаа дахин авч зөвхөн бэхлэвчийг гогцоонд хийж, гадасны бариулаа хоёр гардан шүд зуун эргүүлж татахад байрандаа хий эргээд сугарсангүй ээ. “Муу бяслаг шиг төмрийг битгий хэл, баян түвд худалдаачны мундаг бэх болд цоожийг ганц мушгиад л болгодогсон» гэж аман дотроо үглээд тэмтрэн цоожийг өргөж нүд тулгаж ажсанаа «жигжигхэн төмөр хөх өвгөн манаач шөрмөстэй байнаа. Би ардын хоршооны олон мянган төгрөг, бараа таваарыг хадгалж байгаа хүн. Муу ёрын бузар гартан чи бушуухан холд! Эс хэрэгсвэл цагдаа дуудна. Аягүй бол өнөө гайхал Цогоо, Нэмэх хоёрыг нэрлэх нь халаг байх шив. Цаг эргэнээ гэдэг мөн л нохой юм аа» гэж өөрөө өөртөө шивнэн уурсаж, бүх хүчээр хөшиж эргүүлбэл суга үсэрч бэхлэвч төмрийн битүү гогцоонд углаастай хэвээр байгаа цоожийг бушуухан авч шидээд хамсаатандаа муур болон дохио өгнө.

Морь тэрэгчийг гадаа зогсоож, оронгуут лаа барьжээ. Тонох ажлаа самбаатай амжуулж торго дурдан зэрэг энтэй барааг хамж шуудайд түнхийтэл чихэж, хамгийн сүүлд зузаан модон авдартай мөнгийг дамжлан гарч даачааны голд тавиад шуудайтай бараагаараа хучиж бүтээв.

— Бурхан, буг хоёрын аль нэгний өршөөл байг. Авдартай мөнгө байсан нь аз гэж нэг нь нөгөөдөө сэм шивнээд худалдаж байгаад үлдсэн бололтой хэдэн ам хөх торгыг эвхэж сугандаа лав хавчуулан нөгөөхөөдөө харж,

— Би ардын шинэ хоршооны анхны «хишгийг» хүртлээ. Хоол ихэдвэл зохимжгүй. Эндээс хувьдаа ихийг авах гэвэл лай болно. За хувиа борлууллаа. Бушуу явья гээд, гарахдаа хаалгыг

хуучин байдлаар хааж хээвнэг хөдөлжээ. Морь тэрэгчийг хамсаатны хамт гудамжинд зогсоож,

— За Дэчин гуай! Та эндээ сэргийлж байна уу? Ажил ч бараг бүтэх тийшээ болов шив. Энэ юмыг эзэнд нь тушааж, шангаа аваад ирье гээд Жамсранчой морь тэргийг өөрөө хөтлөн явжээ. Хэлэлцээт нууц хаалга сэмээрхэн онгойж худалдаачин эзэн Далайбуян тонуулын бараа, мөнгөнд хөл алдан баярлаж, шалмаг түргэн буулгалцаж аваад шан гэж мөнгөн зоос голдуу ууттай юм өгч, дараа тавтай уулзаж тусгай шан өгнө гэж амлав. Жамсранчой эргэж гудамжнаа сэргийлэн зогсогч хоёр дээр иржээ.

Морь тэргээ, шангийн хамт хүлээж авсан тэрэгч хархүү,

— Жамсранчой гуай! Дэчин гуай! та бүхэн намайг ийм ажилд битгий дагуулаарай. Морь тэрэг минийх биш, дам хүнийх шүү! гээд дээлийн хормой чичрүүлнэ.

- Зүгээр, зүгээр, Битгий ай! Хоёр ах чинь заагаад өгнө. Дахиад нэг хийхээр дадал сууна. Харин энэ явдлыг хэн нэгэн хүнд сэдэв цохиулбал наад муу бөндгөрөө хага цохиулна гэдгийг мэдэж байгаа биз! гэж Жамсранчой сүрдүүлэн тулгана.

Дэчин өврөөс жижиг буу гарган тонгойлгож «уушгин зүрхт минь олон таван үг гонгинолгүй түргэн зайл» гэж зангахад хархүү амь мэнд салахын мөрөөс болон түргэн гээч салан оджээ.

Далайбуян, бичээч Арвинсантай авдрыг цаг гаруй ноцолдож арайхийж эвдэн тагийг сөхөн харав. Олон

тооны мөнгөн янчаан, цаасан шинэ төгрөг байгааг худалдаачин эзэн нүд гүйлгэн үзмэгц бушуухан хааж, бичээчид хүйтэн гарын бүх юмыг түргэхэн янзалж нуухыг зөвлөөд тэрбээр гарчээ.

Худалдаачин үүдээ түгжиж авдрын тагийг сөхөөд өчнөөн удаан нүд хужирлаж баярлавч сэтгэл үл ханана.

Үүрээс өмнө нууц зоорины хаалгыг сэмхэн онгойлгож ороод задгай асгасан мөнгөн янчаан, цул мөнгөн дээр хормойлж авчирсан олзны мөнгөө асгахад зоосны харших дуун нэн содон сонсогдож, шинэ мөнгө хуучнаа дарахад дотор нь сэрхийж, нурууны нь хүйтэн хөлс дааварлаж гар салгалан чичирхийлнэ.

Худалдаачин үүдээ дотроос давхар давхар түгжиж шунал ихт ус гүйлгэнэсэн нүдээ анин харан ханцуй шамлаж задгай олз юугаан элэгдэн дарж хэдэн хором хэвтэхдээ чих тавин чагнана. Ийнхүү сэтгэл овоо уужирч, нэгийг бодсон худалдаачин өндийж шинэ мөнгийг нуух гэсэндээ биш, хуучин мөнгө шинийн дээр байх ёстой гэсэн хүслэндээ хөтлөгдөж нүдэнд өртөгдөх луут, ёншгойтыг дээш гарган бүүдгэр харцаар ахин дахин ажиж, сэтгэл түгших агшинд «муу ёр» гэсэн санаа гэнэт зурсхийн буухад зүрх нь зогсчих шиг болжээ.

## Есдүгээр бүлэг

### Даачааны мөрөөр

#### I

Олноо түшиглэсэн анхны хоршооныхон уван цуван цугларав. Тэд «ойрын хэд хоногийн адил наймаа сайнтай өдөр болно байх...» гэх зэргээр ярилцан дор дороо баяртай хаалга нээж зарим нь зог тусан гөлөрч, зарим нь орь дуу алдан нүүр дарна.

Хоосон лангуу тавиур хонхойн харлаж хэдэн өдөр худалдсан барааны үнэд хураасан мөнгө төгрөг авдрын хамт алга байв. Сэтгэл хиртхийн зүрх алдагсдын дунд, учир тунгаан ажин бодож буй ахимаг эр,

—Хамаг юм хулгайлагджээ. Дор дороо зогсоцгоож бай! Нэг нь бушуу яваад цагдан сэргийлэхээс цагдаа дагуулаад ирээрэй! Халуун мөрөөр нь буулгаж, учрыг нь тунгаалгая гэж амьсгал давхцуулан өгүүлнэ.

Магадлан мөрдөлт эхлээд удаагүй байхад байцаагч Жав гойд хянамгай ажин,

— Хэн эхэлж хаалга нээсэн бэ? гэхэд худалдагч эрийн нүд томрон сандарч,

— Би түлхүүрдэж онгойлгосон гээд нэрийн цээр гаргах гэж илэрхий оролдоход бага дарга Цогоо,

— Энэ арын хаалга байнга цоожтой байдаг уу? гэж лавлавал,

— Гадна талаас үргэлж цоожтой байдаг юм гэж хоршооныхон зэрэг шахам хариулав. Доторхи магадлагааг дуусгаж гарах үед Нэмэх арын хаалгыг түлхвэл сул байв. Цөм сонирхон гарч үзвэл гурван өргөстэй монгол цоож, суга татагдсан бэхлэвч төмрийн битүү гогцоонд тээглэгдэн газар хэвтэж байжээ. Үүнийг харсан Цогоо, олзуурхан шүүрэхийн оронд бичгийн ширэн савнаас сул цаас гаргаж жийргэлэн бариад эргүүлж, тойруулан удтал үзсэний дараа Жавд жийргийн хамт өгч,

— Тонуулчийг олно доо! гэж бардам зангаар эгдүүтэй хүйтнээр инээмсэглэснээ анзаарч «миний зан араншинг мэдэхгүй энэ хоршооныхон намайг яасан онгиороо эд вэ?» гэж бодсон байх аа хэмээн санагдахад ичих шиг болов.

Наадхи цоожны чинь их бие, бэхлэвч төмрийн гогцоо дээрх дардсыг харахад хурц ирмэгтэй багажаар хүчтэй хөшиж татжээ. Байцаагч аа! Нөгөө түвд худалдаачны байшинг ухсан хулгайчийн хэрэглэсэн багажаар энэ хэргийг давтан үйлджээ гэхэд цоожийг магадлан ажиж байгаа Жав баясангуй царайгаар хөмсөг өргөн,

—Миний ажиглалт таныхтай яг таг тохирч байна. Бид хэзээ нэгэн цагт энэ «боохойн» халуун мөр дээр буунаа! гэж бодож байна гэж нөхрийнхөө сэтгэлийг засавч, үнэний үндэстэй эсэхийг өөрөө нотолж чадаагүйдээ сэтгэл дундуурхан л байв. Онцгойрон ажиглалт хийж буй

Нэмэх, багш гэж нэрлэн хүндэтгэдэг Цогоод хандан,

— Багш аа! Та энэ мөрийг хараач. Мөн ч тодхон үлджээ гэхэд,

— Даачаа тэрэгний мөр байна. Хулгайчид нинжин сэтгэл гэж хэзээ ч байдаггүй. Өлзий бусын тэр үйлтнүүд энд тэндгүй элдэв юмаар нэр усаа дурайтал бичиж үлдээх шахжээ гэхэд Жав,

Хулгайч асар удахгүй баригдана биз. Үлдсэн юмыг эмхэлж дэлгүүрийг нөөц бараагаар онгойлгож ард олонд худалдаа хийлгэх хэрэгтэй. Ер нь тэгээд манаачтай болгохгүй бол болохгүй нь ээ. Манаачтай болтол та нар ээлжлэн манаж хонож, сонор сэрэмжтэй байх хэрэгтэй гэж хэлэхэд тэд «за» гэж толгой дохицгооно.

Цагдаа нарыг явсны дараа ардын хоршооныхны цотроос зарим нь саваагүйтэж өлөн шороон дээр бичээстэй «нэр усыг» олж үзэх гэж үнэхээр мэрийн цөхрөнгөө бараад

— Цагдаа нар дэмий сагсууран онгирсон байх аа. Эд хулгайч нарыг олж барина гэдэг ч ёстой гонж гэж дооглон хөхрөлдөнө.

Цагдаа нар цааш мөшгөн хөөсөөр халуун мөрөө эвхэн зүг чиг заах зааг дээрээс мухардан буцжээ.

Ганц жижиг гэгээвчтэй давчуухан тасалгаанд цугларагчид урт вандан сандал дээр зэрэгцэн сууцгаана. Хуучин улаан салдаазан бүтээлэг навсайтал нөмөрсөн бүдүүн бараг хийцтэй ширээний ард буурь суурьтай өндөр сүрлэг эр суун бүгдийг тойруулан бүртгэх мэт хараад,

— Урьд шөнийн хэрэг явдлын талаар Цогоо яриарай гэв. Бага дарга Цогоо яаралгүй босож,

— Эхний магадлагаагаар хэргийн эзэн гар, хөл бологч этгээдээр гал тавиулж, биднийг чулуу хөөлгөөд ар хударгаар амжсаны шинж байна. Санаа хоёрдуулж байгаа мөхөс баримт нь тонуул хийсэн гурван этгээдийн нэг, хүнд жинтэй дорвилог лагс эрийн гишгэсэн мөр байгаа.

Монгол гутлын улны хэв, даачаа тэрэгний мөрний сэжигтэй мөр эцсийн эцэст ашигтай зүгт хөтлөх шижим байж болох юм. Бас хулгайд алдагдсан бараа зүйл тоймтой. Гэрч нар, магадалсан бичиг баримтаар баглагдаж байна. Зүслэгдэх эдээр түлхүүр хийж үүдийг нээж ч мэдэх л юм гэж итгэл төгс хэлбэл байцаагч Жав,

—Цогоо гуайн нүд бодол хоёр сум шиг тусдаг болохоор хол дэгслээгүй гэж санаж байна. Харин цоож бэхлэвч төмрийн их бие хэсэг дээр гарсан хурц ирмэгт багажийн хөшилтөнд ор гаргасан удаа дараагийн гэмтэнт суга татан гаргах лут хямсаа болноо гэж хэлэхэд дарга өөрийн өвөрмөц ажиллагаанд холбогдох нухацтай хэдэн зүйлийг зөвлөн даалгаж, ноцтой энэ гэмт хэргийн эзнийг түргэн илрүүлэхийг Жав, Цогоо, Нэмэх нарт нэр цохон даалгажээ.

Эргүүлд гарсан Нэмэх яаран ирж Жав, Цогоо нарт илтгэхдээ,

— Даачааны сэжигт мөр зүүн дамнуургачны сондгой гудамжны хавьд шороон дээр маш тодорхой гарчээ. Нэгийгээ үлдээж, хамгаалалт тавиад ирлээ гэхэд Цогоо,

— Амьсгалаа тогтуун байлга. Баярлах болоогүй. Бид одоо очлоо гээд босчээ.

Ул мөр шалгасны дараа түргэн зуур зөвлөж ярилцах агшинд Цогоо,

— Анхны сэжиглэсэн даачааны мөртэй яг тохирох боловч бас л шүүрхий юм зөндөө байна шүү! Хэрвээ гэмт этгээд хоёр тэрэгтэй байгаад нэг тэргээ гаргахгүй хөл хорьчихвол яана гэж эргэлзэхэд Жав,

-Ямар боловч туршаад үзье. Хотын захиргаатай харилцаж үлдэгдэл хог зөөлгөх нэрээр бух даачааг нэг газар цуглуулъя. Тэгээд манай ажил эхэлнэ. Мянга шахам дугуйн мөрийг нүд үзэн ажихад нэгэн уяа алдуурч мэднэ. Өвөг эцгийн шүтээн «Далха» бурхан бидэнд тус хийж туршилт өлзийгөө өгөх байлгүй гэж алиалан мушилзахад бусад нь дагалдан хөгжжээ.

Сүүлчийн хэсэг тэрэг явж өнгөрөхөд шалгагч хэдийн сэтгэлд тусгагдан нүдэнд үзэгдэж хоногшсон мөрний өргөн нарийны хэмжээ, дугуйн гадуурхи цагираг төмрийг мөөртэй бэхэлсэн хадаасны сугарч унасан ор нүх мөн онцгой товгор тавтай хэд хэдэн хадааснуудын хоёр янзын сонирхолтой мөрний хэв барлагдан үлдэнэ гэж итгэсэн нь талаар өнгөрөхөд Жав нэгийг бодож Цогоо бас санаа ургуулан боджээ. Харин Нэмэх царай хөрзийлгөн барьц алдахад Цогоо,

— Бөхийн барилдаантай зүйрлэвэл манай ажлын зөвхөн ам даваанд аль олонтаа тонгоруулж зоогоор тавиулахыг тэр гэх вэ? Дараа жилийн наадамд давахыг үзүүлэмз гэж бодоод соргог сортоотой бай гэж хошин үгээр сургамжлан сануулав.

## II

Нэмэх, өдрийн цагаар амарвал тавтай ууж идээд ганц хоёр цаг ч болов тайчиж тохитой унтаж амардаг ажээ. «...хорин дөрвөн цагийн ихэнхийг ажил албаны төлөө зардаг хүн, амрах хэдэн цагаа аятай тавтай ашиглаж, шинэ хуч сэлбэхийг бодох хэрэгтэй» гэж ах зах хүний буурь зааж Цогоогийн захиж хэлснийг Нэмэх ямагт санаж өөртөө хэвшил болгохыг мэрийнэ. Хэдэн цаг товхийтэл амарч ажилд гарахаар бэлтгэж байтал Сайнзаяа орж ирж түр саатал болов.

— Нэмэх ээ! Би чамд юм сонирхуулах гэж ирлээ. Өчигдөр Жамсранчой ирлээ. Аав ээж хоёр хөл алдаж ойрдоо манайхаар ирээгүй гээд л бууз жигнэж, архи дарс болов. Жамсранчой над руу сээтэн хаяж марзганан байн байн үг өдөхөөр нь би үг дуугарсангүй, байдгаараа л байлаа. «Би чамд сонирхуулах гэж ардын шинэ хоршооноос хэдхэн ам торго авч ирлээ. Голохгүй бол дээл хийнэ биз» гээд боодолтой юм задалж өгөхөд нь «надад торго дурдан хэрэггүй. Даалимба даавуу дээлтэй. Манай эвлэлийн гишүүд баргаар ногоон даавуугаар цамц хийж өмсдөг болсон. Тэднээсээ гаж буруу өнгийн эд юм хэрэглэх хүсэл алга» гэж үнэнээ хэлсэнд Жамсранчой хөмсөг буулган, царай улсхийлгэж,

— Сайн санааны үүднээс чамдаа өгөх гэсэн юм. Тоогдохгүй байвал яая гэх вэ? Муу нэртэй болохоор чи бузар гараар хумсалсан эд байж магадгүй гэж сэжиглэж байгаа байлгүй. Тийм ч биш шүү! Нэгэнт авчирсан юмыг авч буцаад яах вэ? Энд байж л байг гээд орон дээр тавьж гарахад ээж үг дуугарсангүй. Аав торгыг чимхлэн ихэд олзуурхан үзэж,



— Торгон дээр гэхэд, тааран дээр гэгчийн үлгэр гаргаж байх шив дээ. За, гайгүй ээ, задарна, задарна гэхэд ёстой дэндэж байна. Тэгж л бай... гээд баруун талын авдранд хийж цоожлов. Би уулзах далимд зүгээр ярьсан юм. Чи битгий юм бодоорой гэж хэлээд ширтэнэ.

«Дээлийн торго» гэсэн үг Нэмэхийн хамаг анхаарал татсан боловч түүнээ тэрхэн зуур мартан Сайнзаяаг үнсэх гэхэд тэрбээр «хүүе ээ! гэгээн цагаан өдөр яаж болдог юм бэ?» гээд нүүр буруулан гэдрэг цахдана.

Нэмэх, дээлийн торгоны талаар удтал бодож, бодож дарга нарт хэлье гэж шийджээ. Жав, Цогоо нар сэжигтэй юман дээрээ нэг бууна гэхээрээ эргэх, буцах, гайхан тээнэгэлзэх, гуйвах мэтийг үзэн яддаг зүрх зоригтой улс. Жамсранчой ардын хоршооноос авсан гэж Сайнзаяад авчирч өгсөн торго хоршоо ухагдахын урьд өдөр худалдаад үлдсэн дээлийн өнгө мөн байж магадгүй байна. Яагаад гэвэл өнгө, хэмжээ яг таарч байгаа. Ер нь Жамсранчой тэр торгыг хоршооноос эс худалдаж авсан байж болно. Эсхүл бусдаас ч авсан бай тэр падгүй. Тийм учраас Дулдайнхыг нэгждэг хэрэг гэсэн Цогоо, Жав нарын эрс шууд санал энэ удаад ч бүрэн дэмжигджээ. Харин нэгжилтээс чөлөөлөхийг Нэмэх хүсэхэд учир явдлыг арван хуруу шигээ андахгүй бага дарга татгалзсангүй ээ.

Дулдай цагдаа нартай дахин халз тулна чинээ санаагүй учраас гэнэдэв гэж өөрөө өөрийгөө зэмлэх ажээ.

Нэгжигчид сонирхсон торгоо өнгө зүсээр олж аваад санаа амарсангүй. Үг ярианы болон бусад сэжгээр цааш нэгжихэд олон зуун мөнгөн зоос, төгрөг, хэсэглэж боосон хар тамхи гарчээ. «Нууц газар бүлаастай хүний өөрийн хатуу эдлэлийг эдний гарт алдаж орхисноос үхсэн нь дээр болно. Бурхан шүтээн минь өршөөж хайрла!

Ганц муу дээлийн өнгө юу шалих вэ? Авбал авч л байг. Бузар гараар олсон эд биш, харин хар тамхи явдал удаж гай тарина байх аа. Яагаад гэвэл чи Далайбуянтай хуйвалдаж хашраагүй юу? гээд сунтаг буулгахаар гар өргөж адис авахаас өөр замгүй болно. Сайн түнш Далайбуян өгөөжөө хайрлаж байгаа нь үнээн. Бид хоёр «хар бурамнаас» болоод муудалцаж, алгаа цэврүүтүүлснээс хойш хэлхээ холбоо дахин сэргэж зузаарсан маань хэн хэндээ ашигтай л байгаа. Бэл бэнчингээр хөлжүүлсний ид шид миний мухлаг бараагаар дүүрч, ашиг хонжоо чамлахааргүй ээ. Хар тамхинаас олон зуун янчаан хүртлээ, хөөрхий, ноднин намарсан. Далайбуян гуай холоос ирсэн хэдэн тэмээ аргалыг манай хашаанд буулгуулаад маргааш өглөө нь бараг үүрээр өөрөө ирж тусгай тэмдэгтэй арав шахам том аргал цагаан бааданд боож аваад,

— Дулдай түнш ээ! Энэ муусайн аргалыг хэдэн мөнгөнөөс зарж үнийг өөрөө аваарай гээд яаралтай явж билээ. Цагийн дараа цагдаа нар өчигдрийн аргал буулгасан хүнийг дагуулан ирж аргал бүрийг хагачин үзэж ажил удаад,

— Дулдай гуай! аргал жижиглэж ажил ургуулсанд гомдох явдалгүй шүү. Ингэх учир байлаа гэж уучлалт гуйна.

— Юунд гомдох билээ. Харин та бүхний үйл бүтэв үү? хэмээн ам асуух маягаар хүүрнэж нүдээ хялайлган доош харж билээ.

Далайбуянтай яаралтай уулзаж ингэлээ гэдгийг цүхуйлгахад «тэд нэгэнт хожимдсон болохоор чи санаа зовох хэрэггүй. Тэр хэдэн аргал дотор олон мянган янчааны үнэтэй «хар бурам» байсан шүү гэж данжаад гудиггүй хэлээд мушилзахад зэвүү хүрснийг яана. Мэдсэнсэн бол... гэж би амаа барьж билээ. Эд худалдаачныг бариад үнэнийг хэлүүлж магадгүй юм. Аминд тулсан цагт утсан улаан амиа хаацайлдаг хэрэг ээ» гэх цэц бүлаалдсан бодлын дагуу,

—Дарга, цагдаа нар аа! Би чин үнэнээ өчье. Тэглээ гээд төрийн сүлд намайг өршөөнө байлгүй гээд Дулдай эрүүний хонхрын бут сахлыг имрэн бодолхийлнэ. «Худалдаачинтай дахин холбоо сүлбээ тогтоож хичнээн удаа хэдий хэмжээний хар тамхины нууц худалдаа хийж, ашиг завшаан олсноо нэгд нэгэнгүй тооч гэж царай улайлгана даа» гэж Дулдай бодно.

...Ноцтой гэмт хэргийн баримт нэгэнт илэрсэн учраас цагдаа нар нэгжилгийг улам нарийн болгов. Жав, Цогоо нар саравчинд тавьсан даачааг харангуут сэжиглэцгээж яаран шалгавал эрж хайж байсан тэрэгний сэжиг бүхий мөрний тэмдэг, хэмжээ яг таг тохирчээ. Дулдай гэрчлэн хэлэхдээ,

— Манайх ачааны хоёр морин тэрэгтэй. Нэг морио худалдсан учир сул тэрэг нь энэ. Зарц Гомбодоо морь тэрэг хөтөлдөг. Хоёр тэргээ ээлжээр хэрэглэдэг байж болох юм. Би тэр бүрийг мэддэггүй хүн. Харин орой ирэхэд нь олборын хэдэн мөнгийг сайн тоолж авдаг. Өөр юм огт мэдэхгүй гэж гэрчилжээ.

— Би Дулдай гуайн хар бор ажил хийж амь зуудаг үнэн. Сүүлийн хэдэн жилд ажлын морь тэрэг хөтөлж байна. Нэг морио зараад тэрэг нь сул байгаа гэж Гомбодоо нэгэн адил өчихдөө,

— Хоёр тэргээ ээлжээр хөллөдөг.

— Бусдад тэргээ өгч байсан уу?

—Нэр мэдэхгүй, зүс сайн таних залуу та нарын хурааж авчирсан тэргийг морьгүй аваад хоёр хоногийн дараа авчирч өгсөн. Тэгэхдээ тэрэг хэрэглэсний шан гэж арван янчаан өгөхөд нь дургүйцээгүй. Үүнийг Дулдай гайгаас нууж дарсан юм шүү. Тэр залуугаас тэргээ буцааж авсны дараа саявгархан энэ тэргийг нэг удаа хөллөж ажилд гарснаас өөр хэрэглээгүй. Тэрэг чухам юунд хэрэглэснийг ердөө мэдэхгүй. Залууг хаана ч явсан танина гэж Гомбодоо гэрчилжээ. Залуу эрийг цагдаа нар эрэхээр Гомбодоог дагуулан зах зээлээр гарсан ажээ.

### Ш

Шөнө болж, эрт нойрсдог хүмүүс дуг нойрондоо дуг жирсан байв. Жамсранчой ууж идэх нь улам ихсэж, худалдаачин өөд омгорхог харна. Худалдаачин эзэн, түүний битүү дүнсгэр уур уцаартай байгааг тааварлан,

— Жамсранчой! Миний дүү сайн идэж уу! Дарснаас балга. Гадаа их харанхуй боллоо. Юун тухай ирээ вэ? хэмээн далим болгон асуухад Жамсранчой хараа эгцлэн,

— Таны ам санааны аясыг даган могой атгасан миний гар, шангий чинь чамлаад хэцүү байна. Хэдэн янчаан, хүүтэй зээлдуулбэл их сайн байна гэвэл худалдаачин Далайбуян «эв

зүйг олохгүй бол энэ яаж ч, мэднэ» гэж бодон,

—Танд дахиад ахиу шан нэмж өгөхөө хэзээ ч мартажгүй ээ. Одоо наймаа тун муу байна. Хүүтэй мөнгө авсан хүмүүс сохор зоос өгөхгүй луйвардах санаатай гээч. Гар дээр байгаа бэл бэнчингээ урж, зарж дууслаа. Би эцэгтэй чинь ялгаагүй учраас чамайг хайрлан бодож тав, арван янчаан өгнөө. Хүүлэх ганц ч лан мөнгө одоогоор байхгүй гэхэд Жамсранчойн нүднээ доогтой харц одорч.

—Ардын хоршооноос авчирч өгсөн мөнгийг дууслаа гэж үү?

-Хэдхэн янчаан юу байх вэ?! Хай тэр муу авдар өөрөө их хүнд, дотор нь хэдхэн зоос байсан шүү! За тэр яах вэ зүгээр гээд дарс хүндагалж тавиад давхар өрөө рүү намс намс алхаж ороод хаалгаа ёврон хаав.

Жамсранчой базааж зэхсэн цаасанд бодолтой нунтгаа задлан худалдаачны хүндаганд хийгээд ханхайж уух нь сэжиг ажиггүй ажээ. Худалдаачин Далайбуян орж ирж арван мөнгөн зоосоор гар цайлгахдаа «чамлаж ахин нэхвэл яанаа» гэх бодолд дарагдан гар нь аяндаа чичрэн салгалж байгааг анзаарсан Жамсранчой босон харайж хоёр гардан хүндэтгэлтэй авч,

-Гялайлаа, гялайлаа. Ачийг ачаар хариулна. Одоо хоёул хүндагатайгаа тогтоочихъё гэхэд зочноо ингэж баярлан хөгжиж хууртана чинээ санаагүй данжаад давхийн гар сунгаж хүндагатай дарсаа дуустал шимэн зальжинаар тамшаална.

—Таныг тух алдуулсан гэмээ цагаатгахыг хүсэж байна. Намайг дахиад тиймэрхүү ажилд зарвал зараарай гэж ая тал засан хэлсэн зочны үг бүдэг бадаг сонсогдох болов. Юм бүхэн сүүмийн бүүдийж, нүд эрээлжилж зовхи анилдахад худалдаачин «би их согтож байна уу» гэсэн бодлоо гарган хэлж чадалгүй дороо нугдайж нам цохигдсон адил болжээ.

Жамсранчой утсан татуургыг татаж бичээчид дохио өгөв.

-Арвинсан гуай! Танай эзний нойр их хүрсэн бололтой. Орон дээр нь тавгай нойрсуулья гэхэд бичээч гайхан ухарч,

—Юу болоо вэ? Би ойлгохгүй байна гэсэнд Жамсранчой босож, Арвинсанд элэгсгээр хандан,

—Та зарц гэдэс тэжээхийн эрхэнд ингэж хоног сар илээж яваагаа мэддэг биз? Нууц зоорийг зааж, түлхүүрийг олоход туслаарай, хожим танд гэм зэм ирэхгүй ээ. Би хоршооноос хулгайлж танай эзэнд өгсөн олзыг авна. Туслахгүй бол... гэж гар зангидахад бичээч түлхүүрийг хайж хайж уранхай муу шаахайны ул дотроос гаргаж ирэв. Ер сэрэх шинжгүй унтаж байгаа худалдаачин эзнийг хяламдан харсан Жамсранчой, «миний худалдаачинд өгсөн эд мөнгөний үнэтэй, хүндаганд хийсэн эмийн үнэ тэнцэх ёстой. Өгсөн хүн ч тэгэж үнэлсэн» гэж бодно.

Зоорь нэртэй, нүх сүвээр дамжиж ордог газар дорхи жижиг байшингийн хаалгыг онгойлгохоор түлхүүрдсэний дараа Жамсранчой, бичээчид захиж хэлэхдээ,

— Та өрөөндөө ороод тавгай байж бай. Эзэн сэрж энээ, тэрээ болоход хүрвэл би юу ч

мэдээгүй гэж мэлзээрэй гэв.

Юу байдаг бол гэхээс зүрх түгших шиг болно. Хаалгыг алгуурхан татаж, барьсан лааг дээр өргөхөд гэгээ тодрон. Босгон дээгүүр хөл сунган тавиад урагш ахиж чадалгүй байрандаа зог тусаж, газар сул задгай асгасан мөнгөн зоос, төгрөг, баглаа боодолтой нямбай өрж хураасан юмыг нүд гүйлгэн харж яах учраа олж ядан зогсоно.

#### IV

Гомбодоо, цагдаа дагаж олон хөлийн дунд эрэн хайх ажилд явж, нөгөө залуугийн хүйтэн гарыг атгуулахад тэрбээр үнэнээ өчиж улайхдаа,

— Жамсранчой, Дэчин хоёр ардын хоршоог тонох шөнө би Гомбодоогоос гуйж хэрэглэсэн даачаа тэргэнд өөрийн морийг хөллөж очсон. Тэгээд шуудай бараа, авдартай мөнгийг ачиж худалдаачин Далайбуяны пүүсний хавьцаа ирэхэд Жамсранчой «одоо зогсноо» гэсэн. Ачаатай тэргийг Жамсранчой хөтөлж одоход би Дэчингийн хамт хоцорсон. Жамсранчой удаж төдсөнгүй эргэж ирээд, миний морь тэргийг өгөхдөө «шан» гэж зоос өгсөн үнэн. Би «Намайг дахин ийм ажилд бүү хэрэглээрэй. Би яасан ч дахиад ийм юманд явахгүй» гэж хэлээд салснаас хойш нүүр учраагүй гэж залуу, цагдан сэргийлэхэд батлан гэрчилнэ.

Жав, Цогоо, Нэмэх нар дагалдан яваа нөхдийн хамт өндөр шавар хэрмэн хашааг нохойгүй талаас сэм давж оров. Тэд давын өмнө бичээч Арвинсантай уулзаж, эзэн хаана байгааг лавлан асуувал айж сүрдсэн бичээч.

—Эзэн үхсэн, унтсан алиныг бүү мэд!... зоринд чөтгөр бий гэж учир үл ойлгогдох үг үглэхэд Жав, «бичээч Арвинсан нэг бол зүрхний хий туссан байх. Эсхүл арга мэх хайж байна» гэж бодов. Юу ч гэсэн зоориноос эхлэх нь чухал гэж Жав бодоод, зорь заалган очиж сул хаалгыг татаж болгоомжлон орж гар чийдэн тусгахад задгай асгарсан мөнгөн зоос, төгрөг, баглаа бодолтой юм нүднээ тусчээ. Ахиулан зэрэг зэрэг гэрэл тусгаж ажтал баглаатай барааны араас ханхар эр босож, гэрлийн гялбаанаас нүд халхлан нүүр буруулж, доош харна. «Энэ мөнгө, эд барааг хараад миний ухаан санаа битүүрчээ! Хаалга түгжихээ хүртэл мартдаг байна шүү» гэж харамсах сэтгэл харвасан сум адил буух агшинд,

— Жамсранчой! элдэв бусын зан битгий гаргаарай. Худалдаачин Далайбуян гуай та хоёр ах дүүс болон хүж бариа юу? гэх Цогоогийн дуу хүнгэнэхэд Жамсрагчой сэхээ авч,

—Ямар элэнцэг хулинцагийн ах дүү болох вэ? Би, баян данжаадын урхинд урхилуулж ардын хоршоо тонож мөнгө, барааг өгсөн хүн. Сүүлдээ санаа дүйхээ больж өгсөн юмаа ялган авч хоршоонд эргүүлж өгөхөөр мунгинаж байгаа царай энэ дээ? Ашгүй ардын цагдаа нөхөд ирдэг бүүр ч сайн хэрэг гээд гэмшингүй харахад байцаагч Жав,

—Шилийн сайн эрийн санадаг санаа, хэлдэг үг гэж үгийг нь ёжлон мохоов.

Нэмэх, Жамсранчойг нүд салгалгүй ширтэж «Цогоо гуайн гарт дандаа өртөж байдаг, яасан үйлийн үртэй амьтан бэ?... Ийм сайхан ханхар эрд ариун цагаан зам мундах вэ?!» гэж эр нөхөр, эр нөхрийнхөө төлөө бодол өвөрлөнө.

Тэд Далайбуян данжаадын дотоод өрөөнд оров. Данжаад цочир цохиулсан нойрноос дөнгөж сэрэн ядаж байж «...Манайд ямар нэгэн юм болжээ» гэж бодох бодлын эхэнд Жамсранчой, зоорь хоёр нь ээлжлэн орж гарна.

— Хөөе! Арвинсаан! чи амьд байна уу?! Би хэсэг ухаан алдсан байна хэмээн агадан дуу алдахад,

— Эзэн минь би бас тань шиг мансуурчээ гээд бичээч гэмшингүй зогсоно. Жав жирийн байдлаар,

— Далайбуян гуай! Танай пүүсийг нэгжин үзэх шаардлага гарлаа. Байшин савныхаа түлхүүрийг өгнө үү гэхэд худалдаачин сэртхийн гайхах дүр үзүүлэн,

— Юу болсныг би мэдэхгүй. Арвинсан чи түлхүүр өг гэж ихэмсэг хэлэхэд бичээч ширээн дээрх түлхүүр авч Цогоод өгөхөд,

— Энэ түлхүүр дотор таны нууц зоорийн түлхүүр байгаа юм биз дээ гэж ёжтойгоор асуухад худалдаачин Далайбуян гэнэ алдан бие дагжиж,

— Надад нууц сав байхгүй гэж толгой сэгсрэн бүлх залгисан адил болоход Цогоо,

— Та хэлэх ёстой үгээ хэлж байна. Тэгвэл бид мэддэгээрээ түлхүүрдэнэ. Та хамт яваарай гэж тушаав. Нууц зоорины хаалга цоожгүй байгааг харсан Далайбуян тас дайран хөндөлдөж зогсов.

Цагдаа, хаалгыг нээхэд худалдаачин орь дуу тавин муухай бархираад царай нь цонхийн цайж мөнгөн тэмдэгт, янчаан дээр нүд тусган агшин зуур хөшөө мэт болсноо шургаж ойчихдоо хоёр гараар мөнгөнөөс базан атгав.

Далайбуян данжаадын дөрвөн мөч чичиргэнэн татвалзаж байснаа хоёр гартаа атгасан мөнгөө барьсаар босож жалхгүй болсон бор нүдээ эргэлдүүлэн, дотор харанхуйлж өвдөг сөхрөхөд Нэмэх цээжийг тэвэрч Цогоо гар нүүрийн алчуур хүйтэн усанд дүрж данжаадын цээжийг жигнэнэ.

Ухаан сэргэсэн худалдаачин Далайбуянгийн дотор «дөчин таван жилийн өмнө авга ахаа арван настай дагаж унасан газар, угаасан усаа орхин ирэхэд аавын нь захисан захиас санагдав. Хэрэв хүний газар муугаа үзэж, ясаа тавихад хүрвэл хөрөнгө зоорио хүнд бүү үлдээгээрэй. Хөтөвчөө хүртэл шүүр шанага болтол цоолоорой» гэсэн бодол сэрхийн буух чацуу баруун гарын нь ядам хуруун дахь таван цэнгийн алтан бөгж нүднээ тусчээ. Тийнхүү хулгай нүдээр энэ тэрийг ажин анаж хий зай тааруулан алтан бөгжөө шүдээр суга татан залгисан худалдаачин Далайбуян нугалууранд хохсон адил нугжисхийж, тэргүүн нь нугалсан нуруу шиг болжээ.

## V

Цагдан сэргийлэх газрын дарга, ардын хоршоонд халдсан бүлэг хулгайн толгойлогч

Жамсранчойн хийсэн хэргийн арга мэхийг сонирхон анхаарч байцаалтанд өөрөө суув. «Барон хүрээг эзлээд эр хүйст бүрийг цэрэгт татахад би хамагдсан. Тэд ятгахдаа,

—Манай Барон жанжны их цэрэгт сайн дураар орвол сар бүр тавин алтан маниад өгнө. Хэрэв тулалдаанд онцгой гавьяа байгуулбаас маниадыг хоёр дахин нэмнэ. Хоол хүнс, хувцас, буу зэвсгээр бүрэн хангана. Явах хүн байна уу? гэхэд муу амьдрахаар сайн үх гэсэн юм. Ер хүн юу эс үзлээ гэх вэ? гэж бодсон, Тэгээд яалаа! алалдахаар яваагүй юу? Алтан маниадаа хэдийд өгөх ? гэж санамсаргүй асуусны шанд «Май ав? Май» гээд гөрмөл товцог ташуураар бүлдруу гүйтэл цагааны даргад ороолгуулж билээ. Түүнээс хойш анан зэхэж байгаад нэгэн шөнө үүрээр том даргын нь жижиг богцтой мөнгийг, жижиг бууны хамт авч хоёр сайн морь хулгайлан оргож билээ. Битүү нарсан ой дунд төөрөн санд мэнд явж байгаад зэвсэг бүхий хүмүүстэй гэнэт тулгарч баригдаад, гар хөлөө хүлүүлж нүдээ боолгосон. Нүдний боолт тайлахад том, бага буутай хэсэг монгол хүн хүрээлэн тойрч богцтой юмыг уудлан гаргахад зурж эрээлсэн бичигтэй цаас байж билээ. Түүнийг сонирхон шагайж байсан дарга бололтой өндөр эр,

— Энэ юмыг яах гэж авсан бэ? гэхэд би үнэнээ хэлье гэж шийдээд,

— Би цагаан цэргийн дарга нарыг сар бүр тавин алтан маниад өгнө гэхээр нь цэрэгт нь орсон хүн. Гэтэл тэд «маниадаа ав» гээд зодож байхгүй юу? Тэгэхээр уур хүрч, даргын нь богцтой юмыг мөнгө гэж бодоод хоёр морины хамт хулгайлж зугтсан юм гэж хэлэхэд, тэд нэрхийтэл хөхрөлдөж,

—Та амь насандаа ээлтэй уурласан байна. Бид цагаантан биш, улаантан нь байна. Та тэдний цэргийн чухал нууц бичиг баримт, төлөвлөгөө, газрын зургийг бидний гарт оруулсан тун сайн хүн гэж баярлацгааж билээ.

—Та нарт тийм л хэрэгтэй юм бол ав ав гэхэд дарга нь

—Манайхан ардын журамт цэрэг. Чи бидэнтэй нэгдэх үү? гээд учрыг ухуулсан. Би бодож, бодож борогч рүү долоон лан, тавин цэн гэгчээр,

— Одоо аль ч талын цэрэгт орохгүй гэв.

— Тэгвэл цэргийн агт маллаж бай гэж тушааж агтан дээр гаргасан. Хориод хоног агт хариулж, хоёр морь алдаж эрэл сурал болж байтал нэгэн өдөр залуугаар дух атриатсан ширвээ хар сахалтай нуруулаг эр ирж шалган асуугаад,

— Алдсан хоёр морийг өнөөдрийн дотор ол! Хэрэв олохгүй бол байлдааны цагийн дэглэмийг журамлан үг өчиггүй цаазална гээд нарийн хулсан ташуураар хорстол хэд хэд ороолгоод явсан шүү?

«Ардын намынхан гэдэг чинь бас л зодуурын эзэд байх нь гэж бодоод ганц сайн морь шилэн унаажиж оргон зайлснаас хойш баригдахгүй явлаа. Намайг тийнхүү ташуурдсан ширвээ сахалт, ширүүн эр энэ яг мөн дөө! Намайг танихгүй байгаа бололтой. Хэрэв танивал...» гэж Жамсранчой бодож цагдан сэргийлэх газрын даргыг нүдний булангаар ширтэн ажина.



# Аравдугаар бүлэг

## Нүүдэл

### I

— Лхам аа! Гэр зуурын юмаа аялуулж бэлэн болгоорой. Би гадуур ажлаа жин тан болгож, хашаа байшин сахих хүн олсон. Ачлага ирвэл хэд хоногоос хөдөө тийш нүүе. Хоёр хар толгой эндээ гэж ярихад үймээн шуугианаас дайжиж, хүний өөрийн үл ялих эд хөрөнгийг хадгалахад хадны хонгилоос багтай газаргүй болж байх шиг байнаа гэхэд халуун цай домбонд уудалж байсан эхнэр Лхам.

— Охиноо яах вэ? бичиг үгсийн сургууль нь алсдаа хоолтой нь залгуулах юм биш үү! Бага гэрээ бариад үлдээх үү? гэхэд,

— Хэтийн хоолны талаар одоо дурсах эртдэнэ. Чи эндээ үлдээд би оронд чинь тогооны бариул болбол болмоор санагдав уу? Тэгэхэд хүрвэл өөрөөр ярина шүү. Охин бага гэртээ эзэн болон үлдэнэ. Одоохондоо газардахгүй гэж бодож байна. Шинэ цагийн хангал дэгжин харчуултай нийлж учраа олно биз гэсэн нөхрийн хүншгүй үгэнд Лхам паласхийн;

—Бурхан өршөөгөөсөй билээ гээд шүүрс алдаж галд мод нэмэх зуур «охины минь хувь заяа салаа замын бэлчирт хамхуул шиг бөмбөрч байгаа үед орхиод явхад зүрх хүрээ гэж үү... эцэг хүн бүхнийг шийддэг болохоор бүсгүй богино жолоотой би хушуу цорвойлгох хэрэг юун билээ. Жамсранчой хулгай муу нэртэй ч сайн хүний үр удам үнээн. Нүднээ дулаахан зан төлөвшүү, цагдаа хүү Нэмэх ч бас аавын хүү шүү дээ! Тэрбээр алсдаа ямар буян заяатай хүн байгааг хэн мэдэх вэ? Ингээд бодоход энэ нь сайн, тэр нь муу, дээр дор гэж таамаг санах хэрэггүй» хэмээн хоёрдсон бодлын заагт тулж цухалдсан Лхам босож ор сандайлан суув. Охины тухай бодолд орлоо гэдгийг онож мэдсэн Дулдай үг өдөөж,

—Охиноо түшмэл гуайн хүүд сүй бэлгийн дагуу бэр буулгасандаа буулгаж амжсан сан бол алсдаа бид хоёр хожих юм даа! Манай бүл зарц нартайгаа бүх л насаар идээд барахгүй хөрөнгө хогшил нууц зооринд дараастай бий гэж түшмэл ярьсныг би там тум сонсун шүү. Надад хадгалуулсан бага, сага юм ч бий. Цагдаа, цагдаа гээд сөхрөх шахна. Тэр юугаар илүү юм бэ? Жамсранчой шиг янз янзаар элдэвлэж, аргалах арга самбаа, ухаан түүнд алга. Чи даанч мунгинаа байна. Далайбуян бид хоёр хар тамхинаас болж хог малтаж тамаа цайв. Энэ лай охин, та хоёрын магтаал, сүлд болсон цагдаагийн чинь гай юм шүү дээ гэж мушгин хэлээд хоёр зарцаа дуудаж нүүдэлд бэлд гэв.

### II

Ээлжийн манаанаас бууж, гэртээ ирж гэдрэг харан дүнгэнэтэл хухирч байсан Нэмэх хэд хэд угсран найтаагаад сэржээ. Сайнзаяа орны өмнө инээмсэглэн сууж байв. Түүнийг хамрын нүхэнд утас шургуулан дамшигласныг Нэмэх мэдээд, Сайнзаяагийн мөрнөөс татан өндийх далимаар өөр рүүгээ ойртуулж хацарт нь шүргэж амжив.



— Сонин ихтэй. Манайх хэд хоногоос хөдөө нүүх нь ээ.

— Чи яах вэ?

— Би бас л нүүхгүй юу гээд Сайнзаяа мушилзан инээмсэглэв.

— Тэгвэл цагдаа Нэмэх, малчин болноо гэж шийдмэг хэлэхэд Сайнзаяа «танилцсан цагаас хайр сэтгэлээ өгсөн хайртаа түр ч гэсэн бүлх залгиулаад яах вэ» гэж бодоод

— Битгий санаа зов. Би хашаа байшингаа харах нэрээр, бага гэртэйгээ үлдэх дөр хийсэн. Миний ам хэлээр биш, зүрхнээс шивнэсэн үг чиний зүрхэнд... гэхэд Нэмэх баясан хөхөрч

— Миний үнхэлцэг гэж Сайнзаяаг өхөөрдөн хайрлахад,

— Чи бол миний сүүдэр гэж Сайнзаяа хэлээд тас тас хөхрөнө. Нэмэх ч даган баясаж хөгжилдөн байтал эргүүлийн цагдаа орж ирж,

— Нэмэх ээ! Чамайг жижүүр яаралтай ир гэж байна гэснээр тэрээр гарч явав.

Нэмэхийг дөнгөж босго алхан ёс журам гүйцэтгэхээс өрсөн жижүүр хархүү,

—Эрүүгийн гэмтнийг баривчилсны дараа цалгар наазгай байж алдаад Гандан хавьд бүгүүлж, эргэн тойрон бүсэлсэн байгаа. Цогоо гуай зүүн хойт том хүрдний арын суварганы дэргэд бий. Тэнд чамайг бушуу ирүүл гэсэн гэв.

Жижүүрийн яриагаар бол энэ хэрэг явдал ингэж эхэлсэн богинохон намтартай ажээ.

### Ш

Хүрээ захлан шивээлж буусан борчуулын дотор баруун хатавчнаас дээс татаж хөл хорьсон навсгар хар гэрийг хараад, ямар нэгэн хүнд халдварт өвчтөн бий гэж сэжиглэн холуур өнгөрнө. Энэ гэрт эд хогшлоор тохилог, цэвэрхэн ч гэж жигтэйхэн. Өрхийн тэргүүлэгч гэлтэй тагдгар хар хүн хоймор завилан сууж, аяганы ширээн дээр модон таваг дүүрэн тарган махнаас нимгэн нимгэн хэрчиж удаан зажилж, халуун шөл оочлох зуураа «өдий хүртэл амь ульжин яваа минь жаргал л байна. Гэсэн ч... Ай зайлуул Дэчин гуайн лха таван тэнгэр ул дороо оржээ. Би ер нь энэ Хүрээнд хоргодох арга хомс болж байх шив. Лантуу Чойнболын хүү Нэмэхэд хоёр дахь удаагаа тархиа хага буудуулах шахаж, бурхны авралаар хөнгөн шархдаж эдгэрлээ. Гурав дахиа хаана яаж золгодог юм бол...» гэж сэвтэй бодлоо орхиж, түр орогнож буй авгайн зүг аягатай гараа сунган,

—Шөлнөөс тос багатайхан хийгээд өгөөч гэв. Тэр бэр аягаа эргүүлж аваагүй байхад гэнэ сэрэггүй орж ирсэн хоёр хүний нэг жижиг буугаар занган,

—Дэчин, та баривчлагдлаа. Мэсээ тавиад хөдлөлгүй бай гэж тушаажээ.

-Миний нэр ус та бүхний нэрлэж байгаагаас шал өөр, андуурсан байлгүй. Би цагаан мөр хөөж гэдэс тэжээдэг үгээгүү ард шүү. Засгийн хууль хаанаас хилсдүүлэх аж. Барь, барь. Бас сайн

нэгж хэмээн хэгжүүрхэн гэжүүдлэхэд байцаагч Жав,

—Яахаа бид мэднэ ээ. Хутганаас өөр зэвсэг бий юу? гэж тулган асуухад түүний царай сэжигтэй хувирч,

—Надад буу байхгүй гэж яаран хариулах үеэр гаднаас орж ирсэн хүн Нэмэх байв.

Нэмэх, Дэчин хоёр бие биеэ харж хэрсэн бух гэлтэй ширтэлцэн байснаа Нэмэх тэсэж ядахын эрхэнд

—Дэчин гуай! Та намайг таньж байна уу? Би Нэмэх, Чойнбол цагдаагийн хүү гэхэд Дэчин нүд буландан харж,

—Чи буруу таньж байгаа байх аа. Би чамайг үзэглэхгүй юм байх чив гэж хэнэггүй хэлэв. «За ингээд Дэчин гүртэмбэ шороо хөдөлгөх хэмжээ дуусав шив дээ. Хулгай дээрмээр цагаантантай нийлж байсан гээд цагдаагийн оронцог гэрчлэхээр... манаатай байхад нь мэдэлгүй очоод буудуулж амь наана, там цаана гарсан миний шархадсаныг яаж мэдээ юм бол?! Сорвийн хувьд айх аюулгүй. Ер нь Лантуугийн хархүүд өртөх үйл лайтай юм шив дээ. Бас ч болоогүй ээ. Лай зай хоёр хойно, урдаа ордог болохоор байрыг харнаа!...» гэж Дэчин бодоод Нэмэх рүү эгдүүтэй харж нүд анивалзуулна.

—Цагаан Барон сөнөсөн шүү дээ! Та одоо хэний гар хөл болж явна? гэж Нэмэхийг асуухад Дэчин дуулаагүй царай гарган хэлээ зуун сууна.

Биедээ буу авч явдаг сэжигтэйг анхаарч түүнийг нүцгэлэн нэгжихэд зүүн мөрний шонтгорт умайж эдгэрсэн шархны сорвийг харангуут Жав, Нэмэх хоёр сэрхийж, Жав

— Таны энэ сорви тэр жил хулгай дээрэм хийх гэж яваад манаанд буудуулж шархдаад түүнээс тогтсон сорви биз гэхэд Дэчин уур омог орж,

— Тийм, тийм. Та нарын хэлж байгаа цөм үнэн. Намайг тэгээд яах гэв гээд муухай харж шүд зууна.

— Хийвэл бүү ай гэгчээр эр хүн шударга л байх хэрэгтэй гэж Жав хэлээд гэрийн доторхи юмыг нэгжиж долоон сумтай нагаан буу, хоршооны хулгайд алдагдсан бараа өнгө зүсээр гарчээ. Тэднийг энэ айлаас гарахад бүрий болж, салхи сэвэлзэн шороо тоос татарсан байв.

Гурван эрийн гараас энэ яаж мултрах вэ? гэж бодсон цагдаа нар санаа тайвширч Дэчинд хүлэг хэрэглэхгүй сул авч явжээ.

Гандангийн зүүн өмнөх хэсгийн нэгэн гудамжны дунд хэрд явж байтал Дэчин гэнэт эргэн ухасхийж ард яваа цагдааг гэдрэг цохиж унагаад намхан хашаан дээгүүр муур мэт дүүлэн алга болжээ.

Жав, Нэмэх хоёр зугтагчийн хойноос хэд хэд буудаж хөөжээ. Гэсэн ч өнгөрсөн борооны хойноос цув нөмрөв гэгчийн үлгэр болж зугтагч балар харанхуйд шингэн алга болжээ.

Шөнөжин тэр хавийн айл амьтны орон гэр, дуган сүм, хүрдний хавиар нягт нямбай хайгаад хайгаад гэмт этгээдийг олсонгүй ээ.

Дэчин айлын хашаагаар дамжин гурван гудамжийг нэвт гарсны дараа ажиг сэжиг авахуулахгүйн тулд бие сэтгэлээ тайвшруулан хээв нэг алхаж, айван тайван явсаар дацан дуганы сараалжин гэгээвчээр орж, гэгээвчийг эргүүлэн хийсэн нь хэн ч санаанд орохооргүй оронгоо олжээ.

Цагдаа нар лаа дэнлүү болон сүр бадруулж ширээ жавдан, үүгээр түүээр эрж хайгаад гарахад Дэчин босож олбог давхарлан дэвсэж тавтай унтжээ. Өглөө яагаа ч үгүй босож бурхан тахилын цөгцтэй усыг ууж балин шалсай хаман идэж «одоо яая даа» гэж эргэлзэн бодож байв. Тэгсэн тахилч лам ирж бурхдаас адис хүртээд усыг шинэтгэхээр юүлэх гэснээ, цөгц хоосорсныг харж гайхан,

— Өчнөөн жил болоход ийм ер бусын юм үзээгүй сэн. Хайрхаан багш нарын айлддагаар цаг зэвүүрэхээр бурхан хүртэл хилэгнэн догширч зооглож таалсан хэрэг үү... гэж шивнэн эргэтэл хэнгэрэгний бүдүүн иш мод далайсан үл таних хүнтэй халз тулгарч,

— Ээ бурхан багш минь хэмээн огцом чанга уулгалахад нөгөө эр;

— Дуугаа тат. Юун бурхан шүтээн бэ? Аврах эсэхээ би мэднэ. Үг гажвал сунтаг буулгана гэж мэдээрэй. Наад гадуур хувцасныхаа тамтгийг тайлж надад өг! Дараа нь яахыг би зааж өгнө, түргэлээрэй гэв. Үхэн хатан айж сандарсан тахилч лам мангар эрийн модон зэвсгийн зангалтанд юу гэвэл бүхнийг ёсоор хийжээ. Хувцсаа амжиж сольсон дээрэмчин,

—Намайг явсан хойно, хурал эхлэхээс наана гэртээ харьж хувцас хүнараа соль. Ингэсэн гэж нэг ч хүнд үг битгий цухуйлгаарай гээд дуганаас болгоомжлон гарч, өөрийн сайн түншийн хашаанд орж нам жим болжээ. Өглөөний хөл хөдөлгөөн эхлэх үед цагдаа нар Гандангаас ийш тийш явагчдыг нүүр тулан шалгаж арай л шүд амыг татах нь халаг болж эрэл сурал чангарав. Энэ үеэр хар алаг хяз захтай хуучивгар бор шар дээл дээгүүр өргөн улаан орхимж намируулсан тас хар ширэв сахалтай намхан хар лам шар цэмбэн жошоогоо байн байн засаж намба төрхтэй алхалж гандангийн хүр рүү тонгойж буухын даваан дээр араас,

— Хөөе! ламбугуай! түр зогсоорой гэх дуун сонсогджээ. Лам юу ч билээ гэсэн шиг илтэт тоомсорлонгуйгаар эргэн зогсов. Лам зүүн гараа унжуулан ханцуй тавьж, үл мэдэг өргөсөн баруун гартаа шар модон эрхи эргүүлэн маанийн зургаан үсэг тод, тод шивнэн уншиж хүлээн байтал морьт цагдаа ирж жолоо татан хөндөлдөж, ламыг хөлөөс толгой өөд өгсүүлж уруудуулан тогтоож маш хянамгай ажиглаад юм асуух гэтэл дэргэдүүр шууд зөрж өнгөрөхийг хичээн алхаж байгаа улаан царайт хүнийг дуудан зогсоож, сахалт ламын зүг нүүр эргүүлэн,

— Ламтан та явдал суудлынхаа төлөө морилно уу? гэв.

Гэнэ алдсан залуу цагдаа «миний эрж хайж буй Дэчинтэй энэ ламд хавирах төсөөтэй юм даанч алга, хамар, нүд, биеийн өндөр нам яльгүй төстэй гэж бодох боловч хувцас хүнар бүүр таарахгүй байна» гэж бодсоор хоцров.

Хар сахалт лам цааш хол хол алхаж, хааяа зүүнмөрөн дээгүүр эргэн хялалзаж явахдаа «Нүд нь хашир башир сууж гүйцээгүй гэнэн хонгорын эрхээр энэ цагдаа барьц алдав бололтой. Ноолж ноцмоор бол хөгшин ах нь нусгай жаалыг гулд татан унагаад унаажиж арилахгүй юу. Энэ чигт хашир чоно байхгүй. Хаалга нь онгорхой гэж түншийн хэлсэн үг үнэн боллоо. Одоо арга бий дээ» гэж санаа тайвшран алхана.

Хулгайч дээрэмчин муу үйлтнийг эрж сурвалжлах ажлыг улс даяар тараасан зарлах бичигт «...оргодол этгээд нуруу намхан тагдгар, үс хар, хөмсөг хундан, зовхи бүлцэн, зуувин жартгай нүдтэй, эрүү тэгш, ам жимгэр, хамар матигар, чихний омог даруу, зайгүй жижиг шүдтэй, содон мэнгэ сэвхгүй билээ. Биеийн хөдөлгөөн маш шаламгай, явган явахдаа хол хол алхдаг. Нэгэн онцлох юм гэвэл зүүн мөрөндөө сорвитой, бас зүүн мөрөн дээгүүр нүүрээ хагас эргүүлэн ард юу болж байгааг сонирхож ажигладаг хэвшилтэй. Шар товчтой хуучин хөх чисчүү дээлтэй, орой дээр хэрэмний сүүл хадсан эсгий тоорцог, монгол уллагаатай хуучивтар хүрэн гуталтай. Овог Шагдар, нэр Дэчин, ийм этгээд зүс байдал тохирч тохиолдох аваас сайтар нарийвчлан магадалж хэрвээ нэр агч мөн ахул цаг даруйд баривчлан авч өртөө улаагаар тусгайлан цагдан сэргийлэх газар хүргүүлэн ирүүлнэ үү!» гэсэн бичиг хошуу тамга, сум багт, «арав»-ын дарга, өрхийн тэргүүлэгч нарт амаар зарлагдав. Энэ зарлах бичгийн тухай хэсэг зуур оволзож, өдөр хоног өнгөрөх тутам мартагдан «улирсан оны хураах бичигт хураасугай гэсэн цохолтоор аль ч хошуу тамга, сум багт эрэн сураглах дорвитой ажил намжжээ.

Харин цагдан сэргийлэх албаныхан хараа анхаарлаа улам улам хурцатган битүүдээ эрж хайсаар байв.

#### IV

Ачаатай арав гаруй үхэр тэргэн нүүдлийн цувааны түүчээ хүрэн шарны жөрхийг Гомбодоо барьж зам залан гэлдрүүлнэ.

Дулдай, маажинт даавуугаар битүү бүрхсэн мухлаг тэрэгний ам хавьцаа сууж үе үе толгой бүлтайлган талимаатсан харцаа өөрийн урдахь тэрэгний ачаа татлагад гойд тусгана. Ийнхүү Дулдай толгой татан гэдрэг налж мухлагийн мухрын суудалд амь түүс атиран хэвтээ хүнд өвчтөнтэй хааяа хуучлан олбор ашгийн талыг барьж шивнэнэ.

Лхам авгай, зарц Гүнчингийн хамт хэдэн тугалтай үнээгээ нүүдэл бараадуулан тууж, ард үлдэж хоцорсон хайрт охиноо санан бодож даваа гүвээ, уул толгод дээгүүр өнгийн үзэх хүслээр эргэн эргэн харж нулимс тунасан нүдээр ширтэнэ.

Хориод хоног зам зуур сааталгүй нүүдэлсээр суурьших нутгийн зах руу ороход нэр цуутай баян, бас панз наймаанд хэн хүний дор орох эр биш гэдгийг гадарлах хэн Дулдайг зусардан угтаж тавагтай идээ, домботой цайтай ирсэн нь цөөнгүй.

Цоо шинэ хөх майхан урьтан босгож хүнд өвчтөнийг оруулж хэвтүүлээд Дулдай гэр барилцах хооронд нутаг усныхантай энээ, тэрээ болон яриа үүсгэж эд агуурс, мал наймааны үнэ өртөг ямар ханштайг нэгт нэгэнгүй асууж амжжээ.

Дараа жилийн намар мөнөөхөн хэвтрийн өвчтөн өндийн сэргийж ойр зуур морины нуруун дээр гарч малын хошуу эргүүлдэг болов. Нэгэн удаа багийн хуралд Дулдайг төлөөлөн очиж энэ тэр амьтантай танилцан, тамхилж яриа хөөрөө дэлгэжээ.

Багийн дарга «оргодол хулгайч муу этгээд Шагдарын Дэчингийн биеийн байдал, зан төрх, хувцас хунарыг тодорхой дурдаад баривчлан ирүүлсүгэй» гэсэн бичгийг чанга дуугаар уншиж,

—Ийм хулгайч этгээдтэй нэр зүс адилшаах хүн тус багт үгүй учраас дээд газар хариу мэдэгдсүгэй. Энэ албаны чухал нууц бичгийн утга учрыг зөвхөн тархи толгойдоо шингээх хэрэгтэй. Хэрвээ сэжигтэй этгээд илрэх аваас цаг даруйд надад мэдэгдэж бай гэж албархав. Хуралд суугч хоёр хүн үүнийг жигтэйхэн сонирхож нэгэндээ,

—Хорвоогийн түм буман зальтнуудыг алиныг шүүж барах вэ? Ер нь зарлах бичигт дурдсан унжуу хамарт жартгай нүдтэн хаана мундах вэ? Минийх ч, чинийх ч харахад төсөөтэй л юм шиг санагдах байх даа гэж овжигнон цэцэрхэхэд цаад эр үг өлгөн,

—Юун хэлэх вэ? Буянт минь. Яг ингээд ширтэж ажвал таны хамар ч тэр бичигт дурдсан дүрстэй төсөөтэй шиг. Бичгийн дагуу гайгүй сайн элдүүрийг хангатад мушгиад байвал нэг хүн дээр бууж болох л юм гээд хөгжин инээхэд Буянт түмний төлөө сэтгэл зовсон байдлаар,

- Хэрэв тийм этгээд байгаад онож таарвал таны үг ч түүний элгэн дээр халуун хайруул тавихтай адил болгоноо. Гайтан оргодол хулгайч нарын уршгаар бид бүхэнд ч элдэв чирэгдэл учирч нутаг усны цэвэр ариун нэрийг хөөдсөн ч явдал байдаг шүү дээ гэв.

Хурал тарсны дараа, Буянттай үг өдөн ярилцаж байсан эр багийн даргатай аминчлан уулзаж,

— Даргаа! Та Дулдайнд байдаг Буянтын хамрыг анзаарч ажиг уу? Зарлах бичигт дурдсан хамар, ам, нүдтэй мөн ч адилхан юм аа. Алхаа гишгээ нь хүртэл яг гээч гэхэд багийн дарга хэрсүүгээр,

— За байз, тэр үү! Чи сайн ажиж танив уу? Тонгорогны ир шиг ийм хурц явдлыг санасны зоргоор хэн хүнд чалчиж болдоггүй юм. Би ч бас тэгж бодоод л байгаа. Энэ тухайг дуулгадаг газар даруй дуулгана. Тэр болтол таг чиг байгаарай гэж анхааруулан захив.

Багийн хурлын маргааш өдөр,

—За Дулдай гуай, Дэчин гүртэмбэ гуайн нь багийг, багийн хурлынхан хуулаад хаячих дөхлөө. Би одоо түргэн зайлах нь чухал боллоо. Тун удахгүй цагдаа мөр хөөж шиншилнэ. Тэгэхэд хуучин танил, ядарч зүдэрсэн өвчний сүг болсон Буянт гэдэг хүн манайд хэвтэрт байж байгаад биеэ жаал сайжрахаар өндөр гэгээнд мөргөхөөр явсан гэж мэлзээрэй. Бусдыг төлөөлж авах хэдэн лан мөнгөн дээр би царай алдах хүн биш ээ. Харин өөр хүнд өгвөл би баталгаа бичгийн дагуу танаас авч сална гэдгийг бодоорой. Одоо надад мөнгөний хэрэггүй. Ихэс дээдсийн хөрөнгийг хурааж бужигнаж байгаа үеэр эвий нь тааруулаад дайрч үзнэ. Ядаж хэдэн жил улаан хоолойн цаана хаях юм олж авна гэж бодож байна. Жамсранчойг тэд

таваглаж чадахгүй ээ. Мөдхөн гараад ирнэ гэж санаа шулуудсан үгийг сонссон Дулдай дотуур баярлажээ.

Дэчин, Дулдайнхаас унаажин яваад сураг чимээ тасарчээ.

Дулдайн яван яван гүнзгийрэх бодолд «нэг нь бурхны авралаар шилний хонхроо өөрөө цааш харууллаа. Жамсранчой хэдийд ирж, яаж сандаргадаг бол... хадгалуулсан хатуу эдлэлийг цөмийг өгч хоёр яс хагацдаг хэрэг үү? Үгүй тэгж ярихгүй. Хэрэв тэрбээр нүд анивал миний олз болно. Ер нь миний хувь зохиолын жолоо түшмэлийн хүү, цагаандаа гарсан луйварчин Дэчин хоёрын гарт дэнслэгдэж байж болох уу? Болохгүй, яасан ч таарахгүй хэрэг. Талиймар Далайбуянгаас хүүтэй зээлээд буцааж төлөөгүй өрний эрхий хуруу дарсан баталгаа бичиг Дэчингийн сэтгэлд яагаад орж орхих нь тэр вэ? энэ бичиг түүний гарт байгаа цагт Дэчингийн өмнө Дулдай, Дулдай биш үхэр оготно гэсэн үг, хийсэн хийдгийг бүгдийг тоочиж бариулнаа гэхэд би бас хохирно. Юу боловч тулсан цагт л больё. Нохойн хэвтэр дор бүлаастай хатуу хүтүү юмыг уул хад бараадуулбал арай дээр байх аа. Хоёр гурван хүн зарцалдаг, баян чинээлэг гээд хоолноос салах болж байна уу? Гомбодоо Гүнчин хоёрыг ам өрх тусгаарлах нэрээр хэдэн малаа тасдаж аргалах нь зөв» гэх элдэв бодолд хоног тоолон шаналсан Дулдай нойр хоолондоо ч муудаж сэтгэл зовох болжээ. Нэгэн өдөр Дулдай шар өнгөтэй эрдэнэсийн цутгамал дээр харцаа шилжүүлэн гөлөрч,

— За байз, хоёр адилхан өнгийг харьцуулахад ямар харагдах вэ? Мөн дөө мөн, нарны гэрэл ойж туссан, сэтгэлд чамламаар бага жижигхэн үзэгдэх мөртөө чанар жинд, жин хүнд байна. Алтан амь, алтан дэлхий, шижир алт гурав аль нь алиныхаа нуруун дээр сандайлж, аль нь илүү үнэ хүрэх вэ? гэж хэн нэгэн хүн надаас асуувал, алт гэж би багтай хариулна. Хойтон болтол гаргаж үзэхгүй, нэг үзсэн дээрээ сайн харж авья. Байз, байз удаан ингэж ил задгай байлгавал далд эздийн шунал шингэж надад халтай болно» гэж уруул чичрэгнүүлэн шивнээд бушуухан булж дараад мориндоо мордож эргэцэн хорогдож байснаа гэрийн зүг жолоо залж эргэн эргэн харсаар явна.

Дулдай гадаа явахдаа Баян-Өндөр хайрхны энгэрийн цуваа гурван хайлааст мухар жалгын эхний үхэр чулууны хавьцаа хараа тогтоон удтал ширтдэг нь заншил болон хэвшжээ.

Дөрвөн цагийн эргэлтэнд нутаг сэлгэн буух гэрийн буйр үзэж шав тавихад Баян-Өндөр хайрхны энгэрийг л тод биш ч заавал хараа бараатай байхыг бодолцоно. «Ядрахын цагт аминд орох олборын хэдийг хадгалсан ээлт тэр газар илхэн үзэгдэх мөн ч таатай юм аа. Ай хөөрхий зайлуул, Дулдай минь, чи бусдад гэнэ алдаж, сэжиг цохиулуузай. Болгоомжил, болгоомжил. Ээ дээ хүн гэдэг амьтан гэнэхэн бөгөөд эгзэгтэй шүү» гэж бодогдоход хэсэг зуур түг түг түгшин цохилсон зүрх хэвдээ уужрана.

## VI

Гомбодоо цасан шуургатай тааралдаж хээр хонон өрөөсөн хөлийн хурууны үзүүр, хацраа хөлдөөж сар гаруй хол ойр гадагш гарсангүй ээ.

— Лхам аа! Цаад мангар чинь жаварт илүүлсэн төдийгөөр баширлан хэвтээд байнаа гэхэд,

— Иш чааваас, Дулдай минь, юунд ингэж буруугаар мушгина вэ? Гомбодоо Гүнчин хоёр шиг гарын доор хүн хэзээ ч олдохгүй шүү! Чи ямарваа юмыг эрэгцуулж бодоход яадаг хүн бэ? гэвэл Дулдай,

— Энэ хоёроор дутахгүй ээ! Одоо юм, юм нарийсаж засаг тэртэй тэргүй бидний гараас зарц нарыг салгах гэж байна. Дулдай малаа маллаж, махаа идэж чадна аа. Зарц нарын хүчинд өөдрөг явдаг айл гэвэл аав ээжийн буян, алдар нэр, аз хийморьт муу бишүү? Хэдэн малын хошуу эргуулж тойруулахад юухан байх вэ? Одоо өөрийн биеэр аялуулах цагтайгаа золгосон гэж мэдээрэй. Энэ хоёрт өгдөг хөлс, тэр их юмаа аминдаа хэрэглэвэл... Энэ зун зүгээр муу овоохойтой нь таягдаж орхиё. Харин хэдэн шааран мал тасдаж өгөх нь зүйтэй. Түүнээ ганц өвлийн зудад нүд аниулж, хормойгоо сэгсрээд хоцроно. Тэгээд хамтрал хомуунд орж амныхаа багтаамжаар чихэж, голио шиг таргалах байлгүй. Хомуун Гомбодоог дарга ч болгох байлгүй гэж ёжин өгүүлнэ.

## VII

Тэр нэгэн өвөл Дулдай адуугаа оторт өгөхөөр ирэхэд адуучдын дунд үнэгэн лоовууз шиллэж тависан, хар хурган нударгатай цагаан нэхий дээл хөөргөж бүслээд, омголон борлог морины нуруун дээр хондгой сууж, хусан уурга суналзуулан байгаа хүнийг Гомбодоо гэж таньжээ.

— Амархан сайн байна уу? Дулдай гуай гэхэд.

— Мэнд сайн байна. .

— Та надад хэл өгчихгүй. Тэгсэн бол би очоод авчихгүй юу гэхэд Дулдай,

— Мэдсэн сэн бол тэгдэг л байж. Ах нь ядарч байна хэмээн үг алдахын даваан дээр амаа татаж,

— Ямар ч атугай хэдэн малынхаа хойноос дагаж яваад төөргөө харна гэж зүрхшингүй боловч зуунги хэлэв. Буцах замд Дулдай шөнөдөж, авгайдаа уур унтуу болон ирэв. Тэрбээр буурал сортой улаан үнэгэн малгай хулгавчлаад хоёр тал нь цацган үзүүртэй хуучирсан зузаан хар ороолтоор хүзүүгээ ороож боосон мөртөө хоёр хацраа жаварт хайруулж тийнхүү уурласан ажээ.

— Хайран бор халзан хуц минь! Яахаар хуц, ухна ийм амархан турж үхдэг байнаа. Хар бух өргүүлээд хэд хонолоо. Бас л мал болохгүй нь ээ гэж шивнэн халагласаар орж ирсэн Дулдай, эхнэр Лхамд хандан,

— Тэнгэрийн царай нэг л биш. Энэ хавар ч жавар болох нь шиг бололтой. Шар тос бий юу? жаахан үнэр түүлээд тогоо, тогоогоор хар цай чана. Турж эцсэн хэдийн ам хамраар цутгаад байя. Тэгвэл ганц хоёр нь ч эсэн амьд хоцорч магадгүй. Түүний алагтай хэдэн амбан шараа сайн тордьё. Ачлаганы хэдээсээ салж, ачлага гуйхад хүрвэл дүүрч үхэж байгаа нь тэр гэж цухалдана.

— Хөөе Дулдай. Урьд шөнө хонь ямаа нийлсэн долоо нүдээ аньчихжээ гэж Лхам гайхаш

тасарсан янзтай хэлэхэд Дулдай,

—Би түүнийг босгох биш, дуулаад яахав. Доройтоход долоо бүдрэнэ гэгчээр нэг шөнө заавал долоогийн тоонд хүрдэг нь ч юу билээ дээ! Багшийг залж арга чарга хийлгэе гэв.

Багш ламыг залж бурхан шүтээнээ аргалуулж, мал хотоо аршаанаар ариутгуулсан шөнө тугал бяруу, хонь ямаа арвын хөл амарсны дотор сүүтэй хүрэгч үнээ орсон нь гаслаад гаслаад баршгүй гарз болжээ. «Лут гай барцад байна гэж багш лам айлдсан үнэн боллоо. Хэдэн мал ямай, гайндаа гарч л байгаа биз. Гурван хар толгой эсэн мэнд байвал болох нь тэр. Ер нь Гомбодоо Гүнчин хоёроо эргүүлж хаяандаа буулгахгүй бол горигүй болох нь шиг байна. Тэр хоёрыг маллаж байхад өнчин ишиг ч үхэж байсан удаагүй. Би очиж хэлэх нүүрээ барсан хүн. Лхамыг л явуулъя. Дараа нь өөрөө очиж болох юм. Тэгэхдээ хоёулангий нь гарыг олигтойхон цайлгах хэрэгтэй. Тэгсэн байхад эргэж ирээд зүүж сурсан бөгтөр буулгаа хүзүүндээ углахгүй хаа зайлна» гэж удан сэтгэлд эрэгцэх бодлоо зөвтгөн өөрөө өөртөө хий бахархан баярлана.



# Арван нэгдүгээр бүлэг

## Отолт

### I

Хамсаатан гурав хадны ард хоргодож, их замыг нүд чилээн отно. Замын овон товон бут сөөг, түхгэр түхгэр богц тэгнэсэн ачаа бараа бүхий морин хөтөлгөөтэй өртөө улаагаар аялагчид яваа мэт үзэгдэн хий үзэгдэлд илбэдүүлж тэд гайхан эргэлзэнэ.

Энэ үед хотос хонхорт бүүргэнд жолоо сойж, цулбуураар хөвөрхий тушсан гурван морины хааяа хааяа тургих чимээ сонсогдоно.

Хурган дотортой хүрэн чисчүү хувцсаа өмсөж, халиун лоовууз хэлтгий тавьсан ахимаг эр зэрэгцэн хэвтэж байгаа залууд өрөөсөн нүдний дуран өгөхдөө,

— Холоос бүртэлзэх төдий бүдэг бараа олж харлаа, Нөгөө хэдэн гайхал мөн болов уу гэж санана. Гэвч чи олигтойхон дуранд гэж аагирхан хэлнэ.

— Гүртэмбэ ламтаан! тав зургаан морьтой хүн айхавтар ширүүлж явна. Нэг доор бодь мөрөө хөтлүүлнэ гэсэн үг үү? Эдэнд юун лай нь зузаарсан амьтан улаа нэхэж яваа бол гэж онгирон хэлбэл ахимаг эр,

—Элэнцэг хулинцагийн чинь гүртэмбэ лам бэ? Энд чинь тэгж ламтах газар уу? Наад ойворгон амаа татаж, цаг дээрээ сум газардахгүйг хичээ. Цагдаа нарын харц наад муу дурангаас чинь илүү гэж мэдээрэй! Тэд саахалтын газраас бараа үзэж, чимээ сонсож үнэр авч чаддаг увидаст улс шүү! гэж анхааруулна.

Туршуул гэж нэрлэгддэг залуу хархүү дуранг барьж тавин бодлогширно. «Олз их олно. Тэр үнэт ачаа тээш ямар унаагаар хэдийд гарахыг мэдээд ир гэхээр яг л мэдээд ирсэн билээ. Гэтэл тонуулч энэ хүн царай хөрзийлгөн хүйтнээр хяламдаж байх шиг харагдах юм. Би ер нь санаа муутны ятгалганд автагдан гэнэдэж байгаа бололтой. Сумын дарга намайг ажил хий, эсхүл цэрэг, сургууль хоёрын нэгэнд яв. Ингэж дэмий тэнээд юу хийнэ. Аягүйтвэл хулгай худлын хэрэгт ч орооцолдож болно гэж хэлсэн. Ер юу гэсэн үг болж таарах нь вэ?» гэж эргэлзэн байтал,

—Дуранд, дуранд гэх албадлагын үгэнд бодлоо тасалж харвал морьтой хүн биш, яах аргагүй машин үзэгдээд замын гүдэст далдлагджээ. Тэгээд машин гэхийн оронд,

— Морьтой хүн гэж уулгалснаа хархүү анзаарсангүй ээ. Дээрэм тонуулын толгойлогч буу гардан өндийж,

—Бидний гарт орох олзыг авч яваа элч нар байлгүй. Нар орой болж байна. Дөхөж очоод хажуугаас нь гэнэдүүлэн дайрна даа гээд босож мордон хөдлөхөд хоёр эр дагалдав.

Эрвэн сэрвэн мод хяр дээгүүр өнгийсөн намхан уулын зүүн хаяагаар хэдэн нугачаа жалгын

амыг хөндлөн огтолж бэллэсэн дэвсгийн эгц хажуу барин давааны ар өөд өгсөх замын цасанд дарагдсан их өргөн харгуйгаар үе үе хар хөх утаа баагиулан хаялж, урагшлан буй ачааны машины жолооч хурд нэмэн жирийлгэнэ. Ачааг сэргийлж нуруу нийлүүлэн дээр суусан хоёр цагдаагийн босгож барьсан винтов бууны аманд салхи шуугин исгэрч сонсогдоно.

Жолоочийн хажууд суугаа бага дарга Нэмэх хол замд алжаан уйтгарласан сэтгэлээ сэргээхээр хааяа хааяа сонин яриа дэлгэвч сэрэмж болгоомж алдан осол болж болно гэж цэнэн бие барьж явахдаа зам дагуу, орчин тойрныг анан ажиглана.

«Энэ Шимээн бид хоёр анх мөн ч хөглөж билээ. Ёстой түс тас эр дээ. Ийм хүнтэй хамт явахад хичнээн таатай...» гэж бодоод хөгжих сэтгэлээ барьж ядан мушилзан инээмсэглэнэ.

—Юу бодсоон? Хүүхэн санасаан...гээд Шимээн мушилзахад Нэмэх,

— Нэг хүүхэн зүрхнээс уяатай байдаг болсон, түүнээ л бодож явна. Үгүй хө есөн жилийн өмнө тэр нэгэн өдөр би арван тавны цагдаа нэр зүүн дэглэм сахиулах гэж будилж явлаа. Тэтэхэд та хувьсгаалч хүмүүсийн үгийг олон түмэнд хэлмэрчлэн дамжуулж байхдаа индэр дээрээс намайг харахад би бас олж харж билээ энэ бүхнийг бодохоор насан туршид дурсагдах нандин дурдатгал шүү гэхэд Шимээн,

— Тийм ээ. Тэр бүхнийг дэлгэн сөхвөл сонин сайхан, бид хоёр аз заяатай улс. Цагаан дээрэмчдийн гарт үрэгдсэн бол өдийд яс ч байхгүй байгаа шүү дээ. Одоо ч цагдан сэргийлэхэд том дарга, би тээх нэвтрүүлэхэд жолооч болчихоод шинэ замд өөрөө буу барьж, би залуур залж улсын чухал ажилд явж байгааг санахаас сайхан байна гэв.

Сэтгэл баясан бадарсан яриандаа болж яваад Шимээн хурдаа ихэд нэмснээ ч мэдсэнгүй ээ. Нэмэх нөхрөө итгэл төгс харж,

— Шимээн! Би том дарга биш, бага дарга шүү дээ! Харин албаны хувцас, зэвсэг хоёроор том харагдаж болох л юм гэж хөгжилтэй хэлснээ харц гэнэт бишдэж өөрчлөгдөж,

— Шимээн! Тун анаж яваарай. Энэ давчуурч байгаа ам өөд өгсөхөөр дотор жигтэйхэн сэрхийлээ. Биднийг аймгийн төвөөс замд гарахад дотоодыг хамгаалахын төлөөлөгч «та нар тун сэрэмжтэй яваарай. Юмыг яаж мэдэх вэ? Гүйцэд сайн шалгаагүй болохоор дайсны отолт тохиолдож магадгүй юм шүү» гэж захисан. Бидний авч яваа ачаа, дээрэмчдийн хорхойг годгонуулж болно. Таван түм гаруй мөнгөн зоос, төгрөг, бага зэрэг алт, олон зуун лан цагаан мөнгө, бас бус үнэт зүйл байгаа юм. Зам саадгүй явж улсын санд мэнд тушаавал санаа амрах нь тэр гэхэд,

— Энэ юун их мөнгө вэ? гэж Шимээн сониучлан асуухад,

— Их учиртай мөнгө өө! Ядуучуул ихэс дээдэст зээлдүүлсэн юмаа эргүүлэн авч, та бидний сан хөмрөгт нийлүүлэх гэж явна шүү дээ гэж Нэмэхийг хэлэхэд Шимээн тас тас хөхөрч,

— Зээлдүүлсэн биш, мөлжүүлсэн мөлжүүрээ эргүүлэн авч байгаа юм биш үү гэсэн ёжтой үгийг Нэмэх таашаан,

—Шимээн! Чи яг онож хэллээ гээд хөхрөнө. Зайвар зам өгсөн хүч нэмэн зүтгүүлж дөрөлж дээр гарч ирэхэд Нэмэх,

—Энд түр зогсож, жаахан амраад хөдөлье гэв.

## II

— Тэднийг цааш хөдлөхөд нар хариугүй жаргах дөхсөн байв. Ачаан дээр суусан цагдаа нар явах замын чиглэлд буун дуун хэдэнтээ сонсогдсон бүдэгхэн чимээг бага даргад хэлэв.

Хад асга аагилсан шовх уулын зүүн талын сүүдэр буусан замаар том том хөмөн богцтой юм ачсан хөтөлгөө морьтой хоёр элч, улаачийн араас мөр даран ергүүлнэ.

Ойрын бараа тасран үдшийн жавар сэнгэнэн үлээх хоромд замын баруунтай буун дуу хэд дахин нүргэлж үдалгүй үл мэдэгдэх хүмүүс өртөөчид рүү дайрав. Элч, улаач нар морьдын ам татан зогсвол довтлогчид элчийн нэгийг цохин унагааж, улаачийн гараас ачаатай морьдыг бүлааж эгэн зугтаахдаа машины гэрэлд орж ийш тийш займчин сандарч зарим нь харсан зүг буудна.

Дээрэмчдийн толгойлогч амжин ухасхийж залуу эрийн багалзуурыг шахан,

—Чи наад хоёр ёлтгорыгоо ухаж, хон хэрээнд хаяж өгвөл таарна. Туршуулаар яваад эргэж ирэхдээ «олон түмэн мөнгөн янчаан ачсан хөтөлгөө морьтой элч нар өртөөгөөр гарахаар бэлтгэж байна гэсэн чинь аль вэ? Ёстой олзолбол зохих ачааг машинд ачсан гэдэг нь маргаангүй. Чи мөн сайхан чадав аа, чамайг даа...» гээд буугаар огцом гар сунган зангаж,

—Бууж өг. Бүслэгдсэн гэдгээ ойлгоорой гэх үгийг сонссон эр нүд ирмэх зуур ухасхийн харанхуйд алга болжээ.

Аль ч учраа олохгүй дэмий гүйж явсан залууг элч харж, гүйцэж очингуут бүдүүн суман ташуураар шилэн дундуур нь буулгахад түрүү урагшаа харуулдан унажээ. Элч эргэн алхах гэтэл хаанаас нь цохиж байгааг бүү мэд, дагзан дээр нь дан хийлгэхэд салхинд хийссэн малгай адил болов.

Машинд явсан цагдаа нарыг ирэхэд цохигдож унасан элчийн дэргэдээс боссон залуу зугтах гээд баригдав.

—Нэр хэн бэ? Хэнтэй нийлээд юу хийж яваа чинь энэ вэ? гэж бага дарга Нэмэх шалгаахдаа харцаа буруулж, хэлээ зуусан залуу эрийг өрөвдөж «би анх Цогоо цагдаад баригдахад үүнээс ч дор байсан байх аа. Дээрэмчний ятгалганд орсон хөөрхий амьтан байлгүй» гэж боджээ.

—Миний нэр Цэвэгсүх. Гунгаадэчин гуай л намайг өөртөө хань болбол их мөнгө өгнө гэсэн юм. Тэгээд л би ингэж баларч явна гэжээ. Бага дарга Нэмэх элч нарт хандаж,

—Та бүгдийн юм бүрэн үү? Юу авч яваа улс вэ? гэв.

—Юм бүрэн байна. Бид хураагдсан түүх дурсгалын ном судар, эд юм авч явна. Дээрэмчид

МӨНГӨ ЗООС ГЭЖ АНДУУРСАН БАЙХ АА ГЭВ.

—Тэр ч ортой л байх. Та бүхний хүргэж яваа энэ зүйл бол хэдэн түмэн зоос, мөнгө төгрөгтэй зүйрлэх зүйл биш. Алтнаас илүү үнэтэй чухал эрдэнэ авч яваагаа онцгой анхаарч сэрэмжтэй яваарай гэж бага даргын хэлэхэд элч улаач нар толгой дохицгоов.

Шөнө дөл болж нам гүм, анир чимээгүй байв.

Цасан цагаан хучлагат уул толгодын бэл хормой, даваа гүвээ, тал хөндийн замаар түнэр харанхуйг хага зүссэн цагаан гэрэл тэмтчих шиг агаад, машины намуун жигд хүнгэнээ нүрэглэж Шимээн, Нэмэх хоёр хууч хөөрч, нойр сэргэг явна.

Юмны хамт машинд дайгдсан элч нар, дээрэмчин хархүүг хүлж андлах байх гэж санажээ. Тэгсэн залуу эрийг сул суулгасанд бүүр гайхаж түүнээс зэвүүцэн сэргийлнэ.

«Жолоочтой хамт сууж яваа дарга надад ширүүлэх байтугай толгой илэх нь халаг байдаг ямар учиртай юм бол?...За яахав дүүрсэн хэрэг, дүмбийсэн толгой» гэж залуу эр, эргэж хургасан бодлоо цагаатган шулуутгана.

Нэмэх, үнэт зүйлээ тоо ёсоор тушааж дуусаад гэртээ харих замдаа хүлээлгэний хар гэрт царай алдан өлсөж цанган, бодлогоширч байсан Цэвэгсүхийг дагуулж гэртээ аваачаад хооллож ундлаад тавтай амраажээ.

— Цэвэгсүх ээ! Чамайг ажилд оруулна. Чи дургүйцэхгүй биз? гэж Нэмэх лавлахад залуу толгой маажин нүүр улайлгаад,

— Ямар ажилд... Би хийж чадах болов уу? Шоронгийн ажил хүнд байдаг уу гэж хэлээд санаа алдав.

— Чаднаа, чадна. Чадах чадахдаа чи бүүр сайн хийх хүний нэг гэж бодож байна. Чамайг дарга нарт ярьж байж цагдаа болгоно гэхэд Цэвэгсүхийн нүд ихсэн,

— Цагдаа гэнэ үү? Цагдаагаар над шиг амьтныг авах болов уу. Хэрэв авбал би ч... гээд бага дарга өөд баяртай харав.

### III

Өөрийгөө малын эрэлчин гэж нэрлэсэн ханхар эр хоног таарсан айлаас үүр шөнөөр мордож шугуйд морио чөдөрлөн довцгийн орой дээр гарав. Ийш тийш дурандахад нарийн голын эргийн ойролцоо буусан онцгой ганц гэр сэжиг төрүүлжээ. Хоёр өдөр дараалан ажихад өглөө, орой яг тогтмол цагт ганц бие хүүгийн гэрийн урдах эрэг дороос ус барихаар орох нь тун содон үзэгдэв. Тэрбээр ойр орчимд морьтой, явган хүн ирвэл гэрийн гаднах ойр зуурын ажил аялуулсан болж дуу аялан гиншинэ. Шөнийн цагаар отож харуулахад тэднийд хүн хар огт ирэхгүй. Малын эрэлчин явж ороход гэрийн эзэгтэй оёж байсан юмаа бушуухан хумхиж орон дээр тавиад тэрлэгээр бүтээнэ. Баруун хатавчинд нойтондуу тал мах жижиглэн борцолж өлгөснийг битүүхэн хяламдаж «малгүй ч гэсэн айлд мах байж болноо. Гэхдээ хэнийхээс хонь

авсан, хэн гаргаж өгснийг асуухад нэгийг хэлж, хоёрыг заана» гэж бодсон мөртөө энэ удаа сэжиг цохиулахгүй гарах нь зөв гэж шийдэв.

Эрэлчин өглөө эртлэн ирж хүүхний ус авдаг сэтэрхий эргээр орж бие нуун эргэцэн ажиглавал хүүхний гутлын мөрнөөс гадна, том палигар мөр байгаа нь ямар нэгэн эрэгтэй хүн байна гэдгийг гэрчилнэ.

Багийн даргын хамт ирж хүүхний гэрийг нэгжихэд хэн ч байсангүй. Урьд өдрийн оёж байсан зувцаа дээлийг гаргуулж, хэнд хийснийг хүүхнээс лавлахад худалдаж хэдэн төгрөг олох санаатай хийсэн юм гэжээ.

Хонь хэзээ, хэнээр төхөөрүүлснийг асуувал хүүхэн тэвдэсхийж царай хувисхийлгээд «өөрөө голыг тасалсан гэлтэй биш дээ» гэсэн бодол зурсхийн буухад,

— Явуулын танихгүй хүнээр гэв.

— Хонь өөрийнх үү?

— Минийх биш, тэр хүнээс авсан юм.

— За тэгвэл тэр хулгайчийнхаа байрыг зааж өг гэж тулгахад хэсэг зуур гөлөлзөж байснаа,

— Манайд нэг өнжөөд л явсан. Ганц бие ядарсан бүсгүй чамд гай болно... хэрэггүй, хэрэггүй гээд явна билээ. Би орон гэр нь хаана байдгийг асуугаагүй, тэр хүн би тэнд байдаг гэж хэлээгүй гэж яриут гал дээр тогоо тавьж цай үйв.

— Сайхан сэтгэлтэй л хүн юм гэж эрэлчин хэлээд юмыг нэгжиж эхлэхэд хүүхний царай хувисхийж зүүн талын цоохор нүүртэй модон орны хөл дээр ялхисхийн сууж нүүрээ даран уйлав.

Хуучны гурван зуугаад янчаан, цул мөнгө хоёр хэсэг, мянгаад төгрөг гарахад хүүхэн «ямар гээч муухай юм болж байгаа нь энэ вэ? энэ чинь миний талийгаач нөхрийн үлдээж хоцроосон өв» гэж үглээд муухай муухай харж зэвүүцнэ. Хүүхнийг гэрт нь хөл хорьж харгалзуулаад эрэг дагуу шалгаж үзжээ. Ёроолоор ус эргэлдэн ногоорч буй эргийг дээд талаас дүүжингээр бууж магадлахад эргийн дунд хирд дотроос шорооны өнгө дагуу өвсөөр ам бөглөсөн нүх байхыг харжээ, «Эрэг хавьцаа оромж байж магадгүй гэж таамагласан маань....» гэж эрэлчин эр товлон бодож,

— Энд байгаа хүн гараад ир гэж шаардахад таг чиг. Цаасан цэнэгт сумаар хэд хэд буудавч нэмэр болсонгүй. Нүхний чигт эргийг дээрээс нь сэт цохиж, амыг уужимсгаад адууны хомоолоор утахад

— Амь алдлаа гэж цухалдан бархирах дуун гарч галтай угаан дундуур ам хамраа таглан амь түүс гарч ирсэн хүн оргодол хулгайч Шагдарын Дэчин байв. Нүхэн оромжинд хийсэн нэгжилгээр олон сумтай бярдан буу, өчнөөн мянган төгрөг, алтан бөгж, чулуун соруул мэтийн үнэт зүйл гарчээ. Оргодлыг хүүхэнтэй нүүр тулгаж,

—Хонины аминд холбогдолтой нөгөө явуулын хүн мөн үү? гэж асуухад хүүхэн «мөн» гэж ганц үгээр батлан өчжээ.

— Нэмэх ээ! Би чамаас өршөөл гуйхгүй ээ. Гуйх ч нүүр алга. Харин сайн хоол унд идэж уулгахыг хүсье гэж Дэчин хэлээд горилон харахад,

— Яарах хэрэггүй. Юу л идэж ууна, идэж уу! гээд мах чана гэж хүүхэнд хэлэхэд хүүхэн тогоо дүүрэн мах үйж, галаа гар татахгүй өрдөнө.

Дэчин мах идэх зуураа «Дулдай Гомбодоо хоёрыг барьж хэлүүлэх хэрэггүй, хожмын ашгаа бодох хэрэгтэй. Өөд бологч Далайбуяны даршлуулсан эд мөнгийг тэднээс салгах арга бий. Хураагдлын хөрөнгө, мөнгөнөөс дээрэмдэх гэсэн маань бүтэмж муутай болсон боловч намайг авсан гэж тулгах баримт эдэнд байхгүй. Нөгөө муу зүрхээ зүсүүлсэн залууг нүүрэлдүүлбэл зад мэлзээд давчихна. Хоршоо тоносноо Жамсранчой руу бухаж болно. Цагдан сэргийлэх надаас юу олж долоох вэ? Шоронд арваас илүү хонохгүй дээ. Хүлчихвэл л хэцүүднэ. Гэсэн ч...» гэж бодно.

Өртөөний хашин хулын нуруун дээрх янгиа эмээл өгзөг холгон хорсгоход Дэчин огт юман тоонд бодохгүй, хоёр хөл нь дамрын товшуур гэлтэй давьчин сүүл хөдөлгөнө.

Бага дарга Нэмэх байн байн оргодлын гарын хүлгийг ажин харсаар л явна.

Цагдаа л харвал, Дэчин нүүр буруулдаг заншилтай болохоор төв засан сайжруулахын гянданд хорихоор тууж яваа залуу цагдаагийн нүүрийг харахгүйг хичээв.

Арван тавны цагдаагаас ардын цагдаа болж арваадхан хоноод хөөгдсөн хархүүг таньсан Дэчин зог тусаж, Зүүн мөрөн дээгүүрээ хагас эргэн хараад,

—Дүү минь ээ! уулзъя гэхэд хархүү эргэж ирэв.

—Ядарсан муу ахыгаа суллаж өгөөч. Чамд ах нь бэлэн нэг мянга, дараа хоёр мянган төгрөгөөр шагная гэж хэлснээ гэнэт анзаарч, доош харав.

—Гунгаадэчин гуай! Та бас л мөнгөрхөж явдаг хэвээр үү? Би таны бузар хавханд хавхлагдаж байсан гэнэн хонгор Цэвэгсүх чинь байна. Та замын хүнтэй дахиад ийм тийм үг бүү ярь! Эргэж харалгүй чигээрээ яв! гэж захирангуй хэлжээ.

Нэг хоногийн дараа Дэчин шоронгийн хуяг нарын хий зайг тааруулан нарийн мэх хэрэглэж хорих газраас оргож ор сураггүй арилжээ.

# Арван хоёрдугаар бүлэг

## Гэрэлтуяа охин

### I

Хотоос хөдөөд шуудан хүргэхээр тэвш дүүрэн ачаатай «аам» машинд суусан зорчигчид бороо ус, шавар шалбаагт замын сааталд мунгинасаар өглөө нар хөөрсөн хойно голын гарман дээр ирж зогсов.

Гаднаа мухлаг тэрэг тавьсан шинэхэн хөх майхнаас хэдэн хүн гүйлдэн гарч ирснийг харвал хүрээ Вандан, пүүсний бичээч агсан Арвинсан, усч өвгөн нар байв. Тэд ижий ахай болон мэнд ус мэдэлцэн, зочдоо майханд урив. Хоол унд идэж уух хооронд усчин өвгөнтэй яриа хөөрөө тохирч, голыг сал онгоцоор гатлах болжээ. Вандангийн морин тэрэгний гол хугарч саатсан учир Арвинсан авч явахыг хүсэхэд жолооч дуртай зөвшөөрчээ.

Усч өвгөн хайнагийн шаранд хөллөсөн хөндий модон сал онгоцоор дөрөв таслан зөөж гарахад тэд ачаа бараагаа тавтай янзлан засаад баяр хөөртэй цааш хөдөлцгөөжээ.

Хар бараан үүлс гэнэт тал талаас хуран нүүгэлтэж, ширүүн салхитай аадар бороо хувин саваар ус юүлэх адил цутгав. Усны эрэгт буудаллахаар яваа машин, шавартай замаас дайжин тойрох гэсэн нь талаар болж намгийн бамбалзуурт хойт хоёр дугуй тал дундаа хүртэл шигдэж, яах ч аргагүй болж мухарджээ. Хувцас хүнар нэвтэрч нуруод хүйт оргиулан жиндүүлнэ. Удсан ч үгүй үдээс хойш аадар бороо намдсан боловч зүсэр бороо үргэлжлэн нэлийж эхэллээ. Хоногийн дараа нэлэнхүйдээ усанд авахуулсан бургасан шугуйт арлын дунд зоогдсон хэдийн хувь заяанд золгүй явдал тохиолдож болзошгүй болоход зарим нь сэтгэл санаагаар унаж гутрах шинжтэй болжээ.

Бие давхар эхнэрээ төрөхөөс урьтаж эцэг, эхийг бараадуулахаар нутгийн түр чөлөөтэй яваа бага дарга Нэмэх, арилжаа наймаа хийх далиманд Дулдай баянтэй уулзаж Далайбуян данжаадын амьд сэрүүндээ хадгалуулсан мөнгийг авахаар яваа Арвинсан түүнд газарчлагч хүрээ Вандан, зам зуураас машинд суусан Намжаа авгай, жолооч Шимээн нар цөм л дуу шуу хурааж дор дороо хөдлөлгүй сууцгаана.

Бага дарга Нэмэх хүрэн жигүүнэн тэрлэгээ тайлж бор ногоон цэрэг цамц өмсөж дээр нь тэрлэгээ давхарлан өмсөөд хуучивгар цайвар шар дурдан бүс чанга бүсэлж эргэн суухдаа,

— Бид хүнд байдалд орж магадгүй боллоо. Гэлээ ч гэсэн мууг бодож сэтгэл дэмий зовох хэрэггүй. Тэсвэр тэвчээрээр хатуужиж, бэрхшээл бүхнийг давнаа гэдэг зөөлөн хоол заглаад залгихтай адилгүй. Тийм биз, Вандан гуай?...

— Тэр үнэн гээд Вандан хуурамчаар инээмсэглэж энэ тэр хүн рүү харна.

— Яваандаа амь насанд хүрэх ч явдал тулгарч тулалдах ч юм билүү! бүү мэд. Хашир ах, эгч нар юу эс андах вэ? хувь хувийн аяганы хийцийг ариг гамтай хэрэглэх нь хэрэгтэй байх шүү

гэж Нэмэхийг хэлэхэд Арвинсан урт гуулин гаансанд нэрсэн тамхиа асааж утааг хүчтэйгээр хөхөн сорж хамрын нүхээр савсуулан суухдаа ийнхүү бодно. «Энэ цагдаа өөрөө идэх гэсэн нарийн ухаан зарж аяганы хийцээ гамна гэж тушааж байгаа царай энэ дээ» гэсэн дотуур тамирт сэтгэлдээ хөтлөгдөн мантуу, бор еэвэн, танзуур, боорцог голдуу хийсэн тааран шуудайг дарлаж үзээд ар нуруугаараа налж тухтайяа сууна. «Даанч болж бүтэх тавилангүй юм даа. Болдогсон бол жаран хараа эвлүүлэн зүйж завь хийгээд амь зугтан зайлах юм сан» гэж хүрээ Вандан хийсвэр хүслэндээ хөтлөгдөн мэлэрнэ. Вандан хонины болгосон мах, тос даасан том том самнаа боов шар тосон чамартай арвайн гурилтай хар булигаар даалингаа дэргэдээ ойртуулж, дүүрэн юм чихээстэй гурван шуудайгаа битүүхэн ажиж сууна. «Хэрэв энэ улсыг муу юманд хүргэвэл яанаа. Одоо яадаг хэрэг вэ? Нутгийн айлд хэл хүргэе. Голын усыг сэлээд үзвэл яадаг бол...» гэж Шимээн сэтгэл зовнин шанална.

Мушгирсан хүрэн улаан хоормог хором бүрт эрч хүч орж, амь голтой амьтан байтугай ургаа мод, бут сөөг, хад чулууг орвонгоор эргүүлж урвуулан урсгах, усны шуугих чимээ үлгэр домогт гардаг усан галавын тухай санагдуулна. Хүрээ Вандан, хүрээний ч биш, хөдөөний ч биш бүүр хөрзгөр царайлж салдааз цув толгой бүтээн нөмөрч, булигаар даалингаа дэрлэж хэвтэв. «Завхай мод, зартай модонд цохихгүй. За! анхны ганц цохон гараагаар алдаа хожоогоо авнаа хө. Баржаан жамц, далайн хөөс. Бажгар арваар суусан. Гараа тат» гэх үг чихэнд нь сонсогдож даалууны шажигнах дуун сонсогдож, хожсон мөрий нүднээ тусаж зүүдэлсэн Вандан «аавын хүү аз байхад ёоз хүүгээр гэр барина гэж энэ дээ» гэж хашгираад өндийхөд Арвинсан,

— Вандаан сэр, сэр гэж дээлийн энгэрээс угзчина. Зүүднээс сэрсэн Вандан сэтгэл гонсойж эргэн толгой дээгүүрээ цуваа нөмөрч хэвтэнэ. Арвинсан хоол хүнстэй хүүдий савны уяа боодол хөдөлсөн эсэхийг нууцгай шалгаж, чийг татсан хар хүрмээ сул нөмөрч, давхар өмдний нууц халаасаа тэмтрэн дадмаг дарж үзээд «хай, яа» гэж сэм халаглаж шүүрс алдан толгой сэгсэрнэ. «Энэ нэг гэдсээ чирсэн амьтан бушуухан шиг хоёр яс хагацаж эсэн мэнд амаржих болтугай. Бурхан гончигсүм минь, өршөөж хайрла» гэж Намжаа авгай Сайнзаяаг ширтэн ханцуй дотроо сэмхэн наманчлан залбирна. Арвинсангийн сайхан зан хөдөлж манж зан гарган «хоёр мантуу шоо дөрвөлжин зүсэж, нэг ширхэг танур дайвартай өгөхдөө «энэ ч ихэдлээ, тэр ч багадлаа» гээд нэгийг нөгөөгөөр сольж нарийлах нь тэдэнд залхуутай мэт санагдавч, энэ хишгийг хүртэе гэж тэд бодохоос урьдаар цаг нөгцөөж зугаа болгох нь илүү санагдацгаажээ.

## II

Дөрөв дэх өдөр огторгуй хаяа шуун цэлмэж, нар хөөрөн ээхэд Нэмэх эгц дээш босон гар алдлан суниаж хөгжилтэй чанга дуугаар,

— Тэнгэрийн муу арилдаг, хүний муу арилдаггүй гэдэг зүйр үг үнэн гэж үү?... Дөрөв хоног аг таггүй цутгачих юм даа гэхэд Вандан гэнэ алдахгүйг хичээж,

— Тийм нь ч тийм байж болноо. Би ч бүүр хүүхэд байхын хүний юманд шунаж үзээгүй хүн юм шүү! Надаас өлгөж авах ганц сайн нь л тэр гээд таг дуугүй болж ийнхүү бодов. «Тэр жил яалаа! Эхнэр бид хоёр даалуу маалуунаас сэдэгдэн бөөн маргаан болсон. Тэгээд яалаа? Олс дээсний тасархан барин амь насандаа хүрэх дээрээ тулж явахад энэ цагдаа аминд орсныг нүд шалдлах газар байхгүй» хэмээн Вандан дотуураа таашаан дурсана.



Тав дахь өдөр үерийн хүч буурсныг, тэмдэг болгон тавьсан юмаар мэдэцгээж баяр хөөр болов. Арвинсан толгой ганзагалан урвайж таг дуугүй санааширна. Вандан хашир эрийн буурь заах гэж Нэмэхийн чихэнд хошуу цорвойлгон «зарим хүн үхэхээ болохоор ингэж лойдог гэнэлээ. Тэр нь болсон байх» гэж шйвнээд Арвинсанд хандаж,

—Таны бие барагтайхан байна уу? хэмээн сэтгэл зовсон дүр үзүүлэн шалгаахад Арвинсангийн нүүрний арьс ганц атга болон хумиран үрчийж,

—Цаад шөнө айхавтар том хүйтэн гар цамцны дотуур шургаад хөх мах хавьд тэмтчин юм эрсээн шүү! бас хоолой чанга базсаан. Би цагдаа гэж хашгирсан шиг санагдана. Энэ шөнө бүүр муухай зүүд зүүдэллээ. Амин тэжээл хэдэн төгрөгөө усанд урсгаж алдаад хөвж байхыг харж ухас хийгээд орсон чинь амаар ус балгаж үхлээ гэж зүүдлэв. Энэ их муу ёр. Юу болноо, бүү мэд гээд урт гээч санаа алдаж толгой унжуулна.

### Ш

Энэ мөчид Сайнзаяа өвдөж, цөм түүний төлөө санаа тавьцгаав. Сайнзаяагийн царай минчийн хүрэнтэж, байсхийгээд л царай ярвайлган гэдсээ дарж, нулимс цийлэгнүүлэхэд Нэмэхийн яс яйрах мэт болж түшин сууна. Шимээн, Вандан хоёр яах ийхийн чөлөөндгүй машины ачааг тэгшлэн засаж, жолоочийн зөөлөвчтэй суудал, аравчаар ор засаж Сайнзаяаг хэвгүүлэх гэхэд тэрбээр байж ядан, босож суун ёолдог болов. Намжаа авгай, Сайнзаяаг сугадан тэвэрч, аман дотроо маани мэгзэм дүнгэр дүнгэр уншина. Арвинсан царай ярвайлган амьсгаадаж хэрдээ сүрхий тэвдэж,

— Энэ бүсгүйг би жаахан түшин тэвэрч сууяа. Ёстой юм ёсоор гарна, гайгүй гайгүй, битгий айж сандар гэж цайлганаар анхааруулна. Хүүг авах ээжийн тухай ярилцахад Вандан, Арвинсан хоёр үнэхээр үзээгүй гэж үнэнээ ам өрсөлдөн хэлэв. Шимээн «хараад сууж байлтай биш дээ. Болгоно доо» гэж бодоод чухам яахаа төсөөлж мэдэхгүй гайхан байв.

— Би тун дүй муутай шүү! Тэгэхдээ болгох нь болгох л байх гэсэн Намжаа авгайн үгэнд Нэмэх сэтгэл жаахан уужирч,

— Өлгий яах вэ?

— Хамаг чухал юмаа мартаж байгаа юм байна гэхэд,

— Тэрлэгнийхээ өнгийг хуулаад боочихье гээд Нэмэхийг босоход,

— Хэрэггүй, хэрэггүй гэж Шимээн хориход,

— Вандан гуай! Танд илүү дутуу юм байхгүй биз гэж Нэмэх асуув.

— Байхаар барах уу! торго дурдан бишгүй бий. Аль дуртайгаа ав гэж Вандан ам ангайсан мөртөө «үнэ цэнг юу гэж дуугарах вэ?» гэж бодно.

— Бэлэг дэмбэрэлтэй юм болж байна. Торгонд боолгох үр мэндлэх нь дээ. Аль нь зөөлөн бол, дурдангаас хэдэн амыг авья. Үнийг өгнөө гэж Нэмэхийг хэлэхэд Арвинсан,

— Үнэ яах вэ? Би төлнө. Торго зөөлөн, түүнээс нь ав. Надад хэдэн янчаан байна хэмээн тал засахад Вандан «Өө илжиг. Эдний зусарч гэж дээ. Энэ муу завсраар орж холиодог нь юу ч вэ? Хайран хэдэн ам дурдан. Үнэгүй өгч таарлаа. Хүний хүү хорондоо цагдаа, илжиг хоёроос хэнээс нь ч сохор улаан мөнгө авахгүй дээ» гэж хатуу бодов.

—Бусдын хэрэг бүтвэл өөрийнх бүтсэнтэй адил. Ганц ам даавуунд үнэ цэнэ гэхгүй ээ хө. Миний хүн чанарыг Нэмэх мэдэх л ёстой хүн дээ! хэмээн еөгөөхөд Нэмэх дурдан тасдуулж аваад мөнгө гаргаж,

—Май, Вандан гуай, болно биз гэхэд Вандан баацагнаж байсан бараагаа өвөр дээрээ түргэн тавьж, авах гэснээ гар татаж,

—Өө энэ олон төгрөг юунд өгнө вэ? гээд толгой сэгсэрч халгаасангүй ээ. Нарийн бүдүүн бургасыг машины тэвшнээс хэрж тогтоов. Энэ яс модоо ачааны бүтээлэг даавуу, цув, дээл гээд л юухан хээхнээр хучиж бүтээхэд сарлагийн бух гэлтэй овойсон хар овоохой болов. Түүнд тулгар бүсгүй Сайнзаяагийн үе үе ёолон гинших дуу гарна. Нөхрийнхөө гарт байнга тэврүүлэн байгаадаа хүүхэн нэг талаар сэтгэл тайван байвч хайрт эцгээ бодон санан мөрөөднө.

Шөнө харанхуйд амаржиж болзошгүй гэж бодож цэнэсэн Шимээн машиныхаа моторт холбож бэлтгэн зэхсэн гэрлээ хүүхний амаржих байранд оруулан дүүжилж, ахад бэлэн болгосон нь тэдний сэтгэлийг өөгшүүлжээ. Сайнзаяа, түр зуур өвдөж яраглан уйлагнаж бүх биений нь хүйтэн хар хөлс дааварлана. Мэндлэх хүүд авсан ээж болохын төлөө хүн бүр сэтгэл тэмүүлж, дор дороо хөл хөөрцөг болон босоо суугаа дугхийж сэтгэл түгшсээр л байв.

Үүрийн шар гэгээ тусах үед цахилгаан гэрлийн сүүн цагаан өнгөнд мэндэлсэн охины бархирах дуун цуурайтаж, аз заяаны ээл ивээлээр бүх юм ёсоор болжээ. Жолооч Шимээн гал түлж хоолныхоо цүнхнээс мах гарган хөшиглөж буцалгаад шөлийг Сайнзаяад уулгав. Тэр өглөөний нар шарсан цэлмэг сайхан өдөртэй золгожээ.

#### IV

Хэл дуулсан нутгийн эр хайнагийн хоёр шар хөтлөн ирж шавар шалбаагт суусан машиныг татан гаргав. Шинэ хүнд нэр өгөх тухай яриа хөөрөөн болсон мөртөө түрүүлж нэр хайрлаж ам нээх хүнгүй бие бие рүүгээ харж бодолхийлнэ.

— Миний охин ч үүрийн туяа, цахилгаан гэрэлд төрсөн амны хишигтэй охин доо гэж авсан ээж Намжааг хажуудхи хүндээ шивнэхийг чих дэлссэн Нэмэх сэхээ авч,

— Охиндоо Гэрэлтуяа гээд нэр хайрлачихвал яасан юм бэ? гэхэд Шимээн, Намжаа, Арвинсан нар «сайхан нэр» гэж дэмжихэд Вандан «хаашаа ч нэр вэ дээ» гэж үл таашаажээ.

—Вандан Арвинсан хоёр наймаа арилжааны мөрөө хөөхөөр нутгийн эрийг даган явжээ. Машинтай хэд хагас өртөө хэртэй давхиж, Намжаа авгайнд ирж Нэмэхийнхнийг буулгажээ. Шимээн шуудангаа хүргэхээр цааш хөдлөв. Бага дарга Нэмэх чөлөөний хугацаа ойртож байгааг тоолон үглэж сэтгэл яаравч нялхарсан сул биетэй эхнэр, нярай охиноо орхиод явах

зүрх яахан байх билээ.

Сайнзаяагийн тамир тэнхээ суларч царай шумайж, арай ядан хөхүүлж байгаа охиноо ядарч туйлдсан нүдээр өхөөрдөн харна. Сайнзаяагийн суларч доройтсон бие халуурч хэвтэрт ороход Намжаа авгай сандран тэвдэж түвд эмч залан авчирч үзүүлэхэд,

—Нялх биенд тогтсон өвчин хэцүү байдаг. Ер нь амь насанд халтай л байна. Би дийлээ гэж үү? гэхэд Сайнзаяагийн дотор палсхийж энхрий хайрт үрээ элгэндээ тэвэрч, хоёр нүдний нь нулимс бөмбөрнө. Хөхний сүү гэнэт саарч, охиныг цагтахаа болиход угж хөхүүлдэг болов. Намжаа авгай, эр эм хоёрын хойно урд мөнгөн ус аятай бөмбөрч байгаад гэнэ алдуулж Гэрэлтуяа охиныг үрчлэн авах болжээ. Багш ламаа урин залж, сан сун тавиулан идээ будаа, хоол ундаар элбэг дэлбэг, хүүхэд үрчилсний бэлэг дэмбэрэлийг харуулав. Намжаа авгай охины аав ээж хоёрт өлзий хээтэй ижил өнгийн дээлийн торго бэлэг болгон барьж өгчээ.

Хэд хоногийн дараа Нэмэх орон гэрээ бараадахаар нутгийн айлаас үхэр тэрэг хөлсөлжээ. Үйсэн бүрхүүлтэй мухлаг тэргэнд хүүхнээ суулгаж, түүчий хар шарын жөрхний дан оосрыг Нэмэх нутгийн зүг залан оджээ.

## V

Тэр зун хошуу, сумын баяр наадмын дараахан Намжаа авгайнд том мөнгөн гуут улаан сахиус бурхан сүр бадруулан ил зүүсэн хуучивтар шар чисчүү тэрлэгтэй, төмөр хүрээтэй саравчтай, дөч эргэм насны лам морилон иржээ. Лам, шон уяанаас морио уяж, том хар булигаар богцоо босгож тавиад гэр өөд аажуухан алхсаар оржээ. Тэрбээр цай идээний дараа нутаг усны байдал сонирхон огт дуулдаагүй айл сураглах дашрамд өөрийгөө мөргөл эргэлээр яваа ядуу хуварга гэж тайлбарлаад гэрийн эзнийг болгоомжлонгуй сонирхоход Намжаа авгай,

— Өөд болоод олон он жил улирлаа. Тань шиг л буян номын мөр хөөсөн жирийн гэлэн санваартан байсан гээд уй гунигийн сэтгэлээр шүүрс алдана. Үл таних ламтан маанийн зургаан үсгийг үсэг, үсгээр салган тод гээч уншиж байснаа,

— Хол газраас явах замд унаа сурьдаж, бие ядран алжааж байна гэж үглэн хэлэхэд Намжаа авгай,

— Ламтан та өнжиж хонон саатна уу? Сан тавиулж гэр малаа ариутгуульа гэхэд лам толгой таатай гээч дохиод гарч эмээл богцоо оруулж баруун талын бараан дээр тавьжээ.

Мал хотлон, сааль сүүний цаг өнгөрч, борцтой хоолны үнэр гэрт хан хийв. Тогоотой сүү хөөсрөн төдийхөд Намжаа авгай жаахан хүйтэн сүү утгаж сэлбээд,

— Та халуун сүү уух уу? гэж аядуухан асуувал ламтан,

— Ууна аа, би сүүнд их дуртай гээд нөмөрсөн дээлээ ярж, махлаг нүцгэн цээж ханхайлган өндийх нь нэг шөнө ч гэсэн хань бараа гэж олзуурхсан авгайд ая тааламжтай санагджээ. Гэрт нам гүм, хааяа нярай охины уйлагнах дуу сонсогдоно. Хаяаг шууж сөхсөн ханын нүдээр бүлээн салхи сэвэлзэн үлээж, тараг цагааны эсэглэн үнэр хамар цоргино.

Зочин эргэж хөрвөн хий ханиалгаж, хэвтэхээс өмнөхөн тос нэмсэн зулын сүүмэлзэн гэгээрэх гэрлийг нууцгай ажин хэвтэхдээ ийнхүү бодов. «Хай зайлуул алтан дэлхийн өвөр дээр бүүвэйлүүлсэн амьтад аа гэж мөн ч олон янзаар элдүүрээ хангуулах юм аа. Гурван удаа нэр сольж зүс буруулсан өөнтөгт нүүрий минь хорвоо халхалсаар байна даа... Энэ зулын жаргахыг хүлээж хэвтээд ч яахав» гэж бодов. Намжаа авгай хульжсан нойроо хүргэх гэж дээлэндээ толгой шурган нүд аниж хэвтэнэ. Ламтан эрхий долоовоор хуруугаа шүлсдэн амьсгаа даран өндийж зул руу гар сунгав. Зул шархийгээд бөхөхөд «дэнгийн эрвээхэй юү дээ» гэх бодлоор авгай санаа засан, толгой дээгүүрх дээлээ ярахад ламтны уруул хацарт нь шовхийж, ертөнцийн сайн муу юм бүхэн мартагдаж ангасан газарт ган тайлах адил болжээ.

Өглөө яаралгүйхэн боссон ламтан тагшинд хийсэн зөөг цай тавгай ууж, дэвтээсэн ааруул дээр нойтон өрөм хийж хуруугаар этэн зооглох зуураа,

—Энэ охин тун таатай амьтан юм. Ходоодондоо балга сүүтэй бол... гэж магтан сайшаана.

Өдөр хоног улирахуйяа ламтан улам ч амгалан тайван болж суурьших төлөв орж,

— Намжаа! Энэ хөөрхөн бүлбарай охин чинь сэтгэл булааж, намайг махан чөдрөөр чөдөрлөлөө гэхэд авгай элэгсгээр намжирдан инээмсэглэж

— Миний охин аавтай болбол ч... гэв. Тэр цагаас хойш бэлэвсэн авгай Намжаагийнх Галсангунгаагийнх болон нэрлэгджээ. Гэсэн ч нутгийнхан өрхийн шинэ тэргүүлэгчийн нэрд дадаагүйгээс Намжаа авгайнх гэж нэрлэх нь олонтаа.

Галсангунгаа богцноос чойжин ламын өмслөг хувцас хэрэгсэл гаргаж,

—Миний буй хөрөнгө энэ гээд нууж хадгалав. Багийн дарга эхлээд ламтнаас цэрж цэрэвдэг байснаа больж хэд дахин залсны дараа өөрөө нууцаар шавь оржээ.

— Намжаа! Манай охины нэр хаашаа хачин этгээд нэр вэ? Чамайг зөвшөөрвөл нэрий нь...

— Эцэг нь болж байгаа та өөрөө л мэд гэж дуранд нь тавив.

— Тэгвэл би охиндоо Наянтай гэж нэр хайрлалаа гэхэд,

— Бэлэг дэмбэрэлтэй сайхан нэр гээд Намжаа хавтгай цагаан шүд ярсхийлгэн мишээж,

— Ээ Наянтай. Эмээ ээжийн нэрт минь гэж өлгийтэй охиноо өвөр дээрээ авч тэврэн өхөөрдөн үнсчээ.

## Арван гуравдугаар бүлэг

### Тээнэгэлзэн санаашрав

#### I

Үүр дөнгөж тэмдгэрч байлаа. Цагдан сэргийлэх газрын дарга шар ногоон нүдээ алгуурхан эргэлдүүлж, хүн хүн рүү ээлжлэн харж байснаа,

— Шөнийн гурван цагийн орчим, засан сайжруулахад хуулийн хүмүүжих ажилд хөдөө байсан дөрвөн ялтан этгээд харгалзагч хуягт халдаж, барьж хүлээд оргон зайлсан байна. Өнөө гайхал толгойлсон бололтой гэж дарга хэлэв. Байцаагч Жав эс тэвчин яарч,

— Гайхал гэдэг маань Жансранчой биз дээ?

— Тийм ээ, Жамсранчой.

— Түүнийг яс цоожинд хатаавал таарах этгээд гэсэн Жавын хатуурхах үгийг дарга сонсож, ширээний араас алгуурхан босож суран бүсний дан мөрөвчөөс баруун гарын эрхийгээ дэгээдэн барьж бодолхийлснээ,

— Нөхөр Жав зөв хэлж байна. Онц ноцтой хэрэг таригчдыг мэдээжээр... хэрэгтэй юм. Гэвч хүнийг залхаах гэж чих тасартал мушгиж болохгүй. Жамсранчой, Дэчин хоёрын аниастай нүдийг нээж, зөв замд нь оруулах гэж Цогоо гуай «хуучин, шинэ» хоёр гараар мөн ч их татаж чангааж байгааг та нар мэдэж байгаа. Гэтэл тэр хоёр этгээд биднийг яаж зовоож байгааг тоочоод баршгүй ээ... Та хэд түргэн хөдөлж болсон явдлыг газар дээр нь шалган мөрдөж зальт этгээдийг баривчлах хэрэгтэй. Ээ дээ хүний амь нас хохироож, бүлэй уршиг нэмж тарихаас өрсөн шалавлаж үзээрэй, та минь гэснээ хэсэг дуугаа хурааж бодолхийлэн байснаа дахин үгээ үргэлжлүүлэн,

— Жав, Нэмэх, Санж, Данд та дөрөв яв! Жав даргал! Нутгийн идэвхтэн ардын туслалцааг сайн авах явдал хамгийн чухал шүү. Жижиг буу, тавь тавин сумтай винтовоор зэвсэглэх хэрэгтэй. Өөрийн агт уналгаас унаж явцгаа. Өөртөө болон уургын улаа хэрэглэх тусгай зар бичиг шийтгүүлж авахаа мартуузай гээд дотоод ажлын талаар аминчлан захихдаа «Жамсранчой хувьсгалын эсэргүү нарын дуулиаг чих сонсож, оргодол Дэчинтэй сэм нийлж бослогоор далимдуулан тонуул хийхээр хөдөлсөн байж болох юм. Хэрвээ оргодлууд замдаа салж сарнисан байвал хүчээ зөв сайн хуваарилж ажиллаарай, зэвсэг хэрэглэхэд хүрвэл хүний амь нас бүрэлгэж болохгүй. Ардын цагдаагийн нэр төр, нандин чанарыг болор мэт ариун тунгалаг байлгах хэрэгтэй. Аюул хөнөөлд тулгарч, эсрэг эсэргүүцвэл яая гэх вэ? Гэхдээ л тэвдэж сандарч бурууг хийж болохгүй гэж эрс шийдмэг захиж сануулна.

#### II

Оргодол хэдийг Жамсранчой толгойлж замаас цөм унаажин зэвсэглэж амжжээ.

—Хүрэх газар арай л болоогүй байна. Тэнд миний сайн нөхөр гэгч бий. Тэрбээр нууцаар хэлүүлэхдээ «Манай үүгээр лам нар эсэргүү бослого гаргах дуулиа байна. Чи яаж ийгээд оргож ир! Тэдний далимаар тоосоо гүвж бэлжиж аваад уул хадаар амьдаръя» гэж хэлүүлсэн багтай захиагаар бид оргосон болохоор газардахгүй хоолонд залганаа гэж Жамсранчой хамсаатан хэдийн сэтгэлийг засна.

Оргодлуудыг Дамчаагийн гозгор гэдэг ууланд бүгэж байгааг бага дарга Нэмэх мэдээд нутгийн ардуудын тусламжтайгаар бүслэн авчээ. Гэтэл харж хамгаалсан газраа түр орхиж гэртээ харьсан хүмүүсийн хий зайг тааруулан оргодлууд оргон зайлж амжсан байв.

Их загал сумын нутаг Ноён тэх уулын аманд оргодлууд азарга адуу хурааж унаажин одохыг Нэмэх олж харжээ.

Бага дарга Нэмэх нөхдөө дагуулан газрын аль ашигтайг барьж амдан тосов. Оргодлууд мод, хадтай нарийн голын баруун талын бартаатай замаар яаран өгссөөр зэрэгцэн ирэхэд Нэмэх,

—Зогсоцгоо! гэж анхааруулан чанга гээч хэлээд, сүрдүүлэн хий буудахад оргодлууд бургас шугуй руу шурган шивээлж буудаж эхлэв. Нэмэхийн нэг нөхөр шархдаж, хоёр морио алуулжээ. Буун дуу толгой өндийлгөмөгц тасхийж, оргодлууд хориглосоор л ажээ. Бургасан дотор хэдэн хүн морио бөхөлж, ийш тийш элдвийг ажин наашлахыг харсан Нэмэх туслахаар яваа нутгийн идэвхтэн ард гэж мэдлээ. Хэдэн мөчийн дараа тэд иржээ. Оргодлуудыг тал талаас нь дайрч барья гэдэг санал гаргахад нөхөд нь дэмжин сайшаав. Бургас дундуур мөлхөх газар мөлхөж, алхах газар алхаж, гэтэх газар гэтсээр оргодол хулгайч нарын бүгсэн ширэнгэ бургасыг бүслэн авчээ. Нэмэхийн буун дууны дохиогоор оргодлуудыг дайрч нэгийг шархдуулж, хоёрыг гар өргүүлэн барьж гартаа гавлан авцгаажээ.

Тэгсэн Жамсранчой л ор сураггүй алга болсон байв. Байцаагч Жав баригдсан гурвыг аваад хойш буцахад бага дарга Нэмэх үлдэж, Жамсранчойн хойноос эрэлд гарахдаа ёстой л хашир мөрдөгчийн буурь зааж халуун мөрийг нэг олж, дахин алдаж будлин явсаар хадам эцгийн байгаа нутагт нэлээд ойртсоноо мэджээ. Тэрбээр “Энэ далимаар Сайнзаяатайгаа уулзъя гэж бодсон боловч ажлын байдал нэг л боломжгүй санагджээ. Миний явуулсан захиа хүрээ болов уу? Тэр хавиар эсэргүү бослого гарсан там тум сураг байна. Тэд маань ямар шүү байгаа бол...” гэж сэтгэл зовсоор явна.

### III

Үдшийн бүрэнхий тасрах үед буун дуу тас няс дуугарч, хүн хашгирч бархирах чимээнээр Намжаа авгай охиноо зүрхэндээ наалдуулан дарж аман дотроо маани мэгзэм шивэр шивэр уншина. Буун дуу нам гүм болж, хүн амьтан хашгирч орилолддог болжээ. «Иш Галсангунгаа минь та охин бид хоёроо бодвол түргэн ирмээр юм даа. Садан төрлөө бараадна гэж энэ муу бээлийн чинээ охин бид хоёрыг унасан газар, угаасан уснаас минь холтгож хүн танихгүй, газар мэдэхгүй нутагт ирэхэд нөгөө төрөл садан нь байна уу? Байхгүй, тэр ч байтугай таних хүн ч алга байдаг үнэхээр хачирхалтай шүү! Ямар гээч үйл лайгаар энэ хуваргатай тааралдаж, сэтгэл зүрх минь түүний атганд орно вэ? Бурхан сахиус минь л болгоож өршөөгөөч! Хөгшин авгай яах вэ, дүүрсэн хэрэг. Хувь зохиолоор учирч заяасан охин минь амар мэнд байвал болох нь тэр ээ.

Хөөрхий, амьтны эцэг эх болохоор Нэмэх Сайнзаяа хоёр охиноо санан бодож, дурсан ярилцаж л байдаг байх даа! Учирч уулзвал учир явдлаа хэлж хаяанд нь муу бор гэрээ барьж амьдарвал алсдаа охинд минь хэрэгтэй. Ээ Гэрэлтуяа охин минь ээ!...» гэж шивнэн хэлээд сөөсгий сэвлэгт хошуу хүргэн үнсээд гадаа юу болсныг мэдэхээр өндийтөл аянга нэргэх адил тархи толгой дэлбэрэх шиг болж ухаан алджээ. Эдний хотыг тонож дээрэмдэхээр ирсэн шар цэргийн урдаас анчин өвгөн гал нээж буудалцсан боловч өөрөө хүнд шархдах үед тийнхүү дуу шүү болсон юмсанжээ. Харамсалтай юм Намжаа авгай бас зэрлэг суманд амь хохирч, нялх охин элэг эхштэл бархирч, эцэс сүүлдээ амаа ангалзуулдаг болов.

Энэ хэрэг явдлын дараахан нэгэн өдөр тэр хавьд уул хаданд бүгэж байгаа Жамсранчой, уулын амны адгийн хот айлыг харж, буугаад мордьё гэж боджээ. Тооноор утаа манаран баагиж байгаа хотны хойт захын онцгойдуу хар гэрт Жамсранчой явж орвол тулганы үнсийг бужигнуулан бөөцөгнөж байсан эмгэний хормой доороос дөнгөж хөлд орж яваа бондгор бор охин бултасхийн гарч,

— Аав аа! Аав аа! гэсээр гар сарвайлган паацганан дөхөхөд Жамсранчой гар сарвайлган авах гэтэл гэнэт бишүүрхэн эргэж эмээгийн ард орж эмээж айсан харцаар сэм сэм харна. Энэ айлд эмээ охин хоёроос өөр хүн байдаг шинж үнэхээр алга байв. Жамсранчой санаа амран уужирч ор сандайлж өвөр дээрээ буугаа хөндлөн тавиад эелдгээр,

— Эмээ! Танай энэ хавьд Галсангунгаа гэгч айл бий юу? гэж асуухад эмээгийн хоёр нүд орой дээрээ гаран уулгалан шүүрс алдаж,

— Хайрхаан! Чойжин багштаныг сураглаж байна уу?! Өөрөө хайчсаныг бүү мэд ээ! Багштан нэг тийшээ морилоод удаж байна. Уржигдар орой шарын цэрэг гэдэг нь манайхан руу ирэхэд нэг зөнөглөсөн өвгөн юу юуны туханд хүрээгүй байхад урдаас нь буудаж уршиг тариад өөрөө ч амь хохирч, өрөөл бусдын ч амь хохироолоо. Чойжин багшийн хань энэ амьтны эх байхгүй юу гэж хоолой зангируулж нүдний нь нулимс бүрхэв. Эмээ нулимсаа бүснийхээ үзүүрээр арчиж,

—Ийм гайг нүд үзэх юм биш, базар вааны хум пад гээд алдаг, авардаг хоёрын аль нь бол гэсэн шиг сэжиглэн хулгай нүдээр хялав хялав харна.

«Дэчин намайг хүлээж цөхөөд, өөртөө хал бал болж магадгүйг гадарлаж аргагүйн эрхэнд явж дээ. Түүнээс Намжаа авгай, энэ охин хоёрыг амь гол шигээ хайрладаг юм билээ. Ээ дээ, амь ядаж яваа хүнд эхнэр хүүхэд шиг гай байхгүй. Хөөрхий энэ үнхэлцэг шиг охин яана даа. Энэ эмээ, энэ охиныг хүн болгох байтугай өөрийгөө яая гэж байгаа амьтан байна даа» гэж Жамсранчой бодоод,

—Би ухуулагч хүн. Надаас айж эмээх хэрэггүй. Эмээ та юмыг ул үндэстэй сайн ойлго. Танай айлын тэр буудалцаж байгаад таалал төгссөн өвгөн бол ёстой ариун шударга сайн эр байна. Шарын цэрэг гэдэг чинь шамбалын дайн дэгдээгч Ванчин Богдын гар хөл байгаа юм. Ер нь лам багш, бурхад гээд номлоод байдаг орхимж ороогчид чинь оргодол хулгайч ч байж болно, чөтгөр шулмас ч байж болно гэхэд,

—Хайрхаан! Хүү минь бурхдыг тэгэж хэлж болдоггүй юм. Алдас болж хар толгойд чинь гай

түүтгэр ирнэ шүү гэж эмээг сургамжлан хэлэхэд Жамсранчой маг маг инээж зальтайгаар эрэгнэг рүү харж тавагтай өрөм байхыг үзээд,

—За, за эмээ та тэр бурхдаа шүтэж л бай. Би ухуулагч хүн болохоор ухуулж орхилоо. Идэж уумаар юм байвал өгөөч гэж гуйхад «хичнээн сүү шиг сэтгэлтэй, нэрлэхэхийг мэддэггүй сайн хүү вэ?!» гэж баярласан эмээ тавагтай өрөм, хувинтай тараг, айл хонь гаргаж амсуулсан гэдсийг хүртэл авч өгчээ.

—Ухуулагч хүү минь ээ! энэ үнсэнд хаясан шалз шиг өнчин охиныг чадалтай бийтэй хүн амьтан бараадуулна уу! Нэрийг Наянтай гэдэг юм. Зовж зүдэрсэн хөгшид, хүүхэд шуухад тэтгэж тэжээдэг газар ч байдаг сураг дуулдах юм. Тэнд хүргээд өгчихвөл боллоо шүү дээ. Би хүүхдээр хүн хийх чадал тэнхээ даанч алга. Өөрийнхөө зовлогыг яая гэж байгаа өдрөө хүлээсэн амьтан гэж мэдээрэй гэв.

—Эмээ! ийм осол аюултай цагт ухуулагч хүний хийх ажил хэцүү хүнд байдаг. Тэгэхээр энэ охиныг аваад явах боломж тун алга гээд босож үүд рүү хэд алхсанаа, Охиныг эргэн харж «өөд болсон эцэг минь насан эцэслэх үедээ юу гэж хэллээ! Эд хөрөнгөнд бүү шуна. Хүүхдэд хайртай байгаарай гэж гэрээслэн захисан үг бий. Нэгийг нь эс болсон ч, нөгөөгийг нь биелүүлэх хэрэгтэй. Би одоо яах ёстой вэ? Ямар ч гэсэн...» гэж удтал тээнэгэлзэн санааширч бодолхийлснээ охиныг авч явжээ.



## Арван дөрөвдүгээр

### Бүлэг суран хүлэг

#### I

Хааяагүй агь нүдлэн ногоо цухуйж, ээвэр дулаан, нөмөр газрын яргуй цэцэг цэнхэртэн хөхөрчихсөн цаг аа. Өглөө эрт Дэлгэрэх хамтралын албан байрны их зургаан ханатад намхан вандан ширээ тохойлдон бичиг захидал сэтгэл хөдлөнгүй уншиж суугаа бүсгүй улиран өнгөрөх хугацаанд их хотын хөл хөдөлгөөн дунд бужигнаж явсан эвлэлийн гишүүн Сайнзаяа билээ. Тэрбээр энэ хамтралд бичиг үсгийн багшаар ажиллаж байгаа ажээ.

Гэрийн үүдээр түрэмгий маягаар хөл тавин орж ирсэн хүн мэнд ус ч үгүй давшилж, Сайнзаяагийн ширээний өмнө тулан зогсоод,

— Яасан сүрхий албархуу, хэнхэг амьтан гээч вэ? Наадхи чинь юун цоохор цаас вэ? Өнөө гайхал цагдаа довтолгоо юу? Аль эсвэл даян олны өмч хөрөнгийг бас дахин хамах зарлиг тушаал дээд газар буулгаа юу? За, юу нь ч бай чи бид хоёр шигт нь пад алга. Бушуухан хумхиж далд хийгээд гэртээ харь! Эх чинь гэнэт саа өвчинд дайруулчихаад үхлүүт байна. Нарт хорвоод эх үр болон төрснөө бодвол бодоорой. Шинэ цагийн аясыг даганаа гэж хичнээн хүч түрэвч өнөөдрийн хувьд тайранхай үст түнжгэр толгойг чинь би мэдэхээ мэднэ шүү! гэж хэгжүүхэн өгүүлнэ. Хайрт ханийн захидлын үнэ цэнэтэй үгний нандин чанарт сэтгэлийн охь шингэн уусаж амтархан байсан агшинд аавынхаа аагирхсан үгний утгыг ойлгож ядан, дэмий л цочин агзасхийгээд,

— Би өнөөдөр бичиг үсэг заана. Орой л эртхэн харья гэж Сайнзаяа учирлан хэлбэл аав нь,

— Яана гэнээ! гээд бүсэндээ хавчуулсан суран хуйвийг суга татахыг харсан охин хэртхийж, уушиг, зүрх нь амаараа гарчих шахтал айж,

— Ааваа. Би явья. Ээж ээ, ээж ээ гэж мэгшин уйлав. Аавын догшин ширүүн зан, давуу хүчинд хүчлэгдэн хүлэгдсэн Сайнзаяа үл ойлгогдох битүү хатуу үйлийн шалтгааныг олж ядан цухалдсаар хэд хоножээ.

— Бодсоноороо болгоно доо! Дулдай баян гэхэд Ар жаргалантын хонхроос Да хүрээ хүртэл алдар нэрийг минь мэдэх юм чинь гэсэн аавын сүржин бардам үгний учир утгыг ч Сайнзаяа тунгаан шүүж чадахгүй уйтгарлана. Бас үетэнгийн хэдэн залууд бичиг үсэг заах сан гэхээс сэтгэл санаа улам ч их шаналж арга барагдана.

Охиноо хамтралын төвөөс авчирсны маргааш Дулдай зарц Гомбодоотой сэм ярилцаж удаан зөвлөжээ. Гомбодоо тарган сайн морь шилэн эмээллэж, хаашаа явсныг мэдэхгүй, нэг мэдэхэд алга болсон байв. Сайнзаяа биеэ барин, тайван байхыг хичээвч гэрээ санан бодон уйтгарлаж хайрт хүний нь зүгийн тэнгэр хүртэл сайхан санагдаж нүд баясган ширтэнэ. Уул толгодын өндөр нам, сархиаг нугачааг биш, өчүүхэн бага ч гэсэн амьдарч тэмцсэн дэгэн догонт замын сунасан үзүүрийг эвхэн хураах гэсэн шиг бодол болон тэмүүлнэ. Гэсэн ч ээжийн ариун

цагаан сэтгэлийг сэвтээхгүйг хичээн мэрийнэ. Аавыг байхгүй хойгуур,

— Ээж ээ! Надад ямар ч юм ойлгогдохоо байлаа. Аав намайг яагаад ингэж ажил, амьдралын хагацалд учруулахыг оролдоно вэ? Ээжийн охин, ээжийн сүүн сэтгэлийн хайраар ивээгдээсэй гэж горилно гэсэн охины цөхрөнгүй гуйлтын учрыг ухаарсан эх,

—Аяархан ярь охин минь. Аюултай цагт амьд явахад осолтой болжээ. Чамайг хөл хорьсон төрсөн эцгийн нь зөв байх шүү. Төрийн хэрэгт авгай хүүхэн оролцоно гэдэг.. гэвэл Сайнзаяа ухаалгаар учир ухуулан,

— Ээж та! эхийн ухаан бодлоор охиноо улам их хайрлаач. Би бол түмний төлөө, өөрийн аз жаргалын төлөө зорилго санаа нэгтэй хувьсгалт залуучуудын эвлэлийн гишүүн болсон хүн шүү! гэв.

— Томоогүй ч хүүхэн хонгор оо доо! Тэгж дүрсгүйтэж явах чинь буруу. Аавын үгнээс гажвал амь насанд халтай гэж мэдээрэй гээд ээжий нь гар сунган толгойг илж энхрийлнэ.

— Ээж минь та! Аав шиг эд хөрөнгийн хойноос битгий шунаач. Одоо хүн бүр сайн сайхан элбэг баян амьдрах жаргалтай цагтай золгосон шүү! гэхэд эх Лхам наминчлан залбирч,

— Уул нь «бурхан» нигүүлсэн өршөөж, хувь заяаны тавиланг түмэн олонд алаг цооггүй хайрласан үнээн. Гэвч эрээн бараанаар ээдэрч будилах алиныг тэр гэх? Миний охин л аз жаргалтай явбал ээжийн хүсэл ханах нь тэр гэхэд Сайнзаяа хирдхийн уурсаж,

— Та намайг хайрлахын оронд толгойг минь эргүүлж байна. Намайг та нар яавал яа, хамаагүй. Би дуртай цагтаа оргон зайлна гэж тунирхахад сандарч мэгдсэн эх,

—Больж үз охин минь! Би хамаг үнэнийг хэлье? Аав чинь мэдвэл хоёул толгойгүй гэсэн үг. Цаг төрийн байдал бишдэх гэнээ. Баруун хүрээнд босоо ороолон босоод байгаа гэнэ шүү. Юу гээч болохыг үс урт боловч ухаан богино эм бидний ухаан санаа хэзээ ч гүйцэхгүй, охин минь төр, түмэн олон амар жимэр байгаасай л гэж залбирах юм тэр. Миний охин муу юманд хорлогдож гэсэн эцгийн чинь үг үнэн байна гэж ээжийн болгоомжилсон шивнээг сонсож гайхаш тасарсан Сайнзаяа уртаар санаа алдаж,

— Таны хэлж байгааг би мэдлээ. Би ямар ч гай түйтгэрт хорлогдоогүй. Харин сайн сайхан цагийн зорилго бодлогод гэгээрч зөв зам руу тэмүүлж байгааг ээж минь та ухаарч ойлгооч. Ээж ээ! Та намайг ааваас нууж, хайрт хань нөхөр рүү минь явуулаач. Би эрүүл саруул байна. Тэгэхэд өвчтэй болгож ажлаас минь хүртэл гаргалаа шүү дээ. Хүн үрээ ингэж хайрладаг юм уу?! гэж Сайнзаяа эрс шийдмэг хэлээд босож зогсоход, эх байж ядан тэвдэж,

— Охин минь оргоно гэж бүү сана. Цагдаа хүү та хоёрын зам мөрийг би мэдэхээ байгаад удаж байна. Аавын чинь үгээр бол «тэр зол муут цагдаа бүү үзэгдээсэй. Яасан ч охиноо түүнтэй дахин суулгахгүй» гэж андгайлж байхыг ээж нь олон удаа сонсож мэл гайхаж, цэл хөхрөнө гээч боллоо. Эцэг эхээсээ үр хүүхэд нь зөрдөг ёсон байхгүй шүү! Тийм учраас эртхэн тэр хар хүүгээс хөндийрсөн чинь дээр гэж ятгахад, охины царай чинэрэн барайж нүд гялалзуулан уурсаж,

— Ээж та, миний хань нөхрийн тухай муу үг бүү дуугар гээд залгаж үг хэлэх гэтэл аавын хяхар татан ханиах хоолойн чимээгээр эх охин хоёрын өөрөг сөөрөг үг яриа нам гүм болжээ.

## II

Май сарын баяр хаяанд тулж хоног тоолж байсан тэр нэгэн өглөө нарнаар буу зэвсэг бүхий хоёр хүн эсгий үүд гэр дээр хаяж орж ирэнгүүт давшлан ам уралдуулж,

— Хөөе Дулдай! Баян гуай! Та яасан айхавтар бодь нойрсоо вэ? Дээшилж айлдана уу? Өчигдөр оройгоос жан Шамбалын дайн эхэлж, хувилгаан багш нарын айлтгал соёрхлоор манай шар цэргийн ганц хүчтэй уухай хийлтээр Дэлгэрэх хамтралыг сумын захиргаа, хоршоо, сургууль, улаан гэртэй нь цөмийг шатааж голомтыг хийсгэсэн. Тэнд байсан тахиа толгойтон бүрийг хуруу даран цааш харуулаад эсэргүүцсэн зарим хэдийг шар тугаа мялаахаар хүргүүлсэн. Танд ийм баярт үг сонсгохоор наашилсан далиманд танай санаа буруутсан охин шулмасыг мөрдөж ирлээ гэхэд эх охин хоёр орох газар олж ядан бүлтэлзэж, Дулдай яаралгүйхэн босож,

— Би мангар зарцаа та бүхэнтэй уулзуулах туршуулаар явуулсан. Дайралдсангүй гэж үү... ямар нүхэнд шургачихдаг дамшиг вэ? Өчигдөр орой баруун нүдний зовхи жирэвгэнэж баярын совин татсанаас болоод сэтгэл уужран таг унтчихжээ. Бүгдээр бурхны таалалд ивээгдэх болтугай гэж наманчлаад эхнэрийнхээ айж байгааг үл анзаарч,

— Миний хувцсыг авдарнаас бушуу гарга! Наад муу дон шүглэсэн охиндоо ногоон хоргой туузан чимэгтэй түнтгэр мөрт дээлээ өмсүүлж, тайрмал тожгор үстэй толгойд өөрийнхөө хиймэл эхнэр үс өмсгө гэж захирангуй ихэмсэг хэлээд өөрөө хувцаслав. Цэнхэр хилэн дэлбэгэр нударгатай, жигд өлөн хир суусан хөх хамбан дээл хөөргөсхийн бүсэлж, мөнгөн хэт бэлтэй хутга зүүж, хэрэмний сүүл оройд сугсайлган хадсан дөрвөн тал сөхсөн хүрээтэй цагаан эсгий тоорцог духдуулан тавив. Тэрбээр хаш цагаан хөөрөгтэй даалин сав хавчуулж, бурхны зүг алга хавсран наманчилж гурвантаа бөхөлзөөд нүүр эргүүлэн «миний хувцас хэрэглэл буянтай баян хүний нүнжгээр харагдаж байна уу?» гэж асуух адил өөрийгөө толинд тольдоод,

—Би охины оронцгоо өөрийн биеэр жанжин багшид хүргэж бузар буртгийг арилгуулж нэгэн тийш болгоноо. Та бүхэн түрүүлэн морилцгооно уу?! гэж ая тал засан өгүүлээд авдрын таг яаран сөхөж, хүн бүрт арав арван янчаан, аюуш хадаг дэлгэн барив.

Охин Сайнзаяа явахгүй гэж эсэргүүцэн тэмцсэн боловч хүчинд авгагдан гар хөлөө хүлүүлж үхэр тэргэн дээр суужээ. Эх Лхам, зарц Гүнчин хоёр хойно урдаа орж охиныг суллахыг гуйвч Дулдай тэдний үгийг үл ойшооно. Эсэргүү босогчдын төв тийш явах зам зуур эцэг охин хоёр үг зөрсөөр л явна.

—Ээ дээ охин минь юу ч гэх вэ. Тэр жил түшмэлийн хүүтэй чи сууж бид худ ураг бололцсон бол өдийд ингэж муугаа үзэж байхсан болов уу?! Чиний өнөөх түрээ барьдаг «хогийн яамны» цагдаа хаа байна. Жанжин багш нарт буруутсан учраа үнэн зөв өчин айлтгаж бузарлагдсан гай хөөг ариутгуулахаар миний охин зан авир чинь засарч бурууг ойлгож, зөвийг ухаардаг болно. Жанжин дээр ороход намуун түвшин байж үзээрэй хэмээн гуйна.

Сайнзаяа гэгээн цагаан өдрөөр ингэж хар даран зүүдлэх адил аюул нөмрөнө гэж ёстой л огт зүүдлээгүй явснаа бодож, хэрэв сэтгэл санааны шархыг нөхөж болдог сон бол өөрийн нь сэтгэлийн шархыг нөхөөд, нөхөөд нөхөөс авахгүй мэт санагдана. Хот хүрээний ойролцоо нутаглаж, өсөж торнисон насандаа нуруун дээр мордож ноолдог байсан бөөрөнцөг хочтой тугал одоо данхайсан лагс шар болчихоод нунтаг шороо буригласан замаар хүнд мөөртэй хус модон тэрэг чирч эвэр сэжлэн хашигнан алхахад цухалдаж яарсан эцэг нь хулсан ташуураар угсруулан цохино. Тэрэгний шар ташуурдалтын өвчинд цочирдон шингэн хүрэн чацга харвуулан уршиг тарихад урд энгэрээ «будуулсан» Дулдай омог сүр улам бадруулж,

— Ёстой нэг чонын хоол байна. Ингэхийг чинь мэдсэн бол хамтрал хомуунд өгч гуйлгачдын ходоодны хорхойтсон шүлс дардаг байж гэм гэж хараагаад тэргээ зогсоож хувцсанд нялсан баасыг арилгаж цааш хөдлөхөд Сайнзаяа хүлгэнд бие хөшин чилэвч, алжааж ядарсан царай гаргалгүй жишүү харан сууж «дөшинд» давтагдаж буй ариун зүрх нь улам хөвчрөн чангарна. Голыг муу тосолсон модон тэрэгний хяхнах дуу чихэнд чийр болон уйтгар төрүүлнэ.

“Төрсөн ганц охиноо алуурчны гарт өгч нулимс цусыг байтугай амь насанд аюул хөнөөл учруулахаар яарч яваа хөөрхий аавын минь ухаан бодол даанч богинохон, юмны учир мэдэхгүй байна даа! Юу болохыг тэсэн хүлээ. Хэрэв надад муу юм учрах болбол аав намайг авран хамгаална байх. Миний аавын ноён нуруу хазайсан гол шалтгаан хөрөнгөжих шунаг сувдаг сэтгэлд бурантаглагдан ашиг олзын төлөө амь гол тавьснаас шинэ цагийн амьдрал үйлсийн дотор буруудаж, баян чинээлэг феодал этгээд хэмээн нэрлэгдэн хөрөнгөө хүртэл хураалгасанд эрхэж ийнхүү мунхаглахад хүрдэг байна шүү! Юм бүхнийг бурхан тэнгэр бүтээж болгоно гэж хүн чинь тэнэглэж мунхаглахаараа юу ч хийхээс буцдаггүй юм байна.

Эцсийн эцэст эцэг охин хоёр хувьсгалын эсэргүү босогчдын амттай зууш болж хусан бороохойн цохилтон доор амь хохирох ч юун магад. За, яавал яа, хамаагүй. Би ганцаар биш, миний сэтгэл бодлыг авран хамгаалах түг түмэн зорилго нэгтэй нөхөд бий. Юуны өмнө өөрт тохиолдох зовлон, тамлалыг тэсвэрлэн давах хэрэгтэй. Тэсэхийн тулд одооноос зоригоо чангалах ёстой” гэх Сайнзаяагийн бодол,

— Юун улс вэ? зогс! гэсэн гүжир догшин үгсээр хэртхийн цочиж таслагдав. Хүзүүндээ шар, хөх хадган зангиа давхар зүүсэн лам хар холимог хувцастангууд буу зэвсэг бороохой шийдмээр зангаж давшлан хөндөлдөхөд Дулдай тэрэгнээс дэвхрэн үсэрч буугаад мэхэсхийн мэндэлж,

— Би жанжин багшид бараалхахаар яваа нэгэн мөхөс сүсэгтэн гэхэд мориноос буулгүй ханхалзан буй хар хөх лам, шоовон малгай хэлтгий тавьсан чөргөр эр махан улаан нүдээ өлбөлзүүлэн эргэлдүүлж,

— Ардын намынхны туршуул, залины тулам углаж, зэс хошуулж явааг хэн байг гэх вэ? Муу хөгшин нохойн алтан хошууг тоож дуугарах хүн олдох болов уу! Харж л байя. Чамд зовлого биеийг чинь зовоож чилээхгүйгээр элдүүр сайтай нарийн хар суран хүлэг барилаа. Энэ гоолиг дагина авхайг та өөрөө урьтан андалсан явдал бидний ажлыг хөнгөвчиллөө гэж ёжин дамшиглаад Дулдайн хөл гарыг цулбуурын сураар хүлж андлан охины дэргэд суулган цааш хөдлөв.

### Ш

Лхам, охинтойгоо хамт явна гэж мэтгэвч гэрийн эзний хулсан ташуурын гүвдрүүнээс айн ухарч, уйлан хайлан хоцорчээ. Гэсэн ч зовж шаналсан сэтгэлээ барьж, хир даг болсон ширээн дээрх гонзгой хөвхөн хайрцагны нүүрийг түшүүлж залсан бурхан богдын хөргийн өмнө сөхрөн зул мандаагаад наманчлан залбирч,

— Бурхан богд зонховын гэгээн багш минь! Нүгэлт эм намайг эр нөхөр, төрүүлсэн ганц хайрт охин бидний халуун амийг авралдаа багтаан өршөөж хайрла. Түмэн наст богд ламтны мэлмийн өмнө наманчлах нүгэл бишгүй дээ бий. Таны мөнхөд амилсан энэ хөргийг цагийн эрх даган хэдэн жил уул хаднаа залж байлаа гээд адис хүртсэнээ дэргэд ая тал засан бүлтэгнэж байгаа зарц Гүнчинд хандаж,

— Галдаа аргал хий гээд ор сандайлан элэг тэвэрч, бадран улалзах галын өрвөлзөх дөл болон манарах цэнхэр утааг ширтэн байснаа босон харайж хувинтай сүү цацал барин гарч буян хангай, алтан дэлхийн уул усны далд эзэн, лус савдгийг үглэн дуудаж өршөөл ивээл гуйн сүү тал бүр тийш цацлан өргөнө. Аймшигт явдлаас хойш өдөр хоног өнгөрч, нөхөр охин хоёр сураг чимээ дуулдахгүй болохоор Лхам сэтгэл санаагаар унаж, доройтон ядарчээ. Өрх бүтээгээгүй учраас зул жаргасны дараа тооноор ганц хоёр од хальт мулт бүдийн үзэгдэнэ.

Зарц Гүнчин хэл улгүй явчихсан хань нөхрийн тухай элдвийг эрэгцүүлэн бодож, сэтгэл зовон тун дүнсгэр байх болов. Лхам дэг дуг зүүрмэглэн, давхийн сэрж өндийн орны хөндий, авдрын хажуу зай завсар, тогоо шанаганы тавиур, хаяа хатавчны нүх сүв бүрийг нэгжин ажиж зүв зүгээр байснаа цочиж зүрх түг түг цохилон толгойн оройн үс өрвөсхийнэ. Бүхлээр хагас хажуулдан аниж, харан цаг нөгцөөн ядаж байтал үүд сэмхэн онгойж хүн орж ирэхийг гадарласан мөртөө дуугарч эс чадан дороо хий тэвдэж хэдэн хором өнгөрсний сүүлээр,

— Чи хэн бэ? гэж асуувал дуугарсангүй ээ. Хүний амьсгалах бүгшмэл чимээ тодрон, хавирсан чүдэнзний агшин зуурын хурц гэрэлд нэгэн эр өөрийг нь цоргим ширтэн зогсохыг харж «өнөөх шар цэргийнхэн нь юм болов уу? Энэ орой болсон хойно явж байхыг бодоход осолтой амьтад ирлээ» гэж бодов.

— Гүнчээн! Сэр хөөе. Хүн ирээд байна гэж Лхам хань татан хоолой чичиргэнүүлэхэд, гаднаас орж ирсэн хүн,

— Ээж ээ! гэх харанхуйн дунд сонсогдох дуунд хиртхийн цочсон Лхам «охин минь л лав биш дээ. Эрэгтэй хүний боргил бүдүүн дуу...» гэж зурсхийн буухад бүүр ч элдэв юм хамж шимж бодож дэмий л самгардаж байтал Гүнчин амжиж дэн асаахад, түүн рүү жишүү зогсон харж байсан хүн танимхайран,

— Сайн байна уу гэж мэндлэх нь нэг их таньдаг дуу шиг мөртлөө чухам тэр гэж Лхам таньсангүй ээ,

— Сайнзаяа хайчсан бэ? гэж аргадангуй асууж лавлахад Гүнчин таг дуугарсангүй доош харав. Лхам орноос өндийж уй гунигт нүдээ анивчиж,

— Би Нэмэх гэсэн дуунаар Лхам Гүнчин хоёр ухасхийн босож золгов. Лхам нулимсаа нударгаараа ахин дахин арчиж,

— Ашгүй хүү минь хүрээд ирдэг маш сайн байна. Бид ч сайн л байсан. Тэгсэн... дуугүй болж «аав, охин хоёрын аминд орох хүн энэ дээ! Юу гэж цайруулан хэлье дээ. Үнэнийг хэлэх зөв үү? Аль эсхүл буруу юу?» гэж Лхам зүрхшин бодох агшинд Гүнчинд хандаж,

— Түргэн галла! Хоол цай... гээд зарц бүсгүйд юм хамжилцан хийх хооронд Нэмэхийг нүд салгалгүй ажин харна. «Сайнзаяад минь ямар нэгэн явдал тохиолдож дээ» гэж Нэмэх бодсон боловч юу болсныг асуух эвээ олж ядан хулгана. Лхам үг цухуйлгах учраа олж ядан байтал,

— Ээж ээ! Сайнзаяа хайччихсан бэ? гээд Нэмэх хариу сонсохыг яарч сэтгэл догдлон «юу гэх бол» гэхээс яс хавтайн халширч амьсгаа даран чагнана.

— Үнэнийг гарган хэлэхэд түмэн бэрх ээ. Иш чааваас даа! Юмны цаана нааныг мэдэхгүй балчир амьтныг эцэгтэй нь хоёуланг эсэргүү нар бариад явчихсан гэж Лхам хэлээд ам хэл нь аяндаа түгжрэх шиг санагджээ.

— Бурхан шажнаар баг хийсэн муусайн боохой, хөөгөөр будагдсан гурилан лүднүүд, гайгүй ээ! Та нар галд түлэгдэж хярвас болох цагаа далласан даа! гэж бага дарга Нэмэх аман дотроо тод гээч хэлээд хөмхий зуун занана. Нэмэх цай хоол идэж уугаад хэсэгхэн дугхийж, үүр шөнөөр мордож баруун хүрээ чиглэн одов.

Нэмэхийн цай уусан аяга бараг эврээгүй байхад гэнэт орж ирсэн хүний буу зэвсэг сүүн цагаан өнгөөр сүлэгдэн цайж байгаа үүрийн бүдэг гэгээнд ёрдойж, айдас хүргэсэн гэж жигтэйхэн. Гэрийн хоёр амьсгаа даран нам жим хэвтэнэ. Хүүхэд уйлах дуунд санаа хоёрдон гайхсан Лхам орноос өндийсөн чигээр хөдлөлгүй мэлэрнэ.

— Гүнчээн! энэ охиныг аваарай гэх Гомбодоогийн дуунаар Гүнчин зул барьж гэр дүүрэн гэрэл мандав. Хоёр ойтой болов уу? гэмээр охин тэвэрсэн нөхрөө Гүнчин ухасхийн тэвэрч авснаа ч тэр даруйд мэдсэнгүй ээ.

— Лхам гуай! Та бие зүгээр биз? Гүнчээн чи сайн уу? гэсэн Гомбодоогийн мэндийг сонссон хоёр хариу мэндлэх ч сөгөөгүй усан нүдлэх нь ямар нэгэн золгүй юм болж дээ гэсэн муу юм Гомбодоод бодогдуулжээ.

# Арван тавдугаар бүлэг

## Танил дуун

### I

Босогчдын бялуунд тархидуулсан түүчий алаг, хоёр бөөр хонхолзуулан шогшиход ханхай тэрэгний дугуй хад чулуунд цохигдон донсолж, Дулдайн тархи толгойн заадас задрах шиг ангасхийнэ. Дулдай замын займчаа доргилтонд нугасаа таслуулах вий гэхээс ээн, уун үглэн уулгалж хөмсөг атируулан ярвайна. Газар дороос гарч ирсэн адил гарч ирсэн, шар цэрэг ташаалдан ханхалзаж,

—Та чинь шүлс үсчүүлэх төдийхөнд бажга тавьж байх шив. Шөрмөслүүлэх, зүрх сугалуулах, буцалгасан усаар зумлуулахаараа талийх эр юм гэж шар цэрэг элэг доог болгожээ. Дулдай шүд зуун эрэмгийлж буй охиноо харж өрөвдөн хайрлана. «Эдэнд хүлэгдэх гэм зэм хийгээгүй болохоор юунаас айх вэ? Жанжин хувилгаан, лам багш нартай нүүр учран золгоход над шиг баян тарган, нэр хүндтэй хүн «хум, пад» гэхийн зуурт суллагдана. Тэгээд охины минь ногоон, цагаан дарх эх болгон хувилгаж таалбал миний нар баруунаас гарах нь тэр ээ. Уул нь ардын засаг надад нэг их ч гэм болоогүй. Хэдэн мал хураасан бага хэрэг ээ. Феодал гэж нэрлэгдсэн л...» гэж бодсоор шар цэргийн байранд ирснээ мэдэв.

Хар хүрэн оосор бүчтэй том цагаан гэрт Дулдайг чирч оруулахад ухаан бүүдийн самгардаж, борви нугалан сөхрөв. Түшлэг налан суугаа хундан шар хөмсөгтэй тарган шар лам бухан хүзүүгээ шилгээж,

— За хө! Улааны туршуул уу! чи? Шударга үнэнээр өчихгүй бол өрөө зуруулна гэж мэдээрэй гэж пал цүл тулгахыг сонссон Дулдайн хулхи бууж,

— Би, би нэг муу ядарч хавчигдсан мулгуу цагаачин байна. Дээдэс та бүхний их хэрэг үйлийн дуулиагаар бараалхаж, хэрээс хэтэрсэн охины дон бузрыг арилгуулахаар нааш зориод, зам зуур баригдлаа. Будилснаас өөр өчүүхэн ч хар буруу санаа байхгүй гэж охиноор халхавч хийсэнд ламтан хөөргөнөөс шар тамхи халбагадан чимхээд,

— Юун охин билээ? Өлгийтэй зулбадсагаар халхавч хийнэ вий, чи. Хорвоод ховорхон зальтай нохой байх нь ээ. Тэр шуламыг нь оруул гээд тамхиа гуд татан сорж, арзгар хөх шүд ярзайлган сэргэлэн харцаар ширтэж, тайван зогсож буй Сайнзаяаг шинжин ажиж,

— Энэ чинь охин биш, бүсгүй хонгор байх чинь юу билээ гээд маг маг инээж таашаахад Дулдайн дотор мэлсхийж,

— Жанжин та болгоон соёрхоно уу? Мунхаг тэнэг охин минь та бүхний эрх сүрд балмагдан дарагдаж, айлтгалаа дэвшүүлж чадахгүй бөглөрч байна гээд бөхөлзөн навсганахыг харсан ламтан дал мөр хөдөлгөн хий хэхэрч,

— Юу боловч хүлэг андалгааг сулла гэв. Сайнзаяа гар сулармагц толгойн дөнгө хиймэл үсээ

авч дэргэдээ тавиад тайранхай гээгээ гар хуруу хүргэн илж засах агшнаа жанжин ламтны царай барсхийн зэвийж өмнөх ширээн дээрх хонх дамрын хажууд тавьсан жижиг буу шүүрэн атгаж занган,

— Харав уу? та нар, ёстой улааны хашир тагнуулчин байна. Зулбадсагаа дагуулж ирдэг, бас нэг мэх нь байхгүй юу. Хоёуланг дахин сайн хүлэх хэрэгтэй. Хар гэрт хорихдоо тус тусад нь хийгээрэй. Дараа байцааж шүүнэ. Нүдний бүлай болсон энэ хоёр туршуулыг бушуу гарга гэж зандрав.

## II

Хуучин эсгий малгайны толбо тогтсон оройвч дух дарж тавиад, лам захтай шар даалимбан тэрлэг, оймсны түрий шагайлган хөөргөж дурдан бүс бүсэлсэн эр бярдан бууны тугалган сум даавуун дайзанд ярайлган зүүсэн харагдана. Түүний хэнхдэг ярсан цээжний аюулхай мөгөөрс тушаа очирваана бурхны хөрөг санжиганаж, хөх хадган зангиа салбалзуулна. Гар буу урдаа хавчуулсан үс сахлаг, сахал бавгар энэ идэр эр шар цэрэгт ирээд удаагүй ажээ. Энэ хүн өөрийгөө «шоронгийн оргодол, их мулз Жарантай, хуучнаар Сэцэн хааных, ам цуурсан хэрэгт алах ял шийтгүүлж амь хэлтэрч арван жилтэй. Арван хэдэн жил арьс махаа барж, энэ их нүргээнт дуулиагаар бээцгэр хуягийн амиар амь сольж, зэвсэгжин наашилсан маань энэ дээ» гэж бардамгай хэлэх энэхүү сонин намтарт хүний үйл мөр үнэн эсэхийг хөөцөлдөж магадалсан хүн ч гарсангүй ээ. Харин ч эсэргүү нарт итгэл олж баригдаж ирсэн үнэн цагаан үйлтнүүдийг манах харгалзах ажил хийх болжээ. Цогчин жасын гадаа үүдэнд олон шар цэрэгт боорлуулан, чирэгдэж гэдрэг цахдан гэдэлзэж хэрүүл маргаан үүсгэж буй ахимаг эрийг харж, Жарантай таньсан боловч ямар арга мэхээр яаж туслахаа мэдэхгүй арга барагдан зовох болжээ. «Хэрэв би, энэ хүнд тус хүргэхгүй бол Жарантай, Жарантай биш болж... Тэгэхээр одоохондоо утсан улаан амь хар толгойгоо бодох нь өлзийгөө өгнө» гэж зурсхийн буухад, түүнд нүүрээ л харуулахгүй байя гэж шийдэв.

— Муу сайн эсэргүү нарыг ингэхийг мэдсэн сэн бол юунд би хайрт охиноо дагуулан ирж яргачны аманд хаяж өгөөд өөрөө хамт тамлагдаж, махаа зулгаалгаж байх вэ? Та нар охины минь суллан тавь. Өр, төлөөсөнд нь миний зүрхийг сугалж тугаа мялаацгаа. Хөөе охин минь ээ. Сайнзаяа! чи хаа байна вэ? Яргачин лам нар сөнөтүгэй гэж Дулдайг хашгирахад харгалзагч лам дээлийн урд хормойн уранхай тамтгийг тас татан авч аманд нь чихэж дуугүй болгов. Нарийн олсоор хоёр гарыг ар дээр нь баглаж хүлүүлсэн эрийг хар гэрт хороогдох хоногоо хүлээж байгаа улс руу шургаж унатал түлхэн оруулаад хаалгаа цоожилж эргэхэд мөнөөх эрийн хор шар улам буцалж ухасхийн хаалганы самбар мод сэвхийтэл өшиглөж,

— Цадигаа алдсан дээрэмчид миний хувцсыг дээрэмдэж цадаж ханав уу? Цадаагүй байвал наашаа хүрээд ир! Дулдай баян гэдэг чинь бэл бэнчингээр та нар шиг тонуулч, яргачингуудыг зуу, зуугаар золиосолж, нүхэнд булуулах хөрөнгө байна. Гэсэн ч та нарт сохор зоос гарздана гэж бүү сана. Төр түмэндээ хөрөнгө хогшлоо өргөж, та нарын хөлийг хориулж, нүдийг аниулах, ганц тун «эм» базааж бэлтгүүлнэ. Ардын нам, засаг минь «хар тамхиар» хордож мунхарсан намайг «алтаар» арвижин гэгээрсэн охины минь аварч өршөөнө үү? гэж дуу өндөрлөн хашгирч хар гэрийн хаалга өшиглөв.

— Эндэгдэл урьтаж, ухаарал хожимдвол ингэж аймшигтай зөрүү болдгийг бид мэдлээ. Гэсэн



ч бид хүч чадал сорьж, эх орон ард түмнийхээ тусын тулд үхнээ гэж тамлуулагчдын амны уншлага болсон эрс шууд үгийг Дулдай чангаар давтан өгүүлж зодуурын ормоор бүлдруутсан нүүрээ алгаар даран үзэж шүд зууж заналхийлнэ.

Сайнзаяа өдөр дараалан тамлагдавч үг газар гээхгүй эсэргүүцэж тэвчин тэснэ. Хүлгэнд идэгдсэн хоёр гарын бугуй хорсон шаналгаж зулгаагдаж шингэрсэн үсний хуйх нөжрөн бамбайжээ. Түүний, хүү татуулсан цамцы цаанаас мэсийн зурайсан шархтай бие эрхтэн улалзана. Үүд шилбүүрдэн орж ирсэн үл таних гэвш лам гэгч зовлонд нэрвэгдэгчдийг ажигласаар Сайнзаяагийн өмнө очиж удаан ширтэнэ. Хөөрхий бүсгүй хөх няц болсон биеэ эмзэглэн хөдөлж ядан, хавдаж хөөнгөдсөн зовхио арай хийж нээвэл нүдний өмнүүр сайхь эрийн данагар бие тодорсон боловч хавдарт зовхи аяндаа хаагджээ.

Гэвштэн хадаг яндар оосортой нагаан буу бүсэндээ хавчуулж гар сарвайн,

— Сайнзаяа! хонгор минь нүдээ хараач гэхэд «алуурчны газар хонгор сэтгэл, хайр дурлалын үг хэн хэлж таарах вэ» гэж бодсон Сайнзаяа аниатай нүдээ хүчлэн нээж хараад,

— Худлаа! чи, авилгач алуурчин, бурхан нэртэй буг. Миний дэргэдээс шалав түргэн зайл! Бузар гараа ариун биенд минь бүү хүргэ. Үгүй бол одоохон алаад аль. Бушуу түргэн тонил гэхэд гэвш ламтан шивнэн,

— Хайрт минь үнэмшээч! Гэрэлтуяа охиноо бодооч гэх хоромд Сайнзаяагийн нүднээ «хайрт хүн нь тусаж чихэнд дуу нь сонсогдоход нүдээ бүүр тас аньж, хэн хүнд мэдэгдэхгүйг хичээж биеэ барин,

— Чи миний хайрт хань Нэмэх яасан ч биш. Түүний сүрлэг сайхан царай баясгалан бадрах харц сэтгэлд нэвт шувт шингэсэн болохоор би хайрт ханиа нүдээр биш, зүрхээрээ харж чадна. Мах цусаар амсан эдэлж буй мянган гашуун, түмэн зовлонд оюун билэг минь суларсан хэдий ч халамжит хань нөхрөө танина. Ханийн минь ариун сайхан нэрийг зээлдэж бүү гутаа! Миний нөхөр ёстой эрэлхэг золбоотой цагдаа хүн гэв.

— Хонгор минь чи нүдээ хар л даа!

— Харахаас нүд хорсгодог яргачин та нарыг юугий нь харах юм бэ? гэж эрс шууд хэлээд хөмсөг зангидан хэлээ зууж нүүр буруулав.

Гэрийн гадаа зогсож байгаа шар зангиат ахимаг эр,

— Гэвштэн минь түргэлээрэй! Цаана чинь Да ламтан, мээрэн гуайн хамт морилон айсуй гэжээ.

— Дараа өлзийтэй учралаар уулзъя гээд гэвш ламтан огцом эргэж гарав.

### III

Нарны илч буурч, амьсгал бүгчимдүүлсэн дүнсгэр орой болов. Шөнө дундаас өмнөхөн ханхай тэрэг хөллөсөн шар хөтөлсөн гурван шар цэрэг хоригдож байгаа хүмүүсийн гэрийн

үүдэнд тулж зогсов. Тэд харгалзагчтай уулзаж хэдэн үг солиод, хар гэрээс найман хүн гаргаж тэргэн дээр нуруу нийлүүлэн хүлж, олсон татлагаар давхар хэрэн бөхөлж, хэрсүү зан гарган нэг нь тэргийг хөтөлж, хоёр нь буу гардан дагав. Яргалуулах замд шуударснаа гадарласан Дулдай үе үе хашгичин, зүхэж занана. Шар цэргийн нэг дөрөөндөө хөл хүчлэн жийж,

— Хараал зүхлээ татаарай. Буудуулна гэдэг хамгийн аз жаргалтай үхэл гэж санаарай. Хэрэв чи зүрхээ сугалуулсан бол... гэж ам асууна. Дулдай улам уурсан омогдож,

— Үхэлд сайн муу, аз жаргалтай гэж байдаг юмуу? Яаж ч алуулсан мөрдөө мөр. Чи яахав зүрх сугалж бах таваа ханга л даа гэхэд,

— Дуугаа тат гэж зандраад шилбүүрийн суран хуйв тасхийлгэн буулгахад Дулдайн хацрыг халуун төмрөөр хайрах адил болгожээ.

Хүрээний горьтгоос гарч цаашилбал шар цэргийн шөнийн туршуул хэдэн морьтон тойрон бүсэлж шалгаан ороожээ. Туршуулын нэг хадган оосортой нагаан буу гарган бариад,

— Хороодог газар хол уу? гэхэд,

— Тээр бараантаж буй уулын энгэрийн аманд гэв.

—Ер нь холхон шиг аваачих хэрэгтэй юм шүү! Нохой зууж ирээд л... гэж сэжиглэнгүй захиад маани дүнгэр дүнгэр унших нь тод сонсогдоно.

Уулын амны буруу харсан жалга руу орж тэрэг зогсов. Энэ үед хороолгох гэж байгаа хэдийн бодол янз янзаар үймрэнэ. Дулдай ийнхүү бодов. «Тариа тарьж мал маллаж байсан тал сайхан нутаг, хайрт эхнэр, хүүхэд, «эх эцэг» ах дүү, төрөл төрөгсөд минь энх амгалан байтугай! Яасан олон од яралзана вэ? Огторгуй яасан уудам юм бэ? Саяхан үдшийн харанхуй нөмөрч байсан бол одоо үүрийн гэгээ тусах дөхжээ. Гэсэн ч бидний хувьд... үүр цайж, өдөр болохыг би харахгүй ч гэсэн үлдсэн та бүхэн харна, жаргана, цэнгэнэ. Шинэ төрийн сулдэндээ залбирахаас өөр юунд ч залбирч наманчлахгүй. Би яасан ч яргачдаас амь гуйхгүй. Хөөрхий охины минь зорьсон үйлс дэлгэрэн мөнхжих болтугай. Охины минь бодож зорьсон бүгд зөв. Аав нь буруудах, буруудахдаа хязгааргүй буруудаж, хар тэнэгэлжээ. Хатуу эдлэл булсан газраа хөөрхий Лхамдаа зааж өгөх минь ч яалаа. Одоо нэгэнт хожимджээ» гэж Дулдай бодоод, ухаан алдаж сүрдэхгүй байхыг дотуураа хичээн мэрийнэ.

Яргачингууд нуруу нийлүүлэн баглаж хэрсэн олсыг огтчин суллаж,

— Бушуу түргэн бууцгаа гэж шаардах тэр хахир дуу бууны дуу мэт санагдана. Дулдай ганц хоёр агшин ч амьд байхын хүслэнгээр,

— За байзаарай! Үхэлд яарахын хэрэг юусан билээ? гэж хэгжүүрхэн гэжсөнөө өөрөө ч анзаарсангүй.

Буун дуу нүргэлэн уул хаданд үл мэдэг цуурай хадаж замхрана. «Бурхан тэнгэр, аав ээж, үр хүүхэд, төрөл төрөгсөд, түмэн олон, нам засаг минь...» гэх чанга, сул дуу хадаж, навтасхийн

унацгаана. Дулдай эгц босоо эргэн харж зогсоод,

—Би амьд байна. Буудаарай гэж хашгираад элгээрээ харуулдан ойчив. Гэсэн ч түүний амь мэнд, шарх сорви ч үгүй «Би үхээгүй бололтой. Юмны дуу чимээ ил тод сонсогдож байна. Хачин юм даа! Амьгүй хий сүнс үү? Хороолгосон хүн сүнсгүй гэж лам багш нар айлддаг сан» гэх бүүр түүр бүүдгэр бодлоор гарын хүлгийг суллан өндийхөөр оролдож байгаагаа ухаарав. Нүдээ харахад энд тэндгүй тунтайж унасан хүн нүднээ тусаж, сэтгэлийн жолоо дахин алдуурч,

— Хөөе Лхам аа! Миний охин Сайнзаяа! Цагдаахүү Нэмэх ээ! гэж учир зүггүй бархиран хашгичихад хэн нэгэн хүн гүжирмэг гараар дал мөрнөөс базан сэгсчиж,

— Дулдай гуай! Та яаж байна. Ухаан санаа чинь ямар байна. Аргагүй, аргагүй. Айх аюулгүй болсон, тайван бай. Май энэ зангиа зүү! Тэр шийдмийг ав! Түргэлээрэй, эмээлтэй эмээлгүй хэдэн морь байгаа, нэгийг авч унаад гэр рүүгээ яв! Хэрэв шарын цэрэг тааралдвал өөрийгөө шар цэргийн жанжны тусгай туршуул гэж битүүгээр ойлгуулж мэхлээрэй. Ороож шалгаагаад барихад хүрвэл хүч шавхан үзэлцэж түншилцэхээс өөр арга мэх байхгүй гэж мэдээрэй хэмээн учирлаж ухуулж байгаа хүний дуу жигтэйхэн танил содон сонсогдоход Дулдай мэл гайхаж, цэл хөхөрнө гээч болж,

— Төрийн сүлд өршөөлөө. Төр, түмнийхээ төлөө халуун амь, бүлээн цусаа зориулна. Амь нас аврагч таны алдар нэр мөнхжиж, насан өлзий дэлгэрэх болтугай гэж арай ядан эвлүүлж хэлбэл шар цэргийн хувцаст, үл танигдах ханхар эр,

— Энд ганцхан би байгаа биш, хэд хэдэн хүн байсныг хожим хойно сонсож мэднэ байх аа. Хоёр нөхрийн нэрийг төлөөлж, өөрийгөө тодотгон хэлбэл,

— Их мулз Жарантай гэдэг байна. Дулдай гуай! Таны хэлмэгдэн хохирч байгаа охин Сайнзаяаг аварч авахыг би биедээ хүлээнээ. Та шуудхан хариад охиныхоо эхийн сэтгэлийг илбэн засаж бай гэхэд Дулдай, ухасхийн түүнийг хүзүүдэн авч,

— Харанхуйд даанч зүс царай чинь харагдахгүй байна. Дуугаар чинь нэр цохож чадахгүй юм даа. Алив ах нь духыг чинь үнсье гэхэд үл танигдах эр бөхийж духаа өгөхөд Дулдай тэвдэн сандарч шоовон малгайн оройг үнсэх аялуулсандаа сэтгэл сэргэн дотор тал далай мэт болжээ.

# Арван зургаадугаар бүлэг

## Сураг байна уу

### I

Амь мэнд салсан хэд гэр гэрийн зүг салан одов. Дулдай бүрхэг тэнгэрийн нүхэн харанхуйд баримжаа алдан товцог тойрон явлаа. Тэрбээр хоолой хатан ундаасаж, омголтсон уруулаа долоож түр амсхийхээр үхэр чулууны дэргэд бууж морио түшив. Үүрээр мордож эцэнхий саарлын зайдан нуруун дээр өгзөг шалбартал галгиулж, цавины булчирхай цочин бие янгина зарайж, үе үе толгой эргэн нүд эрээлжинэ. Эсэргүү нарт тамлуулж сэтгэлд арилшгүй хөндүүр суулгасан шарх сорвийг бодохоос гол руу хүйт оргиулж «таануустай тэмцэж байгаад яахаа үзнэ дээ! Би л охиноо тамд хийчихлээ. Хөөрхий муу эхнэр минь ямар шүү амь зууж, амьдарч байдаг юм бол доо! Гомбодоо Гүнчин хоёр ч харж хандах л улс даа» гэж бодсоор явав. Дулдайн хамаг бие ясандаа янгинаж бие даагдахгүй ядарч, дахин голын захад бууж амрахдаа морио хэд хазуулахаар өрөөсөн хааг дарж чөдөрлөөд хазаарыг авав. Голын хүйтэн уснаас хэд балгаж, азарганы үндэс хэдийг малтаж идэхэд бие хөнгөрөх шиг болж мордон цааш шогшуулжээ.

Уяаны дэргэд бууж морио сул орхиод арай ядан босго алхаж таварцаглан унахад Лхам, Гүнчин, Гомбодоо нар дуу шүү болон сугадан босгож орны урд талд, авчирч суулгав. Дулдай, лам дээлийн тамтгийн энгэрийг ярж нүцгэн хэнхдэг рүү салбалзан унжих шар зангиаг шувт татан авч барьж ирсэн хусан бороохойн хамт хатавч руу шидэв. Тэрбээр хөндүүр хавдарт гуя өгзөгөө даралж, яраглан хойморт хөл жийн сууж улцайж ядарсан нүдээ эргэлдүүлэн,

— Та нар цөм сайн уу? Би өөрийн хийсэн нүглийн төлөө хувцас хүнараа тонуулан, бие тамлагдах бага хэрэг ээ. Ганц үрээ аюулт тамд түлхэж хаяад ирлээ. Ингэж амьд яваад юу хийнэ гээд үргэлжлүүлэн хэлэх үгээ эс эвлүүлж ядан гэмшихэд Лхам,

— Ээ бурхан өршөө! Охин минь тэгээд яана даа гэж дуу алдаж цурхиран уйлж, ухаан алдан ор дамнаж унавал Дулдай ухасхийн тэвэрч авах гээд өөрөө дороо суун тусаж толгой мансууран эргэж зүрх дэлсчээ.

«Амь аварсан ачтан хэн байж таарах вэ? Жарантай шүү дээ! Тэр хэн ч байг хэлмэгдсэн бид хэдэд бурхан гэсэн үг. Би бурхан тэнгэр, багш лам нарыг хэтэрхий итгэн биширч эцэст нь амь нас алдах шахлаа. Миний сүшиглэн шүтдэг бурхан маань л намайг зодуур тамлуулалтын арилшгүй шарх сорвитой болох, төрсөн ганц охиноо халуун там руу түлхэн оруулах санаа сэтгэлийг төрүүлэв шив дээ» гэж бодсон Дулдай босон харайж бурхнаа шүүрэн авч гал руу хийхэд гал тос дусаасан адил оволзож,

—Хүүе! Дулдай та! яаж байгаа юм бэ? Лай ланчиг дээр үйл лай нэмлээ гэж Лхам аман дотроо дуулдах төдий үглээд нүүр буруулан наманчлан залбирав.

Зарц Гүнчинг сөөсгий сэвлэгтэй балчир охин тэвэрсээр орж ирэхэд Дулдай хөл алдан баярлаж гайхан,

—Энэ юун хүүхэд вэ? гэв. Гүнчин Гомбодоо хоёр ам уралдуулан,

—Бид хоёр ийм хөөрхөн амьтан өргөж авсан гэлээ.

— Алив! Дулдай гуай нь таалъя. Ээ бяцхан дэгдээхэй минь ээ. Зөн билгээр миний үйлт охиныг даллаад ирдэг ч болоосой. Манай Сайнзаяагийн багатай яасан адилхан төстэй алтан гургалдайн ангайхай вэ? Лхам аа! Чи энэний нүд, хамрыг хараач гэхэд Лхам,

— Харин тийм ээ! Харахаас элэг эмтэрч хайр ч хүрч, зэвүү ч хүргэдэг дэгдээхэй гэв. Дулдай хүзүүн дээгүүрээ гар тавин эрхэлж ээнэгшин байгаа охины хонгыг үнсэж,

—Гараас гарсан амьтан юм байна даа! Ийм дэгдээхэйг хүнд өргүүлдэг зүрхтэй эцэг эх гэж бас байдаг байжээ гэв. Гомбодоо, эсэргүү нарын байдлыг тагнахаар, явж байхдаа Жамсранчойтой дайралдаж, эсэргүүнд эцэг эх нь алагдаж өнчирсөн охин авч явсныг авснаа илэн далангүй ярьжээ.

— Түшмэл гуай хүүхдэд маш хайртай хүн байсан юм. Тэр хулгайч, эцгийнхээ энэ сайн чанарыг дуурайсан нь яамай гэж Дулдай нухацтай өгүүлэв. Дулдай биеэ сайн тордсоны хүчээр хэдхэн хоногт бие сайжирч бараг хуучин байдаг хэвэндээ оржээ.

— Гомбодоо! Хоёул юманд явнаа. Цаад хэдийнхээ аль өөдтэйг шилж эмээллээрэй. Чи хотонд дуугаргадаг бярданаа үүр. Сум олонтой явна шүү! Надад буу бий.

Шарынхныг дайралдсан газар нь үгүй хийж үнсийг хийсгэнээ хө! гэж Дулдай эрс шууд хэлэхэд Гомбодоо толгой дохиж, Лхам сэтгэл түгшихийн эрхэнд,

— Дулдай минь та больж үзээч гэж гуйхад Дулдай хүйтнээр мушилзан инээмсэглэж,

— Дайсан гэдэг чинь дайсан байдгийг нүд үзэж, бие шаналж байж мэдлээ. Бие махбод, сэтгэл санаанд тогтсон шарх сорвио хөл хумхин сууж арилгахгүй ээ! гэж битүү хагуу үг өгүүлэхэд Лхам учрыг бүрэн ойлгосонгүй.

— Нэгд шар цэрэгтэй эрэгчин эмэгчнээ үзэлцэнэ. Хоёрт охиноо хайна гэхэд Лхам шууд хориг тавин,

—Тун болохгүй. Больж үз Дулдай минь! Дахиад...

—Дахиад тэдэнд чихээ мушгиулахгүйгээ мэднээ гэж Дулдай ам бардам хариулав.

## II

Дүүрэн тээштэй, ачааны машин эсэргүүнд хэлмэгдсэн нутгийн осолт замаар тоос татуулан хурдалж, даваа даваад газрын уруу хурд хасаж эхлэв. Машины эсрэг талаас тэнгэрт ойж хадсан хоёр хэсэг цагаан саарал тоосон дундаас морьтой хүн суга үсрэн тасарч айсуй. Түүний араас хэсэг морьтой хүн хөөн элдэх нь сэжигтэй байв. Жолоочийн дэргэд сууж яваа нас тонтонги эр хажуудах карбин буунд сум хоолойлон замаг товчилж,

— Таваараш жолооч оо! Манай цэцэн зүйрт «тэмээ хариулсан хүн буурныхаа занг анддаггүй» гэдэг билээ. Би эсэргүү нартай үзэлцэний хувьд гадарлаж байна. Морьтой хүн нэгийгээ хөөж элдсэн заль мэх зохиож бид хоёр руу довтолж байж болох юм шүү! гэхэд жолооч,

— Ойртоод ирэг! Буудаж амжина. Болмооргүй шиг бол машинаар дайруулахгүй юу. Цагаан замд морь машин хоёрын аль нь хүч тэнхээтэй, хурдтайг үзнээ хө гэж хэлээд инээмсэглэв.

— За! тэгвэл манай таваарашийн унааны ид шидийг үзэж дээ гэж хэлээд хэтийн зорилго, зориг хүчиндээ итгэл төгс инээмсэглэж байгаа хүн эсэргүүний хөлд тахлагдсан хоршоо сэргээхээр бараа татаж яваа анхны хоршооны дарга ажээ. Ойртон ирж яваа морьтой хүнийг шарын цэрэг мөн гэж таньсан хоршоо даргын хорсол занал буцалж,

— Гол хүчийг ирэхээс урьтаж энэнийг нь олзолж аваад зугтъя. Бууж өгмөөргүй шиг бол буудаж орхино гээд машины кабинаас үсрэн буунгуут,

— Зогс! гэж чанга дуугаар дохио өгөөд буу хацарлан шагайв. Шар цэрэг зогссонгүй. Хоршоо даргын буу тас хийж нүргэлэхэд нөгөөх шар цэрэг морьтой хамт онхолдон ойчив.

— Та нар эсэргүүгийн хань хамсаатан уу? эсэргүүнд элдэгдэж яваа жирийн нэгэн иргэн Жарантай байна. Буудвал бууд гээд ханхар өргөн цээж түхийлгэн зогсохдоо эргэн харж, ирж яваа морьтой хүмүүсийн урдаас гар буугаар гал нээв. «Энэ нээрээн эсэргүүнд хөөгдсөн хүн болж таарлаа» гэж бодсон хоршоо дарга жолооч хоёр ч морьтой хүмүүсийн урдаас буудахад мориноос нэг онхолдон үсэрч нам болоход бусад дайжин зугтаажээ.

Жолооч, кабины хаалга нээж толгойгоо цухуйлган, зогсож байгаа үл таних эрийг нүд ихэсхэн ширтээд учир зүггүй уулгалан буун харайж,

— Нэмко! Нэмко гэж хашгиран хөх зангиатын хүзүүгээр тэврэн үнсэхэд нөгөөх эр,

— Шимээн! Шимээн гээд хүзүүдэн тэврэв. Энэ бүхнийг гайхан харсан хоршоо дарга «учрыг олноо гэхэд бэрх болжээ. Юм бүхэн холион бантан болон хутгалдсанд...» гэж эргэлзэн бодоод,

— За, түргэлээрэй. Цаад гайхлууд чинь эргэн бүсэлж байна шүү гэж анхааруулав. Кабинд гурвуул шахалдан сууж оорцог хадтай толгой бараадахаар Шимээн машинд хурд хүч нэмэн довтолгоно. Тэр гурав толгойн хажууд машинаа нууж, хадны ард хоргодон тулалдахад зэхэв. Хорь гаруй шар цэрэг тэднийг бүслэн авч, амьд барихыг санаархана.

### III

Бүслэгдсэн гурав, зүрхлэн ойртсон ганц хоёрын хөлийг амрааж хориглон анана. Шар цэргийн бүслэл улам давшиж аюул хөнөөл юу юугүй нөмөрч буй мөчид гэнэт зүг зүгт дайсны араас үл мэдэгдэх хүмүүс довтолж уриа уухай хашгиран дайрч буудалцан бороохой шийдмээр гардан нүдэлджээ.

— Гурвалжин тулалдаан болчихлоо. Тулалдаан ч гэж дээ зодоо цохио болж байх шив дээ гэж

Шимээн хачирхан өгүүлэхэд Нэмэх ёжингуйгаар мушилзан инээмсэглэж,

— Дайсан, дайснаа л дарж намнаагүй нь лавтай байх гэвэл хоршоо дарга,

— Юмыг тааварлан таах бэрх ээ. Сонор сэрэмж сулруулж болохгүй ээ. Эсэргүүнээр далимдуулан дээрэмчид тонуул хийсэн сураг энд тэндгүй байгаа шүү! Хэрэв дээрэмчид бол бидний машинтай бараа руу л шунана гэв. Шар цэргүүд гар өргөн бууж эхлэхэд машинтай хэд ч бие далдлах газраас ухасхийн босоцгоож шар цэргийн араас дайрсан нутгийн идэвхтэн ардуудад тусалжээ.

Шар цэргийг буулган барилцсандаа сэтгэл бахдам яваа Дулдай машины гуравтай уулзахдаа Нэмэхийг шар цэргийн хувцастай байхыг хармагц буу

гаргаж,

—Гомбодоо! Наашаа ир. Харав уу хөөе! Өнөө ардын цагдаа чинь шар, хөх зангиа зүүж лам болчихоод явж байдаг байна шүү. Урвагч муу улаан сухайг нам буудчихья гэж хэлэхэд Шимээн агдан сандарч,

— Манай талынх, бага дарга Нэмэко гэж танилцуулав.

— Аав аа! Би «их мулз Жарантай» гэдэг хүн чинь байна шүү дээ гэсэн үгийг сонсож бүх учрыг ойлгосон Дулдай хоёр гар сарвайн тэлж,

— Миний хүргэн хүү. Миний амийг аварсан ардын төрийн цагдаа гэж хэлээд тэврэн авч хоёр хацар духыг ээлжлэн үнсэх агшинд

— Сайнзаяагаас нь сураг ажиг байна уу? гэж сулхан дуугаар үгээн зөөн асуужээ.

## Арван долоодугаар бүлэг

### Аав яасан бэ?

#### I

Шар цэргийн хувилгаан жанжин Жа, дуудуулсан хамсаатнаа хүлээж цөхөн царай алдаж гуниглана. Үдшийн бүрийгээр сэм орж ирсэн хүн сөхрөн навтасхийж,

— Жа, багштан минь болгооно уу?! Дорд шавь гүртэмбэ Галсангунгаа бараалхан ирлээ гэхэд санаа уужирсан Жа хувилгаан гарт барьсан жижиг бууг тавьж,

— Нөгөө ажил юу болж байна? Маргааш шөнийн дотор эндээс зайлахгүй бол улаантны гарт бүрэн орж муугаа үзнэ шүү! гэж сүржигнэн тулгахад Галсангунгаа,

— Таны айлтгалыг мэдлээ. Бүх зүйлийг бэлэн болгож зэхсэн байгаа. Хэзээ хашаа морилохыг тань хүлээж байна. Энэ ялдамд нэгэн айлтгал байгааг болгоож соёрхоно уу? гэж бэмбэгнэн хэлбэл Жа багш үгийг нь тасалж,

— Галсангунгаа! Түшмэлийн хүү нүгэл хилэнц зузаарчээ. Эцгийг энх тунх байх тэр цагаас одоо хүртэл хулгай дээрмээр амьдарч явна. Энэхүү их үйлсийн дуулиагаар засгийн шоронгоос оргон зайлж энд ирсэн боловч та бүхэнтэй зам мөр нэгэнт нийлэхгүй болохоор тэрвээр ууланд орогнож байгаа. Харин би эндээс ульжуулж байгаа юм шүү! Түүний сүйт бүсгүйн эцэг Дулдай гэгч охины бузрыг арилгуулахаар энд бараалхан ирсэн юм. Гэтэл ардын намынхны туршуул болох нь илэрч, эцэг нь тэр дороо тонилгогдож, нүгэлт хар эм Сайнзаяагийн амийг би аварч нуусаар байгаа. Тэр эмийг сүйт эр Жамсранчойд хүргэж өгнө гэвэл;

— Жа мэдлээ, багш ламтан гэж Галсангунгаа зальтайгаар хариу хэлээд нахилзан бөхөлзөж нүд анивчина.

«Хөвч хангайн ууланд зэрлэгшин амьдрах гурван эрийн дунд нэгэн үзэсгэлэн гоо «согоо» байнаа гэдэг ямар гээч сайхан учрал,тохиол, буян заяа вэ» гэж Жа ламтан сэтгэл санааны донтсон хийрхэлээ дэврээн баясгаж бахархана.

#### II

Намар орой болж, сэрүүн салхи сэвэлзэн үлээж шөнөдөө хар чийг хааяагүй унадаг болсон байлаа. Тийм нэгэн шөнийн нэг цаг өнгийх үед шургааган хашааны дааман хаалга түгжиж том бор гэрт хэдэн хүн болгоомжлон сэм ярилцаж толгой дохин зөвшөөрөлцөнө. Гандаж хуучирсан навс савс хувцастай, үс сахал өрвийсөн, хөнгөн шалмаг эрийг нөхөд нь,

— Манай Санж ч ёстой балиус Лавдан яг биеэр болжээ гээд сэмхэн хөгжилдөхөд зэвэр даасан даавуун өнгөтэй хаваасны утас тасарч хөвөн хэсэг хэсгээр бөөгнөрсөн дээл хөөргөн бүсэлж, үйсэн иштэй том хутга өмнөө хавчуулсан «Лавдан» бохидсон мод толгойгоо



онгойлгох гэж төмөр сэтгүүрээр ухаж төнхөн,

— Бидний гаднах байдал сэжиг бүхий бүлэг этгээд болж чадсан байх аа. Харин санаа сэтгэл маань үйл муутныг дууриахаас ухарч зовоох л байх даа! Гэвч тун анаж өөрийгөө улсын цагдан сэргийлэх газрын албан хаагч цагдаа биш, алаач талаач, оргодлын нэг, уул хад хөвчид орогнон бугшиж байгаа зэвсэг бүхий оргодол улс, эсэргүүгийн жанжин Жа багштаны бүлэгтэй нийлэхээр яваа гэдэгт хатуу итгэж ажиллах хэрэгтэй. Аймгийн төв хүртэл машинаар нууцгай хүргүүлнэ. Цааш замчлах хүн тэнд бий. Хангайн нурууны их хөвч, ой тайгын гүнд жүжиглэж гарна даа. Эр чадлаар унаажин ульжиж явах болно. Хэн самбаа алдвал тэр хохирно шүү гэсэн битүү хатуу яриа хөөрөө дуусаж, шөнийн гурван цагийн үед алсын аян замд гарахаар ачааны машин дээр сууцгаав.

Бүх юм бүдэг харанхуйд хийгдэх тавилантай шиг эд нар бас л шөнөдлөө. Гурвыг тусгай байранд нууж хооллож ундлаад шоронгийн хүний амьдралд шилжүүлэв Хорих байранд оруулж төмөрлөсөн хаалга хяхран хаагдаж ган өргөст монгол цоожны уян хатан дуу данхийх нь содон сонсогдоно. Тэднийг угтаж ирсэн хүн бас бага дарга Нэмэх байв. Сэтгэл хөөрөн мэндэлж, хот хөдөөгийн сонин сайхан, эсэн бусанг сэдэн сэм ярилцахдаа Нэмэхийн яриаг гойд сонирхон сонсоцгоожээ. Тавтай унтаж амарсан хэд өглөөний цайнаас урьтан хэдэн мөч гадаа гараад эргэж ороход нилхийх жигшим муухай үнэр хамар ам руу ханхийж, ханцуйгаар хамар ам таглавал Нэмэхийн царайд ёгт инээмсэглэл тодорч,

—Даснаа хө? гайгүй, дасна. Шилийн сайн эрсээ гэдэгт энэ чинь ариутган таалах утлага байхгүй юу гэж цаашлуулахад тэд «нээрэн ч тийм дээ» гэж ам амандаа хэлээд инээмсэглэцгээнэ.

Жамсранчой талын цагаан гэгч оргодол этгээдтэй хоёул болзоот газар ирж хамсаатнуудаа хүлээж ядан байсхийгээд дурандаж ойн захын балархай зөрөг жимээр сээтэн хаядаг хонгороо гарч ирэхийг харуулдаж нүд чилээн ширтэнэ.« Сайнзаяа ямар хэцүү бэрх зовлон тамлал үзэж байгаа бол? Миний амьдрал ахуй Сайнзаяад хэзээ ч таалагдахгүй, зам мөр ч нийлэхгүй биз дээ. Тэгэхээр яах ёстой вэ? Болохгүй, яасан ч тэгж болохгүй. Хэзээ нэгэн цагт хуурай сайрт газардсан алтан загас чамайг усанд чинь тавина даа!... Хорь шахам жил хулгай дээрэм хийж, шорон гяндан хэсүүчилж өнөө маргааш өнгөрөөж ядан цаг мөч мэрж суух ийм ч амьдрал байх уу даа. Иймэрхүү сохор зөргөөр бүдчин бүх л насыг барнаа гэвэл худлаа. Аав минь амьд ахуйдаа юу гэж захилаа. Аа тийм...» гэж Жамсранчой бодон суухдаа бараа гарч ирэхийг үзэнгүүт,

—Бөөн бараан юм айсуй. Нөгөө хэд маань мөн дөө! гээд, талын цагаан руу талархан харав.

### III

Олон хоног тамлуулж шаналсан Сайнзаяад Жамсранчойн засаж аялуулсан өвсөн хучааст урц, өөрийн орон гэр шиг санагдана. Гэвч... Голдуу борц, хааяа ангийн нойтон махаар хооллож, уулын тагтын тунгалаг харзаар ундална. Сайнзаяагийн хамаг бие улам хөндүүрлэж, хэвтэж сууж ядан тарчилна. Бас толгойн үс бөөс хуурсанд баригдсан болохоор загатнаж зовоох нь их. Сайнзаяа гайтай хөөтэй шавьжнаас салахын тулд гэзгээ хусуулж, бүх хувцсыг солиход арга буюу шилийн сайн эрийн шинж төрхийг олжээ. Жамсранчой, бүсгүйн шарх сорвийг харахаас

зүрх шимшрэн, сэтгэл хирдхийж,

— Эсэргүүнүүд ээ гэдэг чинь ёстой хүн дүрсээ алдсан галзуу чонууд юм даа! Миний хулгайч дээрэмч яах вэ? Чиний хийсэн хэрэг... гээд дуу өндөрлөн босож газар дэвслэн Жа жанжин руу шүлс нулимаhad, жанжин чонын гөлөг аятай нүүр буруулж «энэ гайтай шулмасан гичийг цааш харуулах минь яалаа. Үүнээс болж би энэ зэрлэг хархүүгийн гарыг мялаах байх аа» гэж бодохоос зүрх ширхийж, амаа барина. «Хэрэв хэрэг бишидвэл урьдахыг бодох хэрэгтэй. Ер нь энэ уршиг таригч өлөгчинг...» гэж бодсон Жа хуурамч зан гаргаж эелдгээр,

— Хөөрхий амьтныг амьдаар нь тамлаж гүйцжээ. Дээдэс миний мэдлээс гадуур бурхдын соёрхлоор хийгдсэн ажил шүү дээ! Харин ч би хайртын чинь амийг аварч, чамд авчирч өгснийг чи бодох ёстой гэж бухаж цагаатгав. Сайнзаяагийн хувцас бүхэн элбэгдэж, цонхигор цагаан царайтай, турихан чөрчгөр банди лам шиг харагдана. Тэрвээр аав ээж, охин Гэрэлтуяа, эр нөхөр Нэмэхийн тухай өдрийн бодол, шөнийн зүүд болж сэтгэлийн өвчинд нэрвэгдэх болжээ.

Ямар нэгэн этгээд ажиг сэжиг авсан байж магадгүй гэж тэд сэжиглэн байр сольж, тайгын гүн рүү улам шигэн буув.

\* \* \*

Ар өвөр битүү ой бүрхсэн Баянхүрэхийн нуруугаар олон хоног цааш нааш хэрэн тагнасан хэд ой захлан үзэгдэх зурвасхан ширэнгэ рүү орохдоо хөндлөн огтолж гарахад бага хугацаа орно гэж ярилцжээ. Эгцээр урагшилсан бага дарга Нэмэх, араас яваа гурван нөхөртөө өөрсдийн мэдэх тэмдэг дохиогоор гар зангаж, буугаа бие дээр тавьж өрөөсөн мөрөөр өрөөлдөн ахина. Гэвч түнэр харанхуйд яах учраа олж цөхөн будилна. Тэд ойн ширэнгэн дотор цухалдаж амьсгал давчдана. «Нэгэнт орсон юм туулнаа, ухрах хэрэггүй. Ухарсан юм базаахгүй л байдаг» гэж санасан Нэмэх,

— Миний хойноос бүс, бүснээс барьж мац. Салж төөрвөл үхэл рүүгээ явна гэдгийг санаарай гэж хэлээд намхан зулзаган модыг толгойгоор зүсэх адил яран, урагш хичнээн зүтгэвч тавин алхмаас хэтэрсэнгүй, амрахаас аргагүй болжээ. Бүүр хав харанхуй болж нэг залхам ч ахих арга тасрав.

— Эндээ унтацгаая. Нуруугаа нийлүүлэн тал бүр тийш харж сууцгаа гэж бага дарга тушаав. Үл мэдэг гэгээ тусах нь өглөө болсны тэмдэг ажээ. Түрүүний хүн битүү ширэнгийг ярж цээжээ хавчуулахад арын хүн гар дамжуулан яг адил давтана. Нар жаргах үеэр ширэнгээс дөнгөж амь голтой мултарч, хүн бүрийн гар нүүр шалбарч шархадсан байв. Аяганы хомсодсон хийцнээс ам хөдөлгөх төдий болж, хоёр цаг хэртэй амраад ус олж уухаар цаашлав.

Маргааш үдийн хэрд өндөрлөгийн оройд гарч хоёр өдөр тэнд ийш тийш дурандан ажсаар хөвчийн гүнд өглөөгүүр утаа, шөнө гэрэл олж хараад тэр зүг баримжаагаар явцгаав. Тэнэж төөрөн будилсаар хэд хоногийн дараа оргодлуудын байрыг илрүүлж амдан отов. Оргодлууд өдрийн цагаар харуултай байдгийг тагнаж мэдээд бага дарга Нэмэхийн дотор мэргэн арга буужээ.

Урт буу өвөр дээр тавьж дугхийн байгаа хүнийг хоёр талаас гэнэт дайрч, бэлдэж зэхсэн дээлээр толгойг бүрхүүлэн даржээ. Тэрбээр бархиран сандарч баахан тийчилж байгаад хүчинд автагдсанаа ухаарч, овоохойгоо зааж өгөхөөр бага даргатай хэдийг дагуулан гэтэж эхлэв.

Оргодлуудын хардлага улам нэмэгдэж, модны хатсан боргоцой салхинд унахыг ч андахгүй гурван зэрэг давхийн буундаа хүрч амжина.

Жамсранчой, Сайнзаяад үргэлж халамж анхаарал тавьж аяны хоолны олигтойг идүүлж уулгана. Жа жанжин битүүгээр дургүйцэн нүд хорсдог атлаа дон шүглэсэн тачаадалдаа хөтлөгдөн Сайнзаяаг гэгээн цагаан өдөр нүүрийг түлж гоочлон доромжилсонд Жамсранчойн уур улам ч хүрч дургүйцэн,

—Жанжин тантай зам мөр нийлэхгүй нь шиг бололтой. Яагаад гэвэл та төр улсад тэрсэлсэн дайсан. Би бол жирийн нэгэн хулгайч, тэгэхээр үзэл, зорилго ч таарахгүй байдаг зөв биз дээ. Та эртхэн аргаа бодсон дээр байх шүү гэж түс тас хэлснээр буу, буугаа шүүрч авсан боловч хэн хэн нь зүрхэлсэнгүй, гараа татаж царай буруулжээ. Энэ өдрөөс эхэлж Жа жанжин дуугаа хурааж, Жамсранчой «сүүл» сөхөхөд, Талын цагаан талархаж, Сайнзаяа сайшаан хурцалдаг болов.

Хар модон битүү ойт их хөвчийн ноён оргилын баруун суга асгат хадны өвөрт гурван чулуун тулган дээр тавьсан тогоотой цай уухаар хэдэн хүн тойрон сууцгаана. Хойт талд Жа жанжин, баруун гар талд нэлээн зайдуухан Дэчин, зүүн талд Жамсранчой, түүний хажуу хавирганд Сайнзаяа цай аягалан өгч байтал тэр өдрийн харуул талын цагаан ирж,

— Ажиг сэжиг юу ч алга. Цай уухаар ирлээ гээд Жа жанжны ард байгаа аяга авах хоромд,

— Бүү хөдөл. Гараа өргө гэх сүрлэг дуун дөрвөн зэрэг тал талд хадахад Жа жанжны гар буугаа амжин шүүрч гохдохоос урьтаж талын цагаан, жанжны гар луу ганц дэлсэхэд бууг алдаж гараа ганзагалан гөлөлзөнө.

Бага дарга Нэмэх зогссон байрнаас суга үсрэн урагш хэд алхахад хайрт нөхрөө таньсан Сайнзаяа босож суун тэвдэнэ. Нэмэхийг үг дуугүй гар сарвайхад Сайнзаяа дуу алдан цухирч буутай гарт тэврүүлэн эхэр татан уйлна. Ойт их хөвчийн шувуухай хүртэл шулганан жиргэх нь Нэмэх Сайнзаяа хоёрт охин Гэрэлтуяа нь шиг санагдана. Цэлмэг хөх огторгуйд тогтчихоод чичивгэнэн байгаа шувуухай Сайнзаяад Нэмэхийн нь зүрх шиг, Нэмэхэд Сайнзаяагийн зүрх шиг санагдахад тэр хоёр тэврэлдэн үнсэлцсэнээ ч анзаарсангүй ээ.

—Аав яасан бэ? гэж Сайнзаяа аргадангуй асуухад,

—Амьд мэнд бий гэж Нэмэх хариулав. Ойн гүнд ямар нэгэн чихэнд чийртэй анир чимээгүй, нам гүм. Балар харанхуй ойн гүнээс бууж яваа хүмүүсийн урдахь улбааг алтан наран шижиртэн гийгүүлж, одоо тэднийг төөрүүлэх харгуйгүй, ганц тод зам л луужин гэлтэй хөтлөн зурайна.

## Арван наймдугаар бүлэг

### Захидлын хариу

#### I

Цэлмэг хурц нартай ч дүнсгэр бүгчим өдөр байв. Гэрийн сүүдэр бараадан суусан хүмүүс хярам ууцгааж, өтгөн шаргал цайны тухай үг хэл татлан өгүүлэх хүн цөөнгүй.

—Дулдай гуай! Захидлаа унших уу? гэж горзгор хөх хархүү аядангуй асуухад цохилуурт гаансны толгой тогшин буй Дулдай,

—Лхам аа! Гомбодоо Гүнчин хоёрыг дуудаач, охиноос чинь захиа иржээ гэвэл ухаан жолоогүй орж ирнэ гэв. Залуу хархүү өндөр дуугаар захидал гүйлгэн уншихдаа,

—Хайрт аав ээж, ах эгч нарын амрыг эрье. Та нар цөм сайн байцгаана уу. Бид бие сайн, эрхэлсэн ажил зүгээр. Хотоор онцын сонин гойд юмгүй, хэвдээ байна. Аав таны захидлыг хүлээн авч маш их баярлалаа. Аав та, нийтийн дайсан германы фашистыг дарж устгах их ажилд хувь нэмэр оруулах гэж үнэн цагаан сэтгэлээс чармайж, үр хүүхэд бидэнд нөөж хадгалсан хогшил хөрөнгөнөөс зарж борлуулан агт морьд зориуд худалдан авч зөвлөлтийн ялгуусан хүчирхэг улаан армид бэлэглэсэн явдал туйлын их баяр бахархал төрүүллээ. Шударга хүн төрөлхтөн, нийтийн дайсан германы фашистыг дарвал даян дэлхийд энх амгалан болж, бид бүхэн сайн сайхан амьдрах болно. Аав аа, та ингэж ухаалгаар хандан, гавьяатай үйлс бүтээсэнд тань бид хоёр чин зүрхнээс баярлаж байгаага дахин илэрхийлье. Гомбодоо гуай, Гүнчин гуай! Танай охин Наянтай хичээл номондоо идэвхтэй сайн сурч байгаа. Та хоёрыг битүүдээ их санаж байгаа бололтой байна. Тэгэхдээ гэр энэ тэрээ санаж байна гэж ердөө цухуйлгахгүй. Гүнчин ээжийгээ дууриасан чамбай охин шүү. Бид зуныхаа амралтаар очих санаатай байгаа. Нэмэх маань саяхан фронтод хүргэх бэлгийг манаж харгалзах ажлаар СССР яваад ирсэн. Сонин ихтэй явсныг товчхон бичье. Яг бэлгээ өгөх үед хэд хэдээр хуваагдаж бэлэг тараах комиссынхан явахад мань хүн комисс болоод галын шугамын нэг анги дээр очсон гэнээ. Танкийн суман дарга өндөр цэгц нуруутай туранхайвтар орос хүн комиссын даргад монгол хэлээр рапорт өгч цөмтэй гар барьж мэндлэхдээ өөрийгөө ахлах дэслэгч Семён гэж гэнэ... Гэтэл Дулдай гар даялан мушилзан инээмсэглэж,

— Байз, байз, уншихаа түр азнаарай. Тэр Шимээн гэдэг чинь миний яриад байдаг өнөө орос байна шүү дээ? гэхэд эхнэр нь гайхан эргэлзэж,

— Ямар орос вэ? гэсэнд Дулдай итгүүлэх гэж мэтгэн,

— Яагаа вэ? Тээр жил охин хүргэн бид хэдийн будилж явахад эсэргүүнд тоногдсон хоршоо сэргээх гэж бараа ачиж ирж байсан орос жолооч. Энэ хүн, манай хүргэний ганц ходы түнш нь байхгүй юу?! гэхэд Гомбодоо гэнэт цочин сэрсэн юм шиг,

— Өө тийм, тийм. Оорцог толгойн тэнд гурвалжин дөрвөлжин буудалцахад Нэмэх Шимээн хоёр үнэхээр ижий ахай байсныг санаж байна. Ингээд бодоход юм, юм их сонин, эр хүний

замын хүзүү урт аа гэдэг үг мөн үнэн үг шүү! СССР, СССР л гэнэ, чухам хаана ч байдаг улс юм бүү мэд. Хаа байгаа тэр газар Шимээн Нэмэх хоёр уулзаж л байдаг гэж гайхан бодолхийлэхэд Дулдай,

— За! дүү минь цааш нь уншаарай гэв. Нэмэх эхлээд би андуурч байгаа юм биш байгаа гэж бодогдон бие барин гайхсан боловч гар барих үед үнэхээр наиз нь дүрээрээ нүдэн дээр унаж,

— Нөхөр ахлах дэслэгч ээ! Бага дарга Нэмэх гэхэд Шимээн нэг сүрхий том харснаа,

— Нэмко, Нэмко гээд тэврэн авч үнссэн гэнэ. Урьдын зузаан түншүүд гэж ойлгож мэдсэн дарга, цэрэг, комиссын нөхөд тойрон хүрээлж тэр хоёрыг гар дээр дээш өргөн шидэж, хамгийн хүндтэй баяр талархал хүргэж хөгжин байтал дайсны зүгээс гэнэт гал нээж, таатай уулзалт тасалдсан байна. Ийм шиг л сонинтой явж, их баяртай ирсэн. Та нарт хугас цай, ганц дүнсэн тамхи, Шимээний татаж байсан попроосоо Нэмэхэд бэлэг болгон өгснөөс хэдэн ширхгийг сонин болгож явууллаа. Захидал ирүүлэхийг хүсэн хүлээж амрыг эрэн ёсолсон Сайнзаяа, Нэмэх, Наянтай нар. 1943 оны . . . сарын . . . -ны өдөр гэжээ.

— Ээ төрийн минь сүлд. Хүүхдүүд минь өвчин зовлонгүй, ажил албандаа сайн байгаад баяртай байна. Жаахан цагаан идээ явуулахыг бодъё гээд Лхам зөөгдсөн хярам аягалан Дулдайд өгөв. Дулдай хэсэг зуур бодолхийлэн байснаа,

—Тэр герман-фаашийсат гэдэг чинь өнөө гамин, барон, гучин хоёр оны эсэргүүн нараас долоон доор золигууд гэж бодохоор тун аюултай гэж байгаа. Тэгэхээр хэлэх үг алгаа! Тийм дайсныг шалав даръя гэж бодохгүй хүн гэж байхгүй ээ. Орос улаан цэрэгт хэдэн морь бэлэглэсэн маань маш оножээ. Охин хүргэн хоёрын санаанд дүйж баярлуулсан нь яамай, яамай. Цаанадаж СССР улс, наанадаж манай улс, үгүй ер тэгээд ард бидний өөрсдийн маань тусын тулд хэрэг шүү дээ! гэж Дулдай хэлээд эхнэр Лхам руу гоцлон харж,

— Чи наашаа харж, миний зааж зурахыг анхаарч бай гэхэд «за, ярьшиг даа намайг хар гэнэ шүү. Гучин хэдэн жил харж байгаа юм чинь...» гэсэн бодлоо зөвтгөсөн мөртөө дотуураа таашаан баярласан Лхам үл мэдэг жуумганан инээмсэглэж,

— Юу вэ? гэв.

— Цаад цайгаа нүдээд хүүдийд хий. Хөөрхий дөө муу хүргэн минь хэмжээ дамжаатай оногддог юмаа өөрсдөө хэрэглэхгүй, чи бид хоёр руу л явуулчихсан байх юм. Энэ эрдэнэ мэт ховордсон юмыг айл ах дүү нарт амсуулах хэрэгтэй. Олонтой бол баянтай гэдэг үнэн шүү! Тэгэхдээ хүрэлцээгээ сайн бодож атга атгаар жишиж хуваахгүй бол хүрэлцэхгүй гэж мэдээрэй. Ээ дээ! Лхам минь хүн л ялгаж болохгүй. Гочоо өвгөн, Пагма чавганц хоёр гол ус алгасан нүүсэн хэдий ч чимххэн ч гэсэн юм явуулаарай. Олдсон цагт нь хуваагаад хэрэглэх шиг сайхан юм байхгүй гэж Дулдай итгэл төгс өгүүлэх нь гэрт байсан бүх хүнийг баярлуулсан гэж жигтэйхэн.

## Арван есдүгээр бүлэг

### Нугасны ус

#### I

Хотын төв хэсгийн хөлөрхүү талыг түшиглэн суурьшсан шургааган босоо хашаатай элгэн хүрэн өнгөтэй том хаалганы хажуугийн бага татуурга дээр дүүжилсэн ширмэн хонх дүн, дан дуугарч орж гарагчдад дохио өгнө.

Зүүн бүланд өнцөглөн барьсан жижиг шавар байшингийн хаалга гадагш нээгдэхүйеэ, өглөөнөөс орой заримдаа шөнө хагаслан хөл тасрахгүй бөгөөд хайш, яайш хадагдсан «архины мухлаг” гэсэн хаяг нь «Вандангийн мухлаг» гэж хавь ойрт алдаршаад, тэрхүү сархдаар нэршин буй дорвилог хаягийг Вандан төлөөлөх болсны чухамхүү үнэн учрыг олох гэж хэн хөөцөлдөх сөн билээ. Байшингийн баганхи хэсгийг нарийхан вандан ширээгээр зааглан тасалж, ханын тавиур дээр ярайтал өрсөн шилтэй архины дээд талд жижиглэн худалдаалах эрхийн бичгээ, шиллэсэн үзэмжтэй гуунд нандигнан хийгээд хадаасанд өлгөжээ.

Өглөө эртлэн ирсэн шар тайлагчдын дуудлагаар Вандан, их таван ханатаас мухлаг өөд бараг гүйнгүүт очиж, цоож, ломбоо шалгаж, яаран түлхүүрдвэл хуучин танил хэд бие биеэс өрсөн үхэтхийн зүтгэж харагдана. Уван цуван цугларч ид л оволзуулж эхлэв. Тамхины утаа манаран цэнхэртэж, спиртийн эхүүн үнэр ханхалсан энэ тасалгаанд, хэрэв дасаагүй хүнд бол агшин зуур тогтох бүү хэл шагайхын ч арга алга, энд ч босоо, суугаагаар гурвалжилсан маргаан болж,

— Чам зэргийн хөрзийсөн муу гуйлгачинг бодвол насаар балгах хөрөнгө байнаа хө хэмээн баярхахад,

— Юу гэнээ хө, миний дэргэд чи юу ч биш, чамайг бодвол ажил төрөл, алдар нэртэй хүн шүү. Төмөр царлиа бариад бэхэнд дүрж оюунаа задлахад чам шиг ам баян этгээдийг бараг зуу дахин худалдаж чадах олборыг мөч, мөчийн дотор олж чадна, хараад байгаарай! гэж бардагнавал,

— Хээ, хээ нэг нь баян, нөгөө нь эрдэмтэн болж байна уу? А тэгвэл, би гэдэг амьтан зөвхөн хөлчүүрэгчийн дүрээр нүд үзүүрлэгдэн хүний тооноос хасагдах болж байгаа юм биз дээ. Цагдаа нар намайг халамжлан анхаардаг байтал та нар тэдний дэргэд юу юм бэ?! Ер нь би ажил төрөлгүй атлаа өдөр бүр уугаад байдаг энэ мөнгийг хаанаас олдгийг мэдэх үү? гэж ханхалзаж эхэлбэл,

— За, За! Муу луйварчин панзчин дуугаа тат хэмээн зэрэг зэрэг агсрахад,

— Яана гэнээ. Одоохон үзүүлээд өгье гээд босох гэж оролдов. Нөгөө хэд, хэд хэдээр тэврэлдэн,

—Эвий гөөгий минь, миний ганц алтан түнш. Чамтай танилцаагүйсэн бол ингэж цэнгэн

наргиж чадаа ч билүү? үгүй ч билүү! Бүү мэд хэмээн дэвэргэн егөөдөж,

— Миний ганц итгэлтэй найз сүүн сэтгэлтэйгээ адилхан түрийвч нь төгрөг, мөнгөөр үргэлж дүүрэн байдаг нь тун таатай шүү гээд зузаан хүрэн уруул цорвойлгон нөгөөхийн ам, хамрыг шүлсдэж, нэгэн эр гуниглаж, нөгөө эр шаралхаж,

— Надад ердөө л ерэн найман мөнгөний бутархай байна. Хоёрхон зоос туслах нинжин сэтгэлтэн байна уу! Үгүй юу? Би асууж байна гэхэд нэр үл мэдэгдэгч:

— Эд муу сайн бардам баячуул, бусдын хүч хөдөлмөрийг сорон завшигчид, гаргуундаа гарсан луйварчид, архичин, завхай чалчигчдаас хүндага архины мөнгө горьдох дээр арай ч хүрээгүй байнаа. Аль вэ? хө Вандан эрхлэгч ээ! Миний зээлийн дансанд дахиад нэг лонхын үнэ нэмчих, маргааш гэхэд хуучин, шинэ өрний данс хаагдана гайгүй гэж ханхалзав. Өдөр дараалсан балгуушинд нэвгэрч нэвчин буй нэгэн залуу эрийн элэй балай ухааны бүүр мухар тагт мухлагийн босгон доор хамар хатган ойчсон шиг санагдаж, бөөлжист аманд халуун бүлээн юм байсхийгээд хүрэх шиг болно.

Ус гүйлэгнэсэн талимаа нүдэнд нь оцойж суугаад хэл амаа долоож буй пөөнөгөр шар хавны толгой гурав, дөрөв болж харагдахад нүдээ ахин дахин арчиж ажигласан ажээ.

## II

Худалдагч Вандан найзуудынхаа ая тал засан талархсан тав, арван жүнзэнд ходоод дотор нь халуу даагаад,

— Авцгаа, авцгаа, Байна шүү! Мөнгө ходоод хоёр л мэднэ. Өөрийн эрхээр балгаж жарганаа гэдэг чинь хорвоог бараг тэр аяар нь залгина гэсэнтэй жишээ хавь ойролцоо болов уу! Харин цаас мөнгөгүй атал хорвоог хоолтой үндэстэй нь залгих гэвэл, хорвоо холдоод явчихна. Эсвэл хоолой дээр чинь тээглэнэ. Үгүй бол доошоо цээж зуран ороод халуу дааж, дааж гардаг сүвээрээ гарахгүй, буцаж онги тавих гэж зовооно. Аялуулж болно, үүнээс битгий ай! уул нь хорвоог залгих байтугай бүрмөсөн сорж балруулж байгаа нь тэр гэж мэдээрэй. Миний хувьд энэ огт падгүй. Харин хэдэн балгаар хүндагалах вэ? шилээр нь дугтрах уу хэмээн Вандан байн байн өдөөж байгаад танил, найзууд ба эс танигчдын өвөр түрийвч бүрийг хоосолж, өөрийнхийгөө түхийлгэснээр өдрийн ажиллагаа завсарлана.

Вандан тэр нэгэн өдөр тун хөхүүн байдалтай, тухлахаар завилан сууж, төө хэртэй хаш цагаан соруулаа байн байн зүлгэж, тамхи нэрэн сорж, том мөнгөн аягатай цай руу ширтэн, «...яхав олонд хар буруу санаж яваагүйн ачаар гурван халуун амь эсэн мэнд, амь зуулга ч чамлалтгүй, тарган малын бөөрний өөх шиг л мулцаглаж байна даа хөөрхий. Надтай дөрөө жийсэн зарим атаа жөтөөтөн, Вандангийнх дотуураа айхавтар зузаарч байна.

Гэнэт баяжих их гэмтэй, юу л бол гэж эргэлздэг байх. Гэлээ гэхэд энэ чинь ёстой ариун хөдөлмөрийн үр шим, атаархан дэвэрч, хор шарандаа хахаж цацаад байвал надтай адилхан амьдрах л үгүй юу гэж амыг таглахад хэл нь годгонохоо болино» гэх түгшмэл бодлоо орхиж, жижиг хайрцагны таг нээгээд,

—Миний муу хонгор шар жаахан ойрт. Мөрийг чинь улайлгахгүй явбал сэтгэлийн түвшин энэ дээ. Тэгээд үү!... гэж шалиглан өгүүлбэл гэргий Хандсүрэн айлгүйтэн жуумганаж цаанаа нэг жоготой маягаар намжирдана. Вандан:

—Өнгө нь тааруу ч яс чанарыг бодоод хэдхэн ам энэ «нүдний хорхой татагч» үйтэн хуарийг үнээр цохиод авлаа. Санаанд чинь дүйгээсэй билээ гэхэд нүдний гэм болон ховордсон тэр эд Хандсүрэнгийн харааг булааж том том дугуй хээг нүд гүйлгэн ширтэж,

— Уул нь өтгөн хөх юм уу? элгэн хүрэн тос даасан өнгө байсан бол сайнсан.

Иймэрхүү үнсэн саарал юмыг чинь өмсөөд гудамжинд гарахаар Вандангийн бандгар шар хүүхэн гэхийн оронд пээ бүү үзэгд, Хандсүрэнг харахаар хээрийн амьтан санаанд орлоо гэж хээнцэр авгайчууд хэл амаа билүүдвэл чиний нөгөө «Хүрээ панз»-ын цуутай алдар чинь бузардах вий. Нэгэнт гарт орсон шүү юм бол тэрлэг шидүүлээд гал тогоонд өмсчихье гэвэл Вандангийн хөх инээд хүрч,

—Нээрээ л нэр хугарахаар яс хугар гэдэг үлгэрээр алдар нэрээ хэдэн ам даавуугаар арилжих дээр арай тулаагүй шүү. Тэгвэл энэ та гуайн санаанд дүйхсэн бол уу? гээд хөлс хирний үнэр шингэсэн хуучин дурдам алчуурын үзүүр дэх зангидмал зүйлийг тайлан задалбал хэдэн том сувд, лан гаруй алт байв. Тэгэхэд үнэт, хатуу эрдэнэсийн зүйл рүү удтал гөлрөн ширтэцгээлээ. Нөхөр нь таашаангуйгаар ам нээхдээ:

— Би ямар эд таних биш, алт, мөнгөний дархан л жинд шижир гэхээр нь найдаж хонжооны хэдэн төгрөгөөр гарт оруулсан юм гэж бардамгай маасганахад гэргий нь:

— Энэн дээр ч ёстой эр хүн шиг хөдөлж, онох онохдоо бүүр оньчийг олжээ. Гурван цэнгээр нь ээмэг үлдэхээр нь бугуйд углах юмтай бол юу гэж санаж байна гэхэд нөхрийн нь хөлчингүй харцанд сэтгэл санааны дотоод орчлон тодроод,

— Юу сайхан гэвэл дур сайхан, аль вэ? балгууш байна уу? Үгүй бол оронд нь хацрыг чинь нэг...

— За яршиг даа, тавин хэдэн насыг наслах хүртэл өдөр, шөнийн үйлсийг ялгаж сурмаар юм. Харин гашуун усандаа нэвч, нэвч. Бие махан бодио залуужуулдаг ид шидтэй бол лонхон дотор нь ороод бөглүүлсэн ч болно гэж ёжин өгүүлээд минлүй нэгэн шилийг гарган сарвайхад Вандан хэдий гар сунгаж амжаад балайруулдаг ундааны охинд хордон буй ходоодноос хуран гарсан хар шүлс аманд дүүрэхүйеэ хүд хийтэл эргүүлэн залгив.

### III

Багш Сайнзаяа ирцийн бүртгэлийг сөхөн хараад «Бэлэгсайхан өнөөдөр бас л хичээл таслах нь...» гэж цухалдан бодов. Ангид нам гүм, хааяа бэхний саванд үзэг цохин дүрэхэд тог тог хийж, дэвтрийн хуудсыг эргүүлэхэд үл мэдэг шаржигнах чимээ гарна.

Сурагч Бэлэгсайхан эхний цагийн дундуур хэнэггүй байдалтай орж ирээд ширээндээ суухад багш



—Чи яагаад хичээл таслав?

—Толгой өвдөж халуурсан.

—Эмчийн акт байна уу? гэж багш шалав.

—Эмчийн гэж Бэлэгсайхан хэлээд хэнэг ч үгүй хажуугийн хүүхдээ дооглон үймүүлнэ.

Багш Сайнзаяа «илжигний чихэнд алт хийсэн ч сэгсрээстэй, ус хийсэн ч сэгсрээстэй» гэдэгтэй адил болсон хүүхэд шүү гэж бодсоноо гомдох сэтгэл төрж хичээлээ үргэлжлүүлэн заав. Багш шинэ хичээлийн дараа өчигдрийн хурааж авсан цээж бичгийн дэвтэр тарааж өгчээ.

Нэг дэх эгнээний баруун гар талд сууж буй эмэгтэй сурагчийн араас Бэлэгсайхан сэмхэн чичлэн ёворч,

—Наянтай аа! чи хэд авсан бэ?! харуул л даа гэхэд тэрээр багшийн нүдийг хариулан анаж,

—Дөрөв. Чи? гэж хариу лавлахад,

—Дархан бөгөөд тарган хоёроо авсан гээд хажуугийн сурагчийн чихийг няслаад

—Тавын таахай, таахай хэвдээ биз гэж хочилно,

—ёо, ёо! Багшаа! Бэлэгсайханыг хараач гэхийг сонссон багш,

—Бэлэгсайхаан! гэхэд өндөр нуруутай дүрсгүй жаал шовосхийн босож дороо зогсов.

—Томоотой байна уу! Үгүй юу! гэж цөхрөнгүй байдалтай дуугарвал,

—Багшаа! Би томоотой байна аа! гэв. Хоёр дахь цагийн завсарлагаар багш Сайнзаяаг захирал дуудаж «аавыгаа аваад ир» гэж Бэлэгсайханд хэл гэж тушаажээ.

Тэгэхдээ «битгий тэр чигээр аг таг болчихоорой» гэж анхааруулаарай гэсэн ажээ.

Төдхөн захирлын тасалгаанд ангийн багш, сурагч Бэлэгсайханы аав нар орж иржээ. Захирал ихэмсгээр хоолой засаж,

—Вандан гуай! Энэ тухай асуудлаар бид гурав дахь удаагаа уулзаж байгаа болохоор бүгд ойлгомжтой байгаа биз дээ. Одоогийн байдлаар танай Бэлэгсайхан сурлагаар сул хэвээр, удаа дараа олон цагийн хичээл тасалсан төдийгүй, тамхи татах, нөхдөө шоглох зэрэг сахилга бат алдах явдлыг гүнзгийрүүлж байна. Тэр ч байтугай архи ууж байсан сурагтай байгаа шүү! Ангийн багш нь эцэг, эх та нартай байнга харилцаатай аргагүй ажиллаж байгааг бид сайн мэдэж байна. Та эрх биш юм бодно байгаа гэвэл Вандан илтэд зовонгуйран нүүр үрчийлгэн барсхийж,

—Энэ гайхал хэлээд, хэлээд тун үг авдаггүй хүн. За гайгүй ээ! Чамайг турсагыг чинь өвчөөд

өгье. Тэгэхээр чи элдсэн сур шиг болноо гэж дүрэмдэн өгүүлэхэд захирал дургүйцэнгүйгээр,

— Вандан гуай! Та ахмад настай хүн шүү! Тэгэхээр банз шаахайны амт ч амссан байж болох юм. Хүнийг зодуураар ухааруулж болдоггүйг амьдрал баталж байна. Ялангуяа хүүхдийг зодож нүдэх, хэт эрхлүүлж дураар тавих, үгүй бол сайн сурлагын төлөө элдэв амлалт өгөх, хуурах нь хамгийн харш зүйл байдаг. Та бичиг үсэг мэддэггүй юмаа гэхэд хүүхдээ хичээл тараад очиход унд хоолыг өгөөд, өнөөдөр ямар ямар хичээл оров. Ямар даалгавар өгсөн бэ?! Миний хүү даалгавраа хий. Бич, унш гэж зөвлөж болно биз дээ. Харин хэтэрхий яншиж, загнах, залхаах нь харштай байдгийг бас санаарай гэж зөвлөхөд Вандан цэнээд хэлж чадахгүй байсан үгээ өөрийн эрхгүй урсгахдаа:

—Та бүхэн миний хүүг эрдэм номтой сайн хүн болгох гэж ийнхүү зүтгэн мэрийж байгааг бодохоос баяртай байна! Ээ дээ захирал, багш нар минь хүүхэд гэдэг чинь салхины аясаар дэвж байдаг цаасан дэвүүр байдаг юм байна. Хэлээд, гуйгаад арга барагдахын эрхэнд унадаг дугуй аваад өгсөн чинь бүүр хөл орж алга болчихоод тэвдүүлэхээр барах уу?! Манай гайхал гудамжны гарц гарахдаа дүрэм журам зөрчиж буулгүй буруу гараар жийж орхисон учраас хүний хөтөлж явсан дугуйг мөргөж янбийлгаад, өөрөө золтой л амь мэнд үлдсэн удаа ч бий. Үүний төлөө би цагдан сэргийлэх дээр дуудагдаж хүний дугуй төлж, бас торгууль хүлээж хөөрхөн шоглуулсан гээ. Түүнээс хойш Бэлэгсайханы хөлийг хориод байгаа.

Манайд Гомбодоо гэгчийн навьшгар шар охин байдаг юм. Тэрний сурлага сайн, үг хэлнээс ер гарахгүй, тун томоотой. Түүн шиг байж үзээч гэж би хүүгээсээ гуйж ч үзлээ, зодож ч үзлээ, тун ч үг авахгүй юм аа. Бүсгүй хүүхэд ч шал өөр байдаг юм байна гэж гомдлон өгүүлэхэд багш Сайнзаяа үгийг нь тосон авч,

—Вандан гуай! Сурахад эрэгтэй, эмэгтэйн ялгаа байдаггүй юм. Хүүхдийн идэвх сонирхол, уйгагүй ажиллагаа, багш, эцэг, эх бидний байнгын хандах хандлага л мэднэ. Өөрөөр хэлбэл хүүхдийн сурлага хүмүүжлийн төлөө ажиллах ажиллагаа, тавих шаардлагаас шалтгаална гэдгийг анхаарах хэрэгтэй. Хүүхдийн сурлагын үнэлэлтийг эд юмаар худалдан авч хэзээ ч болдоггүй.

Та энэ тухай эндэж алдаж байвал хожим хойно амаа баривч хожимдоно гэж албаны үгсээр буруутган зэмлэвэл, Вандан сэрхийж,

—Та бүхэн яг л орой руу цоргитол үнэнийг минь хэлж байна.

Би харьж Хандсүрэнтэй хавсайдаж байгаад нэг мэдэхэд Бэлэгсайханыгаа эрдэм номтой гялалзсан эр болгож чаднаа гэж бэлэн зэлэн амлаад бушуухан гарчээ.

Захирлын өрөөнөөс гарангуут Вандангийн бодол мухлагийн ханын тавиур дээр өрөөстэй архинуудын дотроос өөрийн мэдэх тэмдэгт хэдэн шил дээр сэтгэл нь тусаж шалавхан алхана. Тэртээ холоос мухлагийн байшингийн бараа дөнгөж үзэгдэх төдийд олборын шунаг шингэсэн харц шавар ханыг нэвт шувт цоргин мөнөөхөн шилтэй цэнхрүүд дээр яг таг тусах мэт нүднээ л тод үзэгдэнэ.

Хар ухаанд сампингийн эрхийг гүйлгэн эргүүлж олборын хонжвор давхар завших ашгийг

ханцуйд залбиран сэтгэл уужрах шиг болно. «Бурхны авралаар таатай олбор надад заяажээ. Удаан үргэлжлээсэй. Эд байвал эрдэм байхын ч хэрэг юу билээ. Ганц хүүг минь сургуулийн хэдэн хэнхэг ад үзээд байвал гаргачихнаа гэж сайхан юм бий. Энэ Сайнзаяа гэж өлөгчингөөс юу ч болж мэднэ» гэсэн битүү хатуу бодол нь Вандангийн зүрх сэтгэлийг улам ч хордуулах ажээ.

#### IV

Сүүлчийн цагийн завсарлагын хонх дуугараад хэдэн хором өнгөрчээ. Сурагч Бэлэгсайхан гадас хэлбэрээр зориуд үзүүрлэсэн жижиг мод бариад «Нугасны ус» авч байна гэж хэлээд хэдэн хүүхдийг хатгаж чичлэн, гадуур хувцсыг ураад зогссонгүй нэгэн эмэгтэй сурагчийн хацрыг шархалтал зурж хатгаснаар түгшгүй шуугиан дэгдэв. Захирлын тасалгаанд хацартаа цус шүүрэм гүвийсэн зураасан зурвас улаан шархтай эмэгтэй сурагч мэгшин уйлна. Будлиан таригч Бэлэгсайхан багш нарын асуусан үгэнд хариу өгөхийн оронд дуугүй гөлийж, шал ширтэн зогсоно. Даамжран газар авч буй сурагч Бэлэгсайханы асуудлыг нэг тийш болгохоор шийдэн цагдан сэргийлэхээс хүн ирүүлж ноцтой будлианыг хянан үзэхийг хүсчээ. Цагдаа хархүүгийн асуултанд Бэлэгсайхан «Нугасны ус» авах гэсэн юм гэж хариулав.

— Нугасны ус гэж юуг хэлдэг юм бэ?

— Мэдэхгүй.

— Мэдэхгүй байж хэлэхгүй, мэдэж байж хэлдэг юм гэж цагдааг тулган асуухад Бэлэгсайхан таг дуугүй газар ширтэн сууна.

Ингэж суутал Нэмэх орж иржээ. Нэмэх, Бэлэгсайханаас хэдэн асуулт асуугаад,

— Аа, чи чинь Вандангийн хүү вий. Аав нь архины мухлагийн худалдагч хийдэг хэвээрээ юу?

— Тийм ээ. Архи зардаг гэхэд Нэмэх нэгийг бодож,

— Миний дүү нугасны усны талаар хийж чаддаг атал хэлж мэдэхгүй гэдэг худлаа даа гэв. Бэлэгсайхан дуугарсангүй. «Хүүхэд дуураймтгай, энэ жаал заавал нүд үзсэн юмаа дуурайсан байж таарна» гэж амжин бодсон Нэмэх залгаж асуухдаа,

— Чи эмнэлэгт хэвгэж байсан уу?

— Үгүй.

— Хаана, хэн нугасны ус авч байхыг харсан бэ?

— Би хараагүй гэж жаалхүү түгдрэнгүй хариулж үг алдахгүйг хичээнэ. Нэмэх, цагдаад онцлон зөвлөхдөө:

— Энэ сурагчийн будлианыг хөнгөн хуумгай үзэж болохгүй. Цаана нь ямар нэгэн ээдрээ нуугдаж байна. Уул нь цохилдуулах мэх хийхэд хүүхэд томчуулаас амархан гэдэг байх аа. Нэг туршаад үзье.

Тарилгын хорин граммын зүү харуулангуут үүнийг хэзээ, хаа үзсэн бэ? гэж асуу. Тэгэхэд л нэг учир ургана» гэж бодож байна гэжээ.

Бэлэгсайхан тарилгын зүү хармагц сэртэсхийн харснаа «Энэ ахын барьж байгаа зүү яг мөн байна. Эд хаанаас олоод аваа юм бол? Өнгөрсөн өвөл намайг өвчтэй хэвтэж байхад манай аавын найз ууртай харцтай, хууз сахалтай тэр хүн нэгэн өглөө эрт ирээд, аавтай шивнэн ярилцаж байгаад яг л ийм зүү гаргаж аль вэ хө хоёр гурвын нугасны ус аваад орхиё» гээд шилтэй архи хоёр өвдөг завсар хавчиж зүүгээр хатгах шиг болсон. Тэр хүн дээлийн ханцуйг тохойд хүртэл шамлаж халиурсан хар устэй манцгар гараар архины шилийг бяц атгах шиг болж билээ. Аавын хэлсэн үгэнд «урьд шөнө гурав талийсан байна билээ. Нугасны нь усыг тааруу найруу аваарай» гэж захиж байсан нь ямар учиртай юм бол?! За бүгдийг хэлье гэх аймхай бодлоо нууж чадалгүй тэр дороо:

—Ийм зүүгээр, аавын найз үст гарт нугасны ус авахыг би харсан гээд үзэж харсан бүхнээ тэрээр тоочжээ.

## V

Вандан мухлагийн юмсыг эмхлэн аялуулж байтал хашааны гадна сэргийлэхийн болон энгийн хувцастай хэдэн хүн ирэх бараанаар дотор нь хүйт дааж, үүдээ түгжих гэснээ болиод зарагдаж амжаагүй үлдсэн шилний тал дундуур хэртэй архийг ганц амьсгаагаар хөнтрөөд өрөөстэй архинуудын дундаас нэгийг онцлон шүүрч атгаад, хийх газраа олж цөхөн тэвдэхдээ дотуур, гадуур өмдний завсар салтаа руугаа гудран хоёр гуяны хооронд хавчаад хормой буулган засаж ер хэнэггүй царай гарган гэнэтийн зочидтой нүүр тулан мэндэлжээ.

— Вандан гуай! Нэг гэвэл тооллого хийж тооцоо гаргана! Хоёр гэвэл шилтэй архи нэг бүрийн градусыг магадлан шалгана гэж бага даргыг хэлэхэд,

— Тэг, тэг тэгэлгүй яахав гэж тун уриалган хүлээв. «Хүрээ Вандангийн дархан халаатай зодгоос барагтай аавын хүү бариагүй юмсан. Эд шинжиж орхижээ. Хэн хэлсэн байж таарах вэ? Мань үст хараас гарцаагүй. Чамайг бариад буунаа» хэмээн бодож хар санаагаа бузар булайн дошин дээр ирлэв. Тооцоогоор хоёр зуун тавин төгрөг илүүдэвч архины градус хэвийн байдалтай байхад Вандан духанд дааварлах хөлсөө ханцуйн үзүүрээр шудран арчиж, сэтгэл амсхийх шиг болоход тамхиа угсруулан нэрж татна.

Тэрээр бодохдоо «...Бурхан минь эрлэгийн элч нар цалмаа хүзүүнд углах гээд байна. Хийсэн нүгэл баруун гуяны дотор руу гулсан тогтовч аюултай хүйтэн жигнэж байхыг яана. Эд мэдвэл Вандангийн бантан тасарна гэсэн үг. Бурханд буруу санаагүй өршөөнө биз» гэж санаа засан бодно.

— Мөнгө илүүдэх ёсгүй. Хэдхэн мянган төгрөгний бараа, мөнгөний тооцоог та бүхэн хумпад гэх хугацаанд гаргаж байх шив.

Энэ зөв өө! гээд Вандан бэлэн төгрөгийг дэвсгэрт нэг бүрээр ахин дахин тоолно «...илүүдэх нь аргагүй. Хоёр өдрийн гүйлгээний өөртөө ноогдох хувийг хүртэж чадаагүйн уршиг! Хөөтэй муу үсэн бүрзээхэйг хүлээсэн нь гай боллоо. Уул нь тэр чөтгөр бичиг үсэг тоо бодлого сайтай

болохоор өдөр, өдөрт нь тооцоо бодож бүртгээд алздаггүй шүү...» гэж бодоод,

— Дарга нар аа! Би гэдэг, хүнээс цаашгүй амьтан шүү дээ! Бичиг үсэг тоо бодлого мэдэхгүй. Хөөрхий муу Догноогийн тус хүчинд л болж бүтсэн шүү ухаантай тоос хөдөлгөдөг юм гэж аядуухан өгүүлбэл, сэргийлэх албаны ажилтан Цэвэгсүх үг өлгөн,

— Догноо гэдэг чинь ямар шүү хүн билээ? Хууз сахалтай билүү?

— Тийм тийм. Өд сөд нь ургаж гүйцээгүй дэгдээхэй гэсэн үг гэж хэлээд маг маг инээх зуураа «...Харав уу? хөөе. Үс сахлыг хүртэл тодорхой мэдэж байгаа нь миний бодол оножээ.

За гайгүй ээ. Чамайг дөнгөнө. Чи л «Нугасны ус» хамтран авья! ашиг хонжоо их гарна гэж надад анх санаа авахуулснаас ийм хэрэг дэгдэж...» гэж мугуйгаар хар санаалан хаширлав.

—Вандан гуай! Илүүдэл ихэсвэл дутагдал, инээд ихэсвэл ханиад болж ч болох юм. Данс яг тохироогүй учраас дахин шалгаж бодно. Тэгэхэд юм юм ч болж мэднэ гэж хэлсэн Цэвэгсүхийн егөөтэй үгэнд жин дарсан нь илэрхий байлаа. Цөм гэрт орлоо. Тэднийг цайлж гарав. Вандан дээл солих нэрийдлээр буруу харан нөмөглөх завшаанд гуя руу гулгасан шилтэй архийг авч дээлээ хумхин тавихдаа дотор нь хийж амжсандаа санаа сая амсхийжээ.

«Зочид» явахаар босоцгооход Цэвэгсүх гар өргөн,

—Нөхөд өө жаахан хүлээнэ үү!

Би бас л ажил ургуулах нь шиг байна гээд гэрийн эзэн тийш хандан,

— Вандан гуай! та сольж тавьсан дээл дотор нэг юм нууцалчих шиг боллоо. Түүнийг чинь үзэж болох уу? гэнгүүт Вандангийн царай хүрээнтэн барайж,

— Тэг ээ, тэг. Нуух юмгүй нэг шил архи байгаа. Хар усанд дуртай болоод... гэж хоолой түгдрэнгүй хэлэв. Эхний магадлагаагаар энэ архины градус... байжээ.

— За, Вандан гуай! Нийгмийн хөрөнгө рүү зальт арга хэрэглэн бузар гар дүрж байсны учир тайлагдлаа. Одоо «Нугасны ус»-ыг шилтэй архинаас яаж авдгийг бидэнд үзүүлнэ үү гэсэн Цэвэгсүхийн булзах газаргүй асуултанд санаа шуударсан Вандан,

— Вандан гуай нь тэр нугасны усыг авч чаддаггүй ээ. Харин миний түнш нөгөө үст хар авдаг юм гэж хэлэх нь Догноод бүхнээ тохих гэсэн хашрын уран мэх болох нь илэрхий байв.

— Авч чаддаг чаддаггүйг үнэн мөнөөр тунгаах байлгүй гэж цагдан сэргийлэхийн ажилтан Цэвэгсүх хэлээд Ванданг дагуулан архины мухлагийн худалдагч Догноогийн руу очихоор явжээ.

«Хэрэв хэрэг бишидвэл ганц толгойгоороо дуусах хэрэгтэй. Хүн дээр хүн нэмэхээр хэрэг дээр хэрэг хүндэрч ял нэмэгдэнэ гэсэн үг шүү! Догноод мөн ч олон удаа сануулсан даа!

Тэр гайхал тэвдэхээрээ юу гэж халаадаг бол?! Гэсэн ч хүрээ Вандан эмээлээ тохож хазаараа

хазаарлах байлгүй» гэж бардам бодож хол хол алхана.

# Хорьдугаар бүлэг

## Олбор

### I

Даацанд нь тулган овойтол ачсан ачаагаа битүү бүтээж, олсон таталгаар чанбай хэрсэн «ЗИС» машин хотын захад их замын бэлчрийн шалгах хэсгийн зогсоол дээр ирж тормос дарав.

Энэ үед өвлийн богино өдрийн оройн нар уулын цаана нуугдаад эрч орсон хүйтэн жавартай үдшийн гэгээг орчин хэсэгтээ хүчирхийлэн дарсан цахилгаан гэрлийн мянга мянган цэгүүд яралзан анивалзах нь үнэхээр содон харагдана.

— За Гомбодоо гуай! Өнөө сүрхий өндөр давааныхаа «хяр» дээр буулаа. Юу ч гэлээ зам явах бичгээ өгнө үү! Би төлөөлөн бүртгүүлээд үзье. Хэрвээ байцаагч, цагдаа, шалгагч нар заавал нүүр тулж шүд амыг татан татан магадалнаа гэвэл тэр л биз.

Эмнэлэгт үзүүлэхээр ах дүүгээ бараадаж яваа ядарсан өвгөн гэж ягшаад байгаарай. Өөр үг алдаж тун болохгүй гэж болгоомжлон захиад бүхээгнээс гарсан жолооч Бат бариул түгжээ нь суларч гажиг суусан хаалгаа хүч хэрэглэн шилбүүрдэж хаагаад цааш эргэн шийдмэг алхав.

### II

Хашааны гадна ирж зогссон дэнхгэр ачаатай машины бүхээгнээс буугчийг лавлаж харсан арван долоо, найм орчин насны залуу ухасхийн дотогш орж,

— Аав аа, аав аа! Наянтайн аав Гомбодоо гуай ирлээ гэх хүү Бэлэгсайханы үгийг баяртай сонссон Вандан зочноо угтахаар гадагшлав. Танил хоёр мэнд усаа мэдэлцэн, өнөөх гэдэг үгээр яриагаа товчилж ачаа барааны доорхи арьсанд боосон үхрийн мах хэд хэдийг арай ядан түлхэж унагаахад хөлдүү газар пад пэд дуугарах чимээ сонсогдоно. Нааш, цааш зорчигчдын зарим нь бүүр тулж сонирхон ажиж өнгөрнө. Жолооч ачааг засаж буй агшинд Гомбодоо алгыг дахин цайлгах юм атгасан гараа ахиулан сунгаж,

— За, жолооч дүү минь ахыгаа ганц гялайлгалаа. Чамд яаж тус хүргэхийг мэдэхгүй байна. Хойтон очиход чинь сав хоосонгүй гэдэгт итгэж болно. Засгийн буянгаар хэдэн гунжны сүү бялхах юм. Харин энэ зөнөг толгой танихгүй нүүр халааж чадах мангуу шүү! Өвөө дөө! Өвгөн ч гэж дээ одоохондоо залуучуудыг дууриаж аман таяг тулснаас биш, хөлөө дэмнэн догонцох дээр арай хүрээгүй ээ! гэж хошин үгээр үл барин аятайхан ивүүрдэж,

— Май хө! Ганц удаа ч болов гуанздаарай. Ёр нь юм нэмж хэрэглэе гэвэл би бэлтэй л байх шүү! гэж тал засан шивнэхэд ингүүлж амташсан жолооч,

— Зүгээр, зүгээр ах аа! Сүү сааль хонины тарган гулууз махан дээр энэ олон төгрөг мөнгө дайварлах нь танд хохиролтой биш үү?! Гэвч би, та нарыг хүн итгэхээрээ тэнийсэн гар татдаг

улс биш гэдгийг аль эрт ойлгосон гэж дөвийлгөн хөөрөгдөж талархаад Гомбодоогийн мөнгийг өвөртлөн машинаа асаах зуур жолооч эр энэ залуурт унаа, алтан шар зам маань өлзий хишигт олбор хайрласаар байна. Энэ хишгийг «хүртэнээ, хүртэнээ» гэж боджээ.

### III

Машин хөдөлсний дараа боодолтой махнуудыг пүнзэн дотор оруулна гэдэг Гомбодоод тун амаргүй санагджээ. Гэсэн ч хэнээр ямар ч ажлаа хийлгэчихдэг аргатай Вандан, айл хунарынхныгаа дуудаж элдэв шог хошин яриа дэлгэн үүсгэж байгаад махаа бараг пүнзэлж амжжээ. Гомбодоо дух шанаа руу нь хөлс гоожиж ядарсан учраас хүн гар хүрээд «үхэр чулуу юм ав» гээд буцдаг ширлэсэн хоёр шарны махыг ширтэн байснаа,

— Болмооргүй бол гудамжинд орхисон ч яадаг юм. Үхрийн мах үүрээд явчихдаг аавын хүү, эр чадалтан байвал аз нь биз гэж цөхөрсөн байдалтай үг хаяхад Вандан,

— Ээ дээ түнш минь олон хөлийн газар хэцүү шүү. Цаадуул «хулгайч нар» чинь хамсаадаж ирээд даачаа тэргэнд тавиад эд бад хийхээ юманд чинээ санахгүй гэж мэдээрэй. Ер нь урьдын цагт бол та ингэж бардам ам ангайхгүй сэн. Гэлээ гэхэд эдүгээ хэдэн зуун кило юм өргөсөн бяртан, хүчтэн тэв дэлхийд төдийгүй, өөрийн улсад нэр цохогдон цоорч буй үе шүү дээ! Тэд тааралдаж тохуурхаж үүрээд өвгөний хаяа түшүүлэн тавьчихаад тавладаг юм аа гэхэд та сайнаа үзэхгүй гэвэл Гомбодоо бараг суун тустал цочиж,

— Тэгвэл бухуур буруу тийш эргэнэ. Тэр дорвитой өвгөний алдрыг сонсож болохсон болов уу? гэж хариу лавлан асуусанд Вандан завхуул яриаг цомтгохыг хичээн,

— Би гэнэ алдаж, дэвэргэнчүүдийн амны бурааг ул барин бурж орхисон учир, миний үг танд эс ойлгогдох нь зөв өө! Хот, хөдөөгүй цэцэрлэгийн жаалууд ч нэг нь нөгөөгөө өвөө, эмээ гэж дуудах болжээ. Цагдан сэргийлэхийн үүдийг эргэн хурган татагчид тийнхүү «Өвгөнийд очив уу?», «Өвгөнийх юу гэж дуудаа вэ?», Хайдаа «өвгөний. босго» мөн ч өндөршүү гэхчилэнгээр ярьдаг яриа бол цагдаагийн байгууллагыг хүндэтгэсэн хоч нэр нь шүү дээ. Та бид хоёр арван тавныхнаас эхлээд ардын цагдаагийн босгыг мөн ч олонтаа л алхсан байх аа. Аливаа дүрэм, журамнаас гажсан муу юм гэж буруутай үйл хийвэл «өвгөнийд» нүүр тулж мэндлэх л болно доо гэв.

Гомбодоо, охин Наянтайг үнсэж таалан мэндлээд гэрт оржээ.

Вандангийн гэргий Хандсүрэн хэзээнээс унд устай, зочин гийчинд илүүц гар сунгадаг хүн билээ. Цай, идээ хийхээр эхэлж бууз жигнэж, бас хар шөл хийв. Гэрийн эзэн буурь зааж хатуухан балгуушны бөглөө мултлахад, Гомбодоо жижиг богц уудлан өрөм, ааруул, шар тос гаргаж Хандсүрэнд гардуулаад хаяг дээр таван хошуунууд ярайсан гадаад архи нэгэн шилийг Ванданд бэлэглэн гардуулахдаа,

— Шүлс дарах төдий юмаар бэлэг болгох нь ичмээр байна гэвэл балгах дуранд байж ядан буй Вандан,

— Олзыг олуулаа гээд бөглөөг бүлт цохих гэтэл



— Дундын хэрэгцээний юм энд бий гэж бардамнасан Гомбодоо шуудайны ам уяа тайлан таван литрийн хөнгөн цагаан сав гаргаж тагийг авахад шимийн архины охь ханхийв. Вандан хэт халахаас урьтан хэдэн үг сольж авья гэж яарна. «Гомбодоо сүрхий зоригложээ. Мань эрийг нэг л юм чичиж хөдөлгөсөн бололтой» хэмээн тааварлаж үг өдөв.

— Хөдөө нутагт сонин юутай вэ? гэхэд Гомбодоо,

— Сав суулга хоосонгүй л байгаа. Дээр, дороо орж үймэлдэх төлөвгэй. Тээр жилийнх шиг нийгэмчлэх бололтой сонсогдоно.

Дамын үг дамжигтай болохоор үнэмших аргагүй байна гээд хүндагалсан архиа хомхойрон залгиад мах багатай халуун шөл нэмж хийлгэлээ. Гэрийн эзэн угсруулан дугтраад,

— Чи тэгээд хэдийнхээ хөлийг юун айхавтар зэрэг, зэрэг амрааж орхино вэ? гэхэд Гомбодоо болгоомжлон, дуу нам болгож,

— Ингэж л самбаачлан урьтаж, хатуу эдлэл, мөнгө төгрөг болгохгүй бол хүний...

Идэш болох нь гэж цэнээ юу? гэхэд Гомбодоо,

— Яг тийм. Тунтайлж боосон нэг үхрийн мах ямар үнэ хүрэх вэ? Аль хэр гүйлгээтэй байгаа бол? гэвэл Вандангийн нүд сэргэн ихсэж,

— Ер нь хотынхон чинь бүхэл идэш, энээ тэрээ гэхээ больжээ. Хоршоо худалдаанд мах тун элбэг. Гэвч одоохондоо ая зүйг тааруулбал мянга давуулаад өгч орхино. Тэгэхдээ тэр өдрийн од л мэдэж байгаа юм гэв.

Гомбодоогийн царай агшин зуур барасхийгээд хуучин хэвэндээ оржээ. «Да хүрээний хог дээр бол хоног өнгөрүүлж байсан улирсан гунигт ядуу цаг үеийг сөхөн санаад ч яахав! Маргааш дор хаяад хоёр мянга гаруй төгрөг атгах нь дээ. Гарын бэлтэй нийлээд түрийвчинд лав багтахгүй дэг ээ. Богцныхоо буланд лавхан хийнэ. Хөөрхий муу эхнэр Гүнчин минь насан турш алт гэдгийг зөвхөн нүд хужирлаж явснаас биш эдэлж хэрэглэж үзээгүй амьтан. Хуруунд нь хийх хэдэн цэн юмтай харих нь хамгийн зөв» гэж сэтгэл тавин хий уужраад хүндагатай архиа Вандангийн авгайд дахин сарвайж,

—Нэг, хоёр удаа явуулж орхивол нойронд сайн байдгийг юу эс андана аж даа гэж цэцэрхэн шаардаад, далдалж ядамгүй шунаг харцаар Хандсүрэнгийн ээмгийг дагуулан ширтэж,

— Зах зээл дээр хатуу эдийн нэг цэнг хэд гэж дуугарч байгаа бол хэмээн шунангуй лавлавал, Вандан хамар өргөж,

— Дамчдын ам ангайдгаар бол амь наснаас үнэтэй гэхийн халаг байгаа. Авах өгөх дээр тулбал аргалж болох байлгүй гээд хундагатай архиа хүүдээ сарвайн,

—Манай Бэлэгсайхан, балгуушинд хүнээс хол хоцрохгүй шүү!

Ганц хүүгийн идэж уухыг хориглон саах хэрэггүй гэж санадаг. Ирээгүй цагийн хадам

аавгайгаа тулгаад уучих гэж ид бах болгон өгүүлэхэд хүүгийн царай хувьсхийн ичингүйрхсэн боловч архиа сурмаг хөнтрөхийг харсан Гомбодоо нүдэндээ итгэж ядан анивчиж,

— Харин хө, архи залуучуул хоёр авцалдаа муутай арилжаа учраас яваандаа нэг нь нөгөөг тонгорч таарах вий. Шилтэй архи газар алджээ гэхэд хагарна л биз. А, харин хүүхдээ буруу замд түлхэж орхивол... гэж утга төгөлдөр үгээр ёжин өгүүлбэл, Хандсүрэн ярианд ам мэдэн оролцож,

— Таны хэлдэг түмэн зөв. Манай энэ хүүгийн сурч байгаа эрдэм шавхруугаар эхэлж, хүндага тогтоодог болж, одоо бүүр гудардаг болж байгаа юм. Эцсийн бүлэгт юу гээч болж төгсөхийг хувь заяа нь мэдэж дээ гээд Гомбодоогийн үгэнд ивээс болгон нөхрөө егөн зэмлэв.

#### IV

Өглөөний ажил цугларалтын дараа гадуур албаны ажилтан бага дарга Нэмэх харилцуур утасны тоонуудыг яаралтай эргүүлэн залгаад чагнуурыг солгой гараар баруун чихэндээ барьж зөв гартаа хөдөлмөрчдөөс ирүүлсэн нэгэн хуудас шуурхай мэдээллийг барьж үг, өгүүлбэр нэг бүрийг маш анхааралтай ажиглаж,

—Нэмэх байна.

... дугаар хэсгийн жижүүр мөн үү? Чухам хэдийд болох нь одоогоор тодорхойгүй. Хөдөөнөөс хот руу нэвтэрсэн... дугаар номертой «ЗИС»-ний жолооч хэн гэгч, шалган бүртгэх үед ямар нэгэн зөрчил илэрсэн эсэхийг түргэн сонсмоор байна гэхэд жижүүр бүртгэн тэмдэглэх дэвтрийг сөхөн шүүгээд,

—Нөхөр бага дарга аа! ...дугаар номертой машины жолооч Бат өчигдрийн арван долоон цаг хорин минутанд албан газрын хэрэгцээний модон материал ачиж манай хэсгээр нэвтэрсэн байна.

Түүнийг ямар нэгэн зөрчилгүй гэж тэмдэглэжээ.

—Мэдлээ. Өчигдрийн жижүүрийн байцаагч, цагдаа тээвэр шалган бүртгэгчийг над дээр ирүүлнэ үү? гэж захирангуйгаар хэлэв.

#### V

Гомбодоо, Вандан хоёул адилхан хийж байгаа юмандаа хий зай гаргаж яваагүй догичуул учраас бүүр өглөөгүүр амжиж хамар хашааныхандаа ширэнд боосон махныхаа нэгийг мянга, нөгөөг мянга хоёр зуун төгрөгөөр зарж үнийг бэлэн авчээ. Бусад махыг ачуулаад дааман хаалгаа хөндлөн түгжээ модоор чагталж байтал цагдан сэргийлэх албаны хошууч эр халз тулан уулзаж мэндлээд гэрт оржээ. Тэрээр цай, идээ амсаж, тамхилсны дараа,

— Уучлаарай. Би цагдан сэргийлэхийн ажилтан хошууч Цэвэгсүх гэдэг. Та бүхэнтэй нүүр учран илэн далангүй ярилцаж, учраа ололцох нэгэн хэргээр ирлээ гээд үнэмлэхээ үзүүлж юу юунаас урьтан Гомбодоог ороох төлөвтэй байв. Сүүлийн хорь шахам жилийн дотор элдэвт

түншүүлж үзээгүй Гомбодоо юу билээ гэсэн шиг гайхан бантаж байгааг гадарласан Вандан, хошуучийн асуусан асуултын заримыг дэмжиж, заримыг няцаахыг оролдоход хошууч,

— Уучлаарай, Вандан гуай! Та жаахан азнана уу? гээд Гомбодоод хандан,

— Та хэн гээч жолоочийн машинд сууж, ямар тээштэй ирсэн бэ? гэж шалган асуухад Гомбодоо илэрхий барьц алдан тулгамдаж, дэмий л найзын нүдэн дохиог хулгайн харцаар ажин анивчина.

Вандан баруун нүдээ эрмэн дохих нь ч жолооч Батын машинд сууж ирсэн үнэн, зүүн нүд анин толгой үл мэдэг сэгсрэх нь «ачаа байхгүй гэж мэлз» гэсэн утга бүхий дохио гэж ойлгосон Гомбодоо хоолой чичрэнгүй, намуун дуугаар,

—Хөлсөө төлөөд жолооч Батын машинд сууж ирсэн. Ачаа бараг байхгүй гэв. Хошууч:

—Бараг байхгүй ачаа маань хаа байна гэвэл жижиг бүлигаар богцыг заав. Хошууч мушилзан инээмсэглэж ёжтойгоор,

—Өчигдөр орой арван найман цагийн үед Вандан гуайн хашааны үүдэнд удаа дараагаар пид, пид хийх дуу гарч газар нүргэлснийг айл саахалтынхан чинь газар тэсэлж байна уу?! гэж эхлээд санасан гэнэ шүү дээ. Тэр дорвитой чимээ үхрийн ширэнд боосон махыг машин дээрээс унагаасны дуу гэж бидэнд нотлогдсон. Тиймээс ч түүнээ шалган магадалж явна. Ээдрээт энэ аргыг та бүхэн хагалах болж дээ гэж хошууч тулгав.

Вандангийн хүрэн царай агшин агшнаар хохийн цайж санааширлаа. «...Гомбодоо гэдэг хүн төрөлхийн моношин мулгуу эр юм даа. Балрах балрахдаа намайг ч аван хайлах бололтой. Өөрөөр нь үнэнийг хэлүүлье. Би л мултарч гарах нь зөв» гэж хар амиа хоохойлон бодоод ам нээх гэтэл хошууч урьтан,

— За Вандан гуай, та хал үзэж хашир таньсан хүн зочныхоо хэлж байгааг юу гэж бодож байна гэв.

— Түнш маань тулгамдан будилж байх шиг байна. Дам дамаа нөхрийн нэр хүндийг хайрлан хамгаалж байгаа бололтой. Гэвч үгээ засаж залруулан үнэнээ хэлэхэд хождоогүй. Бие ядруу эмнэлэг бараадаж ирсэн хүн шүү дээ гэхийн сацуу Гомбодоо сэхээ аван зориг орж,

— Үнэний өөдөөс худал хуурмагийг зориуд сөргүүлэн тавихаар буруутдагийг одоо л ойлголоо. Дүү хүүгээс юугий нь нуух вэ? Нутаг усны над шиг нэг ядарсан амьтан, намайг итгэж найдаад борлуулж өгөөрэй гэж хоёр үхрийн мах өгч явуулсан юм. Миний хувьд гэвэл ганц охин маань сургуульд байдаг, эднийхийг хэдэн жил дарж байгаа болохоор идэш болгож үхрийн нэг мах авчирсан үнээн.

Тээврийн шан хөлсийг жолоочид төлсөн. Хүний өгч явуулсан хоёр махыг бараг сул шахуу тавьж орхилоо гэхэд, хошууч:

—Үнэндээ тийм байж болно. Гэлээ гэхэд худал хуурмагаар бүрхүүлсэн шинэхэн үнэн тэрхүү

хуурамч бүрхүүлийг дэлбэ тавьж байгаад та мэтгэхгүй байх аа.

Маханд шинжилгээ хийлгэж, зах зээлийн татвар хураалгадгийг Вандан гуай та, нөхөртөө зөвлөөгүй хэрэг үү? гэхэд Вандан хахаж цацан хий ханиалгаж «за тэр эс билүү? бөндгөр дээр цахиур хагалах нь байна. Яая даа байз...» гэж бодож байснаа,

— Тийм нь ч тийм л дээ. Би ухаан дутуутай мулгуу эр болохоор... гэсэнд хошууч дургүйцэнгүйгээр,

— Ухаан санаа дутуу, дулимаг гэдэг үгээр булай бузар бүхнийг хааж нөхөөд байвал та, дахиад тавь гаруй насалсан ч энэ сүв, нүх хэвдээ байх болно шүү! Юу сайхан үнэн сайхан. Ер нь хууль зүйн учир утгыг гүн гүнзгий эс ч өөрийн мэдцийн хэмжээгээр ухаарч байсан сан бол иймэрхүү гэм, зөрчилд яалаа гэж унах вэ? ямар боловч цагдан сэргийлэх газар очиж учир начраа олцгооноо гэж хошууч шийдмэг өгүүлээд суудал өндийв.

## VI

— Гомбодоог албаны байранд орж ирэхэд бичгийн авсаархан ширээний ард суугаа цэргийн дүрэмт хувцастай, цагаан шил зүүсэн дарга түүнийг нэрлэн мэндлээд гар сунгав. Сүрдэж бантсан Гомбодоо,

— Пээ, миний нүд ч нүд гэгч болоо шив. Манай Дулдай гуайн хүргэн байна шүү дээ. Амар сайн байна уу.

— Суу суу. Тэвдэх хэрэггүй. Үгүй та мөн ястай хүн юм аа. Огт өтлөөгүй байна гэх нь Гомбодоод аядуу зөөлөн сонсогдох боловч нэг л биш санагджээ.

«Нэмэх маань ч Нэмэх яг хэвээрээ шүү дээ! Аминчилж гуйгаад, гуйгаад нэмэргүй. Энэ хүн хууль дүрмээ л тулгана. Буруутахын цагт ганц хар толгойгоор дуусах хэрэгтэй гэж Вандангийн хэлдэг зөв байх аа. Вандан жолооч хүү хоёрт л гэм хүргэхээ байя» гэж Гомбодоо бодов.

Бага дарга Нэмэх, Гомбодоогийн хувийн аж байдалтай товч танилцахын далиманд хууль зүйн бодлого, учир утгыг ухуулан хэлж өгөв. Гомбодоо толгой гилжийлгэн шал ширтэж, гэмшин бодолхийлж сууснаа,

— Нэмэх ээ! чи л намайг хогийн хулгайчийн бузар амьдралаас суга татан гаргаж хүний зэрэгт хүргэсэн шүү дээ. Энэ өгүүлж баршгүй ач тусыг бодохоор өөртөө гомдож байна. Би ердөө илүү харж билүү долоосоор яваад энэ насыг барах хүн шиг байна. Одоо намайг явал яа! Би гомдох зүйлгүй хэмээн түс тас өчин хэлэхэд Нэмэх,

— Гомбодоо гуай! Тэр тус миний тус биш. Танд хамгийн их тус ивээлээ хайрласан газар бол ардын цагдан сэргийлэх байгууллага байх аа. Тэгэхээр... гэтэл Гомбодоо үгний дундуур орж,

— Ээ гэгээн төрийн минь сүлд өршөө. Чиний хэлдэг яг үнэн гээд наманчлан залбирав. Тэрээр хэдэн агшны дараа бүх үнэнээ тоочин ярив.

Буруу хэрэг хийснээ цөмийг хүлээсэн Гомбодоо торгуулийн дээд хэмжээгээр торгуулсандаа сэтгэл гонсгор гарч одохдоо үүнээс хойш ингэж эндэж ээндэхүй гэж санаандаа санаж шанаандаа зуужээ.

## VII

—Ингэж эндэхийг мэдсэн сэн бол элэнцгээ хийж нааш зүглэх вэ? хоёр бярууны махаар дутах нь өлзий саарал! Ганцхан хууль дүрэм гажиж, нэр сүрээ гутааж орхилоо. Хүний сэтгэл санаа гэдэг чинь хаашаа ч байдаг юм бүү мэд.

Би бодохдоо хойтон гэхэд манай нутгийн годон Дамбий, ногоон Панжаагаас эхлээд хэдэн бөгс хөнгөнтнүүд хурлын тэргүүлэгчдийн байр эзэгнэн бүх тамжидаараа нэгдэж нийгэмчилье хэмээн мань мэтийг уриалан уруу татна. Уриалга гэдэг чинь албадлага гэсэн үг. Түүнээс урьтаж хэдэн малаа авдарлаж авдаг хэрэг гэж егүүлсэн Гомбодоогийн үгийг хэрсүү байдлаар сонсож суугаа Вандан:

— Дундыг л барьсан дээр байх шүү гэж хаширлан эргэлзүүлэхэд Гомбодоо:

— Дунд гэж ярихгүй. Ердөө сүүлий нь мушгина гэж шийдэмгий өгүүлэв.

Гомбодоо буцах зам зуур зорчигчдод зориулагдсан бүхээгтэй машины намс, намсхийх нэгэн суудлыг эзэлж аваад гонсойж үймэрсэн бодолдоо авган уруу царайтай явна. «Хүн бүхэн нэг нэг янзын бодолтой. Тэр нь өөрт нь зөв байдаг. Би өөрийн бодлыг нутгийнхаа хүйтэн булгийн ундраа шиг сэрүүн тунгалаг гэж санадаг маань зөв үү?! Зөв гэж өөртөө тун сэмхэн шивнэнэ.

Ямар ямар зүс, насны малыг худалдаж борлуулах, нэгдэлд орохдоо ямар малаа өгөхийг нас хүйс зүсээр ялган бодно. Бодлын өм цөм цоорхойд нөхөөс тавих гэсэн шиг хэтэрхий хүчлэн сэтгэснээс зүрх нь гэнэтхэн пэл пал хийж, толгой дүйрэн салгалж эхлэхүйеэ нүдээ тас анин, ар тийш лав налж биеэ сул тавин түр амсхийв.

## Хорин нэгдүгээр бүлэг

### Хууч хөөрөлдсөн нь

#### I

Намрын эхэн сарын тэнгэр цэлийн цэнхэртэж манхайх нь сэтгэлд таатай. Энэхүү номин цэнхэр огторгуйн мандалд дээр хөөрсөн нарны хүчит гэрэл халааж, шарж эхлэхүй тэр нэгэн мөчид хотын захдуу хэсгийн цэцэрлэг дотор налуурт суудал дээр хөдөлгөөн шалмаг байрын намхан нуруутай хөх өвгөн ирж суунгуут хуучивтар бүрх малгайгаа авч дэргэдээ тавиад, мод толгойд тамхи нэрэхдээ «Энд чинь тамхи татаж болдог юм болов уу?» гэсэн шиг зовонгуйгаар ийш, тийш ажиглан харж буй энэ хүн бол хувийн журмаар хот орны хөгжил хөдөлмөр энэ, тэр бүхнийг гурав дахь өдрөө сонирхож яваа тэтгэврийн газрын өндөр настан өвөө ажээ.

Бор шар өнгийн гандмал даавуу тэрлэгийн өвөр рүү гар шургуулан нарийхан мөнгөн оосортой төмөр цаг гаргаж товч дарахад таг нь нээгдэв.

— Дөнгөж арван цаг, эрт байнаа. Өнөөдөр хааны ордон музей үзнэ. Тэнд ороход тун сонин байх вий. Ер нь хуучин юм шинэчлэгдэхээрээ хүний санаанд тэр бүр оромгүй хөгждөг юм байна. Хууччуулаас нэг нь ч тааралдахгүй шүү. Тэдэнтэй хамт үзсэнсэн бол... гэж шивнээд өндийв. Зогсоолд ирж зогссон автобусны урд хаалга руу дөхөж насныхаа ахмадаар түрүү барин, буугчдын өөдөөс сөрөн зүтгэж байтал «Өвөө та жаахан хүлээж байгаач» гэж хэн нэгний зөвлөн хэлэх сонсогджээ.

Өвгөн урагш зүтгэсээр байлаа. Гэтэл дүүрэн сүүтэй хоёр литрийн хөнгөн цагаан сав дээр өргөж барьсан нэгэн өвгөн буухдаа малгайгий нь ар тийш нь хаман унагааж, сүүгээ цалгиулан хүзүү рүү асгажээ. Нөгөө өвгөн гэдрэг ухран унасан малгайгаа авах гэж будилж байгаад автобусаас хоцров. «Хөөгөө хаямар чинь савныхаа тагийг сайн таглахад яанаа» гэж байж ядан ундууцаж бодоод нударгаараа хүзүүнийхээ сүүг арчив.

Цагаан савг ханхар өвгөн зорчигчдын амрах суудал дээр түр амран сууж тамхи татав. Нөгөө өвгөн «...энэ дамшгаас л боллоо. Нүүр тулж хэдэн үг солиход яадаг юм. Айж алгын чинээ болох уу?» гэж цухалдан бодоод дөхөж очвол зүс үзсэн хүн шиг харагджээ. Тэгээд зузаан хүрэмтэй үл танигчийн дэргэд тухтайгаар зэрэгцэн суухдаа «халуун намраар хүрэм өмсөж, юун айхавтар нэмнэх юм билээ. Насных нь байдлаар бол догь толгой бололтой, халж хөрч яваа миний ижил өрөөсөн гутал маань ч юм илүү? бүү мэд» гэж амжин бодно.

—Бууж суухдаа дэс дугаарыг баримтална гэж ер байдаггүй шүү! заримдаа ах захаа ч алдахад хүрэх юм. Сая муу малгайгий минь хамж аваад явчих шахлаа. Хэтэрхий ингээд байвал уу? наанадаж хувцас хүнарын товч, бүч мултарч, цаанадвал өвөр, халаасны хэд гурваа мулзлуулж болох юм гээд «чамаас л боллоо» гэх утгаар өгүүлсэн боловч дараагийн автобусаас хожимдохгүйг хичээж тэр зүг аг маггүй ширтэнэ. Нөгөө өвгөн нэлээн хэрсүү маягаар сэрхийж «аливаа хүнийг харангуут ийм, тийм гэж баримжаагаар цэгнэж болдог бил үү? Мань хашпын зарим үг нэг л биш дээ.

Энэ ч мөн их юм үзээ дээ. Шоронгийн босгыг нэг биш удаа алхаж үзээ болов уу ч дээ» гэж бодоод цааш үг өдөн,

—Урьдын Да хүрээ биш учраас энэ их нүргээн, хөл хөдөлгөөн, хөгжил, хөдөлмөрийн дагуугаар хөлөө тавьж, гараа хөдөлгөх цаг болсон болов уу! гэж би тэнэглэн боддог шүү. За бүүр хараажаар юманд жишээ татахад та ч гэсэн, би ч гэсэн өндөр насаараа ул барин хүмүүс бууж сууж гүйцээгүй байхад нэг нь өмнөөс нь нөгөө нь дээрээс нь амь тавин зүтгэлцсэнээ зөв гэж мэтгэж болох уу даа гэж үг хаян мохоогоод, босож сууж цөхөн байгаа тэрхүү өвгөнийг ахин дахин лавлаж хараад «жигтэйхэн танил нүүр байх юм. Хаана үзлээ дээ. Алдар нэр нь ч бүүр ор сураг алга аа! Түг түмэн хөлийн газар нэргүй таних нүүр алиныг тэр гэх вэ? хашрыг түншээд үзье» гэх гүймэг бодлоор,

— Таныг хаана үзлээ дээ. Таньдаг хүн шиг санаанд орж, гаравч нэр өгч үнэхээр зүрхлэхгүй байна гэж хэлээд нүүр эгцлэн ширтэв. Нөгөөх нь үг дуугүй ойртож, агшин зуур махрангуй ажсанаа царайд нь улаа бутрах мишээнгүй дүр тодорч,

— Би чамайг харангуугаа нүд бодол хоёрынхоо зөрүүг гаргах гэж бүүр тэвдэж орхилоо. Нэг бодоход бие биеэ хайхрахаа больсон садан төрлийн хүн шиг ч, нөгөө бодолд сайн танил шиг ч бас л нэр буудаггүй. За байз автобусны бараа харагдаж байна. Өвгөд заримдаа нэрэлхүү байдаг шүү дээ. Бид хоёрын хувьд тийм дэгжин зан гаргалцаад ч яахав. Нэр усаа мэдэлцье, намайг Дэчин гэдэг. Цагийн эрхээр нутаг усаа орхиж дайжаагүйсэн бол хуучнаар ярихад Дайчин жонон Вангийн хошууны унаган албат гэнэлээ. Чөтгөр алгад гэж дээ, ямар Вангүний албат харьяат байсан ч одоо юугий нь сайрхаж дурсах вэ? гээд өндийвөл нөгөө өвгөн дуу алдан босон харайж, түүнийг тэврэн зууралдахдаа,

— Дэчин гуай минь, Би Жамсранчой байна шүү дээ. Та намайг бодолцоорой. Эхлээд таниж ядав. Он жил олон дахин улирчээ гэнгүүт нөгөөх нь хариу чанга тэврэв. Аль алины нь хэлэх үг ам хэлэн дээр байгаа мэт санагдавч хэлж чадалгүй хоолой зангирна. Хөөрч бахардахын эрхэнд хэн алины нь усан талимаа нүднээ баярын нулимс бүрхсэн харагдах ажээ. Бие биеэ дэмий л ширтэлцэнэ. Хоёр өвгөний энэхүү санамсаргүй уулзалтыг харагсдын зарим нь сонирхож хачирхан харахад бас үл хайхрагчид ч зөндөө. Жамсранчой эхлэн ам нээхдээ,

— За Дэчин гуай! Манайх тун ойрхон. Одоохон хамт очиж хууч хөөрье гэв.

## II

Товхийсэн эд хогшилтой, дөрвөн ханат гэрт хоёр хүний дүнгэр, дүнгэр хүүрнэлдэх нь тодхон сонсогдоно. Хааяа хааяа тас тас хөхрөлдөх ажээ. Ахимаг насны авгай өтгөн шаргал цай чанан аягалж, идээ будаа тавин зочлоход Жамсранчой түрийвчнээс тавьтын дэвсгэрт гаргаж авгай руугаа сарвайхдаа,

—Хуучин, хуучин гэхэд тун хуучны зузаан түнш Дэчин гуайгаа сайн дайлнаа хө. Чи хоршоонд очоод нэг шил юм (архи) оролцуулан мах шөлний юм авчирч хоол хийгээч гэв. Авгай ч тэр дороо торон сав бариад гарч одлоо.

Цай, хоол, архи бэлэн болжээ. Дунд хэмжээний шилэн хүндага ойр, ойрхон харших дууг

хачирхах юун. Мэдээжээр хоёр түнш хуучлах гэж яаравч юунаас эхэлж юу юу ярихаа олж цөхнө. Нэг нь арайхийж яриа үүсэн хөндөвч нөгөө нь зэрэгцэн ам булаалдан бурж үг өгүүлбэрийн утга санааг алдагдуулна. Хагас цаг хэртэй ингэж будилсаар сүүл тийшээ зөвшрөх төлөвтэй болжээ.

Дэчин гуай баруун хойт талын авдарны өмнүүр нугалж тавьсан зузаан гудсан дээр нөмгөнөөр тухтай сууж харагдана. Түүний сэтгэл үнэхээр тайван тэнэгэр бөгөөд өөрийн гал голомтон дээр байгаа шиг санагдана. Халин мэлтэлзэх архитай хүндагаа дээш өргөн хоёул мишилзэв. «Урт насалж, удаан жаргахын төлөө! Эрүүл энх, зол жаргал, сайн сайхан бүхний төлөө! Хөдөлмөрийн амжилтын төлөө, төлөө...» гэх мэт ерөөлийн үгс хэн, хэний санаанд илхэн буувч төвөн хоолой бүлхэлзэн дуу түгжирнэ. Дэчин хоолойгоо хүчлэн засаад,

— Зовсон хүн жаргана гэгчээр төр, улсын буянаар жаргалд умбаж шумбаж байна аа. Жаргалд хүсэл ханах бил үү? Жаргал эдлүүлсэн төрийн сүлд бат орших болтугай! хүндага тавилгүй ууж, хутга тавилгүй мах идэхийн төлөө гэж хэлээд тулгаж ууцгаав.

Өвгөд өөрийн эрхгүй ам халж эхэллээ. Дэчин асааж тавьсан папиросоо авч барин тавин зууж, дээш үлээсэн цагираглан манарах утаан дундаас нэгэн юмыг хайх мэт удаан ажиглаж байснаа,

—Байз байз хө! хорин хоёр онд (1932 он гэсэн утгаар) Баруун аймагт гарсан эсэргүү бослогын үеэр би тэдэнтэй нийлэн хавсайдаж, чи ууланд бүгээд эсэргүүгийн тоносон юмнаас дамаа тонон холиож яваад хоёул баригдаж, арав арван жилээр ял эдлэн гарснаас хойш бид хоёр нүүр учирсангүй. Би шоронгоос мултрангуут энд тэнд ажил хийж явсаар хэдэн жилийн өмнө асрах тэжээх садан төрөлгүй учраас өндөр настны тэтгэвэр асрамжийн газар шилжсэн юм. Тэнд ёстой л жаргалаа эдэлж сууна. Хот орны байдлыг сонирхмоор санагдаад ингэж сэлгүүцэж яваа нь жаргал дэндсэнийх дээ. Хуучин шинэ хоёр төрийн нүүрэн дээр сайн, муу үйлсийн дунд халз тулан хутгалдаж явахдаа халааж, хөргөж, мөн ч их юм үзлээ. Тэгэхдээ энэ гэгээн төртэйгөө золгоогүй сэн бол гамин, барон, цагаантны гарт зүйл дуусаад өдийд ясны үртэс ч үгүй болсон байх даа. Хайрхаан! Гэгээн төрийн сүлд ивээж, түмэн олон маань энх амар байвал болох нь тэр гэж залбиран наминчлаад үгээ дахин залгаж,

—Өнгөрсөн цагийн юм ор мөргүй арилж орхижээ. Далайбуяны пүүс, нөгөө бид хоёрын дээрэмддэг анхны хоршоо хоёрын байсан газрыг олох гээд бараг таамаглаж чадсангүй. Тэр хоршооны суурь, улсын их дэлгүүрийн хавьд л байсан болов уу? Энэ дэлгүүрт өгсөж, урууддаг цахилгаан шат байгаагүй сэн бол тэр зургаа, долоон давхрын оройд над мэт амьтан яаж гарах вэ? За тэгээд ороод очихоор төөрчих гээд байх юм. Үгүй хө чи, бид хоёрын бөөм мөнгө хулгайлан гартаа оруулах санаатай манаа руу нь дайраад би мөрөө сэт буудуулан амь наана, там цаана болон зугтаж байснаа санаж байна уу? мөрний минь шонтгорт умгар цагаан сорви тогтсон гээ. Энэхүү сорви бол миний амьдралын хатуу, ширүүн аливааг туулахдаа зарим үед өвдөг сөхөрч явсныг минь гэрчлэх, маханд сийлэгдсэн арилшгүй тамган дараадас... Гэтэл Жамсранчой тэсэж ядахын эрхээр үгийг тасдан,

— Дэчин гуай би юунаас эхэлж ярихаа таны адил мэдэхгүй л байна. Надад гэвэл шуурга сөрж явсан гунигт цагийн хэдэн хүний нэр л үргэлж санаанд байдаг юм. Би шоронгоос суллагдан гараад ажил, хөдөлмөрт орж засгийн буянгаар хүний зэрэгтэй амьдарч явна. Сүүлийн хэдэн



жилд үнэтэй бараа эдийн агуулах манаж байна. Энэ бол хар бараан юм цайрч, хүн хүнээ итгэж байгаа дорвитой үйлс гэж санадаг шүү. Насныхаа тэтгэврээ аль хэдийн тогтоолгосон. Ангайж залгиад, тонгойж бие засаад сар бүр нэг зуун далан төгрөг зүгээр хүртнээ гэдэг чинь урьдынхаар бол санаанд орох байтугай бодоод, бодоод ухаан гүйцэхгүй шүү дээ. Дэчин гуай минь хэлэх үг олдохгүй нь байна. Ер нь больё гэхэд Дэчин жуумганан хөгжингүйгээр,

— Урьд цагийн бид хоёрын намтар ихт явдал ул болж, ухаан санаа маань дөл болж хувирчээ гэж бодвол сэтгэл ханамжтай байх сан. Энэ бүхнийг түр зуур орхин хойш тавиад ганцхан үг шивнэн асууя.

— Чи үнэнээр хариу хэлээрэй. Тэр үнэ цэнэтэй их юмнаас биеэ барьж чадалгүй хумсалж нэгэнтээ эргүүлж авсан нэр төрөө бузарлав даа! гэнгүүт Жамсранчой хөмсөг өргөн таашаангүй харж,

— Ийм сайхан цагт тийм бузар бүлайг давган үйлдэх байтугай санахад бөөлжис цутгах болжээ гэхэд Дэчин хүндагалсан архиа өргөн толгой дохиж,

— Үгүй хө, хууччуудаас нэг ч сураг байдаггүй, нөгөө муу Гомбодоо л малчин болчихоод манаргаж яваа гэж там тум сонссон. Үнэн худлыг бүү мэд гэхэд Жамсранчой өргөсөн хүндагатай архиа амтархан залгиад, хахаж цацан сандарвал Дэчин:

— Дахиад нялхрах гэж байдаг уу? Хурай, хурай! Байнаа, байна. Засгийн буянгаар юу л хүсвэл бэлэн байна гэж доогтой боловч бахархан өгүүлнэ. Жамсранчой халуун цай оочилж хэдэн агшныг өнгөрөөгөөд,

—Дулдай баян л насалж чадсангүй дээ. Өдийд байгаа бол янз, янзаар эргэж хөрвөж, тоосоо хадааж явах л хүний нэг дээ.

Цагдан сэргийлэхийн нөгөө Цогоо арван тавны цагдаа байсан гэхэд хүний мөсөөр тун зүгээр дээ. Хүний сайн нь урьддаг гэгчээр бас талийсан гэнэ лээ. Харин Нэмэх чинь ёстой л Нэмэх нэрэндээ тохирсон хүн дээ. Тэрний цовоо сэргэлэн, хөдөлж аашилж байгаа нь идрийн гялалзуур хэвээрээ шүү. Бага дарга нэртэй боловч том зөвлөх ажилтай гэнэ лээ. Дэчин дуу алдан сэргэж,

— Нэмэх эцгийнхээ нэр төрийг хадгалж яваа нь таатай байна. Ум мааны бад мий хум, түүний эцэг Чойнбол чинь одоо бодоход зөв үзэлтэй хүн байж дээ хөөрхий. Нэмэхийг том тушаалын ажилтай гэв үү? гэж сонирхов.

— Бага даргаар насан турш ажиллаж байсаар чөлөөнд гарсан боловч сул цалин авч зүгээр суухгүй гээд тэр байгууллагын ажлыг мэдэж гадарлахын хувьд залуу хүмүүст үргэлж зөвлөж, тусалж байдаг бололтой. Түүний зүүн баруун энгэр гэдэг нь одон медалийн тууз, тэмдгүүдээр битүү, бүүр дүүрэн, эндээс аваад энийг хүртэл гэж Жамсранчой гар сарвайж Дэчингийн зүүн энгэрийн эгэм хавьцаагаас доош нь уруудуулан бүслэхээс дээгүүр багцаанд хурууны өндөгнүүдээр дарж жишээ татан заав.

Дэчин бахархангуйгаар толгой сэгсрэн таашаагаад,

— Нэмэхтэй нэг тавтай нүүр учрах юм сан. Хөдөөлөхөөс өмнө түүнд аминчлан хэлж сэтгэл цайлгах учиртай юм. Миний хэлэх үгийг энэ хорвоо дээр надаас өөр хэн ч мэдэхгүй. Ганц бил мэднэ. Энэ нэгэн юмны нууцыг тайлах түлхүүр нь би юм. Энэ талаар дараа ярина. Түүний гэргий Сайнзаяа ямар шүү байдалтай байгаа вэ? гэж сүүлийн хэдэн жил сургийг олж сонсоогүй гэж цэнэнгүй асуув. Жамсранчой энэ нэрийг сонсонгуут залуу халуун насаа дурсан санаж суудалдаа бие займчин сэтгэл нь ихэд хөдөлнө.

— Сайнзаяа нь Сайнзаяа нэртэйгээ адил аз жаргалтай тун сайн яваагаар барахгүй, нэр хүндтэй буурал багш болжээ.

Удахгүй гавьяат, мавьяат нь болох байх аа. Энэ ярианы ялдмаар нүүр үзээд ул барьж байгаа ч биш үнэхээр нэр гаргаж хэлэхэд хэрвээ та хорин хоёр оны эсэргүү бослогын үед тэдний жанжны дэргэд ганцхүү олборын төлөө шадарлаж байгаагүй сан бол!... Бид хоёр нууцгай холбоо бариагүйсэн бол Сайнзаяагийн амь насыг аврахад тун хүнд байсан даа гэхэд Дэчин хэсэг зуур саатан бодож байснаа,

—Тэр яахав цаг үедээ тэгэхээс өөр замгүй байжээ. Одоо түүнийг цөмийг мартаж хэрэгтэй. Би Дэчин, Дэчингунгаа, Буянт гэхчилэн зээлдсэн нэрээ бүрмөсөн мартсан! Одоо муу юм санаж бие сэтгэлээ хордуулах хэрэггүй. Миний хувьд энэ муу бузарлагдсан зовлогыг хүүр болохын цагт хэсэгхэн ч болов ариун сайхан хөрст газрыг бүү бузарлаасай гэж боддог, гэхдээ хаа үхэх вэ? гэхэд үхэх газар олноо гэж үү? Бодноо бодно, тун сайн бодно. .

Хорвоод хосгүй нэгэн ачтаны ачийг хариулж чадаагүйдээ өөрт гомддог. Тэр цаг гэгч юутай хэцүү гуниг зовлон байгаа вэ. Орох хоргодох нүх сүв ч олохгүй, өдөр шөнийг өнгөрүүлсэн болж ядарч зүдэрч явсаар бэлбэсэн авгай Намжаатай урьдын буяны ачаар тааралдсан юм, ёстой л миний аминд орсон доо! Тэр хөөрхий амьтныг эсэргүү нарт амь хохироод байсан яг тэр үеэр чи намайг сураглах санаатай тэдний хотонд очиж, үл таних эмгэний асрамжинд байсан түүний өргөмөл охин Наянтайг өвөртлөн дүүрээд явж байтал аз таарахад Дулдайн зарц Гомбодоотой хээр санаандгүй уулзалдаж, охиныг түүнд шилжүүлэн өгөхөд тэр дуртайяа үрчлэн аваад явсан гээ биз дээ. Одоо тэр бүсгүй хэн нэртэй байгаа бол гэж онцлон асуув. Жамсранчой өөртэйгөө ярих адил бодолхийлснээ,

—Эмгэнээс үг цохин таныг битүү сураглавал, Хайрхаан! Чойжин багш хаашаа заларсныг бүү мэд. Түүний авгай Намжаа алагдаж аюулд учраад өнчирсэн охин Наянтай нь энэ дээ гэж хэлж байсан шиг санагдана. Би Гомбодоод өгөхдөө Наянтай гэж нэрийг дамжуулан хэлснээр тэр нэрээр нэршсэн байна лээ! Харин хэний охин болох энэхүү богинохон намтрыг одоо хүртэл хэнд ч яриагүй гэхэд Дэчин өрөвдөнгүйгээр санааширч,

— Наянтай нэр ч ёстой өөрийн нь нэр биш ээ. Нэрийг би сольж будлиан тарьсан толгой байхгүй юу, бурхны оронд очихоос өмнө үнэн учрыг тайлан хэлж өгнөө! Одоохондоо арай болоогүй эртэднэ гээд түрийвчээ уудлан хоёр хорин тавт гаргаж,

— Намайг бодвол чи чинь бараг хүүхэд гэхэд хилсдэхгүй дэг.

Хоршоонд гүйнгүүтээр очиж нэг шил юм аваад ир. Илүү мөнгөөр нь чи чихэр авч идээрэй гэж хошигнон өгүүлэхийг сонссон Жамсранчойн хөх инээд хүрч,

— Миний хайрт охин чихэр авч ид хэмээн үг давгаж авгай руугаа сарвайж тэд хөхрөлдөн хөгжилдөнө. Хоёр өвгөн ам халахаас халиад согтох төлөвтэй болжээ. Сүрхий даацтай намтарчилсан яриа хөөрөө сүүл рүүгээ холион бантан болж, аль аль нь хачирхалтай боловч өөр өөрийн амьдралын үнэнд ойрхон ч биш үнэнээс бүүр ургаж гарсан яриа хөөрөөгөө ойлгох сөхөөгүй болж нам унтжээ.

— Хөөе! Чи амьд байна уу? талийх цагтаа тэссэн атал одоо ийм амархан диваажинд явчлаа гэж үү? Хөөе Жамсранчой битгий маяглаад бай. Чамаас би юм асууя. Цагаан шөрмөс Вандан сурагтай юу гэвэл Жамсранчой толгой дээгүүрээ нөмөрсөн дээлээ ярж,

— Тэр ёстой шөрмөстэй аавын хүү юм даа. Нанчдаа зооглож жаран харыг шажигнуулсан хэвээр тун дарагдахгүй яваа шүү. Харин ганц хүү нь базаахгүй яваа дуулдана лээ. Хүүгээ Вандан л тийм болгосон гэж олон түмэн Ванданд буруу өгдөг гэж байгаа. Үнэндээ ч үнэний хувь бий. За тэр яахав бусдын явдал пад алга гэж дуу нь суларсаар дүнгэнэтэл хурхирчээ.

Дэчин ч нойронд дарагдаж амьсгалын хий түрэгдэн гарахад тачир шар сахалтай нимгэн уруул нь бүлхэлзэнэ.

### III

Шөнө дунд ойртжээ. Жижүүрийн байранд үйлчлэгч залуу эмэгтэй цаг барахын эрхэнд өндөр настан Дэчингийн хууч яриаг амтархан сонсоно.

— Та тэгээд лам явсан юм уу? гэж эмэгтэйг лавлахад,

— Ламаа хат, ламархах нэрээр ёстой л заль мэхний тулам болон хувирч хорвоогийн тоосыг тэнгэрт тулгал хадаан таваргаж яваа царай нь тэр гээд үргэлжлүүлэн нэг их давах нь юу юм, дугах л үгүй байх хөөрхий зайлуул. Намжаа гэдэг төлөв түвшин авгай надаас болоод эсэргүү нарын гарт амь үрэгдсэн, мөн нутгийн томоо бүхий хүн Чойнбол гэгчийг цагаантанд барьж өгөөд өөрийн амийг хоохойлж байсан зэрэг хамгийн бузар нүгэл үйлдсэн тэр бүхнээ гэмшин санаж үнэн, худал хоёр юу байдгийг ялгаж, танихтайгаа болов. Чухамдаа үнэн худал хоёр гэдэг чинь ялгаж салгахад нохой ажлын нэг дээ. Гаднаас хүнгүй байна. Надад чам шиг охин дэгдээхэй энэ насанд заяагаагүй учраас үр биеийн мөрөөсөөр чамайг төрсөн охиноо гэж санаад духан дээр чинь нэгэн удаа үнсье. За боллоо. Энэ үнсэлт миний насан туршид хатуу ширүүнд эрсэдсэн зүрх сэтгэлийг агшин зуур гэлгүй баясган мялаасныг би мэдэрч байна. Одоо үед бүхний санаанд өчүүхэн ч хар бараан толбо байхгүй бөгөөд цөм сэтгэл цайлган цагаан үнэн шударга гэж бодъё. Тэгвэл үнэн, худал алиныг ялгахад амирлангүйгээр барах уу? тун түвэгтэй дээ. Тэр лугаа адил жишээ бишгүй байна гэж тайлбар тавин өгүүлбэл залуу бүсгүй,

— Нээрээн л тийм юм даа. Өвчний онош тавихад ч бас л үнэн, худал хоёр хамаарагдана гэж хариу товхийтэл хэлэхэд Дэчин өвгөн,

— Нүгэл, нүглийн дундаас ганцыг ч болов цайруулаад мөрөө харах сан гэж үнэн голоос санадаг гээд Намжаа авгай, Гэрэлтуяа охины талаар өрөвдөлтэй явдлыг бодож гэнэт үгээ таслан сулбайн санаашрав. Үйлчлэгч эмэгтэй:

— Өвөө! цааш яриач дээ хамаг сонин сайхан дээр нь зогсчих юм. Таны яриа чинь тэр аяараа түүх намтар ахмад үеийнхний амьдрал тэмцэл байна шүү дээ! дутуу хагас сонсоод дотор хачин болж орхилоо. Ярь л даа Дэчин гуай хэмээн тунирхан мишилзэхэд Дэчин:

— Яринаа, ярина, ярихад хүнд байна. За тэгээд би Намжааг гарах газаргүй хавхдаж авахын тулд мунхруулах мэх хэрэглэхдээ,

Өргөж авсан хоёр ойндоо ойртож яваа Гэрэлтуяа охины нь нэрийг Наянтай гэж зориг дураар өөрчлөн будилаантуулснаас уршиг соёолж, одоо болтол Наянтайгаар нэршин яваа учраас төрсөн эцэг, эхээс нь үүрд холдуулан хатуу тавилан руу түлхсэн муу ёртой толгой. Энэ охины төрсөн эцэг Нэмэх, эх Сайнзаяа хоёр нь эсэн мэнд сайн сайхан аж төрж байгаа гэнэлээ. Одоо Гэрэлтуяатайгаа бараг нэг дор байгаа ч төрсөн охиноо мэддэггүй бололтой, яаж мэдэх вэ дээ, мэдэхийн нөхцөл байхгүй.

Би л нүүрэлдүүлэх учиртай. Тэр Наянтай бүсгүйг Гомбодоо гэдэг хүн үрчлэн авч хөлий нь дөрөөнд, гары нь ганзаганд хүргэжээ. Гэрэлтуяа хөөрхий амьтан том болж, нэг хар хүүтэй суугаад айл өрх болсон гэнэ гэсэн өвгөний ярианы ээдрээнд сонирхол татагдсан боловч энэ намтрын утгыг мэдэхээ больж будилсан эмэгтэй:

— Өвөө! Таны үгний учир утгыг ойлгохоо болилоо. Дараа тодорхой яриулна. Орой болжээ. Та ядарч байх шиг байна унтаж амар гэж шаардахад Дэчин дотроо дургуйцэн

— Дараа ярих зав олдох болов уу даа гэж дурамжхан дуугарав.

— Дэчин нүдэн хараагаар үүр дөхүүлжээ. Тэрээр орон дээрээ аажуухан өндийж хэдэн мөч бодол болон суув. Юу бодсоныг бүү мэд.

Битүү цагаан даавуутай хөнжлөөс сэмээрхэн сугарч босоод шалмаг хувцаслалаа. Насан туршид өөрт нь улиг домог болон хэвшсэн боловч залхаж гүйцэн буй нэгэн үйлээ давтахаар шийджээ. Насанд дарагдаж, суларч доройтсон бие сэтгэл нь гайхмаар сэргэж, далан хэдтэй биш, дөчин хэдэн насан дээрээ дүүгүүлж яваа идэр эр шиг хөнгөн шингэн хөдөлж гэтсээр гарч хашаанаас нэлээн зайтай холдоод эргэж харан зогсож наманчлахдаа,

— Гал голомт бологч тэтгэврийн гэр минь үүрд баяртай. Чи намайг сүүлийн арав шахам жилийн дотор өдөрт гурав хооллон, саруул сайхан өрөө тасалгаанд зөөлөн орон дээр бүүвэйлж байлаа хөөрхий. Энэ мангар толгой чиний буян хишгийг цаашид даахгүй гэдгийг ойлгоод алсын замд шуудрав. Намайг халамжлан тойлж байсан эндхийн сайхан сэтгэлтэй бүх хүмүүс минь баяртай. Үүрийн шаргал гэгээн доор ногоорон байгаа цэцэрлэгийн дотор миний тарилцсан нэгэн залуу хуш бий. Чиний мөнх ногоон байдагтай адил миний үзсэн, харсан сайн сайхан бүхэн мөнхөд ногоорон дэлгэрч байх болтугай гэж шивнэн хэлээд эргэж харалгүй цааш алхжээ..

Нэг биш удаа явсан мэдэх газраар хянамгай ажиж урагшилна. Хадархаг уул өөд авирсаар дүнх хөх сүрлэг байцны орой дээр гарч өнгийв. «Энэ рүү хийсчихвэл тарчлахгүй таатай газар сан ч! Ийм сайхан хадан цохиог бузарлаад юу хийнэ» гэж бодонгуут дахин доош бууж, захалж ургасан хэсэг модны дэргэд очиж өлийн ажиж, бүсний үзүүрийг тайлах зуур «Энэ лут мөчир

намайг баараггүй даана. Гэвч ийм сайхан гоолиг үзэмжит модны мөчрөөс замба тивийн бузар булай бүхэн шингэж гүйцсэн хувцсанд ороолттой бөөн мах дүүжлээстэй байх нь тун эвгүйгээр барах уу? Үүнийг бузарлаад яахав» гээд Шанаган тохой гэдэг тогтмол устай нуга тийш зүглэв. «Пээ, өнөө арван хар нүгэлтэн Дэчин энд талийсан юм гэнэ лээ. Бүү үзэгд! холуур авья гэхүүлэхийн оронд, хүний нүдэнд хэзээ ч үзэгдэхгүй газрыг сонгох хэрэгтэй» гэж шийдмэг бодсоор эрэг дээр ирж, хэдэн метр өндөр цавчим хэсгийг дотроо шилэн сонгоод даах чадлын хэрээр эр зааж авчирсан бөөрөнхийдүү чулууг бүсээр хэрээд үлдсэн үзүүр хэсэгт богиновгорхон гогцоо гаргаж хүзүүнд углаж үзлээ.

Үнэндээ зүдэрч тарчлахгүйн төлөө үхэн хатан чармайж талийх бэлтгэлээ тун нямбай хийжээ.

Чулууг эрэгний ирмэг амсардуулан болгоомжтой тавиад хоёр талаар хөл алцайн жийж, салтаанд хавчив. Хэдэн агшинд ийш тийш сэжигтэй ширтэж магадлаад чулуунд бэхлээстэй гогцоог хүзүүнд углан орчин дэлхийг дахин нэгэнтээ нэгжин ажиглалаа.

Тэнгэр огторгуй өөд нүд эргэлдүүлэн ажсаар зүүн урд зүгт чанх дээшээ жадан хэлбэрээр тогтон бараантаж буй зэгэл саарал үүлэн дээр гал цог нь арилж буурсан харцаа удтал тогтоон ширтэж, «Хөөрхий Наянтай охинд Гэрэлтуяа нэр нь эргэж өгөгдөх болтугай! Хорвоо чамаас Дэчин би хагацъя! Надад гомдох юм гэвэл нийгэм олны тусын тулд ажиллаагүй л гомдолтой!

Тийм ч учраас нийгмийн хоолноос хороогоод байж байх эрх алга» гэж бодогдлоо. Тэрвээр сэтгэл тайвшрахыг оролдовч хожигджээ. Амьсгал нь аяндаа ширүүсэн бөглөрч тэвдүүлэв.

Энэ агшинд чухам юу үйлдэж байгаагаа мэдрэх сэхээ тасравч үхлийнхээ төлөө шалмаг, чадмаг ажиллаж эхэллээ. Өөрийгөө хороох аюулт «оньс» чулуун дээгүүр бөгтрөн бөхийж газар тулсан хоёр гараа цасан гулгуурын таяг мод хатган түлхэх адил хүчлэн ёворч, бүх биеэр урагш тэмүүлэн зүтгэх агшинд араас нь булиа хүчтэн хүнд нүсэр хөлөөр өшиглөн үсэргэж унагаах шиг болжээ.

Тэрхүү эргэлдэн ногоорч буй гүн цээл рүү навсайж унахдаа полхийх үл мэдэг чимээ гараад усан мандал дээгүүр дугариг долгио намуухан үелзсээр бүдгэрэн замхарчээ.

# Хорин хоёрдугаар бүлэг

## Хүрэгч үнээ

### I

Улирал улирлаар нутаг сэлгэхэд Бичигт хадны өвөр, хянган дов, Агуут голын хөвөөн дээр боровтор нэгэн гэр, хот айлаас онцгойдуу харагддаг байв. Тэднийхийг Гомбодоогийнх гэх бөгөөд нэгдэлд орохоос татгалзаж үлдсэн хэдэн өрхийн нэг ажээ.

Гэрийн эзэн, гэргийтэйгээ хамтран, үнэн голоосоо үхэн хатан зүтгэж «хорондоо хүний дор орохгүй юм хүна» хэмээн амины цөөн тооны бод малын хойноос борив бохис хийлгэхгүй хөдлөөд, хөдлөөд амьжиргаа ахуй нь нэгэн хэвдээ байлаа. Доройтоход долоо бүдрэнэ гэгчээр хайртай борлог морио чононд сэглүүлж, хойтон хавар нь сүүтэй үнээгээ шаварт унагааж үхүүлснээс хойш Гомбодоо сэтгэл санаагаар дорой явдаг болжээ.

Аль нэг талаар дутмаг, гуцмаг явсан үе тэнгийнхэн нь хүртэл нэгдэл нийгмийн гэр бүлд багтаад хэдэн жилийн дотор сэргэж өндийн, тов хийсэн айлууд болсныг нүд үзээд бачимдан явдаг болсноо хэнд ч хэлэхгүйг хичээнэ.

Тэрээр өдөр хоног өнгөрөх бүр шинэ содон юмсыг учир тунгаан ядаж ихэд хачирхан ажиглахад амьдралын сорилт дунд аливааг туулан өнгөрүүлж буй гүн атриат магнай дээгүүр нь зол жаргалын зөгнөл үе үе тодроно. Заримдаа эзгүй хээр ганцаараа атал үл мэдэг мишээхийг харвал үнэхээр сонин сайхныг бодох болсных. Чухам юу бодож тэгсний нь таахуйяа түмэн бэрх ээ. Гэвч олон салаалсан бодлын нэгэн зангилгаанд.«... Манай гол ус, унаган нутаг мөн ч өөр болж байна даа.»

Зэлүүд буйд нутгаар хүмүүс ажил ундруулан, яах ийхийн завгүй Номгон уулыг хүртэл шилээр нь сэт татаж, дардан зам гаргаад машин тэрэгний цуваа нааш цааш хөврөх боллоо. Тэр ч байтугай Уртын голыг боож урсгалыг Хишигтэй тийш нь залан, хэзээнээс нойрсонги Цэцэгт хөндийд үр тариа халиурах болов.

Нарлаг сайхан тал нутгаар мал сүрэг багширч, урьд өмнө шон гадас ч үгүй байсан Нарангийн тохойд суурин бий болж, шөнийн цагт гэрэл гэгээ гялалзан машин, техникийн дуу нүргэлэхийг сонсоход таатайяа. Энэ ид шидийн хүчин чадал ч биш хүн л бүтээгээд байна. Хүний ухаан, зориг хүч гэдэг ямар их ундраа вэ? Манай хойч үеийнхэн мөн ч аз заяатай улс аа. Би хождох нь юу билээ. Энэ нүргээн дунд ороод тоосоо харвал яах бол... ай хөөрхий өнгөрсөн цаг гэгч юутай гуниг, зовлон байгаа вэ? Намайг хуучин хүрээний хог дотроос ардын цагдаа нар малтан авч аварсан явдал ардын засгийн л ач шүү дээ!...» хэмээн сайн сайхан, эрээн барааныг эрэгцүүлэн бодох болжээ.

Тэр нэгэн оны сүүлчээр урт хавар шувтран, эхний борооноор хэнз ногоо сэргэж байсан өдрүүдэд нэгдэлч олны хамтын гэр бүлд багтахаар санаа шийдсэн хүсэлтийг ёсоор болгосон учир Гомбодоо хар санаа өвөрлөөгүй ч хашир догь зан гарган хамгийн сүүтэй алаг бөөрт, мүүлэн эвэрт хоёрыгоо тугал бяруутай нь, мөн сайвар хээрийгээ аминдаа хоцроож амжжээ.

Тэрээр хатиарт гунж, гурван хөхт, шударга бор гэхчилэн голдуу нэр хочтой муувгар малаа оролцуулан цөмийг нийгэмчлээд «Энх» нэгдлийн гишүүнд гэргийтэйгээ элсэн оржээ.

## II

Нэгдлийн дарга Дондов шинэ гишүүн Гомбодоотой уулзан аж байдалтай нь танилцаад,

— Танай гэргий Гүнчин сааль сүүнд шалмаг сайн. Та өөрөө мал ажиллагаанд хэнээс ч дугахгүйг бид мэднэ. Та хоёрт саалийн үнээ арвыг хариуцуулж өгөхөөр шийдсэн гэв. Гомбодоо бодолд автан хэсэг дуугүй байснаа:

— Бид хоёр чинь баян Дулдайнд зарц байгаад засгийн ачаар буулгаа мулталсан хоёр, малын ажилд тааруухан даа. Тийм олон үнээ дийлэхгүй болов уу? Тавын зэргийг авбал болно биз дээ гэв.

— Арвыг өгнө. Та нарын амь зуултанд ч ашигтай шүү дээ. Та гэргийтэйгээ зөвлөн ярилцаад нөгөөдөр гэхэд ирээрэй гэж нэгдлийн дарга хэлжээ.

— Тэр сайхан ажлыг хийлгүй яахав. Эв эрүүл байхад эхнэрийн гар хөл өвчтэй гэдэг үг амнаас чинь яаж гараа вэ? гэж гэргийдээ загнуулж бантсан Гомбодоо арван үнээ аваад азаа туршихаар шийдэв. Мал бүрийг дараалан нягталж нүдлэн авахад арав дахь нь гунжин насандаа хээл хаясан хүрэн дөнж сүрэгт хамгийн залуу бөгөөд давьтар муухантай нь байв. Анхны үед авч хариуцсан үнээд бараг арван зүгтээ бэлчин арилахуйд тэр бүхний хойноос нүд бэлчээн, биеэр хөөцөлдөх нь эр эм хоёрын амнаас зүй бусын үг цухалзах шалтаг болж, өөрийн бус үхэр сүргийн түвэг ургуулсан ажилд бэрхшээж бэрэвших нь илэрхий болжээ.

Түрүүчийн хяруу унасан нэгэн өглөө Гомбодоо үс, зүс гөлчилзөн гялалзаж буй мөнөөхөн хүрэн дөнжийг гоцлон хараад «Энэ мялан яавч сувай байх аа, сувай л байж үзээсэй билээ. Бяруу шүдлэн адилдуу зүсний юмаар орлуулж аргалаад энэ өвөл тогоо тосолбол сайн сан» гэж бодоод булхгар шалангий нь тэмтрэн илтэл, биедээ цочир хүрэхээр дөнж хүчтэй тийрлээ.

Гомбодоо дуу тавин дороо суун тусаж, зүүн шилбээ атгаж барилан хараал зүхэл болсноо босож гэрт ороход гэргий Гүнчин уулгалан өндөсхийгээд,

— Яаж харлах нь энэ вэ? гэжээ.

— Яаж гэнэ шүү! Цэвэл авгайг аг маггүй ширтэж байгаад, зэлний гадсанд торж ойчин, хянган шилбээ хугалчих шахаа юу гэж тавлахын халаг шив дээ. Цагаа ирэхээр мал хүртэл ухаан сууж орхидог юм байна. Нэгдлийн нэг муу өмбүүний дэргэдүүр зөв зүгээр өнгөрөх гэтэл тийрч орхилоо, ёо, ёо гэж уулгална.

— Хүрэн дөнж үү?

— Тийм ээ тэр чинь, тун адтай мал...

— Мал хэлгүй боловч хөлтэй шүү дээ. Дөнжин үнээ догшин байдгийг мартаа юу? Маажиж

малтаа л биз.

— Тиймээ эзэн годон Дамбий шигээ л юмны түрүүнд годгонон ижлээ хаяад ийш тийш зулран, намайг үргэлж тамладаг сүрхий «мялзанг» цааш харуулбал хавирган дээр нь балиусны зузаан мөртэй тэнцэх тэвээрэг байна уу? үгүй юу? гэж үзсэн юм гэхэд гэргий нь хэртхийн цочиж,

— Амьтан хар нүгэл, олны хөрөнгийг бузар гараар хумсалж яахан болох вэ? Мөрөөрөө байгаа эзний нь битгий нэрлэж хочил.

Тэднийх чинь хэзээнээс сүүтэй үнээний удамтай айл. Ирэх хавар дөнжнийхөө тугалын халуун чихийг атгаж авахаа хичээж бай гэвэл,

—Чи л өөрөө сайн хичээж үз. Би ч... хэмээн үг сөргүүлэн өгүүлээд орон дээрээ суун тусаж эмзэглэн ёлно.

### Ш

Өглөөгүүр тас хайрам жаварлаж цантаж манарсан цасан хялмаа будагнах нь хүйтрэхийн шинж байлаа. Гомбодоо дадсан заншлаар эртэлж босоод тавгай цайлж, малын баасыг арилган хэвтрийг зэхэж янзлаад үхрээ бэлчээрт гаргахдаа хүрэн дэнжийг өвсний хашаанд барьж уяв. Хүрэгчхэн ижлийн хойноос мөөрч, уяж угзчин, гэдрэг цахдаж толгой сэжнэ.

Гомбодоо гэрт эргэж ороод үг дуугүй тамхи нэрж айхавтар шунаг соров. Цай аягалан тавиад үзүүр нь шөвгөрч элэгдсэн үйсэн иштэй дунд хэмжээний балиусыг гардаж ирийг шалгаад орны хөндийнөөс зөөлөн билүү авч үрэхдээ «Багалзуураар гэдэс тэжээж явахад зоригтой байж гэм. Одоо мал муу хийх гэхээс зүрх алдах болжээ.

Бусдын харааг соронзон шиг татах иймэрхүү содон идшийг өөрөө л аялуулахаас хэнийгээ гуйх вэ? Багалзуурын цус авахад хутга маань богинодож харлах бий дээ! Дотор өөхнөөс гадар нь сайн байгаа болов уу?» гэж бодов. Гэвч өөхийг ярахад аяндаа мэдэгдэнэ. Гуя оролцуулаад хоёр хөл зарахад цай, тамхины үнэ бардаагаар тоншино» хэмээн хол ойрыг зүйж бодоод шүдэнзний мод хэрчиж шалгасан хутгаа гэрт нь дүрж дэргэдээ тавилаа.

—Гүнчин минь цус авах сав бэлдээрэй. Сэвсийг урд хонхорт лавхан асгана гээд хус модон иштэй хангинуур сүх авч, хагалсан түлээний залтсан дээр хэд дахин тоншиж үзэв. Тэгээд мушгимал суран аргамжны эвхээсийг задлах зуур «...уул нь өөрийнх бол ч хөлийг хэрээд босоо байлган нэг тавихад л тунтайн унадаг сүхэн цохилуурчин сан даа, хүний юм хүчтэй, хүзүүний мах хатуу гэгчээр болгоомж хэрэгтэй шүү! Хэрэв улайруулан алдаж хөглөвөл Дондов дарга чинь «Чи хө хүрэгч үнээнээс урьтаж миний духаар турших чинь яагаав» гээд л үг дуугуй шууд хатуу гараар оруулчихаж мэдэх нөхөр дөө! Энэ бол түүний түмэн зөв. Гэвч лай ч бий, зай ч бий гайгүй биз» гэж сэтгэлээ өөрөө засав.

Тэвдэнгүй гадагшилсан гэргий Гүнчин буцаж оронгуут,

—Чи тэр бузар хар санаандаа одоохон хүр! Би явдаг замаараа явлаа гэж бахардан уурсаж,



авдар онгойлгон онгичиход Гомбодоо огт хэнэггүй байдалтай цээжээ түхийлгэн тайван харж,

—Мөн дөө хө явбал явж л байхгүй юу. Би буруутай ажил хийх гээгүй. Хөлөө яваад хөлсөө гэгчээр нэгдлийн охин тугалыг эр тугалаар сольсноо хэнд ч ам бардам хэлнэ. Солио холионы нас зүсэм нь ижилхэн. А харин хүй сүв нь уруугаа, хойшоо харсан гэвэл тэр зөрүүд оногдох ялыг би дуртайяа хүлээнэ. Ямар ч том дарга хэн гуай ч ирсэн хэлэх үгээ мэднэ хэмээн бухимдан ханхалзаж байтал гадаа машин ирж зогсох чимээгээр Гомбодоо давхийн гарч ажин харвал суудлын тэрэгнээс ганц жолооч бууж тулан мэндлээд гэрт оров. Сандарч тэвдсэн Гүнчин авгай гал тогоо угсран цай үйлээ. «Өнөөдөр газрын мухраас гайтай доншуул хүрээд ирэх нь энэ вэ? Жолооч нар хямд төсөр үнээний мах, сүү эргүүлж яваа биз. Хэдэн бөөрөнхий сүүгээр хуурч шилий нь бушуухан харахгүй бол идэш оройдох нь байна» гэх цэц булаалдсан бодолдоо хөтлөгдсөн Гомбодоо зочны зүг хандан,

— Алдар хэн билээ? Манай үүгээр ямар ажилтай явна гэж ээрэн лавлав.

— Миний нэр Цэвэгсүх, цагдан сэргийлэхэд ажилтай. Таныг Гомбодоо гэдэг байх аа.

—Тийм ээ! Гомбодоо.

— Та намайг танихгүй л байгаа бололтой. Ноднин жил таныг Нэмэх гуайнд айлчилж очих үед тэднийд тааралдаж байсан шүү дээ гэтэл Гомбодоо дуу алдаж,

— Бага дарга Нэмэхийнх үү! танихаар барах уу? Бараг садан төрлийн сүлбээтнээс илүү ижил дасал болсон улс байхгүй юу. Тэд цөм сайн биз. Сайнзаяагийн бие тааруухан дуулдсан... Миний охин Наянтайн багш нь шүү дээ.

— Тэд цөм сайн. Зам их гажихгүй бол танайхаар ороод ирээрэй гэсэн гэхэд Гомбодоо дотуураа барьц алдан бантаж буй агшинд хүрэгч үнээний байн байн мөөрөх дуун сонсогдож зүрхийг түгшүүлнэ. «...эд сэдэв цохисон бололтой, яг л нүдий нь олоод бууж байна. Нэгэнт гарах газаргүйгээс хойш үнэнээ хэлээд өршөөл гуйя уу?! тун гутамшигтай хэрэг боллоо. За байз яах вэ» гэж бодсон Гомбодоо гэргий өөдөө гэмшингүй байдалтай харж,

— Аль вэ? Гунчин минь наад гал тогоо чинь яагаад дүлийрээд байна даа. Түргэлж үзээч, цайгаар уях шиг яршиг ховорхон байдаг гэж зулгайдан өгүүлэв.

Зочинд өтгөн шаргал цай аягалж, шар, цагаан тос, боорцгон идээтэй таваг тавин гардуулсан Гүнчин эртэн суухдаа,

— Жолооч оо! хэрэв хот явах бол намайг дайгаад явах зай байх сан болов уу? Ганц охиноо бараадъя гэж нүүрмэг гуйгаад «...хөөрхий муу өвгөн минь жаахан зөрүүд зантай, өөр өөгүй. Энэ танихгүй хүнээр далимдуулан хулхий нь буулгаж авбал уу?...» гэсэн огцом бодлоор нөхрөө хяламдан харав.

— Гүнчээн! Наад хүн чинь жолооч биш, алба ажлаар яваа сэргийлэхийн дарга хүн байна шүү дээ! Юм хум төхөөрөөгүй байж яаж болох вэ? Тэгээд ч өнөөдрийн ажлыг бүүр цэглэж чиний хэлдгээр яг больё хэмээн аргадсан буулт үгэнд тайтгарсан гэргий нь:

— Харин ээ, тэгэх үү дээ гээд бушуухан гарч хүрэгч үнээнд өвс тавьж өгөв.

#### IV

Хэдэн жилийн дараа үхэр сүргийн суурь дээр тохилог цагаан гэр харагдана. Нутаг нугынхан бол түүнийг харангуут Гомбодоогийнх гэж хэлэх билээ. Зуны дэлгэр сайхан цаг. Тэр нэгэн өдөр Гомбодоо гэртээ гэргийн хамт тухлан сууцгааж энэ, тэрийг цэц булаалдан хүүрнэнэ. Радио хүлээн авагчийн намуун тод сонсголыг чих тавин чагнасан Гомбодоо:

— Хөөе Гүнчээн! Сонсож байна уу?

— Сонсохоор барах уу? нэг талаар тун сонин, нөгөө талаар итгэмээргүй юм байна гэв. «...жил дараалан арван таван үнээнээс төл гарздалгүй бойжуулж, саалийн хугацаанд үнээ бүрээс... литр сүү сааж сайхан амжилт гаргасан «Энх» нэгдлийн тэргүүний үхэрчин Гомбодоо, саальчин Гүнчин» гэхтэй уралдан дуу өндөрлөсөн Гомбодоо,

— Үнээнүүдээ олигтойхон шувгар аа гэж би чамд үргэлж үг зардаг эс бил үү? ямар байна гэв. Гүнчин авгай малилзан жуумганаж,

— Тийм дээ. Шувгар гэдэг хоосон үгний дайвраар дэлэн дүүрэн сүүтэй болдог бил үү? Түүний оронд атга чимх өвс бордоо багадахгүй тус хүргэнэ шүү дээ

—Ер нь юм гэдэг хачин юм аа хө! Тэр жил танд арьсаа хуулуулах гэж нүд үзүүрлэгдсэн хүрэн дөнж одоо хамгийн сүүтэй хүрэгч үнээ болоод....

—Боль, боль нэгэнт өнгөрсөн юмыг сөхөн ам боогоод яахав гэж хэлээд гэмшлийн эрхээр гүн шүүрс алдсан Гомбодоо дахин сэргэж чих тавин,

— Пээ! Манай нэгдлийн, манай хүрэгч үнээний улаан тугалын дуу мөн дөө, цаанаа л адтай мөөрч байна. Ингээд хүн, малтайгаа дэвэн дэлхийн түмэн тамжидаар паянгаа дэлгэж гүйцлээ гэсэн үг үү? Уржигдрын ирдэг залуу хэдийдээ амжиж бидний дуу шууг яагаад бичээд авч орхино вэ? гээд их л тааламжтай мишилзэнэ.

# Хорин гуравдугаар бүлэг

## Зүрх түгшицгээв

### I

Хэд хоногоор орон гэрээ орхин дайжиж, гадуур хөлчүүрхэн цэнгэж яваа Бэлэгсайхан элдэв заль мэх хэрэглэн ааваас алдуулж авсан хоёр тавьтын сүүлчийн нэг төгрөгийг үзүүлэн,

—Найз хонгорууд минь надад байгаа нь энэ ээ хө. Нэг хоёр гээд нэмэрлээд байвал шар тайлах юм бардаагаар цугларах вий гээд бие сулбайж хөл гар суларч гуйван, үс гэзгийг араас хараад эрэгтэй, эмэгтэй нь үл ялгагдам болжээ.

Хувцас хунараар хээнцэр дэгжин хоёр найзын халаас өврийг тэмтчин эргүүлж үзээд хорь, гучин мөнгөний бутархайгаас үл хэтрэхэд бачимдан уурсаж, нулиман өндийв.

Гэрээ бараадах зам зуур үл таних эмэгтэйгээс сонгино гуйж зажилж, гашуун аагийг шүлстэйгээ хутган залгиж, дотор халж булингартан буй шарыг дарах гэж оролдоно. Бас нэг өвгөжир хүнээс ширхэг тамхи гуйж асаалгүй зуугаад, ганхаж гуйвсаар байшингийн довжоо шалан дээр сандайлан сууж, арзайж ширэлдсэн үсээ таван хуруугаар самнан илмээр болж, бүүр ч хүүхэд айж зэвүүцэм болгож орхив.

— Пээ, бүү үзэгд, цаана чинь Вандан гуайн согтуу хар сууж байгаа харагдана. Холуур тойроод гаръя. Мөнгө нэхээд шарлаадаг золиг гэнэ лээ гэхийг дутуу хагас чих цохисон Бэлэгсайхан:

—Яана гэнээ. Дахиад ийм үг миний чихэнд дуулгавал аман хүзүүгий чинь ар дээр чинь гартал нааж орхино гэж мэдээрэй.

Би цэнгэл жаргалаа эдлэхдээ таанууд шиг ажил албаны хэнхэг цагаан солиотнуудыг тоож харах ч үгүй. Мөн их хуцав аа. Та нар юу юм бэ? Архийг чинь засаг хориогүй, газар болгон цэнхэртэн цэлийж байдаг ариун сайхан идээний дээж шүү! Та нарын амаар эс увал барав гэж согтуурхана. Тэрээр зорчигчдын дунд яваа сэргийлэгчийг онож хараад биеэ барьж газар ширтэв. Сэргийлэгч ч үл таних согтуу залууг эргүүлдэн ажсан боловч ороож өөлөх юмгүй учраас анзаараагүй юм шиг өнгөрлөө.

Бэлэгсайхан сэргийлэгчийг өнгөрсний дараа дахин маадайн сэргэж алба амины ажил төрлийн төлөө нааш, цааш зорчин явагчдад эсэн бусын үг хаяж өднө. «Нэг ч таних нүүр тааралддаггүй шүү. Өнөөдөр мөнгө санахын гарз болох нь бололтой. Гэсэн ч ухаа л ууна. Одоо яах вэ?! А тийм айл гэр болоход Наянтайд аав ээжийн авч өгсөн бэлгийн юм бишгүйдээ бий. Лав л наамал ултай гутал, нанжин гахай гөлөм авдранд байгаа. Түүний нь нууж аваад хэдэн төгрөгнөөс өгч орхидог хэрэг ээ! Бушуухан харья. Наянтай ажилд явчихсан. Аав шартаад хэвтэж байгаа биз. Ээжийг гарах орох хооронд...» гэж бодогдох агшнаа өөрийн эрхгүй босон харайж гуйвж дайвсаар гэртээ арай гэж иржээ.

Хандсүрэн авгай согтуу хүүгээ хараад хэртхийн дотор эвгүй санагдавч, тэр дороо сэтгэл уярч өрөвдөн хайрлаж ор засан хэвтүүлэв.

—Бэлэгсайхан минь чи даанч яав даа. Эр биеийн цээнд хүрч эхнэртэй боллоо. Амьдрал ахуйгаа бодвол бодохоор болжээ.

Чиний хань чинь бүдүүн тоймын зүйр жишээ татвал хорвоод ховорхон, ёстой шижир алт шиг амьтан шүү!.

Бэр минь ажлын төлөө зүтгэж борив бохисхийлгэхгүй явахад чи архи, хар усаар унд хоол хийж галзуурч явна гэнээ. Гашуун усанд толгойгоо мэдүүлсэн хүн сайнаа үздэг гэж үү? Ёстой нохойн баас, гудамжны луйварчин, шоронгийн хадаас болно доо. Нөгөө ажил юу болсон?! Бэлэн бэлэн! Одоохон ажилд орлоо гээгүй бил үү? Дандаа хуурна, худал хэлнэ гэж яншин цухалдахад

—За, за! ээж дөрвөн цагийн эргэлтэнд хэл ам таталж байх юм. Би мэдэж байна. Та хоёрыг нэг их зовоохгүй гэж бодож байгаа шүү. Ажил олж хийхдээ л хийнэ.

—Ээж ээ! Наянтайн цалин буугаа болов уу? гээд Бэлэгсайхан хий огиулав. Эх нь улам цухалдаж,

— Мөн дөө! Нэртэйгээр нь намайг зодох чинь дутаад байна уу? гээд дуу хурааж, шаналан бодолхийлнэ. Хүү нь шар ногоон өнгийн хөөсөөр хий огиулж, амьсгаа нь тасалдах шиг болсноо «ээж ээ аав аа! Би үхлээ» гэж бархирахад Хандсүрэн хий сандран, бас шартан хэвтэж буй нөхрийн зүг хандан,

— Аль вэ? Аргалах юм байна уу! Хүү минь хэцүүдлээ. Бөөлжсөнд нь цус байна. Яах билээ, түргэн тусламж дуудах уу! гэж самгардан сандрахад Вандан орондоо өндийж суугаад нүцгэн цээж гарган хэр хэр хийтэл маажиж, тамхиа нэрэв. Тэрээр энэ бүхнийг тоох шинж ер алга. Хүү огиулсаар, эх нь тэвдсээр л ажээ.

— Түргэн тусламжийн хэрэг юу байна, энэ шилтэйгээс л балгуулчих гээд Вандан дэрэн дороосоо шилтэй архи гаргаж мөнгөн аяганы дундуур хийгээд,

— Хандсүрэн май хө. Үүнийг түргэн балгуулчих. Дараа нь загасан нүдэн жонхуу өгөөд унтуулж орхи. Зүгээр зүгээр гэх нөхрийн үгэнд сайхь эх хууртан бага зэрэг тайтгаравч айж тэвдсэн хэвээр ажээ.

Гэрт хэсэг зуур нам гүм болж Бэлэгсайхан хамар тачигнуулан хурхирав. Хэдэн мөч унтаад сэрэхэд дотор нь овоо онгойсон байв. Эцэг эхийн нүдийг хариулж байгаад Наянтайнхаа гоёлд өмсдөг ганц гутлыг Бэлэгсайхан даавуунд боож аваад сэмхэн гарч одлоо.

Тэрээр гурав хоног гэртээ ирсэнгүй «Бэлэгсайхан минь яагаа юм бол ингэтэл удаан явдаггүй сэн» гэж Наянтай дотроо байж ядан сэтгэл зовно. Хандсүрэн, хүүгийн сураг гаргаж ир гэж эцгийг нь үг хэл татлан гаргахад Вандан хавь ойрд шагайгаагүй түнш айлуудаар хэсэж, балга тагш юмаар ходоодоо халааж дөрөө чангалаад оройхон ирэхдээ,

—Хүн ямар шүү нүхэнд орохоороо ингэж мэдээ чимээгүй аг таг болдог байна даа хэмээн худлаар зовонгуйрсан дүр үзүүлнэ.

Эхийн зүрх сэтгэлд хадаастай мэт байнга урган бугшиж буй түгшүүр улам лавширч «хүүгийн минь зан төлөв хувиран үнэхээр эвдэрч гүйцлээ. Хараажаар түүний залуу насны цог золбоо бууран доройтож, царай алдан хөрзийгөөд, дуу шуугаа хурааж, сав л хийвэл хэрүүл маргаан үүсгэхийг оролдох боллоо.

Ийм ч хүүхэд арай байгаагүйсэн. Бага дунд ангийг сайн дүнтэй төгсгөсөн мөртөө ахлах ангиас улиран улирсаар сургуулиа орхисон боловч ажилд ороод хэдэн жилийн турш нэр сайнтай явж байж билээ.

Тэгээд юу хатгасныг бүү мэд. Гэнэтхэн ажил төрөл ч үгүй болж адаг сүүлийн бүлэгт иймэрхүү нохойн замаар орчихлоо. Ээ дээ мөн хэцүү еэ, ядаж байж ятга хөгжимд дуртай гэгчээр эхнэр аваад хүний үрийг давхар зовоохыг яана. Гомбодоо, Гүнчин хоёр томоотой улс учраас ийм тийм яриа гаргахгүй байгаа биз. Бэр охин минь манайд муугаа үзэх нь шиг бололтой.

Гэртээ харина уу? гэж санаа авахуулахад «Ээж юу гээд байгаа юм бэ?! битгий зөв. Болохоосоо болохгүйг хүртэл, болохгүйгээсээ болохоо хүртэл үзнэ гэж бодож байгаа шүү» гэж хариу хэлэх юм. Энэ нэг бодлын зөв ч юм уу? гэж эргэлзэн алмайрна.

## II

Хүү Бэлэгсайхан улам зэрлэгшин дампуурч, гэрээсээ гадна гудамжинд гэртэй болов. Тиймээс ч гэр бүлийн дотор явган хэрүүл үүсэж өдөр бүрийн тогтмол аж байдал алдагдах болжээ. Гэвч эцэг, эх хоёр нь энэ бүхэн чухам юунаас болж буй ноцтой шалтаг учрыг олж чадахгүй дэмий л надаас, чамаас гэлцэн хий маргаж цагийг барна. Тэр хоёрын тус тусын бугшмал бодол санаа гэнэт цухалзан илрэв. Юм бүхэнд чамаас боллоо. Эцэг муутын уршиг гэж Хандсүрэнг хэл амаа билүүдэхэд Вандан шар нь оволзож,

— Хандсүрэн! чи ер нь бодолтой байж үз! Арай хийж олдсон ганц муу бандийг дуранд нь өсгөнө гээд яагаа ч үгүй байхад торгоор биеийг ороож, тостой хоолоор ходооды нь тордчихсон чинь хариу ач тус нь гэвэл ажил хөдөлмөргүй царай алдаж, идэж унтахын тулам болжээ. Тэрээр сүүл сүүлдээ «Ээж ээ! Бие засах сав байна уу! ёо ёо турж үхэх нь, хоол байвал өгөөч. Аманд зуух ширхэг тамхи ч үгүй боллоо. Мөнгө аль» гэхэд нь ээж нь “Одоохон шөлтэй аятайхан хоол хийгээд өгье. Ээж нь хоршоонд очно, тэгэхдээ папирос аваад ирье” гэж толгой илэн үнсэж үлгэдгийн уршгаар ямар шүү хүн болж байгааг харж, ойлгож байгаа биз гэж эх рүү бүх бурууг чихээд бие сугаран цэвэр үлдэхийг эцэг оролдоно.

Эх нь эцгийн үгийг сонсонгуут тачигнаж гарна. Та юу хэлэх гээд юу хэлж байна. Юманд чинь учир утга, эх адаг гэж байдаг байх аа. Тэгвэл хүүгээ өсөх бага наснаас нь өдий хүртэл тахиж шүтэн, толгой дээрээ гаргаж, сайн цагийн эхэнд заяасан ганц үр минь яамай, яамай, дураараа байг. Идэж уухыг нь бүү цагд. Миний буяныг эсэн мэнд байхад ч, энгэрт үүрт нойрссон цагт ч идээд, идээд барахгүй, хутга барьсан ч гараа эсгэнэ, аав нь огтлоод өгье гэж байсны чинь гайгаар одоо хорин хэд хүрээд талх зүсэх гээд гар хуруугаа эсгэж байсныг та

бэлхнээ нүд үзээ биз дээ?! Хүүхэд согтохоор хэвлүүн байдаг юм, май миний бандь үүнийг уучих гэж шавхруугаар шахсаар байгаад одоо юу болж байна! Гэдсий нь өлсгөж, мөр улайлгаагүйн бурууг би хүлээнэ. А харин гудамж руу тэмүүлж буй тэр аймшигтай бузар булай гайг хэн хүлээх болж байна.

Үүд хаалгыг нээж өгснөөрөө тан дээр л тохогдох байх шүү! Хэдхэн хоногийн өмнө архидаж, архидаж шартаад ирэхэд нь шараа тайл гээд архи хүндагалж мөрийг алгадаж байснаа санавал зүгээр болов уу? Хэд хэдэн удаа хэрэг зөрчилд холбогдож түүний төлөө чи бид хоёр цагдан сэргийлэх дээр хүртэл дуудагдан очиж ам тангараг өгч байснаа мартаа юу? Тэр үед үр хүүхдээ зөв боловсон хүмүүжүүлэх нь эцэг, эхийн үүрэг гэж тулган шаардахад та ойлгосон юм шиг байн байн толгой дохиж байсан эс бил үү?! Юмны түвшин хазайгаад ирэхээр буруу бүхэн минийх, чинийх гэж мэтгэлцэх нь хайшаа ч юм гэж дундыг барихгүй шүү гэж омогдонгуй өгүүлэхэд нөхөр нь дув дуугүй дүнсийж гэргийн хэлсэн бүхнийг эргэцүүлэн бодно.

«...Манай Хандсүрэн номчирхвол надаас хавьгүй давна. Нээрээ л үнэн шүү. Миний буруу их бий. Хэт эрхлүүлж архи дарсанд сургасны гайгаар хүүгийн зам буруутлаа, яаж шүү засаж залж авдаг юм бэ?!»

Харин одоогоор буруу бүхэнд би л гэж хүлээж өвдөг сөхрөөд байвал авгай маань сүүлээ сэврээн дээрээ тавиад толгой дээр сандайлах гэнэ» гэж харшин бодоод,

— Хандсүрэн минь, чиний хэлдэг ихэвчлэн зөв. Гэхдээ аль алинд маань бий. Би одоохон яваад бүүр нэг хочий нь бартал сураглаад ирье гээд гадагш гарахаар бэлтгэж эхэлтэл хаалга тогшин зөвшөөрөл аван орж ирэгч сэргийлэгч залуу байлаа. Тэрээр мэнд мэдэж цай, идээ амссаны дараа суурьшил, орон сууцны хаяг болон ам бүлийн овог нэр, насыг магадлан сонирхоод, тэмдэглэлийн жижиг дэвтэр сөхөж харангуут,

— Хорин зургаан настай Вандан овогтой Бэлэгсайхан танай хүү юу гэж лавлав.

— Тийм ээ, манай хүү. Юу болоо вэ гэж эцэг, эх хоёул ам булаалдан асуув.

— Ноцтой танхайрлын хэрэгт цагдан сэргийлэх газар баривчлагдаж мөрдөгдөж байгааг мэдэгдэхээр ирлээ гэхэд эцэг эх хоёрын царай нэгэн адил барсхийн, зүрх нь түгшицгээв.

## Хорин дөрөвдүгээр бүлэг

### Бид хоёр яваандаа хожно

#### I

Бэлэгсайхан сархдын найзуудтай хөлхөлдөн таних, үл таних айл, их төлөв гудамж, зах зээлээр архидаад хоёр хоножээ. Гурав дахь өдрийн өглөө хоргодож унтсан байшингийн доод харанхуй тасалгаанаас гарахад хүмүүсийн ид ажил, албаны цаг байлаа. Аль хэдийний ажил, сургуулиас хөөгдсөн үеийн залуу Соохондой гэгч гэнэт уурсан агсарч,

— Луйварчидаа, мөнгөө гаргацгаа. Би хэдэн өдөр даасан, өнөөдөр чадахгүй шүү. Уул нь надад янчаан байнаа байна. Нүдээ хужиралцгаа гээд аравт, хорин тавтуудыг сагсайтал атгаж баярхахад нөгөө хоёрын хорхойтсон өлөн харцанд нь горилсон шинж тодроод,

— За, за ганц шил юм авч балгая. Бид хоёр өнөөдөр мөнгө олноо, гайгүй гэж Бэлэгсайхан царайчлангуй хэлэв. Нөгөөх нь бүүр хамар өргөн дээрэлхэж,

— Та хоёрын мөнгөжихийг хүлээвэл нар баруунаас гарахыг хүлээхтэй ойролцоо байх вий. Хотод нохой нүдний гэм болсон одоо үед хавны хатсан жогорхой олох лугаа адил та бидний мөнгөний олбор тэнцэнэ гэж мэдээрэй. Та хоёр минь өдий хүртэл мөнгө олох аргыг сураагүй атал нөхрийн халаас руу улаан цайн дайрдаг гэгээн цагаан өдрийн дээрэмчид юм. За гайгүй мөнгө олох арга мэхийг заагаад өгнө. Хэн, хэн чинь дөрөвдүгээр ангийн тоо бодож чадна биз! За гүйцээ, бас л нэг лонхны бөглөө мултлах уу? гэж буусхийн лавлав.

—Тэр сайхан ерөөл баг сайхан орших болтугай гэж хэлээд шүлс залгиж харагдана. Гурвуулан олны хөлөөс дайжиж нэгэн цэцэрлэгийн шигүүд орж, цамц тайлан дэвсэцгээж, нэмэртэй авчирсан хэдэн шилээ бараг хоосрохын багцаанд талимаатсан нүдээр бие биеэ ширтэн, ногоон дээр эргэж хөрвөнө. Соохондой хоёр найзын бэл бэнчин тасраад уух дуран дээрээ боогдон буйг далимдуулан хэдий нь бодсон санаагаа шууд илчилж гарав.

— Өнөөдрөөс эхлэн мөнгө олох аргаа хамтран туршина аа. Заримдаа мөнгө өөрөө халаасанд орчдог мэргэн мэхийг би мэднэ. Ялангуяа дэлгүүр худалдааны үйлчилгээ ид оволзож дэс дугаар алдагдан үймж буй цагаар, автобусанд ороход дотор нь чихэлдэж буй хүмүүсийн анхаарал алдагдсан сандруу үед, за тэгээд нэгэнт нүдэлсэн хүний цүнх юм уу? халаасанд нь... гэтэл Бэлэгсайхан нүд томруулан гэдэлзэж,

— Тэр ярихгүй ээ хө, иймэрхүү олбороор балганаа гэвэл бараг дуслын төдийг амсаж чадалгүй шоронгийн хаалга түлхүүрдүүлнэ. Цаадуул (сэргийлэгчид) чинь ёстой улаан хөлтийг урдуураа гаргахаа больсон одоо үед... гээд толгой сэгсрэв. Соохондой мөр мурыж хөдөлгөн гар зангидаад,

— Чи мөн их хуцав аа. Хоёр новш, миний мөнгөөр өдөр дараалан уугаа биз дээ! Тэр чинь тэгвэл нарийн нууц аргаар олсон мөнгө. Та бүхэн идсэн ууснаа амаар буцааж гаргахгүй шингээх л болно. Эвгүйхэн үнэрээр хэхэрвэл тоогүй еэ гэж элэг барин дооглоход Бэлэгсайхан

хор шараар оргиход бэлэн оволзож буй уур унтууг тэсэн барьж,

— Миний найз учир тунгаан ойлгох хэрэгтэй. Би нүд үзсэн баримтат жишээ хэлье. Хэд хоногийн өмнө сонин содон баримт байсныг чих дэлсээд дэлгүүрт очсон юм. Ёстой л чиний хэлдэг шиг дээр дороо орон орон алдаж байв гэхэд Соохондой үгэн дундуур тас дайрч,

— Хэрэв надад тийм юм тааралдсан бол тэгээд яая гэв.

—Тэгээд үү? Наана чинь хулгайч луйварчин мөнгийг нь авчихлаа. Бариад аваарай гэж нэгэн авгай хашгираад товч мултран онгойсон хоосон цүнхээ энэ тэрд харуулан уулгалан үглэнэ.

Суйлаачийн сураг ч алга байлаа. Энэ шуугианаас болж үйлчилгээ түр зогсон, хүмүүс өвөр, түрий, дотор гадна халаасаа тэмтрэн магадалж харагдав. Гэтэл цагдан сэргийлэхийн хошууч Цэвэгсүхийн тогтуун боловч цаанаа эрэлхэг сүртэй дуу сонсогдон,

— Хулгайч, суйлаач баригдсан! энэ байна. Та нар харцгаа гээд үл таних хөрзгөр залуугийн хулгайлсан мөнгийг гарт нь атгуулан дээр өргүүлж байгаад зургийг авав. Хохирогч авгай бүхнээс урьтан амьсгаадан урагшилж, залуугийн гарт атгаастай мөнгөө нүд салгалгүй ширтэнэ. «Муу сайн луйварчингуудыг ингэж байх хэрэгтэй. Манай сэргийлэгчид мөн ч овсгоотой байна даа. Ер нь нөгөө бага дарга Нэмэх, энэ Цэвэгсүх хоёрын байгаа газраас хулгайч нар юм олж долооно гэвэл бэрхтэй болж байгаа даа» гэх бахархлын шивнээ үг сонсогдож байлаа. Үүнийг хараад би бүр бие чичрэх шиг санагдсан гэхэд,

— Хээ, чиний зүрх чинь уушги гэсэн үг шив дээ. Ийм байж архи, авгай хоёрт санаархаад юу хийнэ. Хөнжилд шурган салтаанд толгой хавчуулан дугжирч насыг бар, чиний жаргал чинь тэр дээ. А, үгүй бол миний үгэнд орж амтат олбороор жаргалаа эдэлбэл аштай юу гэж зугуухан ятгав.

Санаа бодлыг үл тохирох шижмээс үүдэгдсэн, хэрүүл маргаан нь хэтрэн нүдэлдэж эхлэв. Соохондойд нүдээ хавдтал цохиулсан залуу ухаан алдан сандарч зугтаан алга болов. Үлдсэн хоёр, хүч сорилцон нүүр нүүр рүү хэд хэд тавилцаж, нэг нь хацартаа нөгөөгийн нь хөмсөг хэгз цохигджээ. Гартаа нэг нэг шил бариад хэрэн зогсож буй агшинд цагдан сэргийлэхийн гадуур эргүүл албаны офицер хошууч Цэвэгсүх хэдий нь амжиж ирээд машинаас бууж харагдлаа. Баривчлах байрт аваачих зуур машин дотор Бэлэгсайхантай зэрэгцэн сууж буй Соохондойн сэжигтэй эвгүй хөдөлгөөнийг анхааран ажигласан сэргийлэгч, Соохондойг гоцлон зааж,

—Нөхөр залуу! томоотой суугаарай. Хэрэв та гар хөлөө гаж буруу хөдөлгөх гээд байвал бас тогтоох юм бидэнд бий гэж сүрдүүлэнгүй өгүүлэхийг Соохондой үл ойшоох маягаар сонсов.

—Та нарын даавуун хүлэгний амтыг овоо үзлээ. Харин нэг сүрхий төмөр гав байдаг юм гэнэ лээ. Түүний чинь углаад авахад яадаг юм гэж сагсууран өгүүлнэ. Тэр хоёрыг нэгжлэгийн тасалгаанд оруулав. Нүд хариулан гөлөлзөн байгаа Соохондой, Бэлэгсайханы чихэнд,

—Өнөөдрөөс сангийн будаагаар өл залгажээ. Өчиг ам зөрж болохгүй гэж анхааруулан шивнэв. Бэлэгсайханы хар алаг судалтай цамцны гаднах зүүн халааснаас нусны алчууранд



боодолтой юм гарав.

Задалбал утсан хэлхээтэй бөөн түлхүүр байлаа. Бэлэгсайханы нүүрний арьс чацав татав татганан, гайхсан төлөвөөр,

—Энэ түлхүүрүүд минийх биш гэж булзааруулан яаруу хариулжээ.

Түүний үгийг ойшоож авах хүн алга. Түлхүүрүүдийг ялган салгаж дугаар номороор нь актанд бичиж буй хошууч Цэвэгсүх,

—Хараажаар гэрч нарын дэргэд халааснаас чинь гарсан учир булзахыг битгий яар. Харин түлхүүр нэг бүрийн цоожийг эзэн хүн онгойлгох адил түлхүүрдэнэ гайгүй, аль эсвэл учир шалтгаан тоочиж хэлэх л болно гэж үгээ хүйтэвтэр давгаад гэрчийн хувиар холбогдох хүмүүсийг магадлан асуухад «Түлхүүрүүд Бэлэгсайханы халааснаас гарсан» гэж нэгэн зэрэг ам ангайхад тэдний дундаас найз залуу Соохондойн «Тийм, тийм үнэн» гэж баталсан хэл ээдрэнгүй дуун тун содон сонсогдоно.

Бэлэгсайхан гэнэт уурсан давшилж,

—Өө муу үхэр оготно, чи юун овсгоотой гүтгэж амжина вэ? Ийм олон түлхүүр надад байхыг чи хэзээ харсан бэ? Хэргийн эзэн эд мөрийнхөө баримтанд гэрч болох гайгүй биз. Харин миний түлхүүр гэж хэргээ хүлээхээ.. гэж хэлээд нүүр рүү нулимжээ.

— Сэргийлэгчид ээ. Би энэ согтуугийн доромжлолыг яасан ч хүлээхгүй шүү гэж Соохондой хариу давшлав.

— Дэг дэглэмтэй байхыг дахин сануулъя. Хэрэгсэхгүй бол... гэтэл Соохондой гулсхийн царай буруулан ухарч урт сандал дээр бөгсөөр лагхийжээ.

Хоёр сар гаруй мөрдөгдсөний эцэст, Соохондой үйлдсэн гэмт хэргээ бүрэн хүлээжээ. Тэрээр халаасны дадлагатай суйлаачаас гадна гэр, байшинд түлхүүр тааруулж эд юм хулгайлахдаа үнэхээр мэргэжсэн байв.

Бэлэгсайханы халаасанд түлхүүр сэмхэн шургуулж гэмт хэргээс мултрахыг оролдсоноо ч Соохондой хүлээжээ.

Бэлэгсайхан ууж согтууран удаа дараа танхайрсан ба Соохондойн хулгайлсан эд юм худалдан борлуулсны үнэ мөнгөөр учир мэдэж архидсан зэрэг хэрэгт хэдэн жил хоригдох ял шийтгэгдэн засан хүмүүжүүлэх газар шилжжээ.

## II

Вандан дунд зэргийн босоо шилбэт мөнгөн хундаганы амсар хальсан архийг ганц амьсгалаар хөнтрөн, дахин дүүргэж тавиад бантагнасан бодлын санаанд орсон бүхнээр сэтгэлээ дэвэлзүүлж санааширна... Ээ дээ юу ч гэх вэ. Муу хүүгийн замыг би л буруутуулж орхилоо. Ганц юм гэж эрхээр нь хатаахдаа, архинд сураг гээгүй ч хүүхэд согтохоор хөөрхөн байдаг гээд хундаганы шавхруугаар шахаж, цутгаж байхад эх нь намайг буруутган «нялх амьтныг архичин

болгох нь үү? Чамайг дуурайвал архины лүү, арилжааны дон шүглэсэн булай амьтан болно» гэхэд би биедээ хир халдаахгүйг хичээж «Чи юу гэж аман доторхи махан хутгыг билүүдэнэ вэ? Миний хоол, хоол болмооргүй шиг санагдаад байвал ирсэн замаараа сурсан дуугаа ая бариад буцсан чинь дээр. Хүүгийн толгойг аав мэддэг зан заншил эзэн болж, Бэлэгсайханы ямар хүн болохыг би даана. Ертөнц дээр эр хүйсээр нэрээ зарлан мэндэлсэн муухай амьтны эцэг нь хэн бэ? гэхэд хүрээ Вандан энд байнаа хө гэж ам бардам хэлэх бүрэн үндэстэй биш үү?

Харин хүүгийн оронд чам шиг бүдүүн шар богино жолоотны дүр төрхтэй төсөөдүү жижигхэн шар чавганц төрсөн сөн бол түүнийг ямар хүн болгохыг чи мэдэх ёстой байсан. Би хар ухаанаар бүгдийг төсөөлөн мэднээ. Хүү бид хоёрын амьжиргааны төлөө хэн ч ам ангайж хуруу дүрэхгүй байвал сайн сан» гэж хэлээд амыг нь таглаж байж билээ.

Одоо бодоход хүний сайн хань гэхээр хэрэгтэй юм зөвлөж байжээ. Архи, тамхи, савсаг зүйлд донтуулж орхисны гайгаар хүү маань шавар шалбааганд уначихлаа. Урьдантай адил ивэн хахуульдаж болдогсон бол урьд одоогийн олборын хэд байна л даа. Дөрвөн хар толгой идээд, идээд барахгүй, хүүгийн хүүхдүүдэд юм үлдэнэ. Шоронгийн цоожийг мөнгө төгрөгөөр түлхүүрдэж болдоггүй юм аа гэхэд яавал, юугаар онгойлгож болохыг бодон байж шийднэ» гэж шивнээд хүндагатайг шимж залгиад ярвайж яртайн хурсан шүлсийг зуухны хажуугаар нулимав. Тэрээр толгойн ард хоёр гар зөрүүлэн дэрлэж гэдрэг харан хэвтгээд гуньж гутарсан бодолд шүүрс алдана.

Энэ үед гэргий Хандсүрэн цүдгэр бэр Наянтайг дагуулан орж ирэнгүүт ам хэл татлан ягшиж гарав.

— За ямар байна. Сайхан байна уу? Хүүхдийг бага балчраас дэндүү эрхлүүлж архи, тамхинд сургаж, мөнгө төгрөгөөр туйлуулсны чинь ид шид шоронгийн мухар сахиулав шив дээ. Ганц үрээ хүний гарт хийчихээд байгаа мөртөө ер чацав хийх шинжгүй, гашуун усаа гударч суугааг хараач. Мөн ч цайсан дотор шүү. Чухам юугаар цайрдахаар хүний дотор ийм болдгийг мэдэх сэн. Чамайг ингэхийг чинь мэдсэн бол тэр жил оршуулгын газар хүзүүнд углаж байсан олсны гогцоог татаж орхисон болоосой. Тэгсэн сэн бол энэ цайрсан дотортны бахыг одоо яалаа гэж хангаж байх вэ? гээд хэдэн хуруу хэртэй архитай шилийг шувт татан авч орны хөндий рүү гулсган түлхэхэд шилний харших чимээ сонсогдов.

Вандангийн гэжүүн зан хөдөлбөл тамхи баагиулан, архи байвал шимээд, хүний өөдөөс таг дуугүй гөлийгөөд суучихдаг зантай. Харин энэ удаа тэгж чадсангүй. Авгайгаа юу хэлэх нь вэ гэдгийг чих тавин чагнаж, ам л ангайхыг больё гэж бодсон Вандан таг дуугүй царай барайлган сууна. Эхнэр Хандсүрэн сэхээ самбаагүй үглэх нь ширүүн салхитай мөндрийн балбаа шиг халшрам сонсогдох ажээ.

Хандсүрэн үглэхээ больж, жаахан уужрахад, Вандан бодож бодож, сая ам нээн,

—Хандсүрэн минь, үгний өөнд өнгөрсөн юмыг босгон амилуулж хүний сэтгэлийн шархыг хөндөх шиг хамгийн бузар адгийн юм байдаг гэж үү? Энэ бол хорон санаат атаа, жөтөөтөн нарын бараг хоол унд нь шүү дээ. Чи минь юмыг бодолтой ярьж байгаач! Дэлхий шиг уудам тэнүүн нөхрөө байхад юунд ингэж цухалдана вэ?

Урьдын адил өвдөг газардах цаг биш ээ. Миний түших тулах түншүүд хотын төвөөс захыг хүртэл бий. Баянзүрхийн бараг ар, чиний нөгөө цагаан гүүний хөх үлгэж байсан тэр газраас...

—За яршиг даа. Би хэзээ гүү хөхөж байсан юм. Сүүгий нь уусан үнээн гэв.

— Юу ч гэсэн яахав, тэр цагийн юм. Тэгээд баруун тал нь Сонгино хайрхны зүүн дэв. Миний гүүний айраг хийж байсан тэрхүү газраас нийслэл хот маань урт нь өөртөө илүүгээр элбэг эргэлдэхээр тэлсэн шиг, миний зузаан түншүүд мөн тиймэрхүү хэмжээнд утгагдах юм чинь... Ердөө л одоохон гараад айлын утсаар юм уу, биеэр халз тулж нэгэн найзынхаа чихэнд нэмэртэй шивхийхэд л ажил бүтэж, хүү маань суллагдан ирнэ. Хоёр, гурван жилийн хугацаа юу байх вэ? Одоогийн жаргалтай үед цаг мөч гэгч нь нисдэг тэрэгний сэнс эргэлдэх адил түргэн өнгөрнө. Чи бод! Урьд зовж зүдэрч явахад олон нэгэн өдрөөр жишихэд дүнжин гарвын нөгөө том хүрдийг арайхийж бүтэн эргүүлэхтэй тэнцдэг байж. Нэг мэдэхэд Вандангийн Бэлэгсайхан ял эдлэх хугацаа дууссан! Ажил сайн хийж, томоотой тохитой амьдраарай, гэртээ алхаад «марш!» гэх вий гээд хүд хүд инээхэд Хандсүрэн арга барагдан бачимдан уурсаж,

—Уухай бас утасдах гэнэ шүү. Нээрэн л чи бид хоёрын тоглоомын хүн. Тэгээд гажиж эвдэрсэн хог шаарнуудыг дэмжиж тэтгэж бас хүмүүжүүлж өгөх гайгүй биз! Ер нь чи чинь согтуурахаас халиад, галзуурах нь шив дээ. Согтуу дээр галзуу, энэ хоёр дээр бусдыг үнэгэн залиар шулах мөлжүүрийн донг нэмбэл юу болох бол? Шорон, гяндангийн газар арын хаалга гэж байдаг юм уу? Тархи толгойд багтаж шингэх үгийг олж яривал сайнсан гэхэд Вандан дооглонгуйгаар инээмсэглэн эргэж авдраас нэг шил архи гаргаж хэд хэд угсруулан балгаад, Хандсүрэн рүү муухай харж,

—Чи юу юм бэ?... гэж хөгшнөө агсарсан миний туйлын буруу. Би буруугаа мэдэж байна. Хоёр хөгшин хар толгой бие биеэ үгээр залгиж суух хэрэг алга, зүгээр хоёулаа эвлэрье.

Би амь гол шигээ хайртай чинийхээ санаа сэтгэлд юм хийчихээгүй байгаа гэхэд гэргий нь хэлэх үг олж цөхөхдөө,

— Чамд зөнөг, мунаг хоёр л дутаа юу? Бусад нь гүйцсэн байх шүү. Чи тэгээд муу хүүгээ хараад өрөвдөх сэтгэл төрөв үү? Үгүй юу?

— Төрөхөөр барах уу? Үс гэзгээ мөлчийтөл хусуулчихсан данхар толгойг халыг хараад өрц минь татаж орхисон.

— Өрц гэнэ шүү элэг цөсний чинь архаг өвчин хөдлөө биз. Чамаас болж зүрх гажигтай болох нь байна. Оройтсон хэдий ч замаа хардаг юм бил үү? гэж бодогдох боллоо. Тэгэхдээ энэ муу бэрээ дагуулаад явнаа,

— За да тэгвэл бүүр шившгээ тарина. Битгий тэгээч. Чамайг зуларвал би амаар шороо үмхэнэ. Миний бандгар шар минь намайг хайрлаач гэхэд,

— Шар тос үмхэх байлгүй гэхэд Вандангийн омог бардам зан хөдөлж,

— Алаг хорвоод алт ч үмхэж болно. Хандсүрэн минь эхнэр хүн эр нөхрийнхөө толгой дээр гарчихсан байх шиг шившиг байхгүй шүү гэж үг мохоон мэтгэхэд Хандсүрэн хялалзан шилбэлзэж,

—Олон үггүй, маргааш эрт хүүд минь эргэлт аваад яв. Аль хаалгаар орохоо өөрөө мэд гэв.

—Мэднээ мэднэ, хүрээ панз үхэн үхтэлээ арын хаалгаар амьдрахаа мэднэ. Энэ сүр дуулиатай нэрийн доор тулаад буухад дороо зохицно. Ердөө л амархан сайн байна уу гэхэд сайн, та амар сайн байна уу? Вандан гуай ор, ор гээд хаалга нээнэ. Арын хаалганы цоож бол нүднээ үл үзэгдэх гайхам увидастай гэж мэдээрэй.

Түлхүүрийн оронд янз бүрийн юмаар ивээс ивэхэд дотор онгойлгож амьсгал уужруулдаг ид шидтэй. А, харин шоронгийн арын хаалганы учрыг олж татахгүй бол нэг мэдэхэд өвөр талын ордгоор нь Вандан панз орж ууна, иднэ, мөрийтэй тоглоно, дэнчин буулгана гээд л арга ширэг алиныг тоочиж барах вэ? гээд хуурамчаар инээмсэглэж аягатай архиа дугтарчээ.

### Ш

Тэр нэгэн өдрийн орой амралтын цагаар, гадаа сандлын түшлэг налуурдаж зэрэгцэн суугаад элдвийг хүүрнэн буй хоригдол хоёрын нэг нь,

— Би гашуун усанд толгой мэдүүлж халуун чулуу долоосон, өгөө авааны хар толбыг ажлын тоосоор үзье гэж үнэхээр шийдэн зориглож, таны хойноос мөр дараад элдчихсэн чинь гүйцэгдэх юм биш ээ. Өнөөдөр нэг дөрөө харшив бололтой гэж хэлсэн залуу эр, гарт барьсан уран зохиолын номыг бушуухан унших сан гэхдээ хуудсуудыг харалгүй эргүүлж байв. Догь эр боловч хашир, башрын даваанаас хальтрахыг алиныг тэр гэх вэ? Байргашиж нас тогтсон овжиндуу харцтай хар хүн том модон гансанд нэрсэн тамхиа угаа баагиулан даамай гэгчээр сорж,

— За хө, Бэлэгсайхан минь чи эр хүний хэлдэг үг, санадаг санаагаар зоригоо чангалан жолоодуулсан байна. Энэ түмэн зөв.

Нэгэнт шийдсэнээс хойш оройхон гарсан ч ширүүхэн шиг дайрнаа хө. Ах чинь зуугаас доош бууж үзээгүй. Тэгэхдээ надад хоёр зуун өдрийн од шиг оногддог. Харин чамд бол хоёр зуун тавь ч санаан дур байна. Залуу халуун нас юунаас халшрах вэ?

Буцалгаад бай, буцалгаад бай. Гурван жилийг ажлын хоногийн тоосоор ихэвчлэн гүвээд мултарсан шиг сайхан юм байхгүй.

Тэгээд гэртээ харьж авгай хүүхэд, аав, ээж дээрээ очиж жаргана. Би яваандаа чиний дөрөөн дээр тавхай тавьж чадвал дээд зэргийн зол болох вий гэхэд Бэлэгсайхан хөгжингүй боловч даруу төлөвөөр,

—Ах гуай! муу дүү хүүгээ дэндүү дөвийлгөж цаасан малгай өмсгөөд байвал... гэсэнд нөгөөх эр хэсэг дув дуугүй байснаа элэгсэг маягаар харахад Бэлэгсайхан хөгжингүй боловч даруу төлөвөөр,

— Миний нүүр ямар шүү байна. Угаасан юм сан. Хир буртаг нь арилаагүй байна уу? гэхэд ахимаг эр:

— Үгүй дээ хө. Хүмүүжих хөдөлмөрийн ундраа бүтээлээр угаагдсан нүүр царайд яалаа гэж хир тогтох вэ? Анх ирснээ бодвол царайд чинь хүрэн бор хөрс сууж байна. Цааш нь энэ рамаа түшиж гүвээд бай гэж захих гэсэн юм. Ер нь шөрмөсөн чулуу «Жонш» чинь олигтойхон хөвсийлгөөд байвал хүмүүжих ажилчин нэг бүрийн аминд орох төлөвтэй... гэтэл яриан дундуур гүйнгүүт ирсэн залуу эр:

— Бэлэгсайхандаа баяр хүргэе өнөөдөр чи чинь хоёр зуун далан хувь даржээ. Худал гэвэл тооцоолох самбар дээр очоод хар! Яг таг үнэн шүү гэхэд Бэлэгсайхан итгэж ядсан байртай өндийвөл нөгөө ахимаг эр:

— Чиний амжилтыг сонсоод миний дотор нар мандах шиг санагдав. Ёстой л үсэрч наалдан, үзэж алдаад бай хө. Самбарыг сонирхье гээд зэрэгцэн алхах хоромд хашааны гадна их хаалганы дэргэд зугуухан ирж зогссон «ГАЗ-69» машинаас цагдан сэргийлэхийн бэлтгэл бага дарга «ахлагч»-ийн дүрэмт хувцас хэрэглэсэн ахмад насны ханхар цээжтэй сэргэлэн байрын эр буугаад хянагчийн зүг тэвхэлзэн алхалж харагдав. Тусгай үнэмлэх үзүүлэн дотогш нэвтрэнгүүт нөгөө гурвыг чиглэлээ. Бэлэгсайхан зогтусан эргэж,

— Ах маань мөн байна, ойрдоо ирээгүй юм сан гэнгүүт хэд алхаад нүүр учирлаа. Ахмад сэргийлэгч түүний гарыг дотноор чанга атгах зуур баруун хацрыг үнсээд, нөгөө хоёртой элэгсгээр мэндлэн ярилцах гэтэл ойрхи самбарын өмнө дагуулан аваачиж танилцуулбал Бэлэгсайханы хөдөлмөрийн амжилтын дээжинд бахдан, баярлахын эрхээр ахмад сэргийлэгчийн царай улаа бутран ягаарч Бэлэгсайханыг өөр рүүгээ татан тэвэрч,

— Дахиад ирэхэд гурван зуун хувь давуулан биелүүлээд байгаарай. Хянангийн хурал удахгүй хуралдана. Чамайг оруулах гэж байгаа, бараг мултрах байлгүй гэж бодож байна гэж буруугаа цагаатгах ганц нөхцөл бол хүмүүжих газрын дотоод дүрмийг биелүүлж сахилга батыг дээд хэмжээгээр сахин, хөдөлмөртөө онцгой амжилт гаргаж чадвал тэртэй, тэргүй ажлын хоногоор бамбайдана гэж захиж амжаад тэдний хамт байранд нь очиж гар тээшийн ширэн савны амыг нээж үхрийн болгосон тарган мах, гахайн шарсан өөх, чанасан өндөг, гурилан боов зэрэг идэнги амтлаг зүйлийг өгөх зуур,

— Танайхаар сая ороод ирлээ. Цөм сайн байна лээ. Наянтай дараа ирнэ. Охин чинь том болж байна. За баяртай ажил, ажил... гэж давтан захирад, сэтгэл ихэд хөдөлсөн Бэлэгсайхан:

— Нэмэх ах аа! Танд тун их баярлалаа. Баяртай гэж хэлээд хаалга хүртэл үдэж гаргав. «Бэлэгсайхан шал өөр болж, үүнийг хөдөлмөр л хүмүүжүүлжээ.... Бид хоёр яваандаа хожноо» гэж бага дарга Нэмэх бодохоос баярлажээ.

# Хорин тавдугаар бүлэг

## Ач охин

### I

Тэр нэгэн үйл явдлаас хойш олон он жил өнгөрчээ. Гэр дүүрэн цугларсан зочдын дунд бэлтгэл бага дарга Нэмэх, түүний гэргий ахмад багш Сайнзаяа, нэгдлийн малчин Гомбодоо, гэргий Гүнчин, гэрийн эзэн Вандан, гэргий Хандсүрэн, манаач өвгөн Жамсранчой гэргийн хамт, Вандангийн хүү Бэлэгсайхан, түүний гэргий Наянтай нарын зэрэг удам угсаа, ажил амь зуулт аль нэгээр бие биенээ арван хуруу шигээ андахгүй хүмүүс байлаа.

Найр эхэллээ. Хонины бүхэл мах, шар тосон дүйлттэй, шар тосонд чанасан том ул боов, өрөм, бяслаг, чихэр жимсэн чимэгтэй тавгийн идээ намхан ширээн дээр тавьж, янз янзын архи өрж, луун хээтэй том эрээн алаг хуланд айраг мэлтэлзүүлэн амтархан шимцгээнэ. Гол хоймор завилан суусан Вандангийн өмнө хонины ууц тавьжээ.

Бэлэгсайхан Наянтай хоёрын ажлын газрын найзууд зай завсаргүй үйлчилнэ. Таваг, тавгаар бууз жигнэж тавина. Сэвлэгээ авахуулж байгаа охинд ерөөлийн үг хэлээд янз бүрийн бэлэг гардуулна. Гурван дугараанд хүмүүс халж эхлэв.

Хуурч өвгөн хуурдаж, уртын дууны ая барин, ерөөл хэлнэ. Вандангийн ач охины дуулсан хүүхдийн хэд хэдэн дуу бүгдийн анхаарлыг ихэд татаж, дахин дуулуулж өхөөрдөцгөөнө. Эдний дундаас олон хүн амьдрал ахуйгаа оочоо, цоочоо сөхөн санаж дотроо дурсавч хэн ч түүнээ ил гарган хэлээгүй л байв.

Ахмад багш Сайнзаяа ингэж бодов «...өвгөн бид хоёр мөнх хорвоогийн жаргал, зовлонгийн дугтраан дунд хоёрхий нялх амьтнаа гараас алдсан тэр цагаас хойш олон он жил улирчээ. Хувь заяа маань дутахад үрчлүүлсэн Намжаа авгай эсэргүү нарт амь үрэгдсэнээс болоод Гэрэлтуяа охин минь үүрд төөрөлдсөн юм даа.

Гомбодоогийн Наянтайг л охиноо биш ч гэсэн мөн гэж элгээ дэвтээн арван жилийг төгсгөн хоолтойгоо залгасан. Нөхөр нь будилж будилж одоо хүний зэрэгтэй хүн болжээ. Хөөрхий хөөрхий, охин минь байсан бол бас л нярайлж хүүгийн даахь авч байгаа даа» гэж эргэн хурган бодно. Ач охин хадам өвөө, эмээ нарын гар дамжин энхрийлэгдэнэ. Вандан яриа хөөрөө дэлгэхээр Хандсүрэн авгай тохойгоор сэмхэн нүдрана. Үнэндээ найр эхлэхээс өмнө Ванданд элдэв чалчаа яриа хөөрөө гаргаж болохгүй гэж гэргий нь хатуу хориглон, төлөв түвшин байхыг анхааруулан захисан ажээ. Орой болж хүмүүс бараг тарж хүн цөөрөв.

Гадаад дотоодын хатуу архиар шавдуулсан Нэмэх, Гомбодоо, Жамсранчой нар согтох тийшээ хандаж үг олшрон хоёр гурваар хошуу холбон хууч хөөрөлдөнө. Авгайчуул ч өвгөдөөс нэг их хоцролгүй ам хэл мэдэн бурж гарав. Харин Бэлэгсайхан ганц хоёр хундагаас илүү уусангүй. Тэрээр үеийн найзууддаа юу хийж яаж яваад муу зам руу хальтарч зовж зүдэрсэн тухайгаа хүүрнэхэд нөхөд нь анхааралтайяа сонсоно.

«Хүнд хөдөлмөрийн үр шимээс өөр жаргал байдаг гэж үү?» гэсэн Бэлэгсайханы үг онцгой анхаарагджээ. Амьдралын ээдрээн дунд өгөө, авааны зарим үед амь дүйн тэмцэж явснаа бодож голлох хэдэн нөхөд, найз нарынхаа нэрээр нэг бүрчлэн нэрлэн дуудаж аз жаргал урт удаан наслахыг Нэмэх ерөөж хүндага тулган уух гэтэл нөгөөдүүл нь үнсэх гээд барьц алдан хацар нүүрийг шүлсдэнэ. Хэн нэг хүн хүндагатайгаа цалгиулан дээр өргөж,

— Манай Нэмэхэд мөнгөн буурал дүрийг хорвоо хайрласан боловч мөн толиотой хэвээр байна. Хар багаас цагдан сэргийлэхэд орж тэр цагаас таньдаг, эс таньдаг гэж ялгаварлан зааг тавилгүй хүн бүрийн төлөө амь дүйж явсанд тань баяр хүргэе гэхэд Нэмэх,

— Цаасан малгай томдвол шүхэр болон задарч энэ найрнаас намайг хөөргөөд явчихвал та нарт ямар вэ гээд хөгжин хөхрөхөд хүмүүс дагаж хөхрөлдөв.

Ач охин дамжигдан энхрийлэгдсээр Нэмэхийн өвөр дээр шилжин ирэхэд тэрээр үнсэн таалахад охин хүзүүгээр тэврэн инээмсэглэнэ. Тэгээд одон медалиудын үелсэн олон туузыг тоолон сонирхож,

— Энэ ямар одон бэ? Энэ ямар тэмдэг вэ гэж хүүхдийн гэнэн цайлган санаагаар шалгаана.

— Охин минь чи том болоод одон тэмдгийн энэ олон туузыг бас зүүнэ гэж товчлон хариулахыг сонссон Жамсранчой, дуу өндөрлөн,

— Хөөе охин минь! Чи өндүүр болоод наад өвгөн аав шигээ ийм олон одон зүүж алдар гавьяатан болоорой гэснээ өвгөн аав гэнэ шүү! За байз үгээ олж хэл, сүхээ олж ишил гэж хууч үг бий! Жинхэнэ өвөө аав нь Вандан болж таарах нь ээ. Гомбодоо бас өвөө нь... Тэгээд бүгдийн маань ач шүү дээ. Тэгэхдээ нэг л өвөө чиний ёстой өвөө аав нь... гэтэл авгай нь ичиж тэвдэхийн эрхэнд автан доогуур сэмхэн чимхсэн чимхэлт чангадсан эсэхийг бүү мэд Жамсранчой дороо хавчин ёолов.

Нэмэх сэжиг аван жуумалзаж,

—Хөөе хөө хэн залхааж байна? Наад өвгөн чинь түүнээс өөрөөр залхаавал бууж өгч магадгүй гэхэд Жамсранчой маадайж толгой гилжийлгэн бодолхийлнэ. «Жамсранчойгийн гавьяа, амьдаар төөрөлдсөн хэдийг би одоо нүүрэлдүүлнэ. За байз, юу гэж хэлэх вэ? Чухамдаа наад охин чинь Сайнзаяа та хоёрын ач шүү дээ! Энэ Наянтай бол Намжаа авгайд өргүүлсэн таны Гэрэлтуяа охин чинь байхгүй юу. За миний хэлэх үг боллоо.

Та бүгд дахин дахин тэврэлдэн үнсэлц! Хагацал гунигаа тайлцгаа! Дараа нь би ний нуугүй ярина» гэж хэлье гэж шийдээд үг дуугүй гар өргөн босов.

—Жамсранчой их согтжээ. Унтуул гэх үг түүнд бүүр түүр сонсогдсон ажээ.

# Table of Contents

<a href="#">I бүлэг. Нүд үл итгэнэ</a>
<a href="#">II бүлэг. Нөхрийн захиа</a>
<a href="#">III бүлэг. Эхний мэнд</a>
<a href="#">IV бүлэг. Бажгар дурдан алчуур</a>
<a href="#">V бүлэг. Алганы хатиг</a>
<a href="#">VI бүлэг. Алганы хатиг</a>
<a href="#">VII бүлэг. Цагаан гүүний сүү</a>
<a href="#">VIII бүлэг. Нууц зоорь</a>
<a href="#">IX бүлэг. Даачааны мөрөөр</a>
<a href="#">X бүлэг. Нүүдэл</a>
<a href="#">XI бүлэг. Отолт</a>
<a href="#">XII бүлэг. Гэрэлтуяа охин</a>
<a href="#">XIII бүлэг. Тээнэгэлзэн санаашрав</a>
<a href="#">XIV бүлэг. Бүлэг суран хүлэг</a>
<a href="#">XV бүлэг. Танил дуун</a>
<a href="#">XVI бүлэг. Сураг байна уу</a>
<a href="#">XVII бүлэг. Аав яасан бэ?</a>
<a href="#">XVIII бүлэг. Захидлын хариу</a>
<a href="#">XIX бүлэг. Нугасны ус</a>
<a href="#">XX бүлэг. Олбор</a>
<a href="#">XXI бүлэг. Хууч хөөрөлдсөн нь</a>
<a href="#">XXII бүлэг. Хүрэгч үнээ</a>
<a href="#">XXIII бүлэг. Зүрх түгшицгээв</a>
<a href="#">XXIV бүлэг. Бид хоёр яваандаа хожно</a>
<a href="#">XXV бүлэг. Ач охин</a>